



БОЛОВСРОЛЫН
ЯАМ



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ТОХИРУУЛГА ХИЙХ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨМЖ

УЛААНБААТАР ХОТ
2025 ОН

“Нарны гэрэл нь мод эсвэл амьтан гэж тодорхой нэг зүйл дээр тусдаггүй, нар өөрийн цацрагаараа бүх дэлхийг гэрэлтүүлдэг”.

Нарны нэгэн адил багш өөрийн цацрагуудаа бүх сурагчдадаа адил түгээх ёстой.

(Я.А.Коменский)

АГУУЛГА

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР.....	6
УДИРТГАЛ.....	8
НЭГ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ТОХИРУУЛГА ХИЙХ ОНОЛ, АРГА ЗҮЙН ҮНДЭС	9
1.1.Тэгш хамруулан сургах боловсролын суурь ойлголт, тэгш хамруулах үзэл санаа.....	9
1.2. Сургалтын хөтөлбөрт тохируулга хийх сургалтын онолын үндэслэл	11
1.3. Суралцахуйн түгээмэл загвар, ялгаатай зааварчилгаа.....	14
1.4. Сургалтын хөтөлбөрт тохируулга хийхэд ICF буюу “Олон Улсын Үйл ажиллагааны Ангилал”-ыг харгалзан үзэх нь	19
ХОЁР. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ТОХИРУУЛГА	25
2.1. Агуулгын тохируулга.....	28
2.2. Арга зүйн тохируулга	30
2.3. Сургалтын орчин ба хэрэглэгдэхүүний тохируулга	31
2.4. Үнэлгээний тохируулга	38
ГУРАВ. СУДЛАГДАХУУНЫ ХӨТӨЛБӨРТ ТОХИРУУЛГА ХИЙХ АРГА ЗҮЙН САНАА	46
СУДЛАГДАХУУНЫ НЭР: МОНГОЛ ХЭЛ	46
СУДЛАГДАХУУНЫ НЭР: МАТЕМАТИК	59
СУДЛАГДАХУУНЫ НЭР: БАЙГАЛЬ ШИНЖЛЭЛ	75
СУДЛАГДАХУУНЫ НЭР: НИЙГМИЙН УХААН.....	88
СУДЛАГДАХУУНЫ НЭР: КОМПЬЮТЕРЫН УХААН	95
СУДЛАГДАХУУНЫ НЭР: ДҮРСЛЭХ УРЛАГ, ДИЗАЙН.....	105
СУДЛАГДАХУУНЫ НЭР: ХӨГЖИМ	119
СУДЛАГДАХУУНЫ НЭР: БИЕИЙН ТАМИР	129
СУДЛАГДАХУУНЫ НЭР: КАЗАХ ХЭЛ	144
СУДЛАГДАХУУНЫ НЭР: ТУВА ХЭЛ.....	154

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Суралцахуйн болон сэтгэл судлалын онолын үзэл санаа онолын чиглэл	14
Хүснэгт 2. Сургалтын хөтөлбөрийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээнд нийцүүлэх хувилбарууд	24
Хүснэгт 3. Сургалтын хөтөлбөрт тохируулга хийх төрөл	27
Хүснэгт 4. Тохируулсан хэрэглэгдэхүүн	35
Хүснэгт 5. Ажтизмын хүрээний эмгэгтэй сурагчийн хөтөлбөрийн тохируулгын жишээ.....	43
Хүснэгт 6. Жишээ тохируулга (1-р ангийн математикийн хичээл)	45
Хүснэгт 7. Уншихын бэрхшээлтэй сурагчийн хөтөлбөрийн тохируулга.....	47
Хүснэгт 8. Нэгж хичээлийн төлөвлөлт	48
Хүснэгт 9. Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн тохируулгын жишээ	53
Хүснэгт 10. Дискалькулиагийн нийтлэг шинжүүд	59
Хүснэгт 11. Суралцахуйн бэрхшээлтэй суралцагчийг дэмжих арга	64
Хүснэгт 12. Нэмэх, хасах үйлдэлтэй холбоотой баримтын мэдлэг	69
Хүснэгт 13. Үржүүлэх, хуваах үйлдэлтэй холбоотой баримтын мэдлэг	69
Хүснэгт 14. Хичээлийн алхамчилсан жишээ	71
Хүснэгт 15. Суралцахуйн үр дүн, тохируулга	77
Хүснэгт 16. Хүрэх үр дүн ба мэдлэг, чадвар, төлөвшил	77
Хүснэгт 17. Хичээлийн алхамчилсан жишээ	78
Хүснэгт 18. Үнэлгээний шалгуур	81
Хүснэгт 19. Суралцагчийн ахицыг үнэлэх хуудас	82
Хүснэгт 20. Нэгж болон ээлжит хичээлийн төлөвлөлт	84
Хүснэгт 21. Суралцагчийн ахицыг үнэлэх хуудас	88
Хүснэгт 22. Суралцахуйн үр дүнг өөрчлөх алхам	90
Хүснэгт 23. Хичээлийн алхамчилсан жишээ	91
Хүснэгт 24. Үнэлгээний шалгуур	94
Хүснэгт 25. Сургалтын хөтөлбөрийн тохируулга хийсэн жишээ	100
Хүснэгт 26. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах жишээ	101
Хүснэгт 27. Хичээлийн алхамчилсан жишээ.....	102
Хүснэгт 28. Хичээлийн алхамчилсан жишээ.....	103

Хүснэгт 29. Хичээлийн алхамчилсан жишээ	104
Хүснэгт 30. Хичээлийн алхамчилсан үе шат.....	107
Хүснэгт 31. Үнэлгээний тохируулга (1-2, 3-5).....	109
Хүснэгт 32. Хичээлийн жишээ	110
Хүснэгт 33. Хичээлийн жишээ	114
Хүснэгт 34. Өөрийн үнэлгээний хуудас	118
Хүснэгт 35. Хичээлийн төлөвлөлт	121
Хүснэгт 36. Хичээлийн үе шат	122
Хүснэгт 37. Хичээлийн төлөвлөлт	125
Хүснэгт 38. Хичээлийн алхамчилсан төлөвлөлт	131
Хүснэгт 39. Тохируулга хийх алхам	132
Хүснэгт 40. Суралцагчийн одоогийн бодит байдлыг үнэлгээ.....	133
Хүснэгт 41. Нэгж хичээл	134
Хүснэгт 42. Суралцахуйн үр дүн, тохируулга.....	134
Хүснэгт 43. Үнэлгээний тохируулгын жишээ	136
Хүснэгт 44. Агуулгыг хялбаршуулах тохируулгын жишээ.....	145
Хүснэгт 45. Орчны тохируулгын жишээ	146
Хүснэгт 46. Үнэлгээний тохируулга	146
Хүснэгт 47. Ээлжит хичээлийн хөтөлбөрийн жишээ (2-р анги).....	148
Хүснэгт 48. Хичээлийн төлөвлөлт	152
Хүснэгт 49. Үнэлгээ.....	152
Хүснэгт 50. Үнэлгээний шалгуур	157
Хүснэгт 51. Суралцагчийн ахиц амжилтыг үнэлэх хуудас.....	158

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

№	Нэр томьёо	Тайлбар
1	Тэгш хамруулах боловсрол	<p>“Бүх суралцагчдын нийгэм, соёл, боловсролын үйл ажиллагаа дахь тэгш оролцоог хангах, боловсролын гаднах болон доторх бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг бууруулах замаар сурагч бүрийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн боловсролын үйлчилгээг хүргэх үйл явц” хэмээн тодорхойлсон байна.</p> <p style="text-align: right;">(UNESCO, 2008)</p>
2	Ялгаатай хэрэгцээ	<p>Хүний боловсрол эзэмшихтэй холбоотой хөгжлийн бэрхшээл, онцгой авьяас, хэл, соёл, жендер, нийгэм, эдийн засаг, байршлын ялгаанаас үүдэлтэй хэрэгцээг хэлнэ хэмээн заасан.</p> <p>(Боловсролын багц хуулийн 3.1.24-т)</p>
3	Хөгжлийн бэрхшээлтэй хүн	<p>“хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг (ХБХЭТХ 4.1.1)</p>
4	Суралцахуйн түгээмэл загвар	<p>СТЗ гэдэг нь (1) хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдалд тохирсон, оролцоог хангасан хамгийн боломжит байдлаар дэмжих, (2) мэдээллийг олон аргаар хүргэх, (3) мэдлэгээ илэрхийлэх олон хувилбар байна.</p>
5	Ялгаатай зааварчилгаа	<p>Суралцагч бүрийн сурах боломжийг нэмэгдүүлэхийн тулд төрөл бүрийн сургатын үйл ажиллагааг санал болгож тэдний ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн заах арга зүй. багш хичээлээ уян хатан зохион байгуулж суралцагчдын ялгаатай түвшинд тохируулан мэдлэгийг олгох боломжтой</p> <p style="text-align: right;">(UNESCO 2013)</p>
6	Тохируулга	<p>Сургалтын хөтөлбөрийг өөрчлөхгүйгээр суралцагчдын сул талыг нөхөж хичээлийг нийцүүлсэн байдал. Суралцагчид бусадтай ижил агуулгаар суралцаж, үе тэнгийнхэнтэйгээ хамтдаа суралцаж, хөгждөг.</p> <p>(<i>Human rights education series: topic book 5</i>)</p>
7	Тэгш хамруулах хөтөлбөр	<p>. Бүх суралцагчдын олон талт хэрэгцээ сонирхол, өмнөх туршлага, хувийн шинж чанарыг харгалзан боловсруулсан сургалтын хөтөлбөр. Энэ хөтөлбөр нь бүх суралцагчдад сургалтын үйл ажиллагаанд адил тэгш, жигд оролцож хамтран суралцах замаар сурахуйн туршлага хуримтлуулах, тэдний ялгаатай байдлыг үл харгалзан эрх тэгш боломжийг олгоход чиглэнэ.</p> <p>(Bureau international d'éducation, Paris)</p>
8	Тэгш хамруулах анги	<p>Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыерөнхий боловсролын сургуульд зохих дэмжлэгтэй үйлчилгээ үзүүлдэг анги танхим.</p> <p>(https://www.citizensinformation.ie/en/education/the_irish_education_system/special)</p>
9	Анги зохион байгуулалт	<p>Анги нийтээр эерэг зан төлөвийг дэмждэг системийг бий болгох явдал юм. Суралцагчид сургалтын ихэнх хэсэг, цаг хугацаа, анги танхим, материалыг зохион байгуулах замаар ангийн менежмент</p>

		амжилттай болно. Ангийн менежментийн талаарх философиудыг судалж, анги танхимдаа зөвшөөрөгдөх эерэг зан төлөвийг бий болгон хадгалах нөөцийг олох нь чухал юм. (Classroom Management: Resources for Parents, Teachers and School-Based Professionals.com)
10	<i>Хөгжлийн хоцрогдол</i>	Хөгжлийн хоцрогдол /бодит юмуу дүйцүүлсэн насныхаа түвшинд тохирсон хөгжлийн үзүүлэлтээс гүйцэтгэлээрээ нэлээд хоцорч яваа хүүхдэд хамаатай /ICF/ ...0-3 настай буюу нярай, нялх хүүхэд, 3-9 настай буюу бага настай хүүхдийн хувьд биеийн хөгжил, танин мэдэхүйн хөгжил, харилцаа, нийгмийн буюу сэтгэл хөдлөлийн хөгжил, дасан зохицох (зан үйлийн) хөгжил гэх мэт хүүхдийн хөгжлийн аль нэг чиглэлд илрэх хоцрогдол, саатал /IDEA/
11	<i>Шилжилтийн төлөвлөгөө:</i>	ГСТ-өөр хичээллэх сурагчид нь боловсролын тухай хуулийн шаардлагад нийцсэн шилжилтийн төлөвлөгөөтэй байх ёстой. Шилжилтийн төлөвлөгөө нь сурагчдын хэрэгцээнээс шалтгаалаад дараах хувилбарт чиглэлтэй байж болно. <ol style="list-style-type: none"> 1. СӨББ, сургуулийн зөвлөл, мөн эмчилгээ, асаргааны хөтөлбөр, 2. анги, бүлэг, сургууль хоорондын шилжилт 3. дунд сургууль руу болон сургуулиас шилжих 4. хичээл, анги, судлагдахуун хоорондох шилжилт 5. Шилжилтийн төлөвлөгөө нь шилжилт шаардлагатай сурагчдыг дэмжиж, стратегийг баримтжуулж өгдөг. (Glossary of Terms used in Special Education by Alison Morse [August 10,2015]).
12	<i>Хөгжлийн бэрхшээлд хандах Нийгмийн загвар</i>	Энэ загвар нь ХБХ эрхээ эдлэх чадавхийг хязгаарлаж байгаа нийгмийн болон дэд бүтцийн гэх саад тотгорыг арилгахад анхаарна. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хүний эрхээ хэрэгжүүлэх. Үүнд ХБХ-ийн талаарх эерэг хандлага үзэл бодлыг сурталчлах, энэ үзлийг төлөвшүүлэх, барилга байшинг өөрчлөн нийцүүлэх, мэдээллийг ойлгомжтой хэлбэрээр өгөх ХБХүний ямар ч ялгаваран гадуурхалтгүй бүрэн оролцоог хангах, Нийгмийн загвар нь нийгмийн орчны янз бүрийн арга замыг хүлээн зөвшөөрдөг, (Human rights education series: topic book 6)

УДИРТГАЛ

Сүүлийн жилүүдэд тэгш хамруулан сургах боловсролын хууль эрх зүй, бодлогын баримт бичгүүд олон улсын гэрээ, конвенцээр хүлээсэн үүргийнхээ дагуу боловсронгуй болж, хүүхэд рүү чиглэсэн хүртээмжтэй, ялгаварлан гадуурхалтгүй, адил тэгш боломжийг олгоход чиглэгдэж байна.

Өмнө нь боловсролд өөрчлөгдөх ёстой субъект нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бөгөөд тэдний бие махбодь, оюун ухаан, сэтгэл мэдрэхүйн үйл ажиллагааг сайжруулах, өөрчлөхөд гол анхаарлаа хандуулдаг үе байлаа. Харин одоо тэгш хамруулан сургах боловсролын хувьд өөрчилбөл зохих субъект нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд биш, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хүлээн авахгүй байгаа боловсролын тогтолцоо” байна. Иймээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулахдаа дараах зорилтыг хангаж ажиллахад анхаарч байна.

- Боловсролын хүртээмж, чанар, үр өгөөжийг дээшлүүлэх,
- Бүх хүүхдүүд чанартай бага, суурь боловсролын үнэ төлбөргүй аливаа ялгаварлан гадуурхалтгүйгээр эзэмших,
- Боловсролын үйлчилгээний хүрээ, арга замыг сайжруулах,
- Сурах орчинг сайжруулах, эрх тэгш байдлыг хангах,
- Суралцагчийн онцлог, хэрэгцээнд суурилсан сургалтын хөтөлбөр, сургалтын орчин, багшийн сургалтын арга зүйд тохируулга хийх, харилцаа, хандлагыг өөрчлөх,
- Тэгш хамруулан сургах олон улсын сайн туршлагаас суралцах

Ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хөгжих, сурах онцлогтой хүүхдийн хувийн онцлог, ялгаатай хэрэгцээ, сонирхлыг харгалзан суралцахуйг оновчтой төлөвлөн зохион байгуулах нь боловсролын үйлчилгээг хүртээмжтэй, чанартай үзүүлэх ажлын суурь үндэс нь болно.

ЕБС-ийн багшид ялгаатай хэрэгцээтэй суралцагчид сургалтын хөтөлбөрт тохируулга хийж, тэдний сургалтын хүртээмж, чанарыг сайжруулахад багшид арга зүйн дэмжлэг шаардлагатай байна.

Боловсролын зорилго нь хүүхдийн хэл яриа, танин мэдэхүй, бие бялдар, харилцаа, нийгэмшлийн чадварыг дэмжиж ерөнхий болон суурь чадамжийг эзэмшүүлж, сургуульд суралцахад хүүхдийн онцлог, сурах арга барилын ялгаатай байдал, хэрэгцээ, сонирхлыг нь хүндэтгэн хөгжүүлэх, суралцахуйд тэгш оролцох боломжийг бүрдүүлнэ. Сургалтын хөтөлбөрт тохируулга хийх нь сургалтын зорилго, агуулгыг өөрчлөх бус, харин хүүхэд бүрийн оролцоо, суралцахуйг дэмжих, саадыг багасгах замаар хөтөлбөрийг илүү хүртээмжтэй, уян хатан болгох арга зам юм.

Сургалтын хөтөлбөрт хийх тохируулга нь суралцагчийн ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандаж, сурагч өөрийгөө эерэгээр үнэлэх, хүлээн зөвшөөрөх, суралцах идэвх, өөртөө итгэх итгэл нэмэгддэг.

Иймд ерөнхий боловсролын сургуулийн ялгаатай хэрэгцээтэй (хөгжлийн бэрхшээлтэй) суралцагчид шаардлагатай тохиолдолд сургалтын хөтөлбөрт тохируулга хийх чиглэлээр арга зүйн зөвлөмжийг боловсруулан хүргэж байна.

Арга зүйн зөвлөмжид тусгасан онолын болон арга зүйн жишээг сургалтад шууд хэрэгжүүлэх албагүй бөгөөд хүүхдийн тусгай хэрэгцээ, ерөнхий, суурь чадварын түвшинг харгалзан сургалтын хөтөлбөрт тохируулга хийж, танхимын болон бие даах, хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар суралцагчийн хөгжлийг дэмжих, амжилттай суралцахад нь дэмжлэг үзүүлэх арга зүйн санааг авч хэрэгжүүлж болох юм.

НЭГ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ТОХИРУУЛГА ХИЙХ ОНОЛ, АРГА ЗҮЙН ҮНДЭС

1.1.Тэгш хамруулан сургах боловсролын суурь ойлголт, тэгш хамруулах үзэл санаа

Тэгш хамруулан сургах боловсрол гэдэг нь ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг арилган, суралцагчийн харилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээ, чадвар, онцлог шинж, сурах хүсэл эрмэлзлэлийг нь хүндэтгэн үзэж бүх нийтэд чанартай боловсрол олгоход чиглэсэн тасралтгүй үйл явц юм”¹

1994 онд Испани улсын Саламанка хотноо зохион байгуулагдсан дэлхийн боловсролын хурлаар “Саламанкагийн тунхаглал”-д сургуулиуд нь “...бие бялдар, оюун санааны байдал, нийгмийн гарал, хэл, соёлын цөөнх, алслагдсан бүс нутаг, хөгжлийн бэрхшээлтэй болон боловсролын тусгай хэрэгцээтэй суралцагчидийг бусад суралцагчийн нэгэн адил хамруулах, бүх суралцагчийн сурах хэрэгцээ, шаардлагыг хангах ёстой” хэмээн тунхаглан зааж, тэгш хамруулах боловсролын үндсэн зарчмуудыг тодорхойлжээ. Мөн “суралцагчийг одоо байгаа сургууль, цэцэрлэгийн орчин, хөтөлбөрт дасан зохицохыг шаардахаас илүүтэй сургууль, цэцэрлэгийг суралцагч бүрийн онцлог хэрэгцээнд тохируулсан боловсрол олгодог болгох ёстой хэмээн үзсэн байна. (НҮБ, Суралцагчийн сан, 2013)

Тэгш хамруулах боловсролын үндсэн зарчим нь сургууль, цэцэрлэгүүд бүх хүүхдэд боловсрол олгох үүргийг хүлээх ёстой бөгөөд суралцагч бүрийг эрх эдлэгч хэмээн үзнэ гэсэн үзэл санаанд оршино.

Тэгш хамруулан сургах боловсролыг амжилттай хэрэгжүүлэхэд улс орон бүх өөрийн орны үнэт зүйл, нийгэм, эдийн засгийн хөгжлийн онцлогийг тусгасан хууль эрх зүйн хүрээнд төрийн зүгээс бодлогоор дэмжих нь чухал байдаг.

Тэгш хамруулан сургах бодлогын үндсэн зарчмууд

¹ Олон улсын боловсролын 48 дугаар бага хурлын дүгнэлт, Зөвлөмж, Женев, 2008 оны 11 дүгээр сар

Тэгш хамруулан сургах боловсролд ялгаатай хэрэгцээтэй (хөгжлийн бэрхшээлтэй) суралцагчийн боловсролын тэгш байдал, хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх зорилго бүхий дараах үндсэн зарчмыг баримтална.

- Суралцагч бүр суралцах чадвартай;
- Эрт үеийн тусламж үйлчилгээний зарчим
- Боловсролын засан сайжруулах чиглэлтэй байх зарчим
- Сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд өөдрөг, хүмүүнлэг үзэл баримтлалын үүднээс хандах зарчим
- Боловсрол, нийгмийн дасан зохицох чиглэлтэй байх зарчим
- Тэгш хамруулан сургах боловсролд үйл ажиллагааны онолыг баримтлах зарчим
- Анги нийтийн болон ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр ажиллах зарчим
- Тэгш хамруулан сургах боловсролын удирдлага зохион байгуулалт шаардагдах зарчим

Тэгш хамруулан сургах үзэл санааны үндэслэл

Нийгмийн үндэслэл:

Нийгмийн ялгаварлал үүсгэхгүйгээр бүх суралцагчийг хамтад нь сургаснаар хүмүүсийн харилцан ялгаатай байдалд хандах хандлагыг өөрчилж, нийгэмд хамтран аж төрөх харилцааг бий болгоно.

Эдийн засгийн үндэслэл:

Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдэд зориулсан тусгай сургууль байгуулахаас илүүтэйгээр ердийн сургуульд бүх суралцагчийг хамт сургах боломжийг бий болгох нь эдийн засгийн үр ашигтай байна.

Боловсролын үндэслэл:

Суралцагч бүрийн харилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээ, чадвар, онцлог шинж, сурах арга барилын ялгаа, суралцах хүсэл эрмэлзлэлийг нь хүндэтгэн, хүртээмжтэй, чанартай боловсрол олгох сургалтыг зохион байгуулах нь бүх хүүхдэд үр өгөөжтэй байна.

Тэгш хамруулан сургах боловсролын тухай ойлголт нь боловсролын бүхий л салбарыг хамардаг.

Өөрөөр хэлбэл тэгш хамруулан сургах боловсрол нь бүх нийтийн боловсролд тулгамдаж буй бэрхшээлүүдийг шийдвэрлэх, суралцагчийн харилцан адилгүй байдлыг хүлээн зөвшөөрөхөд боловсролын бодлого, үйл ажиллагаа, практикийг чиглүүлнэ. Тэгш хамруулан сургах боловсрол нь сургуулийн өмнөх боловсролоос эхлэн дээд боловсрол, цаашилбал насан туршийн, насанд хүрэгчдийн боловсрол, академик болон мэргэжлийн

сургалт, хичээлээс гадуурх үйл ажиллагаа гэх мэт албан, албан бус боловсролын бүхий л үйл ажиллагаа, түвшин, салбарт хамааралтай байна.

Тэгш хамруулан сургах боловсрол нь тулгарч буй аливаа бэрхшээлийг шийдвэрлэн, сайн туршлагад тулгуурлана.

Суралцагчид боловсрол эзэмших, сурах үйл явцад идэвхтэй оролцох, чадавхиа (боловсролын болон нийгмийн) нэмэгдүүлэхэд нь тулгарч болзошгүй бэрхшээлийг олж тогтоон, шийдвэрлэх нь тэгш хамруулан сургах боловсролын гол үйл ажиллагаа юм. Бэрхшээл нь ихэвчлэн хандлага, үйл ажиллагаа, багш, мэргэжилтний нөөц боломж, бодлого, байгууллагын бүтэц, удирдах үйл явц, дэд бүтэц, хүрээлэн буй орчин зэргээс голчлон үүсдэг. Сургалтын байгууллага, сургууль бүр, тэгш хамруулах сургалтын зохистой орчинг буй болгоход зөвхөн асуудал шийдвэрлээд зогсохгүй, мөн үр дүнтэй хэрэгжиж байгаа сайн үйл ажиллагаа, туршлагад онцгойлон анхаарч, түүнд суурилан ажиллах нь үр дүнтэй байдаг.

Тэгш хамруулан сургах боловсрол нь *үл ялгаварлал* болон *тэгш боломж* гэсэн үндсэн зарчмуудаар баталгааждаг.

Тэгш хамруулан сургах боловсролын үзэл баримтлалд боловсролын хүртээмж, чанар, гүйцэтгэл, үр дүнг хамааруулах бөгөөд суралцагч төвтэй заах арга дутагдалтай чанаргүй сургалт, хөгжлийн дэмжлэг үзүүлж чадахгүй, хүртээмжгүй сургалтын хөтөлбөр, сургалтын хэрэглэгдэхүүн, хөгжлийн бэрхшээл, хүйс, гарал угсаа, хэл зэргээр ялгаварлан гадуурхах, сургуулиас хасах, сургуулийн орчин тохируулгагүй, хүртээмжгүй байх, үнэлгээний ялгавартай хэлбэр, гэр сургууль хооронд, боловсролын шилжилтийн /бага боловсролоос суурь боловсролд шилжих, суурь боловсролоос ахлах болон мэргэжлийн боловсрол руу шилжих үе/ уялдаа холбоо сул байх зэрэг нь суралцагчийг амжилттай тэгш хамруулан сургахад сөргөөр нөлөөлж байх магадлал ихтэй байна.

Тэгш хамруулан сургах боловсрол нь сонирхлын бүлгүүдийн идэвхтэй оролцоог шаарддаг.

Тэгш хамруулан сургах боловсролыг хөгжүүлэхэд төрийн байгууллага (яам, оролцогч байгууллагууд), суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, багш, иргэд, иргэний нийгмийн болон хувийн хэвшлийн компани гээд бүх оролцогч талууд чухал үүрэг гүйцэтгэж, идэвхтэй оролцоотой ажилласнаар тэгш хамруулан сургах боловсролын хөгжил, соёлд чухал хувь нэмэр оруулна.

1.2. Сургалтын хөтөлбөрт тохируулга хийх сургалтын онолын үндэслэл

Аливаа сургалтын хөтөлбөр нь "бүх нийтийн боловсрол"-ын үзэл санаанд нийцсэн суралцагч бүрийн сурах арга барилын ялгаатай байдал, онцлог, тэдний хэрэгцээ, сонирхлыг харгалзсан байх нь боловсролын тэгш байдал, хүртээмж, чанарыг хангахад чиглэгдэнэ.

Тэгш хамруулан сургах боловсролын сургалтын хөтөлбөрийн бодлого нь хүний эрхэд суурилж, суралцагчийн ялгаатай хэрэгцээ, чадварыг харгалзсан уян хатан сургалтын хөтөлбөрөөр (ерөнхий нийтлэг сургалтын болон ялгаатай байдалд суурилсан сургалтын агуулга хоёрын тэнцвэрийг хадгалсан байна) нийтээр хүлээн зөвшөөрсөн боловсролын чанарын үндсэн түвшингээс хүртэх боломжийг өндөр байлгахад чиглэнэ. Тэгш хамруулан сургах боловсролын сургалтын хөтөлбөр нь 21-р зууны боловсролын дөрвөн тулгуур ойлголт болох- мэдэхэд суралцах, үйлдэхэд суралцах, оршихуйд суралцах болон хамтдаа амьдрах, суралцахад суурилна. анхаарлаа хандуулсаар, боловсролын тогтолцоонд хийгдэх өөрчлөлтийн цогц үйл явц байна.

Тэгш хамруулах боловсролын сургалтын хөтөлбөр нь ялгаатай хэрэгцээтэй (хөгжлийн бэрхшээлтэй) суралцагчийг боловсролын үйлчилгээнд тэгш, хүртээмжтэй хамруулах зорилготой байна. Өөрөөр хэлбэл суралцагч бүрийн онцлог хэрэгцээнд нийцсэн боловсролд хамруулах, тэдний суралцах чадвар, оролцооны түвшинг нэмэгдүүлэх, хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцох чадвартай болгох, өөртөө итгэх итгэл, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, боловсролын тэгш хүртээмжийг хангахад оршино.

Тэгш хамруулах боловсролд ялгаатай хэрэгцээтэй суралцагч(хөгжлийн бэрхшээлтэй)-ийг сургахад дараах зарчмыг баримталж ажиллана.

- Суралцагчийн ялгаатай байдлыг хүндэтгэсэн, аливаа ялгаварлан гадуурхалтгүй, тэгш, хүртээмжтэй байх;
- Суралцагчид эрт үеийн хөгжлийн үнэлгээ хийх, тулгарч буй суралцахуйн сорилт, хэрэгцээг тодорхойлох;
- Суралцагчийн ялгаатай байдлыг харгалзан хөгжих, суралцах, дасан зохицоход нь боловсролын дэмжлэгийн үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэх;
- Бие махбод, оюун ухаан, сэтгэхүйн онцлог, нийгэм, соёлын ялгаатай байдлаас үл хамааран суралцагч бүрийг сургуульд тэгш хамруулж, авьяас чадвар, нөөц бололцоогоо таньж мэдэх, хөгжүүлэх адил тэгш боломж, нөхцөлөөр хангах;
- Монголын түүх, соёл, хэл, сэтгэлгээ өв уламжлал, дэлхийн өв соёл, үнэт зүйлд суурилах;
- Хүн бүрийн эрхэм чанарыг ойлгох, хүндэтгэх, хүний эрхийг хангах, хамгаалах үзэл санаанд суурилах;
- Суралцагч бүрийн насан туршдаа суралцах үндэс суурийг бүрдүүлэх, тэдний авьяас чадвар, чадамжийг таньж мэдэх, хөгжүүлэх, бие даан амжилтад хүрэх боломжийг тасралтгүй дэмжих;
- Багш, суралцагчийн технологийн мэдлэг, чадварыг тасралтгүй дэмжих зорилгоор сургалтын үйл ажиллагаанд мэдээлэл харилцааны технологийн хэрэглээг дэмжих;
- Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санаанд тулгуурлах;

- Суралцагч танин мэдэхүйн, нийгмийн, бие бялдрын, соёлын болон ёс суртахууны үнэт зүйл бүхий агуулга, арга хандлагад тулгуурлах;
- Суралцагч, багшийг таатай, аюулгүй орчинд сурч хөгжих, ажиллах нөхцлөөр хангах, сургалтын дэвшилтэт технологи, тоног төхөөрөмж, хэрэгсэл ашиглах боломжийг олгох;
- Суралцахуйн баяр баясал, үнэ цэнийг хүүхдэд мэдрүүлэхүйц багшлахуйн болон үнэлгээний арга зүйг хэрэгжүүлэх;

Тэгш хамруулан сургах боловсролын хөтөлбөр боловсруулахад анхаарах асуудлууд

- Сургалтын хөтөлбөрт тэгш хамруулах ойлголтыг дэмжих ямар үнэт зүйлсийг багтааж байна вэ?
- Хүний эрх, суралцагчийн эрхийн асуудлууд багтсан уу? эдгээрийг яаж заах вэ?
- Амьдрах ухааны агуулга багтсан уу ?
- Хэл, соёл, жендерийн асуудалд анхаарсан уу?
- Хүрээлэн буй орчны асуудал багтсан уу?
- Багшийн заах арга суралцагч төвтэй байна уу?
- Агуулга хоорондоо интеграцчилагдсан уу?
- Агуулгын давхардал байна уу?
- Үндэсний үнэлгээний системтэй хэр зохицолддог вэ?
- Сургуулийн ажлыг үнэлэхдээ хөтөлбөрийн өөрчлөлтийг хэрхэн авч үзэж байна вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын хөтөлбөрт тохируулга хийх нь дараах **суралцахуйн болон сэтгэл судлалын онолууд** дээр тулгуурладаг.

1. Хувь хүний хөгжлийн онол

- Хүүхэд бүр өөрийн хөгжлийн онцлог, чадвар, сонирхолд тулгуурлан суралцдаг.
- Сургалтын хөтөлбөрт тохируулга хийх нь хүүхдийн суралцах идэвх, амжилт, нийгмийн оролцоог нэмэгдүүлдэг.

2. Хэрэгцээнд суурилсан сургалтын онол

- Сургалтын хөтөлбөр нь хүүхдийн хэрэгцээг тодорхойлж, түүнд нийцсэн зорилго, агуулга, арга зүйг төлөвлөж, сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг бүрдүүлж, үнэлгээ нь уян хатан байна.
- Сэтгэл зүйн дэмжлэг, тусгай хэрэглэгдэхүүн, орчны тохируулга хийгдэнэ.
- Эдгээр онолын үндэслэлүүд нь хүүхэд бүрийн онцлогт нийцсэн, хүртээмжтэй, чанартай боловсрол олгоход чиглэсэн байдгаараа ач холбогдолтой байна.

Бүх суралцагчийг боловсролд тэгш хамруулж, үндэсний сургалтын хөтөлбөрт бүрэн хамрагдах боломжийг олгох үүднээс сургууль, анги танхим, сургалтын үйл явц, сургалтын хөтөлбөрийн агуулгын хүрээнд дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

Иймээс сургалтын хөтөлбөрт тохируулга хийж, хэрэгжүүлснээр хүүхдийн суралцах идэвх, амжилт, нийгмийн оролцоо дээшилж, суралцах үед сэтгэл ханамж, өөртөө итгэх итгэл нэмэгдэнэ.

Сургалтын хөтөлбөрт тохируулга хийхэд дараах **суралцахуйн болон сэтгэл судлалын онолын үзэл санааг харгалзан тусгана.**

Хүснэгт 1. Суралцахуйн болон сэтгэл судлалын онолын үзэл санаа онолын чиглэл

Онолын чиглэл	Эрдэмтдийн төлөөлөл	Эрхэмлэх гол санаа	Хөтөлбөрийн тохируулга хийхэд тусгаагдах гол санаа
Хүмүүнлэгийн онол	А. Маслоу, К. Рожерс	Хүн бүр хөгжих эрхтэй, хувь хүний хэрэгцээ, сэдлийг хүндэтгэнэ	Хүүхдийн өөрийн онцлог, сонирхолд нийцсэн зорилго, орчныг бүрдүүлэх
Когнитив онол	Ж. Пиаже, Ж. Брунер	Оюуны хөгжлийн шат бүрд суралцах арга өөр байдаг	Хүүхдийн сэтгэхүйн түвшинд нийцсэн агуулга, арга, хэрэглэгдэхүүн, материал ашиглах
Нийгэм-соёлын онол	Л. С. Выготский	Хөгжил нь нийгмийн харилцаанд явагддаг, “ойролцоо хөгжлийн бүс”-д суурилдаг	Багш, үе тэнгийнхний дэмжлэгтэй, хамтын орчныг бүрдүүлэх
Ялгаавартай сургалтын онол	К. А. Томлинсон	Суралцагч бүрийн ялгааг хүлээн зөвшөөрч, уян хатан сургалт зохион байгуулах	Агуулга, арга, үнэлгээг суралцагчийн онцлогт нийцүүлэх
Олон талт оюун ухааны онол	Х. Гарднер	Хүүхэд бүрийн оюуны давуу тал ялгаатай	Давуу чадварт нь тулгуурлан суралцахуйг дэмжих

1.3. Суралцахуйн түгээмэл загвар, ялгаатай зааварчилгаа

Сургалтын хөтөлбөрийн агуулгыг ялгаатай боловсруулахгүйгээр багш нар багшлахуйн арга барилаа **“Суралцахуйн түгээмэл загвар”**-тай уялдуулан боловсруулах нь сургалтын хөтөлбөрт тохируулга хийх онолын үндэслэл болно.

Суралцахуйн түгээмэл загвар цаашид **(СТЗ гэх)** гэдэгт нэмэлт тохиргоо, тусгай загвар шаардахгүйгээр бүх хүн ашиглахад тохиромжтой, энгийн бүтээгдэхүүн, программ, орчин болон үйлчилгээний хэв маягийг ойлгоно гэжээ.

СТЗ гэдэг нь (1) хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдалд тохирсон, оролцоог хангасан хамгийн боломжит байдлаар дэмжих, (2) мэдээллийг олон аргаар хүргэх, (3) мэдлэгээ илэрхийлэх олон хувилбар байна. Тодорхойлж хэлбэл СТЗ нь олон төрлөөр оролцоог хангах (“яагаад” суралцаж байгаа вэ буюу сурах сэдэл); олон төрлөөр үзүүлэх боломж бүрдүүлэх (“юу” сурах вэ буюу мэдлэг, мэдээллийг олон янзаар үзүүлэх, таниулах); олон төрлөөр илэрхийлэх боломж олгох (хэрхэн суралцах, сурсан, мэдсэнээ олон янзаар илэрхийлэх) гэсэн үндсэн гурван зарчмын хүрээнд тодорхойлогдоно.

Нэг ангид суралцаж буй хүүхэд бүр хүсэл сонирхол, ур чадвар, хүйс, гэр бүлийн орчин, мэдлэг туршлагын хувьд харилцан адилгүй байдаг. Иймд хүүхэд бүрд тохирсон нэг хэв загварын багшлахуйн арга барил байх боломжгүй юм. Харин СТЗ-ын гурван зарчмыг хэрэгжүүлснээр багш хичээлийг илүү хүртээмжтэй, хүүхдийн тэгш оролцоог бүрэн хангасан хэлбэрээр заах боломж бүрддэг.

Суралцахуйн түгээмэл загварын зарчмын дагуу хөтөлбөрийг хэрэгжүүлэх жишээ суралцахуйн бэрхшээлтэй хүүхэд дээр жишээ болгон танилцуулъя².

➤ ***Нэгдүгээр зарчим “Суралцахуйн бэрхшээлтэй сурагчийг сэдэлжүүлэх замаар оролцоог хангах”***

Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдийн хувьд суралцахуйд учирч буй бэрхшээлээсээ хамаараад суралцах сэдэл нь өөр өөр байх учир багш тухайн хүүхдийг суралцах үйл явцад идэвхтэй оролцуулахдаа олон арга замыг эрэлхийлэх нь зүйтэй.

- Хүүхдийн сонирхол, чадвар чадамжид тулгуурла Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдүүд юуг, хэрхэн сонирхох нь хүүхдийн онцлогоос шалтгаалж өөр байх тул багш тухайн хүүхдийн сонирхолд нийцсэн байдлаар арга барилаа өөрчлөх хэрэгтэй. Зарим сурагчид шинэ, шинэлэг санаачилгад дуртай байдаг бол бусад нь тогтсон хэв загвараар суралцахыг илүүд үздэг. Үүнтэй адил зарим сурагч ганцаараа хичээллэхийг илүүд үздэг бол бусад нь багийн ажилд идэвх, санаачилгатай оролцдог байх жишээтэй. Мэдээж бүх суралцагчийн нөхцөл байдалд тохирсон тэдний оролцоог хангах тогтсон оновчтой загвар гэж үгүй. Харин багш хүүхдийнхээ хэрэгцээ сонирхлыг танин мэдэж, өөртэй нь болоод эцэг эхтэй нь ярилцах нь хамгийн үр дүнтэй арга юм. Хүүхдүүд илүүтэй сэтгэлийг нь хөдөлгөсөн хичээлд идэвхтэй оролцож, сэтгэгдлээ хуваалцаж, асуулт асуух нь олонтоо. Иймд хүүхдийн дуртай номыг нь дахин унших боломж олгоорой. Хүүхдүүд уншиж сурахаасаа өмнө үлгэр, түүх олон дахин сонсож, харилцан ярианд өөрийгөө дасгах сонирхол өндөр байдаг. Хүүхэд өөрөө хийхийг хүссэн

² (2022) Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл., “Тэгш хамруулсан боловсролыг дэмжих арга зүйн зөвлөмж”

болон төлөвлөсний дагуу бүлгийн ажлын хүрээнд хүүхдүүдтэй хамт дуу дуулж, шүлэг уншаарай. Эд зүйл, хүүхэлдэй гэх мэт биет үзүүлэн ашиглан ярьж буй түүх, дуулж буй дуугаа илүү бодитой, сонирхолтой болгож болох бөгөөд хүүхдийн суралцах үйл явцыг бодит үйлдлээрээ дэмжих нь чухал.

- Биеэрээ оролцох боломжтой үйл ажиллагаа санал болгох Сургуулийн өмнөх насны хүүхдүүд тоглоомд суурилсан үйлд идэвхтэй оролцдог бөгөөд практик тоглоом, даалгаврын тусламжтайгаар суралцах үйл явц нь идэвхжиж байдаг. Тэдэнд дуу дуулах, шүлэг унших, усаар тоглох, баримлын шавраар тоглох, жүжиглэх чадваруудыг зааж өгвөл ахлах ангийн сурагчид шиг ширээний ард удаан суух шаардлагагүй, хичээлд идэвхтэй оролцоно. (айл гэр болж тоглох, хувцаслах г.м) Харин бага ангийн сурагчид ширээний ард 15-20 минутаас удаан суувал залхаж эхэлдэг. Тиймээс багш 15-20 минут тутамд хүүхдийн сонирхлыг өдөөх үйл ажиллагаа явуулах эсвэл сурагчдад завсарлах хугацаа өгөөрэй. Энэ үеэр сунгалтын дасгал, дуу дуулах, шүлэг унших зэргээр ангийг бүхэлд нь хамарсан үйл ажиллагаа зохион байгуулж болно.
- Олон мэдрэхүйг зэрэг ашиглах замаар суралцах, суралцахуйн үйл явцыг хөгжилтэй байдлаар хөтлөн явуулах Бүх суралцагчийг мэдээлэл хүлээн авах тэгш боломжоор хангахын тулд мэдээллийг олон мэдрэхүйгээр зэрэг дамжуулан хүргэх нь чухал. Хүүхэд хүрэлцэхүй, сонсголын, харааны, амтлах, үнэрлэх мэдрэхүйг ашиглах замаар хүлээн авсан мэдээллээ төвөггүй эргэн санадаг. Энэ төрлийн суралцахуйн үйл явц нь сурагчдыг нэгээс илүү мэдрэхүйгээ ашиглаж суралцахуйг дэмждэг тул олон мэдрэхүйг зэрэг ашиглах замаар суралцах гэж нэрлэдэг. Жишээ нь:
 - Бүх зураг, график, бичлэг, хөдөлгөөнт дүрсийг текстээр эсвэл аман яриагаар тайлбарлах
 - Гол санаагаа илэрхийлэхийн тулд бодит эд зүйл эсвэл брайл график ашиглах
 - Цэцэрлэгийн насны хүүхдүүдэд зориулсан “шидэт уут” хийгээрэй. Багш нь уутанд эд зүйлс хийх бөгөөд хүүхэд тухайн эд зүйлийг мэдэрснээр юу болохыг нь таах
- Өдөр тутамдаа хэвшүүлж мөрдүүлэх алхмуудыг сайн хэвшүүлэх нь чухал. Бага насны хүүхэд цэцэрлэг, сургуулийн тогтсон дэг журмын талаар төдийлөн сайн ойлгодоггүй бөгөөд хүүхдэд тухайн өдөр сургууль дээр ирээд юу хийхээ мэдэхгүй байж болно. Иймд өдөр тутамдаа мөрдөж хэвшсэн дадлуудаа сайтар тайлбарлан өгвөл тухайн хүүхэд өдөрт юу хийх, яах ёстойгоо төвөггүй ойлгодог болно. Багш хичээл бүрийн эхэнд цагийн хуваарийн зурагт үзүүлэн ашиглан хүүхдүүдэд тодорхой тайлбар өгөх нь зүйтэй. Зарим хүүхдэд “одоо”, “дараа” гэсэн зурган картуудыг ашиглахад ганцаарчилсан туслалцаа хэрэг болж мэднэ.
- Бага ангийн сурагчид мөн өдрийн тогтсон хэвшилтэй байх нь олон талын эерэг нөлөөтэй. Сурагчдад шинэ агуулга орох бүрд цагийн хуваарийн үзүүлэнг байршуулах ба үйл ажиллагаа дуусахад хурааж, дараагийн хичээлийн цагийн хуваарийн үзүүлэнг гаргаж тавингаа яриа өрнүүлээрэй.

- Бие даалтыг олон янзаар гүйцэтгэх сонголт өгөөрэй Сурагчид хийсэн даалгавраа олон хэлбэрээр танилцуулж болно. Жишээ нь сурагч бие даалтаа ганцаараа хийх эсвэл бүлгээр хамтарч ажиллах; Бие даалтаа ямар байдлаар танилцуулах боломжтой байгаагаа сонгож болно. Жишээ нь өөрийн түүхээ компьютер дээр шивэх эсвэл гараар бичих, ангийнхаа найзтайгаа хамтран богино бичлэг хийх эсвэл цаасан дээр бичих, богино хэмжээний жүжигчилсэн тоглолт бэлдэх эсвэл танилцуулга бэлдэх, сэдвээ жагсаалт дотроос сонгох-шинжлэх ухааны хичээл дээр судлах, тайлан бичих агуулгатайгаа холбоотой сэдэв сонгох /жишээ нь цаг агаар/ г.м
- Нэг үйлээс нөгөөд шилжих цаг хугацааг үр дүнтэй ашиглах Нэг үйл ажиллагаа дуусаад нөгөөд шилжих завсрын үед анги эмх замбараагүй байвал хүүхдийн зан төлөвт нөлөөлдөг. Иймд багш нар шилжилтийн үед ангийг хэрхэн зохион байгуулахаа бодолцох хэрэгтэй. Багш хичээл дуусаж буйг хэлэх, элсэн цаг, хөгжим гэх мэтээр биет үзүүлэн ашиглан мэдэгдэж болно. Шилжилтийн үед багш суудал хуваарилах, даалгавар оноож өгөх зэргээр дараагийн үйл ажиллагаандаа бэлдэж болно.
- Хүүхдийг магтаж, урамшуулаарай Хүүхдийн сайн, зөв хийж буй үйлдлийг сайшаа. Ялангуяа ангидаа эерэг дулаан уур амьсгал бүрдүүлж буй хүүхдийг магтаж, дүрмээ дагахгүй байгаа сурагчдад эелдгээр сануулж хэлэх хэрэгтэй. Энэхүү арга нь бүх хүүхдэд тохирдог. Зарим хүүхдэд бусдын өмнө багшид магтуулах нь ичгэвтэр байдаг тул багш эрхий хуруугаа гозойлгох, мөрөн дээр нь гараа тавих зэрэг энгийн аргуудаар санаагаа ойлгуулж болно.
- Нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх үйл явцад нь дэмжлэг үзүүлээрэй Хүүхэд өөрийнхөө хичээлийг хийж дууссаны дараа тусгай хэрэгцээт найддаа тусалж, суралцахуйн үйл явцад нь дэмжлэг үзүүлж болно. Бие биедээ тусалснаар бэрхшээлтэй хүүхэд болоод ангийн нөхөд хамтдаа суралцаж, хөгждөг. Үүнийг “үе тэнгийн хүүхэд нь багшлах” арга барил гэж нэрлэдэг. Гэхдээ энэ нь бэрхшээлтэй хүүхдэд зөвхөн ангийн найз нөхөд нь л туслах ёстой гэсэн санаа биш юм. Тиймээс суралцахуйн бэрхшээлтэй хүүхэд юунд дуртай, ямар ур чадвартайг сайтар судалж, сонирхол дээр нь үндэслэн суралцахуйн үйл явцыг нь дэмжих нь чухал юм.

Хоёрдугаар зарчим: Суралцахуйн бэрхшээлтэй сурагчид сурсан мэдлэгээ олон хэлбэрээр үзүүлэх

Суралцахуйн бэрхшээлтэй суралцагчид мэдээллийг харилцан адилгүй хүлээж авч, ойлгодгийн зэрэгцээ бас сурсан мэдсэнээ илэрхийлэн үзүүлэх арга хэлбэрийн хувьд өөр хоорондоо болон бусад хүүхэдтэй харьцуулахад нэлээд ялгаатай байдаг учир багш сурагчдыг мэдлэг эзэмших олон арга замаар хангах хэрэгтэй. Зарим нэг арга замыг энд зөвлөмж болгож байна.

- Текстийг хялбаршуулах Текстийн унших түвшнийг хялбаршуулснаар (жишээлбэл, үгийн тоог цөөлөх, мэддэг үг ашиглах, энгийн дүрмээр, өргөн хэрэглээний хэлц ашиглах) сэдвийн гол санааг хүртээмжтэй ойлгоход тусалдаг. Энэ арга нь ялангуяа оюун ухааны бэрхшээлтэй хүүхдэд тохиромжтой бөгөөд үе тэнгийнхэнтэйгээ ижил агуулга судлах ч хүүхдийн онцлогт тохируулж хялбаршуулсан байдаг нь давуу талтай
- Зураг, график, эд зүйл, бичлэг ашиглах Хүүхэд зурагт үзүүлэнгийн тусламжтай түлхүүр үг, үйл явц, үлгэр түүхийг төвөггүй ойлгох боломжтой байдаг учраас суралцахуйн бэрхшээлтэй хүүхдэд боломжтой нөхцөлд нь зурагт үзүүлэн, график дүрслэл зэргийг ашиглах нь ихээхэн үр дүнтэй байдаг.
- Хүүхдийн үгийн санг баяжуулах Суралцагчид аливаа сэдвийг заахдаа тухайн сэдэвтэй холбоотой хүүхдийн өмнөх мэдлэг ойлголт дээр нь тулгуурлан заавал үр дүнгээ өгдөг аж. Зарим сурагчид багшийн заах гэж буй сэдвийн талаар ямар ч ойлголтгүй байж мэднэ эсвэл ойлголттой ч шинээр заах сэдэвтэй хэрхэн уялдахыг мэдэхгүй байж болно. Тиймээс өмнөх мэдлэгийг сэргээж, танин мэдэхүйг нь идэвхжүүлэх, эсвэл шинээр зааж буй сэдэв нь өмнөх мэдлэгтэй нь хэрхэн холбогдохыг тайлбарлаж өгөх зэргээр хүүхдийн суралцахуйг олон янзаар дэмжиж болно.
- Нэмэлт аргуудыг дурдвал: Хүүхдийн өмнөх мэдлэгийг сэргээхийн тулд утгын зураглал хийх хэрэгтэй. Тухайн ангид суралцаж буй сурагчдыг баг болгон хувааж судлах гэж буй хичээлийн сэдвийн талаар а) юу мэдэх, б) юуг мэдмээр байна, в) хичээлийн төгсгөлд юу сурснаа эргэж дүгнэж, ярилцах гэсэн гурван төрлийн даалгавар өгөөрэй. Сурагч сэдвийн талаар юу мэдэж буйгаа заавал хэл яриагаа илэрхийлэх шаардлагагүй бөгөөд цаасыг гурван багана болгон нугалаад дээр нь зурах эсвэл утгын зураглал хийж болох юм. Мөн бичих чадварт сайн суралцагчаар бүлгээ төлөөлж, санаагаа ярилцан бичүүлэх боломж бий. Сурагчдад ойлгуулах ёстой гол санаагаа урьдчилан бэлд Багш нар аливаа сэдвийн агуулгаас зайлшгүй сурах ёстой гол санаа болоод, санаагаа сурагчдад хүргэх олон төрлийн арга замыг тодорхойлох нь зүйтэй (жишээ нь аудио ном, диаграмм үзүүлэн, YouTube-ийн бичлэг, харьцуулалт эсвэл зүйрлэл). Ийнхүү тодорхойлсон агуулгаа хүүхдийн эцэг эхтэй хуваалцвал тухайн хүүхэд гэртээ мөн суралцах боломж бүрдэнэ.

Гуравдугаар зарчим: Суралцахуйн бэрхшээлтэй сурагчид үйлдэл хийж, түүнийгээ илэрхийлэх

Суралцагч бүр өөр өөрийн гэсэн арга замаар суралцахуйн үйл явцаа чиглүүлж, сурсан мэдсэнээ илэрхийлдэг тул багш сурагчдаа өөрсдийгөө илэрхийлэх олон арга замаар хангах нь зүйтэй.

- Бод-Хамтар-Хуваалц аргачлалыг ашиглах

- Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдийг ангийн найзтай нь хослуулж, хамт сургах хэрэгтэй.
- Багш хичээлийн сэдэвтэй холбоотой асуулт асуухад хүүхэд бүр дотроо зөв хариулт юу байж болохыг бодно (Бодох);
- Хосоороо сууж байгаа сурагчид хоорондоо аль нь зөв хариулт болохыг ярилцана (Хамтар)
- Ангийн нөхөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зөв хариултаа бичихэд нь туслах эсвэл хоорондоо ярилцаад зөв гэж үзсэн асуултаа цаасан дээр бичнэ (Хуваалц).
- Эсвэл багш асуусан асуулттайгаа холбоотой хариултаа зургаар үзүүлж болох бөгөөд сурагчид зөв гэж бодсон хариулттай холбогдох зургийг сонгож болно.

Суралцахуйн түгээмэл загварын үндсэн зарчим нь **ялгаатай зааварчилгаа (Differentiated Instruction)**-тай уялдана. Хүүхэд бүрийн суралцах түвшин, чадвар, сонирхол, анхаарал, туршлагын ялгаа нь багшийн зааварчилгааг нэг хэлбэрээр бус, харин олон хувилбараар хүргэхийг шаарддаг. Ялгаатай зааварчилгаа нь хүүхдийн хөгжлийн түвшин, суралцах хэв маягт тохируулан багшийн зүгээс зорилго, үйл ажиллагаа, хэрэглэгдэхүүн, дэмжлэгийг ялгаж өгөхийг хэлнэ. Ингэснээр хүүхэд өөрийн түвшинд амжилт мэдэрч, суралцахуйн туршлагыг эергээр хүлээн авдаг.

Тохируулга хийхийн өмнө багш хүүхдийн хэрэгцээ, орчны нөхцөл байдлыг нарийвчлан ажиглаж, судлана. Хүүхдийн хэл яриа, танин мэдэхүй, хөдөлгөөн, бие бялдар, харилцаа, нийгэмшлийн чадварыг ажиглаж, ямар тохируулга хэрэгтэй болохыг тодорхойлох хэрэгтэй. Мөн суралцагчид орчны хүртээмж, хэрэглэгдэхүүний аюулгүй байдал, дуу чимээ, гэрэл, ангийн зай талбайн хэмжээ зэргийг харгалзаж орчны тохируулга хийнэ. Ингэснээр суралцагчийн сурах үйлд тулгарах саадыг багасгах, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Тэгш хамруулсан боловсрол нь сургалтын хөтөлбөрийн тохируулгын үзэл санааны суурь болдог харин суралцахуйн түгээмэл загвар буюу Universal Design for Learning (UDL) тэгш хамруулах боловсролын хэрэгжилтийн бүтэц, ялгаатай зааварчилгаа (DI) нь хэрэгжүүлэх арга хэрэгсэл болдог.

Орчин үед сургалтын хөтөлбөрт тохируулга хийх нь зөвхөн ялгаатай хэрэгцээтэй (хөгжлийн бэрхшээлтэй) суралцагчид биш, бүх суралцагчид зориулсан хүртээмжтэй боловсролын загвар байна. Ингэснээр бүх суралцагчид ялгаварлан гадуурхалтай, өөртөө итгэлтэй, чанартай, хүртээмжтэй боловсролын үйлчилгээг авч, тэгш хамруулсан сургуулийн соёл төлөвшихөд түлхэц болох юм.

1.4. Сургалтын хөтөлбөрт тохируулга хийхэд ICF буюу “Олон Улсын Үйл ажиллагааны Ангилал”-ыг харгалзан үзэх нь

Хөгжлийн бэрхшээлийн төрөл болон оношилгоонд ач холбогдол өгөхөөсөө илүү олон улсад хөгжлийн бэрхшээлийг тодорхойлоход өргөн хэрэглэдэг ICF буюу “Олон Улсын

Үйл ажиллагааны Ангилал"-ыг ашиглаж, тухайн суралцагчийн давуу болон сул талыг илрүүлж, тухайн хүүхэд өдөр тутмын үйл ажиллагаанд оролцоход ямар бэрхшээлтэй тулгарч байна гэдгийг гол шалгуур болгон авч үздэг аргачлал юм. Хэрэв бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээг авч үзэхдээ дан ганц оношилгоонд суурилбал адилхан бэрхшээлийн оноштой хүүхэд бүр адил хэрэгцээ, дэмжлэг туслалцаа хэрэгтэй болно гэсэн дүгнэлтэд хүрэх магадлалтай. Мөн албан ёсоор оношлогдоогүй ч өдөр тутамдаа тодорхой хэмжээний бэрхшээлтэй учирдаг хүүхдүүд дэмжлэг туслалцаанаас орхигдох тохиолдол цөөнгүй байна. Түүний оронд багш нар хүүхдүүдээ ажиглаж ямар хүндрэл бэрхшээл тулгарч байна вэ гэдэгт анхаарлаа зүй ёсоор хандуулах нь илүү хүртээмжтэй гэдгийг зөвлөж байна. Багш хүн багшлахуйн үйл явцдаа хараа, сонсгол, оюуны хөгжил, хэл яриа, хөдөлгөөний гэх мэт олон төрлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах хэрэгцээ шаардлага гарч байна.

Зарим багшийн хувьд хараа, сонсгол, харилцаа болоод хөдөлгөөний огт чадамжгүй хүүхэдтэй ажиллах хэрэгцээ шаардлага ч тулгарч болно. Үйл ажиллагааны бэрхшээлийг илүү чухалчлан анхаарна гэдэг бол тухайн хүүхдэд онош тавих эсвэл оношийг өөрчилнө гэсэн үг огтхон ч биш ээ. Тиймээс орчин үед хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын дэмжлэгийг цогц байдлаар үзүүлэхэд ICF буюу Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангиллын дагуу салбарын мэргэжилтнүүд хамтран хүүхдэд хөгжлийн ерөнхий үнэлгээ хийж, хамтын шийдвэр гаргаж ажиллах эхлэл тавигдаад байна.

ICF- Олон Улсын Үйл ажиллагааны Ангилал



Олон Улсын Үйл Ажиллагааны Ангилал буюу ICF бүтэн нэршлээр International Classification of Functioning, Disability and Health гэнэ. Үүнийг шууд утгаар нь орчуулбал Үйл Ажиллагаа (Functioning), Чадвар Алдалт (Disability), Эрүүл мэнд (Health) -эд хамааралтай Олон Улсын Ангилал гэсэн үг болох юм. Монголын хөрсөнд Олон Улсын Үйл Ажиллагааны Ангилал гэж хөрвүүлэн хэрэглэхээр тогтсон байна. ОУҮАА нь эрүүл мэнд болон эрүүл мэндтэй холбоотой нөхцлийг ангилах зорилготой ангилал юм. Эрүүл мэндийн байдал гэдэг нь өвчин эмгэг, улмаар жирэмсэн, хөгшрөлт, хөгжлийн бэрхшээл, стресс гэх мэт нөхцлийг багтаасан хэллэг юм. Эдгээр хүмүүс Стандарт орчинд юу хийж чадах вэ (чадамжийн түвшин) мөн одоо байгаа орчиндоо юу хийж чадаж байна вэ (гүйцэтгэлийн түвшин) гэдгийг олж харах боломжоор хангаж байдгаараа энэ ангилал давуу талтай юм.

Өөрөөр хэлбэл чадвар алдалттай хүмүүсийг тусгайлан авч үздэг байсан анагаахын загварт суурилсан цаг саяхан байсан бол өнөөдөр нийгмийн загварт суурилсан эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлэх болсон. Шинэ ангилал гарснаар бид нийгмийн загварт суурилсан үйлчилгээг үзүүлэх боломжтой боллоо.

ОУҮАА нь ямар учир шалтгаанаар гэмтсэн эсвэл хөгжлийн бэрхшээлтэй болсон бэ гэдгийг чухалчлахгүй, тухайн хувь хүний үйл ажиллагааг нийгэм дунд орж (ажиллах, суралцах гэх мэт) хэмжих хэрэгсэл болсноороо давуу талтай. Нийт хүн амын цөөхөн хувийг “чадвар алдалттай хүмүүс” гэж тусгаарлах хэрэггүй, бүгд адилхан нэг шугаман дээр зогсож байгаа гэсэн ойлголтыг боловсролын салбарт ч бий болгож байна.

◆ **Бие махбодын үйл ажиллагаанд хамааралтай хэллэг:**

- **Үйл ажиллагаа (functioning)** гэдэг нь бие махбодийн үйл ажиллагаа, биеийн бүтэц, зорилгот үйл болон нийгмийн оролцоог бүхэлд хамарч багтаасан хэллэг
- **Чадвар алдалт (disability)** гэдэг нь үйл ажиллагааны чадвар алдагдал, зорилгот үйлийн хязгаарлагдал, нийгмийн оролцооны хязгаарлагдмал байдал бүхнийг хамарсан хэллэг
- **Биемахбодийн үйл ажиллагаа (body functioning)** гэдэг нь бие махбодийн эрхтэн тогтолцооны бүхий л физиологийн үйл ажиллагаа (үүнд сэтгэцийн үйл ажиллагаа багтана) юм.
- **Биеийн бүтэц (body structures)** гэдэг ойлголтонд биемахбодийн анатомийн хэсгүүд болох эрхтэн, мөчдүүд болон тэдгээрийн бүрэлдэхүүн хэсгүүд хамаарагдана.
- **Гэмтэл (impairments)** гэдэг нь биемахбодийн бүтэц, үйл ажиллагаанд үүссэн бэрхшээл буюу үйл ажиллагааны мэдэгдэхүйц хазайлт болон бүтцийн алдагдлыг хэлнэ.
- **Зорилгот үйл (activity)** гэдэг нь тухайн хувь хүний зорилгын гүйцэтгэл буюу идэвхитэй үйлийг хэлнэ.
- **Нийгмийн оролцоо (participation)** гэдэг нь нийгмийн аливаа үйл ажиллагаанд хамрагдаж, оролцох үйл явц юм.
- **Зорилгот үйлийн хязгаарлалт (activity limitations)** гэдэг нь тухайн хувь хүн зорилгот үйлийн гүйцэтгэх явцад бэрхшээл учрахыг хэлнэ.
- **Нийгмийн оролцооны хязгаарлагдмал байдал (participation restrictions)** нь тухайн хувь хүн нийгмийн ямарваа нэг үйл ажиллагаанд оролцоход хүндрэл бэрхшээл учрахыг хэлнэ.

◆ **Нөхцөл байдлын хүчин зүйлд хамааралтай хэллэг:**

- **Хүрээлэн буй орчны хүчин зүйлс (environmental factors)** гэдэгт хүмүүсийн амьдарч буй, өдөр тутмын амьдралаа явуулж байгаа бие махбодийн, нийгмийн, хандлагын орчинг бий болгох хүчин зүйлс орно.
- **Хувь хүний хүчин зүйлс (personal factors)** хувь хүний амьдрал, ахуй дахь тусгай нөхцөл байдал

(Bickenbach et al, 2012) (Geyh et al, 2004)

Энэхүү ангилал нь хүмүүст нийгмийн саад бэрхшээлийг бууруулах, арилгах, нийгмийн дэмжлэг туслалцааг авах, зохицуулагчаар оролцох замаар эрүүл мэнддээ анхаарч, урьдчилан сэргийлэх, сайжруулах, нийгмийн оролцоог (ажил хөдөлмөр эрхлэх, суралцах) нэмэгдүүлэхэд шаардлагатай мэдээллийг агуулсан үндсэн суурь ойлголтыг өгнө.

ICF-ийг бүрдүүлэгч хүчин зүйлс

<i>ICF-ийн хүчин зүйл</i>	<i>Тодорхойлолт</i>	<i>Жишээ</i>
Сэтгэл санаа, Бие махбодийн үйл ажиллагаа	Биеийн эрхтэн системийн физиологийн үйл ажиллагаа /сэтгэл зүйн үйл ажиллагааг багтаана/	Оюун ухаан, сэтгэл хөдлөл, хараа, сонсгол, хөдөлгөөн, тэнцвэр, булчингийн чадал гм/
Биеийн бүтэц	Эрхтэн, тулгуур эрхтэн, ба түүнийг бүрдүүлэгч хэсэг гэх мэт биеийн эрхтэн системийн анатомийн хэсэг	Тархи, нурууны нугас, дээд болон доод мөч, дотор эрхтэн гэх мэт
Үйл ажиллагаа	Хувь хүнд тулгамдсан асуудлаа шийдвэрлэх үйлдэл гүйцэтгэх байдал	Харилцаа, хөдөлгөөн, өөртөө тавих анхаарал, халамж, гэрийн ажил гэх мэт
Оролцоо	Амьдрал, амьдралын үе бүрт аливаа үйл ажиллагаанд оролцож байгаа байдал	Ар гэрийн амьдрал, боловсрол, ажил эрхлэлт гэх мэт
Хүрээлэн буй орчны хүчин зүйл	Хүмүүсийн амьдарч аж төрөн буй материаллаг болон нийгмийн орчин, хүмүүсийн нийгмийн хандлагын орчныг бүрдүүлдэг хүчин зүйлүүд	Халамжийн хэрэгсэл, хүмүүсийн харилцаа, хандлага, олон нийтийн үйлчилгээ, тогтолцоо, хууль гэх мэт
Хувь хүний хүчин зүйл	Гэр бүл, амьдралын орчинд байгаа хүмүүс болон өөрийн зүгээс хамааралтай хүчин зүйлүүд	Боловсрол, нийгмийн шалтгаан, амьдралын хэв маяг

Хүүхдийн хөгжлийн бодит байдлыг ICF-д суурилан дээр дурдсан хүчин зүйлээр тогтоохоос гадна тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн онцлог, сурах хэв маягийг харгалзан сургалтын хөтөлбөрт тохируулга хийж, хэрэгжүүлэх нь багшаас ихээхэн хичээл зүтгэл, хүч хөдөлмөр шаардана.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онош, бодит байдлын үнэлгээнд суурилж **тусгайлан боловсруулсан сургалтын хөтөлбөр** хэрэгжүүлэх нь хүүхдийг бусдаас

тусгаарлагдсан орчинд сурах хэрэгтэй гэдэг хандлага төрүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй зөвхөн тусгай, мэргэшсэн багш ажиллах ёстой гэсэн зөрүүтэй ойлголт төрүүлдэг.

Бүх багш нар сурах арга барилын ялгаатай, тусгай хэрэгцээтэй ажиллах ур чадвар эзэмшиж, хүртээмжтэй сурган хүмүүжүүлэх ухааныг урьтал болгож, ангид зааж буй аливаа сэдвийн агуулга бүх хүүхдэд тохирсон хүртээмжтэй байх ёстой гэж олон улсын судлаачид үздэг.³

Улс орнууд сургалтын хөтөлбөрөө хүүхэд бүрийн онцлогт тохируулж, хүртээмжтэй болгох гурван аргыг тодорхойлжээ. Доорх хүснэгтэд дэлхийн бусад улс оронд хэрэглэж байгаа хөтөлбөрөө өөрчлөх, тохируулга хийхээс эхлээд бие даах чадварыг хөгжүүлэх нэмэлт заавар, зааварчилгаа өгөх зэрэг олон чухал санааг багтаасан гурван төрлийн хөтөлбөрийг тайлбарлалаа.

Хүснэгт 2. Сургалтын хөтөлбөрийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээнд нийцүүлэх хувилбарууд

<i>Сургалтын хөтөлбөрийн төрөл</i>	<i>Тодорхойлолт</i>	<i>Жишээ</i>
<i>Тохируулгат сургалтын хөтөлбөр</i>	<i>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд энгийн сургалтын хөтөлбөрт тусгагдсан сургалтын үр дүнд хүрэх ч үнэлэх аргачлалыг тухайн хүүхдийн чадварт тохируулж, нийцүүлсэн байна.</i>	<i>Харааны бэрхшээлтэй хүүхэд брайл сурах бичиг ашигладаг бол сонсголын бэрхшээлтэй хүүхэд дохионы хэлээр боловсрол эзэмшиж, харилцдаг.</i>
<i>Баяжуулсан сургалтын хөтөлбөр</i>	<i>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бусад хүүхэдтэй ижил агуулга судлах бөгөөд бие даах чадварыг дэмжсэн нэмэлт заавар, зөвлөмж багтсан байна.</i>	<i>Харааны бэрхшээлтэй хүүхдэд хөдөлгөөн, орон зайн чиг баримжаа олгох чадвар олгох хэрэгтэй. Сонсголын бэрхшээлтэй хүүхдэд харилцах харилцааны хэрэгсэл дохионы хэлний чадвар олгох хэрэгтэй.</i>
<i>Өөрчилсөн сургалтын хөтөлбөр</i>	<i>Бусад хүүхэдтэй ижил агуулга судлах ч сургалтын үр дүн өөр байдаг ганцаарчилсан суралцахуйн арга зүй юм. Адил оноштой, адил хэрэгцээтэй гэж ерөнхийлөхөөс илүүтэй хувь хүний онцлогт тохируулан сургалтын төлөвлөгөө боловсруулан өөрчилсөн</i>	<i>Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бусдаасаа хэл яриа, танин мэдэхүйн хувьд хоцрогдох магадлал өндөр байдаг тул нийгмийн амьдралын суурь чадварын хичээлүүдийг ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр суралцаж,</i>

³ Флориан & Спрат 2013; Уэстбрук., 2013) Хэйс, Тернбулл, Моран (2018)

	<p><i>хөтөлбөр</i> <i>байна.</i> Эх сурвалж: Хэйс, Тернбулл, Моран нар (2018)</p>	<p><i>амьдралын</i> <i>суурь</i> <i>чадваруудыг эзэмшдэг гэх</i> <i>мэт.</i></p>
--	---	--

ХОЁР. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ТОХИРУУЛГА

Сургалтын хөтөлбөрийн тохируулга гэдэг нь ялгаатай хэрэгцээтэй (хөгжлийн бэрхшээлтэй) суралцагчийн танин мэдэхүйн түвшин, чадвар, суралцах арга барилын ялгаатай байдлыг харгалзан сургалтын хөтөлбөрийн (агуулга, арга зүй, сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, үнэлгээ) тодорхой нэг чиглэл болон хэд хэдэн чиглэлд өөрчлөлт оруулж, тухайн сурагчийн суралцах үйлд дэмжлэг үзүүлэх үйл явц юм.

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сургалтын хөтөлбөрт тохируулга хийх үндэслэл нь олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, өөрийн улсын боловсролын бодлого, эрх зүйн баримт бичиг, тэгш хамруулах боловсролын зарчим болон хувь хүний хөгжлийн онолд тулгуурлагдгийг өмнө өгүүлсэн билээ.

- ***Сургалтын хөтөлбөрт тохируулга хийх үндэслэл:***

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшихэд суралцагч бүрд адил тэгш боломж бүрдүүлэх зорилгоор тэдний ялгаатай хэрэгцээг харгалзан үндэсний сургалтын хөтөлбөрт талуудын оролцоотой тохируулга хийж, хэрэгжүүлнэ⁴

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө: Ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн хөгжлийн онцлог, хэрэгцээг харгалзан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн санал, зөвшөөрлийг үндэслэн боловсруулна.

Дэмжих сургалтын хөтөлбөр: Сургууль завсардсан, сурлагын хоцрогдолтой, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих сургалтын хөтөлбөрийг боловсруулна.

Хос хэлний сургалтын хөтөлбөр: Өөр хэл бүхий үндэстний цөөнхийн суралцагчдад зориулан агуулга болон хэлийг интеграцчилан суралцахуйн арга зүй (АХИС)-г баримталж, тохируулга хийнэ.

Нэмэлт сургалтын хөтөлбөр: Ерөнхий боловсролын түвшинд оюуны өндөр чадамжтай, авьяастай суралцагчдад ахисан түвшний агуулга бүхий нэмэлт сургалтын хөтөлбөрийг боловсруулна.

Жишиг сургалтын хөтөлбөр: Гадаад дахь Монгол хүүхдүүдэд зориулсан эх хэл, түүх, соёлыг таниулах агуулга бүхий сургалтын жишиг хөтөлбөрийг боловсруулна.

⁴ СӨБ, Бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал (2024)

Суралцагчийн хөгжлийн онцлог, ялгаатай хэрэгцээг харгалзан үндэсний сургалтын хөтөлбөрт тохируулга хийх аргачлалыг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага боловсруулна хэмээн Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтыгн хөтөлбөрийн үзэл баримтлал (2024)-д заасан байна. Иймээс сургалтын хөтөлбөрт тохируулга хийх үндэслэл нь дараах байдлаар тодорхойлогдож байна. Үүнд:

1. Олон улсын болон Монгол улсын боловсролын бодлого, эрх зүйн баримт бичиг

- НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, Хүүхдийн эрхийн конвенц, Монгол Улсын Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, Ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах журам гэх мэт.

Эдгээр баримт бичигт *боловсролын тэгш хүртээмж, оролцоог* хангах үүрэг тусгагдсан.

2. Тэгш хамруулах боловсролын зарчим

- Бүх хүүхэд *ялгаварлалгүйгээр боловсролд тэгш хамрагдах* эрхтэй.
- Сургалтын хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог, хэрэгцээнд нийцсэн байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрийн *оюуны, бие махбодын, сэтгэл зүйн* онцлог харилцан адилгүй тул сургалтын хөтөлбөрийг *уян хатан* болгох хэрэгцээ үүсч байна.
- Сургалтын хөтөлбөрт тохируулга хийхэд хүүхдийн *суралцах чадвар, оролцооны түвшин* харилцан адилгүй байгааг харгалзаж үзнэ.
- Сургалтын арга зүй, орчин, хэрэглэгдэхүүн нь хүртээмжтэй, уян хатан, дэмжлэг үзүүлэхүйц байна.

• Сургалтын хөтөлбөрт тохируулга хийх алхам:

1. Суралцагчийн бодит хэрэгцээ, чадварыг үнэлэх
 - Сэтгэл зүй, танин мэдэхүй, хэл яриа, хөдөлгөөн, нийгэмшлийн байдалд үнэлгээ хийх
2. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ) боловсруулах
 - Суралцах зорилго, дэмжлэгийн арга замыг тусгайлан тодорхойлох
3. Сургалтын хөтөлбөрт тохируулга хийх
 - Агуулга, арга зүй, сургалтын хэрэглэгдэхүүн, орчны болон үнэлгээнд өөрчлөлт оруулах
4. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сайжруулах
 - Дэмжих багш, туслах багш, апплекейшн, бусад дэмжих технологийг ашиглах
5. Үнэлгээ хийх

- Явцын болон үр дүнгийн үнэлгээг уян хатан хийх (ажиглалт, бичиж чадахгүй тохиолдолд амаар хариулах, ярьж чадахгүй тохиолдолд бичих, компьютер ашиглах, бүтээлийн үзэсгэлэн, зурагт болон үгт карт зэрэг боломжтой бүх хэлбэрийг ашиглах гэх мэт)

• **Сургалтын хөтөлбөрт тохируулга хийх чиглэл :**

- Хөтөлбөрийн агуулга
- Сургалтын арга зүй
- Сургалтын хэрэглэгдэхүүн, орчин
- Үнэлгээ зэрэг байж болно.

Хүснэгт 3. Сургалтын хөтөлбөрт тохируулга хийх төрөл

№	Сургалтын хөтөлбөрт тохируулга хийх төрөл	Тайлбар
1	Агуулгын тохируулга	Суралцахуйн зорилт, үр дүнг өөрчлөх, даалгааврын түвшнийг хүүхдийн хөгжлийн түвшинд тохируулах суралцах сэдвийн болон дасгал, даалгааврын тоог бууруулах, агуулгыг хялбаршуулах, модификаци хийх
2	Арга зүйн тохируулга	Суралцагчийн суралцах арга барилын ялгаатай байдлыг харгалзан ялгаатай болон тодорхой, ойлгомжтой зааварчилгаа өгөх, тохирсон арга хэлбэр сонгож хэрэглэх багаар, хосоор, бүлгээр ажиллах, (зураг, дохио, биеэр үзүүлэх, дохионы хэл, брайл бичиг үсэг, аппликейшн ашиглах, хугацаа сунгах гэх мэт), сэтгэл зүйн болон мэргэжилтний дэмжлэг, зөвлөгөө, эцэг эх, асран хамгаалагч, багш нарын хамтын ажиллагаа
3	Сургалтын хэрэглэгдэхүүн, орчны тохируулга	Биеийн хөдөлгөөний чөлөөтэй байдлыг дэмжих орчин, техник хэрэгслийн дэмжлэг, агааржуулалт, сандал, ширээ, матрас, зөөлөн буйдан, амрах, тайвшрах хэсэг, үйлийн болон сэтгэл зүйн таатай орчин гэх мэт
4	Үнэлгээний тохируулга	Хүүхдийн оролцоо, ахиц амжилтыг чанарын аргаар уян хатан үнэлэх нь чухал. (уламжлалт шалгалт бус ажиглалт, аман яриа, бүтээлээр үнэлэх, ахицаа үнэлэх гэх мэт)

Сургалтын хөтөлбөрт хийж байгаа эдгээр тохируулга нь хоорондоо уялдаа холбоотой бөгөөд бүгд харилцан шүтэлцээтэй сурагчийн хэрэгцээнд суурилсан хөгжлийг дэмжихэд чиглэнэ.

- ***Дэмжих технологи***

Суралцагч бие эрхтний органик гаралтай хөгжлийн бэрхшээлээс үүдсэн; эсвэл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээл; сэтгэл хөдлөл, зан араншингийн асуудал, эсвэл унших, бичих, ярих, тоо тооллын асуудлаас үүдэлтэй суралцахуйн бэрхшээлтэй байж болно. Дэмжих технологийг ашигласнаар суралцагчийн сургуульд суралцах нөхцөлийг хөнгөвчилж, боловсролын хүртээмж, чанарыг сайжруулах боломжтой.

Дэмжих технологи гэдэгт хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн хөдөлгөөний чадварыг сайжруулж, амьдралын чанарыг дээшлүүлэхэд зориулсан олон төрлийн технологийн шийдэл, хэрэгсэл, систем хамаарна.

Дэмжих технологи нь суралцагчдад суралцах, бусадтай харилцах, ойлголцох, хөдөлж явах, үе тэнгийн хүүхдүүд шиг хичээлдээ адил тэгш оролцоход нь тус болно. Тухайлбал, ярих чадваргүй суралцагч электрон ярианы аппликейшн, төхөөрөмж ашиглах, харааны бэрхшээлтэй суралцагч томруулдаг шил, томруулах програм эсвэл дэлгэц уншигч, аудио программ ашиглах зэрэг нь боловсрол эзэмших үйл явцыг харьцангуй хялбаршуулж өгдгөөрөө сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой байна. Сургалтын хөтөлбөрт тохируулга хийх чиглэлийг дэлгэрэнгүй авч үзье.

2.1. Агуулгын тохируулга

Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт агуулгын тохируулга хийх нь багшаас тухайн хүүхдийн хөгжлийн онцлог, сурах арга барилын ялгаатай байдлыг таньж мэдэх, ингэснээр хүүхдийн сурах, хөгжихөд саад учруулж буй сул талыг ойлгох, давуу талыг тодорхойлох замаар давуу талыг сул талыг нөхөх зорилготойгоор хэрэгцээнд суурилсан сургалтын хөтөлбөрийн агуулгыг өөрчлөх, уян хатан хэрэгжүүлэх үйл ажиллагаа юм.

Сургалтын хөтөлбөрт агуулгын тохируулга хийх нь суралцагчийг өөрийнх нь хэрэгцээ, сонирхолд нийцсэн, сурах арга барилаар, тодорхой хуваарийн дагуу, боломжтой хурдаар суралцахад нь дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ. Сургалтын хөтөлбөрийн агуулгад тохируулга хийхдээ дараах зарчмыг баримтална.

- *Сурагч төвтэй байх*: Сургалтын үйл ажиллагааг сурагчийн хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн зохион байгуулах;
- *Уян хатан байх*: Хатуу төлөвлөлтөд бус сургалтын орчны нөхцөл байдал, суралцагчийн оролцооноос хамааралтай байх
- *Ялгавартай байх*: Суралцагчийн ялгаатай байдлыг харгалзсан байх
- *Тэгш хамруулах*: Тэгш хамруулах зарчимд суурилсан байх

- Тусгай хэрэгцээт болон онцгой авьяастай хүүхэд гээд бүх хүүхдийн хэрэгцээг хангах

- **Агуулгын тохируулгын үе шат**

Агуулгын тохируулгыг тасралтгүй, тогтмол хийж, суралцагчийн суралцах үйлд ямар өөрчлөлт гарч байгаагаас хамаарч хийж хэрэгжүүлэн.

Үе шат I. Хүүхдийн хөгжлийн бодит байдлыг судлах

-Ажиглах,

-Хөгжлийн үнэлгээ хийх

-Хэрэгцээг тодорхойлох

Үе шат 1-ийн хүрээнд хүүхдийн бодит байдлыг илрүүлж, таньж мэдсэнээр тухайн суралцагчид ямар хэрэгцээ байгааг тодорхойлж, тусгай хэрэгцээт ямар дэмжлэг (хэл яриа хөгжүүлэх, танин мэдэхүйг хөгжүүлэх, бие бялдар, хөдөлгөөний идэвхийг дэмжих гэх мэт) хэрэгтэй болох, ямар чиглэлээр, юуг хэрхэн тохируулах хэрэгтэйг тодорхойлно.

Үе шат II. Сургалтын агуулгын тохируулгыг төлөвлөх

Хүүхдийн хэрэгцээг ойлгож, мэдсэнээр дараах чиглэлээр тохируулгыг төлөвлөнө.

1. *Агуулга (Content): Сурагч юуг сурах вэ? (суралцагчийн ойлгож, мэдэх танил үг хэллэгтэй сэдэв, агуулгыг төлөвлөх, шинэ үгийн утгыг тайлбарлах, хэрэглэх, хөнгөнөөс хүндрүүлэх зарчмаар агуулгыг төлөвлөх, хичээл хоорондын агуулгыг интеграцилах, хүүхдийн дуртай, сонирхдог зүйлийг мэдэж агуулгыг төлөвлөх гэх мэт)*
2. *Арга зүй / (Process): Сурагч хэрхэн суралцаах вэ?*
 - Ялгавартай дасгал ажиллах: Тухайн суралцахуйн зорилтод хүрэхийн тулд олон янзын аргаар ажиллах (Жишээ нь, зурах, бичих, баримлаар барих, биеэр дүрсэлж үзүүлэх).
 - Ангийн суралцагчдад харилцан адилгүй даалгавар өгч, тохирсон дэмжлэг үзүүлэх
3. *Орчин (Environment): Сурагч хаана сурах вэ?*
 - Анги зохион байгуулалт (хүүхдийн сурах идэвхийг дэмжих орчин бүрдүүлэх)
 - Дэмжих өрөө, тасалгаа (тусгайлсан), Жишээ нь: аутизмтай хүүхдэд тайвшруулах өрөө байх
4. *Үр дүн / (Product): Сурагч сурснаа хэрхэн илэрхийлэх вэ?*

Илэрхийлэх олон хэлбэр: Сурагч дохионы хэлээр, брайл бичгээр, зургаар, бүтээлээр, зохиомж хийх, биеийн хэлэмжээр, цахим технологи ашиглаж гэх мэт

Үе шат III. Хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх

- Төлөвлөсөн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- Хэрэгжүүлэх үед багш, багш нарын хамтлаг хамтын хичээл сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь хамгийн үр дүнтэй байна. Зарим багш чиглүүлэгч, зарим нь найз, зарим нь туслагч байх гэх мэт
- Тухайн сурагч бүрт тохирсон дэмжлэгийг үзүүлэхийг чухалчилна.

Үе шат IV. Сайжруулах, дахин үнэлэх

- Хэрэгжсэний дараа тохируулга үр дүнтэй байсан эсэхийг үнэлнэ.
- Тухайн тохируулга хүүхдийн хэрэгцээнд нийцсэн эсэх, сонирхолтой сэтгэл ханамжтай байсан эсэх, суралцахуйн зорилтын үр дүнд хүрсэн эсэх, цаашид вуг анхаарч сайжруулах хэрэгтэйг тодорхойлно. Ингэснээр тухайн тохируулгыг дараагийн удаа ямар байдлаар хийхийг мэдэх болно.

Үе шат V. Эцэг эх, асран хамгаалагч, багш нар хамтран ажиллах

- Суралцагчийн мэдээллийг эцэг эх, асран хамгаалагчтай кейс хэлэлцүүлэг, уулзалт хийх байдлаар зөвлөлдөж, тэдний санал, сурагчийн хүсэл сонирхлыг тохируулга хийхдээ тусгаж ажиллана. Багш нар сургуулийн Дэмжлэгийн багийнхан хамтарч ажиллана.

Агуулгын тохируулгыг хийх алхмыг нэгтгэж үзвэл дараах дараалалтай хийгдэнэ.

Үүнд:

1. Хүүхдийн хөгжлийн үнэлгээ хийх (ажиглах, хэрэгцээ, сонирхлыг тодорхойлох)
2. Хөтөлбөрийн тохируулгыг төлөвлөх (агуулга, арга зүй, орчин, хэрэглэгдэхүүн, үнэлгээ)
3. Хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа (төлөвлөлтийн дагуу),
4. Хэрэгжилтийг үнэлж, сайжруулах
5. Багш нар, эцэг эх, асран хамгаалагчтай хамтарч ярилцах, санал солилцох, хамтран ажиллах болно.

2.2. Арга зүйн тохируулга

Арга зүйн тохируулга нь СТЗ-т суурилсан суралцагчийн сурах арга барилын ялгаатай байдлыг харгалзан тэдний мэдээллийг хүлээн авах онцлогийг харгалзан ялгаатай зааварчилгаагаар уян хатан арга зүйгээр хичээлийг зохион байгуулна.

Сургалтын хөтөлбөрт арга зүйн тохируулга хийх нь багшийн хичээл төлөвлөлт, уян хатан заах арга, суралцагчийн хүүхдийн ялгаатай хэрэгцээг хүндэтгэсэн хандлагад суурилна. Арга зүйн тохируулга хийхэд хичээлийг багаар, хосоор болон ганцаарчлан дасгал, даалгавар гүйцэтгэх, суралцах үйлийн хурдыг харгалзан хугацааны тохируулгыг ялгаатай байдлаар (уртасгах, багасгах) төлөвлөхөөр тусгадаг. Ямар хичээл байгаагаас хамааран суралцагчдын ажиллах арга хэлбэрийг сонгож болно. (багаар, хосоор, бүлгээр, ганцаарчилж ажиллах)

• Арга зүйн тохируулгын үндсэн зарчим

- *Уян хатан төлөвлөлт* – Аливаа хичээлийн явцыг олон хувилбараар төлөвлөх
- *Суралцагчийн сул талыг хүлээн зөвшөөрөх* – Давуу талыг ашиглаж сул талыг хөгжүүлэх
- *Суралцагчийн оролцоог дэмжих*, сурагч өөрийн аль болох дээд боломжоор оролцох, өөрийн бодит чадварт түшиглэсэн оролцоо байх (оролцооны түвшинг сайн, муу гэж ялгахгүй)

- *Хамтран суралцах* –Сурагчид хамтран хөгжих, тэмцээнд оролцох, урлагийн үзлэг, спортын дугуйлан секцэд хамрагдах, харилцах боломжийг олгосон байх

Суралцагчийн сурах арга барилын ялгаатай байдлыг харгалзан суралцагчийн суралцахуйг дэмжих нь чухал байна. Сонсголын бэрхшээлтэй сурагчид харааны хүртэхүйд суурилсан сургалт, харааны бэрхшээлтэй сурагчид тэмтрэх болон үнэрлэх, сонсох, хүртэх мэдрэхүйд суурилсан сургалт, аутизмтай сурагчид харилцааг дэмжсэн, зурган солилцооны арга үр дүнтэй байх, оюуны хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн хувьд хийсвэрлэх сэтгэхүй сул хөгжсөнтэй холбоотой бодит зүйлийг хүрч, барьж байж илүү мэдлэг ойлголт эзэмшдэг байх жишээтэй. Харааны ой тогтоолтоор суралцах (Visual) хэв загварт суурилсан бол зурагт карт ашиглан мэдээлэл өгөх, зураг зуруулах, олон өнгө ашиглах, дүрс бичлэг үзүүлэх гэх мэт

Арга зүйн тохируулга нь сурагч бүрийн суралцах хэв маяг, хурд, сонирхол, онцлогт нийцүүлэн хичээлийг төлөвлөх, зохион байгуулах, багш, туслах багшийн зүгээс үзүүлэх дэмжлэгийг өөрчлөх, тохируулах үйл явц юм. Өөрөөр хэлбэл, суралцахуйн зорилгод хүрэхийн тулд олон ялгаатай зааварчилгаа, уян хатан арга зүйг хэрэгжүүлэх юм.

Арга зүйн тохируулга нь "Хүүхэд бүр ялгаатай, нэг арга бүх хүүхдэд таарахгүй" гэсэн зарчмыг хүлээн зөвшөөрч, багш өөрийн "арга зүйн боловсруулалт"-ийг байнга туршиж, сайжруула, суралцагчийн хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн уян хатан, бүтээлчээр ажиллах ур чадвар юм.

Арга зүй:

Ганцаарчлан ажиллах арга зүй: Ялгаатай хэрэгцээтэй (хөгжлийн бэрхшээлтэй) хүүхдийг ганцаарчлан дэмжлэг үзүүлэхдээ аль болох бодит сургалтын хэрэглэгдэхүүн ашиглах, ашиглаж байгаа хэрэглэгдэхүүн нь хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт нийцсэн, танил, өдөр тутмын амьдралд нь хэрэглэдэг үзүүлэн байх, дадлага ажил, юмсыг бодитоор барьж атгуулж, хүртүүлэх арга, идэвхжүүлэх арга, урамшуулах арга, дүрслэн үзүүлэх, дүрд тоглох, тоглоомын арга, эерэг зан үйлийг төлөвшүүлэх арга (ABA-аутизмтай хүүхдийн хувьд), дэмжих (хэл яриа хөгжүүлэх, хөдөлгөөн дэмжих, харилцаа, нийгмийн харилцаанд татан оролцуулах), ажиглах, даган дуурайх, давтах, асуулт тавих, ярилцах зэрэг аргыг илүү ашиглах нь үр дүнтэй байна.

Багийн арга зүй: Дүрэм тогтоох, кааварчилгаа хэрэгжүүлэх, сонголттой хувилбартай даалгавар, урамшуулал, харилцан ярилцах, харилцаа тогтоох, зааж байгаа зүйл нь ач холбогдолтой байх, харилцан дэс дараагаар үйл ажиллагаанд оролцох, дэг мөрдөх

Ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн сурах үйл ажиллагааг дэмжихдээ арга зүйн олон хувилбарыг сонгож хэрэгжүүлэх, суралцагчид хамгийн үр дүнтэй байгаа арга зүйг хувилбартайгаар хэрэгжүүлэх, багшийн дэмжлэгийг тохируулах нь сайн үр дүнтэй байна.

2.3. Сургалтын орчин ба хэрэглэгдэхүүний тохируулга

2.3.1. Сургалтын орчны тохируулга

Сургалтын орчныг суралцагчид аюулгүй, эрүүл, хүртээмжтэй, тохируулгатай орчинд сурч, хөгжих боломжоор хангагдсан байх хэрэгтэй. Энэ нь сургалтын орчин (материаллаг,

үйлийн, сэтгэл зүйн таатай орчин), тэгш хамруулсан орчин (тохируулгатай, дэмжлэгтэй, хүртээмжтэй ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн хэрэгцээнд суурилсан), хүртээмжтэй (сургуулийн талбайн зай хэмжээ, тохижилт, цахим хэрэглэгдэхүүн хангамж, нөөцийг бүрдүүлсэн) байх нь суралцагчид эрүүл, аюулгүй, хүртээмжтэй сургалтын орчин байна гэж үздэг.

Сургалтын хөтөлбөрийн агуулга нь "юу сурах", түүнийг хэрэгжүүлэх арга зүй нь "яаж сурах", суралцах **орчин, хэрэглэгдэхүүн** нь "хаана, юугаар сурах" вэ гэдэг асуудлыг бүхэлд нь шийддэг. Суралцагчийн суралцах сонирхол, идэвх, бүтээлчээр сэтгэх, сонирхон судлах, асуудал шийдвэрлэх, бие даасан, дасан зохицох үйлд сургалтын орчин шууд нөлөөлдгийг олон судлаачид онцолсон байна.

Тэгш хамруулсан сургалтын орчинг дараах байдлаар авч үзэж болох юм. Үүнд:

- Сургалтын тэгш хамруулсан орчин (хүүхэд бүрийн ялгаатай хэрэгцээ, харилцан адилгүй байдлыг хүндэтгэн үзэж хичээл, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, нийгмийн харилцаанд оролцох боломжийг бүрдүүлсэн хүртээмжтэй, тохируулгат дэмжлэгтэй орчин)
- Сургалтын үйл ажиллагааны болон сэтгэл зүйн ая тухтай харилцааг бүрдүүлсэн орчин.
- Суралцагчийн өөрийгөө таньж мэдэх, өөрийгөө эерэгээр үнэлж, хүлээн зөвшөөрөх, өөрийгөө боломжоор ажиллах тохируулгатай орчин
- Бусад хүмүүстэй ялангуяа бага боловсролын хүрээнд нийгмийн харилцаанд оролцох нийгмийн танил орчин байна.

Түгээмэл загварын сургалтын орчин нь сургалтын орчныг “суралцагчийг орчиндоо нийцүүлэх” бус, орчныг тухайн суралцагчид нийцүүлсэн тэгш хамруулсан сургалтын орчин байх бөгөөд суралцагч бүр суралцах, тэгш оролцох, .

Сургалтын орчин нь судлагдахууны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, суралцахуйн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад нөлөөлөх гол хүчин зүйл учраас суралцагчийн сурах арга барилын ялгаатай байдал, хэрэгцээ, сонирхолд нийцсэн хүүхдийн оролцоог идэвхжүүлсэн, туршиж үзэх, хийж бүтээх явцдаа суралцах боломж олгосон орчин байна. Иймээс сургалтын тохируулгат орчныг дараах байдлаар бүрдүүлэхэд анхаарна.

- **Эерэг таатай уур амьсгал бүхий харилцаа:**

- Багш-сурагч, сурагч-сурагч бие биенээ сонсдог, хүндэтгэдэг, урам зориг өгдөг;
- Бодит орчинд ойр, практик хэрэглээтэй байх, суралцахуйн үр дүнд хүрэхэд дэмжлэг үзүүлэхүйц орчныг бүрдүүлэх (жишээ нь: хувийн ариун цэврийн болон хувцасны булан, гэр орны эд хогшил, гэрийн ажил, хуанли, огноо, цаг хугацаа харуулсан үзүүлэн таниулах материал, анги, сургуулийн макет, тээврийн хэрэгсэл, замын хөдөлгөөн, үйлчилгээний газрууд дэлгүүр, эмнэлэг, эмийн сан зэргийг харуулсан булан, макет байх);
- Сургалтын хэрэглэгдэхүүний талаарх тэмдэг, тэмдэглэгээ нь ойлгомжтой, энгийн байх (хүүхдийн нас, сурах арга барилын онцлогийг харгалзсан зурагт самбар, тэмдэг, тэмдэглэгээ, өнгө, тэмдэгтэй байх, “Захирлын өрөө”, “Бие засах, гар угаах

газар”, “Эмчийн өрөө”, “Хувцас солих хэсэг”, “Биеийн тамирын заал”, “Номын сан” гэх мэт байршлыг тэмдэглэсэн тэмдэг, тэмдэглэгээ, самбарууд;

- Бие даан хийж сурах боломжийг бүрдүүлсэн байх (ажиглах, оролцох, туршиж үзэх, бие дааж гүйцэтгэх дасгал, даалгавар хийх булан, тоглох, ярилцах, урлаг, уран сайхны үйл ажиллагаанд оролцох бусад холбогдолтой хэрэглэгдэхүүн, харилцан ярианы аудио, видео бичлэг гэх мэт);
- Харилцах, хамтран ажиллах боломжтой; сурагч алдаанаасаа суралцах, санал, хүсэлтээ чөлөөтэй илэрхийлдэг;
- Багш туслагч, зөвлөгч, чиглүүлэгч байж, сурагчийг өөртөө үйлчлэх, эрүүл ахуйн зөв дадал, хэвшилтэй, өөрийгөө илэрхийлэх, бусадтай харилцах ур чадвартай, нийгмийн танил орчны үйлчилгээнд оролцох чадвартай болоход дэмжлэг болдог;
- Суралцагчийн тууштай байдал, идэвхтэй оролцоог дэмжиж, амжилтыг урамшуулдаг;

- **Эрүүл, аюулгүй, хүртээмжтэй анги танхим:**

- Суралцагчийн сэтгэл санаа, бие махбодын эрүүл мэндийг дэмжсэн;
- Суралцагчийн хөдөлгөөн хийх, бие биетэйгээ харилцах боломжтой, уян хатан зохион байгуулалттай;
- Суралцагчийн өөрөө хийх, бусдаас дэмжлэг авах, бүтээлч үйл ажиллагааг дэмжсэн, хүртээмжтэй орон зай, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан, нэмэлт тохируулга хийсэн орчин байх;
- Сургалтын интерактив, дижитал хэрэглэгдэхүүн ашиглах боломжтой;

- **Ялгаатай хэрэгцээг харгалзсан орчин:**

- Суралцагчийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрсөн, түүнийг хүндэтгэсэн;
- Суралцагчийн суралцах хэв шинж, ялгаатай хэрэгцээнд тохирсон төрөл бүрийн сургалтын материал, хэрэгслийг бэлтгэх, ашиглах боломжтой;
- Дохионы хэлний орчуулга, толь бичиг, аудио, видео хэрэглэгдэхүүн, брайл хэрэглэгдэхүүн, зурагт, үгт карт, сонголттой, хувилбартай дасгал, даалгаврын сантай;
- *Уян хатан байх:* Багш болон хүүхдүүд өөрсдийн хэрэгцээндээ нийцүүлэн өөрчлөх боломжтой байх.

2.3.2. Сургалтын хэрэглэгдэхүүний тохируулга

Ялгаатай хэрэгцээтэй (хөгжлийн бэрхшээлтэй) хүүхдийн сургалтын хэрэглэгдэхүүнд тохируулга хийх арга зүй нь олон улсын “Хандлага-Орчин-Сургалтын хэрэглэгдэхүүн” (Universal Design for Learning – UDL), “Хувь хүнд тохирсон дасан зохицуулалт” (Adaptation/Accommodation) зарчмуудад суурилж хийгдэнэ.

- **Сургалтын хэрэглэгдэхүүнд тохируулга хийх зарчим:**

1. *Хүүхдийн хэрэгцээ* – орчны үнэлгээнд суурилж хийгдэх

- Хүүхдийн хөгжлийн онцлог (хараа, сонсгол, ой тогтоолт, хэл яриа, хөдөлгөөний хөгжил гэх мэт)
 - Сургалтын орчинд байгаа бэрхшээл (анги танхим, ширээ, сандал бусад тавилга, дуу чимээ, гэрэлтүүлэг)
 - Сургалтын зорилго, суралцахуйд тулгарч буй тодорхой саад, хүндрэл
2. *Жижиг, тодорхой, хэрэгжүүлэхэд хялбар өөрчлөлт хийх*
 - Хичээлийн агуулгыг өөрчлөхгүйгээр танин мэдэхүйн ачааллыг бууруулах
 - Хэрэглэх арга, хэрэгслийг өөрчлөх, сонголт өгөх
 3. *Олон мэдрэхүйд түшиглэх сургалтын хэрэглэгдэхүүн*
 - Харааны, сонсголын, гарын хөдөлгөөнөөр барьж мэдрэх материалаар баяжуулах
 4. *Уян хатан, сонголттой орчин бий болгох*
 - Хүүхэд өөрт тохирох аргаар сурах боломжтой байх
 - ***Сургалтын хэрэглэгдэхүүний тохируулгын үндсэн төрлүүд***

1. Харааны бэрхшээлтэй хүүхдэд тохируулга

- Том үсгийн хэмжээг 18–24 pt болгох
- Өндөр контрасттай өнгө ашиглах (хар дээр цагаан, цагаан дээр хар)
- Брайль үсэгтэй материал бэлдэх
- Дүрс, диаграммыг томруулж энгийн болгох
- Тактиль (барьж мэдрэх) зурагт карт, рельеф бүхий хэлбэр дүрс ашиглах
- Дуугаар уншиж өгдөг аудио материал бэлтгэх

2. Сонсголын бэрхшээлтэй хүүхдэд тохируулга

- Контентын гол санааг дүрс, зураг, схемээр илэрхийлэх
- Доод гарын дохио хэл/хиймэл дохио ашиглах боломж олгох
- Аман тайлбарыг бичмэл хэлбэрээр хавсаргах
- Богино, товч, цэгцтэй өгүүлбэр ашиглах
- Видео материалыг заавал хадмал орчуулгатай болгох

3. Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохируулга

- Агуулгыг жижиг хэсэгт хуваах
- Нэг даалгаварт нэг үйлдэл агуулсан байх
- Жишээ • дүрс • загвар ашиглаж ойлголтыг бататгах
- Өнгө, дүрс, дүрслэлтэй материал түлхүү хэрэглэх
- Давтамжтай, үе шаттай дасгал өгөх
- Зааврыг богино өгүүлбэрээр, тодорхой заах

4. Хөдөлгөөний хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохируулга

- Барьж тогтооход хялбар том бариултай хэрэгсэл өгөх (бал, хайч, багц материал)
- Ширээ сандлын өндрийг тохируулах

- Товшилт багасгасан дижитал материал ашиглах
- Хичээл дээр хийж гүйцэтгэх хөдөлгөөний тоог багасгаж, хугацааг сунгах

5. Аутизм болон зан үйлийн бэрхшээлтэй хүүхдэд тохируулга

- Альтернатив даалгавар өгөх (зурах, загварчлах, богино бичвэр гэх мэт)
- Тайван орчныг бүрдүүлэх (дуу чимээ багасгах, анхаарлаа төвлөрүүлэх хэрэгсэл)
- Богино хугацааны даалгавар, түвшин ахиулсан материал өгөх
- Шагнал урамшууллын систем ашиглах

Хүснэгт 4. Тохируулсан хэрэглэгдэхүүн

Бэрхшээлийн төрөл	Энгийн хэрэглэгдэхүүн	Тохируулсан хэрэглэгдэхүүн
Харааны бэрхшээл	Жижиг дүрстэй үсгийн карт	Том үсэг, өндөр контрасттай, тактиль тэмдэгтэй
Сонсголын бэрхшээл	Дуу авиатай видео	Хадмал орчуулгатай, зураг схемтэй видео
Оюуны хөгжлийн бэрхшээл	Урт заавартай даалгавар	1–2 алхамтай энгийн заавар, дүрстэй тайлбар
Хөдөлгөөний бэрхшээл	Жижиг бариултай хайч	Том бариултай, хялбар атгадаг хайч

• Сургалтын хэрэглэгдэхүүнд тохируулга хийх алхам

1. Хүүхдийн хэрэгцээг тодорхойлох

- Багш • туслах багш • эцэг эх • сэтгэл зүйч хамтран үнэлгээ хийх

2. Суралцахад тулгарч буй саадыг илрүүлэх

- Харах боломжгүй?
- Сонсох хүндрэлтэй?
- Бичиж чадахгүй?
- Агуулга төвөгтэй байна уу?

3. Тохируулгын төрлийг сонгох

- Агуулгын тохируулга
- Хүргэх арга барилын тохируулга
- Хэрэглэгдэхүүний өөрчлөлт
- Суралцах орчны тохируулга

4. Сургалтын хэрэглэгдэхүүнд өөрчлөлт хийх

- Материалын хэлбэр: зураг, аудио, тактиль
- Хэмжээ: томруулах, энгийн болгох
- Даалгаврын төрөл: сонголттой, үе шаттай
- Хэрэглэгдэхүүн: том бариул, тактиль тэмдэглэгээ

5. Туршиж сайжруулах

- Хүүхэдтэй ажиллаж үр дүнг үнэлэх
- Хэрэгцээнд тохируулж дахин сайжруулах

Аутизмтай хүүхдийн сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэж, тохируулах арга зүй: Аутизм, аутизмын хүрээний эмгэгтэй (ААХЭ) хүүхдэд зориулсан **сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх, тохируулахад** бодитой, хэрэгжүүлэхэд хялбар байх чиглэл юм. Багш нарын аутизм, аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн сургалтад голчлон хэрэглэдэг АВА, ТЕАССН, UDL, Визуал дэмжлэг зэрэг арга зүйд тулгуурлаж байна. Үүнд дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна.

Жишээ. Аутизмтай хүүхдийн онцлогийг ойлгож, хэрэглэгдэхүүн бэлтгэх ААХЭ-тэй хүүхдийн нийтлэг хэрэгцээг сургалтын хэрэглэгдэхүүнд тусгана.

1. Харааны мэдээлэл давамгайл байх

- Уншиж ойлгохоос илүү зураг, дүрс, пиктограмм, өнгөний код илүү үр дүнтэй.
- “Юу хийх вэ?” “Яаж хийх вэ?” “Дараагийн алхам юу вэ?” гэдгийг харааны хэлбэрээр заах хэрэгтэй.

2. Тодорхой бүтэц, дараалал тодорхой байх

- Агуулга, даалгавар, өдөр тутмын хөтөлбөрийг алхамчилсан, “эхлэл–дунд–төгсгөл” хэлбэрээр зааж өгөх.

3. Хэт их мэдээлэл анхаарал сарниулах

- Шинээр өгч байгаа мэдээлэл тодорхой, хэт олон биш, нэг хуудсанд тодорхой нэг ойлголтыг дэс дараалалтэй, тодорхой байдлаар тусгасан байна.

4. Мэдрэхүйн мэдрэмжид тохируулах

- Дуу чимээ, гэрэл, өнгө нь тухайн хүүхдэд тааламжтай ба ачаалал өгөхгүй байх.
- Тактиль материал (барьж мэдрэх), зурагтай карт, хялбар хүүхдэд илүү ойлгомжтой.

Аутизмтай хүүхдэд тохиромжтой сургалтын хэрэглэгдэхүүний төрлүүд

1. Визуал дэмжлэгтэй материал

- Пиктограмм (PECS хэв маяг)
- Хичээлийн дарааллын самбар
- Дүрст чиглүүлэг (step-by-step cards)
- Зан үйлийн дүрэм зурагчилсан хэлбэртэй
- “Working for...” урамшууллын систем (token board)

2. Зорилтот ур чадварт тохируулсан хэрэглэгдэхүүн

- Хэл яриа: зураг-харгалзуулах карт, нэр томъёоны карт
- Нийгмийн ур чадвар: нийгмийн үлгэр (social stories), дүрт комик
- Танин мэдэхүй: өнгө, хэлбэр, тоолол, ангилал хийх карт
- Өөрөө өөртөө үйлчлэх: хувцаслах, бие засах, гар угаах алхамчилсан карт

3. Мэдрэхүйн ачааллыг зохицуулах материал

- Стресс бууруулагч тоглоом
- Текстуртэй карт (зөөлөн, барзгар гэх мэт)
- Чимээгүй ажиллах булангийн тэмдэглэгээ
- Жигд өнгөтэй фонтой хичээлийн холбогдолтой зурагт карт

Аутизмтай сурагчид сургалтын хэрэглэгдэхүүн тохируулах 5 алхам

1. Хүүхдийн хөгжлийн түвшин, хэрэгцээг үнэлэх

- Харилцаа
- Танин мэдэхүй
- Анхаарал төвлөрөлт, зан чанар
- Мэдрэхүйн онцлог

2. Суралцахад тулгарч буй саадыг тодорхойлох

- Заавар ойлгохгүй байна уу?
- Дараалал ойлгохгүй байна уу?
- Хэт олон өнгө, дүрс анхаарлыг сарниулдаг уу?
- Хөдөлгөөний хүндрэлтэй юу?

3. Хэрэглэгдэхүүний хэлбэрийг сонгох

- Зурагт карт уу?
- Алхамчилсан заавар уу?
- Барьж мэдрэх материал уу?
- Видео загварчлал уу?

4. Харааны бүтэц бий болгох

- Өнгө, дүрсээр
- Дарааллын сум заах
- Нэг хуудсанд нэг даалгавар байрлуулах
- Дуу чимээ, нэмэлт агуулга багасгах

5. Даалгаврыг алхамчлан хялбаршуулах

- Энгийн → Дундаж → Нарийн түвшинтэй хувилбар гаргах
- Сонголт цөөнтэй байхаар эхэлж, аажмаар нэмэгдүүлэх

Турших, сайжруулах

- Хүүхэд хэрэглэж үзэхэд ойлгомжтой байгаа эсэхийг ажиглах
- Судлагдахуун: “Юу тохирч байна? Юу саад болж байна?” гэж үнэлэх

Жишээ 1: Үсэг сурах флашкарт (тохируулсан)

- Нэг талд том үсэг: “А”
- Нөгөө талд нэг зураг: “Алим”
- Хэт олон өнгө, дуу чимээтэй зураг хэрэглэхгүй
- Фон цагаан эсвэл нэг өнгөтэй (тод биш, сулавтар өнгө байх)

Жишээ 2: Өдрийн хуваарийн самбар

- “Ирлээ → Хичээл → Амралт → Хоол → Гэртээ харих”

- Бодит зураг эсвэл пиктограмм ашиглах
- Дууссан даалгаврыг самбарын хажуу тийш нь зөөж ажилласан хэсэгт байрлуулах

Жишээ 3: “Зан үйлийн дүрэм” зурагт карт

- Дүрсэлсэн зураг + 1–3 түлхүүр үг:
- “Гараа өргөөрэй”
- “Чимээгүй суугаарай”
- “Ээлжээ хүлээгээрэй”

Жишээ 4: Алхамчилсан даалгаврын карт

Суралцахуйн үр дүн: “Дүрс хайчлах”

1. Цаасаа барина.
2. Хайчаа нээнэ.
3. Шугам даган хайчилна.
4. Хайчаа тавина.

(Алхам бүрийг зургаар нэг үйлдлээс нөгөө үйлдэлд шилжих процессыг зургаар дүрсэлж харуулна)

Жишээ 5: Урамшууллын самбар (Token Board)

- 5 од → шагнал
- Шагналын хувилбар: тоглоом тоглуулах, зураг зурах, завсарлага авах
- Хүүхэд сонголтоо өөрөө сонгох боломжийг олгох

Жишээ 6: Хэрэглэгдэхүүн бэлтгэхэд анхаарах зүйлс

- Өнгө нь зөөлөн, хэт тод биш
- График энгийн, олон дүрсгүй, ойлгомжтой байх
- Үсгийн хэмжээ том (18–24 pt) байх тохиромжтой
- Хүүхдийн сонирхолд тулгуурлах, танил байх (машин, тоглоом, амьтан, дуртай амттан гэх мэт)
- Даалгаврын үргэлжлэх хугацааг богино байлгах (3–7 мин)

2.4. Үнэлгээний тохируулга

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын хөтөлбөрийг үнэлэх үнэлгээнд тохируулга хийх онол-арга зүйн үндэс, хэрэгжүүлэх аргачлал нь мөн л UDL, Inclusive Assessment, Differentiated Assessment, Functional Assessment зарчимд тулгуурлана.

1. Онолын үндэс

Хөгжлийн бэрхшээлтэй (ХБХ) хүүхэдтэй анги, багийн сургалтын үйл ажиллагааны үнэлгээнд тохируулга хийхдээ олон улсын хандлагад тулгуурладаг. Үүнд:

1. Universal Design for Learning (UDL) – Хүн бүрт нээлттэй сургалтын дизайн

- Суралцах олон арга, мэдээлэл авах олон хэлбэр, хариу илэрхийлэх олон арга ашиглах.

- Үнэлгээг уян хатан, хувь хүнд тохирсон, саадыг бууруулсан байх.

2. *Inclusive Assessment – Тэгш хамруулах үнэлгээ*

- Үнэлгээ нь хүүхдийн чадварыг илэрхийлэх боломж олгох, саад болох орчноос ангид байх.
- Үнэлгээний зорилго нь хүүхдийг ангиасаа ялгах биш, хөгжлийн ахиц, хэрэгцээг тодорхойлох.

3. *Differentiated Assessment – Ялгавартай үнэлгээ*

- Хүрэх үр дүн, зорилго ижил мөртлөө гүйцэтгэлийн түвшин, арга, хэрэглэгдэхүүн өөр өөр байна.
- Үнэлгээг тухайн хүүхдэд хүрэх үр дүнгээр тодорхойлсон ГСТ-тэй уялдуулах

4. *Functional Assessment – Үйл ажиллагаанд суурилсан үнэлгээ*

- Сурагчийн сурах арга барилын ялгаа, суралцах ур чадвар, өдөр тутмын амьдралд оролцох чадвар, нийгмийн оролцоог хамтад нь авч үзэж үнэлнэ. (ялангуяа аутизм, оюуны хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн хувьд чухал байна). Үнэлгээг тодорхой хугацаанд давтамжтай хийх нь үр дүнтэй үнэлгээ болдог. Энэ нь явцын (ахицын) үнэлгээг хийснээр тухайн сургалтын хөтөлбөр, багшийг арга зүй, сургалтын хэрэглэгдэхүүний тохирцыг үнэлж, эргэх холбоотойгоор сайжруулах, дахин шинээр боловсруулах эсэхийг багш нарт хэлж өгдгөөрөө давуу талтай байна.

Сурагчийн үнэлгээний зорилго нь суралцахуйн үр дүнг тодорхойлох, сурагчийн хөгжил, ахицыг дэмжих, суралцах арга барилыг төлөвшүүлэх, багшийн заах арга, сургалтын хөтөлбөр, орчин, хэрэглэгдэхүүнийг сайжруулахад чиглэгдэнэ. Өөрөөр хэлбэл сурагчийн үнэлгээ гэдэг нь түүний эзэмшсэн мэдлэг, чадвар, төлөвшлийн давуу болон сул талыг илрүүлэх, суралцахуйн үйл ажиллагааг дэмжих, ахиц, амжилтыг урамшуулах, хүрсэн түвшинг үнэлэхэд чиглэнэ. Үнэлгээ нь тухайн суралцагчийн хөгжлийн бодит чадварыг тодорхойлж, зөвхөн оноо тавих биш, харин сурагчийн ахиц дэвшил, суралцахуй, тасралтгүй хөгжлийг дэмжихүйц үйл байна.

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж буй суралцагчийг үнэлэх чиглэлийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан журмыг баримтална.

• **Үнэлгээний зарчим:**

- Хүүхдийн цогц хөгжлийг хангасан байх;
- Хүүхдийн хөгжлийн талаарх бодит байдлын судалгаанд тулгуурласан байх;
- Хүүхдийн гүйцэтгэлийн үр дүн, ахиц өөрчлөлтийг бусадтай нь харьцуулахгүй байх;
- Өдөр тутмын үйл ажиллагааны явцад тасралтгүй, эргэх холбоотой сайжруулж байх

- Хүүхдийн гүйцэтгэсэн үйлийн үр дүн, гүйцэтгэлийн явцад илэрч буй хичээл зүтгэл, хандлагыг авч үзэх

- **Үнэлгээний төрөл**

1. Гарааны үнэлгээ: Хүүхдийн хөгжлийн бодит байдлыг тогтоож, хүүхдийн хөгжих, сурах онцлог, сурах арга барилын ялгаатай байдлыг таньж мэдэх
2. Явцын үнэлгээ: Ганцаарчилсан сургалт үйл ажиллагааны явц, хүүхдийн хөгжлийн онцлогт ажиглалт хийх, тэмдэглэх, хөтөлбөрт тохируулга хийх, хэрэгжүүлэх
3. Үр дүнгийн үнэлгээ: Ганцаарчилсан сургалт, үйл ажиллагааны үр дүн, хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх, сайжруулах

Үнэлгээний тохируулга гэдэг нь сурагчийн юу ойлгож мэддэг, юу сурсанаа тодорхойлж, суралцахад нь тулгарч байгаа бэрхшээлийг багасгах, улмаар арилгах, өөрийнхөө сурах, хөгжих чадвараа боломжит дээд түвшингээ харуулах олон янзын боломжийг олгох зорилготой байна.

- **Үнэлгээний тохируулгын чиглэлүүд**

- Үнэлгээний зорилгод тохируулга хийх
- Үнэлгээний аргын тохируулга
- Үнэлгээний шалгуурын тохируулга
- Үнэлгээний орчны тохируулга
- Үнэлгээний хугацаа ба урамшууллын тохируулга

- **Үнэлгээний тохируулга хийх үе шат**

1. *Сурагчийн бодит байдлыг судалж, таньж мэдэх, хэрэгцээ сонирхлыг илрүүлэх* (үнэлгээний болон ажиглалтын хуудас, эмнэлгийн карт, эцэг эх, асран хамгаалагчийн ярилцлага, ХБХЭСХК-ийн кейс...)
2. *Үнэлгээний зорилгыг тодорхойлох:* “юуг үнэлэх вэ?” (оролцоо, ахиц, өөрчлөлт...)
3. *Үнэлгээний арга, хэлбэрийг уян хатан болгох:* (сурагчийн хөгжлийн онцлог, хэл яриа, танин мэдэхүй, бие бялдар, хөдөлгөөн, харилцаа нийгэмшлийн чадварыг харгалзах)
4. *Сурагчийн сурах арга барилын ялгаатай байдлыг харгалзах* (зурагт болон үгт карт, дохио, брайл бичиг үсэг, дижитал хэрэгслийн тусламжтайгаар тайлбарлах)
5. *Үр дүн, ахицыг тэмдэглэх:* Сурагч, эцэг эх, асран хамгаалагч, дэмжих төвийн багш нарын хамтын үнэлгээг хийж, сайжруулах, эргэн харах

- **Үнэлгээнд тохируулга хийх төрлүүд**

1. Даалгаврын хэлбэрийн тохируулга

- Аман хэлбэрээр асуух
- Зурагт даалгавар ашиглах
- Алхамчилсан, энгийн текст
- Сонголттой хариулт байх
- Бичвэр текстийг томруулах
- Аудио хэлбэрээр уншиж өгөх
- Дохионы хэлээр, видео /жишээ ашиглах

2. Цаг хугацааны тохируулга

- Хугацааг сунгах
- Үйл явдлыг гол гол хэсгээр нь хэсэгчилж үнэлэх
- Завсарлага өгөх

3. Орчны тохируулга

- Дуу чимээ багатай, тайван намуун орчин бүрдүүлэх
- Туслах хэрэгсэл ашиглах (компьютер, томруулдаг шил, линз, том товчлууртай төхөөрөмж...)

- **Хөгжлийн бэрхшээлийн төрлөөр тохируулга хийх арга зүй**

1. Аутизмтай хүүхэд

- Визуал даалгавар (зурагт сонголт)
- Богино хэсгээр үнэлэх
- Өдрийн бүтэц ойлгомжтой байлгах
- Танил асуултын загвар ашиглах
- Социал стресс багатай орчин
- Зан үйл зохицууллын төлөвлөгөөтэй уялдуулах

2. Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд

- Хялбаршуулсан үг, нэг ойлголт нэг өгүүлбэр
- Алхамчилсан үнэлгээ
- Жишээ → даалгавар → бататгал хэлбэр
- Ахицын хувь хэмжээг үнэлэх (baseline – progress monitoring)

3. Харааны бэрхшээлтэй хүүхэд

- Том үсэг, өндөр контраст
- Аудио үнэлгээ
- Брайль хувилбар бий болгох
- Тактиль материал ашиглах

4. Сонсголын бэрхшээлтэй хүүхэд

- Хадмалтай видео
- Бичмэл заавар
- Дохио хэлний багшаар дэмжүүлэх
- Богино өгүүлбэртэй текст

5. Хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэд

- Том товчлууртай төхөөрөмжөөр хариулах
- Бичих даалгаврын оронд аман хариулт эсвэл сонголттой карт
- Цаг сунгах

Үнэлгээнд тохируулга хийсэн жишээг танилцуулья.

Жишээ 1. Аутизмтай хүүхдэд математикийн хичээлийн тоо таних үнэлгээ хийх

Зорилго: 1–10 хүртэл тоо таних

Энгийн үнэлгээ: “Энэ ямар тоо вэ?” гэж асуух

Тохируулга хийсэн үнэлгээ:

- Сурагч ярилцаж хариулахгүй тул зурагт карт байрлуулна
- Хавсаргасан дөрвөн тоон картнаас зөв тоог зааж сонгох
- Үргэлжлэх хугацаа: 5 минутаас хэтрэхгүй
- Зорилго өөрчлөгдөхгүй, харин тооны хариу илэрхийлэх арга өөрчлөгдөнө.

Жишээ 2. Оюуны хөгжлийн бэрхшээлтэй сурагчид унших чадварын үнэлгээ

Зорилго: 3 үгээс бүрдсэн өгүүлбэр унших

Тохируулга:

- Өгүүлбэрийг том үсгээр, нэг мөрөнд байрлуулах
- Танил үгийн сан ашиглах
- Сурагч өгүүлбэрийг уншиж дуусаад өгүүлбэрийн утгыг зурагтай хослуулах даалгавар өгөх
- Хэрэв унших боломжгүй бол сонсож ойлгох үнэлгээнд шилжих

Жишээ 3. Харааны бэрхшээлтэй сурагчийн байгалийн ухааны хичээлийн үнэлгээ

Зорилго: “Өвсөн идэшт амьтан” сэдвийг ойлгох, харилцан ярилцах

Тохируулга:

- Амьтдын тактиль зураг (рельеф зураг) бэлтгэх
- Аудио тайлбар ашиглах
- Сурагч амьтны баримлыг тэмтрээд зөв ангилалд байрлуулах

Жишээ 4. Сонсголын бэрхшээлтэй сурагчийн нийгмийн ухааны хичээлийн үнэлгээ

Зорилго: Дүрэм журам ойлгох

Тохируулга:

- Хадмал бичвэр бүхий богино видео
- Үндсэн ойлголтыг дүрс, схемээр тайлбарлах
- Багш дохио хэл/бичмэл тайлбар хэрэглэх

Жишээ 5. Хөдөлгөөний бэрхшээлтэй сурагчийн бичих чадварын үнэлгээ

Зорилго: Өөрийгөө танилцуулах 3 өгүүлбэр бичих

Тохируулга:

- Том товчлууртай гар, эсвэл дижитал бичлэгээр хариулт өгөх
- “Аман ярилцлага” → багш бичгээр тэмдэглэх
- Сурагчийн бүтээлч илэрхийлэл алдагдахгүй, зөвхөн арга нь өөрчлөгдөнө... гэх мэт.

Үнэлгээнд тохируулга хийж, сурагчийн өдөр тутмын үйл ажиллагааг ажиглаж, тогтмол тэмдэглэл хөтлөх нь сурагчийн сургалтын хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжүүлэлтийг хянаж, сайжруулалтыг хийхэд чухал байдаг.

Аутизм, аутизмын хүрээний эмгэгтэй суралцагчийн сургалтын хөтөлбөрт тохируулга хийх арга зүйн жишээ (ерөнхий)

Ерөнхий мэдээлэл: Аутизмтай (эсвэл аутизмын хүрээний эмгэгтэй – АХЭ) суралцагчийн сургалтын хөтөлбөрт тохируулга хийх арга зүй нь тухайн суралцагчийн харилцаа, нийгмийн ур чадвар, анхаарал төвлөрөл, мэдрэхүйн онцлог зэрэгт нийцүүлэн боловсролын үйл явцыг өөрчилж, дэмжихэд чиглэнэ.

Жишээ: Суралцагч “В”, эмэгтэй, ерөнхий боловсролын сургуулийн 5 дугаар анги, эрүүл мэндийн байдал: Аутизмын хүрээний эмгэгтэй F84 (СЭМҮТ) оноштой. Тухайн суралцагчийн хувьд хөгжлийн ерөнхий зураглал нь дараах байдалтай байна.

Суралцагчийн төлөв байдал

- Оюун ухааны индекс IQ 65 (хэл яриа, оюун ухааны чадавхи 51, үйл хөдлөл, зан төлөвийн оюуны чадавхи 100)
- Бичиг уншиж ойлгох, үргэлжилсэн урт яриаг ойлгохдоо муу, үг, 2-3 үгээр ярьдаг, өөрийгөө илэрхийлэх чадвар сул
- Зохион бичлэг хийх чадваргүй
- Үсэг хуулан бичих, зураг зурахдаа маш сайн
- Ихэнхдээ өөрийнхөө ертөнцөд байгаа мэт харагдах бөгөөд хүнтэй харилцахдаа тааруу
- Хооллох зуршил нэг хэвийн (гоймон иддэг)
- Зарим тохиолдолд гэнэт уурлан сонин дуу авиа гаргах, этгээд үйлдэл гаргадаг
- Ангийнхан нь дээрэлхэж үл тоомсорлодог

Ар гэрийн байдал:

- Аав, ээж, эмээ, өвөө 2 дүүгийн хамт амьдардаг. Ам бүл 7
- Эрэгтэй, эмэгтэй дүү нар нь эгчтэй харилцах, тоглох дургүй
- Эмээ, өвөө нь охины гаргаж буй үйлдлийн талаар үргэлж ээжид нь гомдол хэлдэг. /Бэрхшээлийн талаар мэдлэг дутмаг/
- Аав нь хүүгээ өсгөхөд огт оролцдоггүй ээж нь ядардаг.

Сургууль дээрх байдал:

- Ангийн багш нь суралцагчийн бэрхшээлтэй холбоотой ойлголт муу, үр дүнтэй дэмжлэг үзүүлж чадахгүй байгаа.
- Сургуулийн зүгээс ганцаарчилсан дэмжлэг үзүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх санал тавьсан ч ар гэрийнхэн нь татгалзсан.

Энэхүү суралцагчийн хувьд аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдэд тохиолддог дараах нийтлэг шинжүүд байна гэж үзэх магадлал өндөр байгаа тул сургалтын хөтөлбөрт тохируулга хийж үзье.

Хүснэгт 5. Ажтизмын хүрээний эмгэгтэй сурагчийн хөтөлбөрийн тохируулгын жишээ

№	Хөгжлийн хүрээ	Онцлог шинж	Гарч буй ахицын тэмдэглэлийг бичнэ.
1	Харилцаа	Хэл яриа хөгжлийн хоцрогдолтой, аман бус харилцаа давамгайлсан, зурагт карт, видео контент үзэх сонирхолтой.	Харилцаанд орох үйл бага багаар нэмэгдэж байна. Ялангуяа тоглох явцад үг хэлэх, өөрийгөө илэрхийлэхийг оролдож байна гэх мэт
2	Нийгмийн ур чадвар	Гэр бүл, ангийн найз нөхөдтэйгээ харилцах, дүрэм, дэг мөрдөх, өөрийн ээлж дарааллыг хүлээхэд хүндрэлтэй.	
3	Хувийн сонирхол, зан үйл	Давтагдмал, хэвшмэл хөдөлгөөн, хэт эмзэг сонирхол	
4	Мэдрэхүйн боловсрол	Хэт мэдрэмтгий эсвэл мэдрэхүйн саатал (дуу чимээ, гэрэл, амт, үнэрт их эмзэг)	

Сургалтын хөтөлбөрт тохируулга хийхэд дараах бүрдэл хэсгийг цогцоор нь харгалзан үзнэ. Сургалтын хөтөлбөрт аутизмтай суралцагчийн хэрэгцээ, сурах арга барилын онцлогт тулгуурласан агуулга, арга зүйн тохируулга хийх. Үүнд дараах чиглэлээр дэмжлэг үзүүлэхэд анхаарна.

- Харилцаа, нийгмийн ур чадвар, танин мэдэхүйг дэмжих
- Мэдрэхүйн тэнцвэртэй орчин бүрдүүлэх

Сургалтын хөтөлбөрт тохируулга хийх чиглэлүүд

1. Агуулгын тохируулга
 - Товч, тодорхой, ойлгомжтой мэдээлэл өгөх
 - Нэг удаа нэг даалгавар өгөх (алхамчилсан байдлаар)
 - Давтагдсан хичээл, дүрсжүүлсэн мэдээлэл ашиглах
2. Сургалтын арга зүйн тохируулга
 - Визуал (харааны) дэмжлэгтэй заах→ Зураг, пиктограм, видео, схем ашиглах
 - Шагналын систем, хүлээлт тодорхой байх
 - Эерэг аргаар чиглүүлэх, "үйлдэл"-д суурилсан заавар
3. Харилцааны дэмжлэг

- Хэл ярианы хөгжлийн түвшинд тааруулж:→ Дохионы хэл, зурагт карт, PECS (Picture Exchange Communication System) систем
 - Сэтгэл хөдлөлийг таних самбар, нүүрний зураг ашиглах
4. Нийгмийн ур чадварын сургалт
 - Тоглоом, дүрд тоглох
 - Амьдралын “түүх” ашиглан (жишээ: “Хэрхэн найзтайгаа тоглох вэ?”)
 - "Сайн зан авир"-ыг давтан сургах
 5. Хугацааны тохируулга
 - Богино хугацааны хичээл, давтамжтай амралт
 - Албадлагагүй сайн дурын оролцоонд суурилсан хичээл
 6. Сургалтын орчны тохируулга
 - Тайван, дуу чимээгүй орчин (магадгүй тайвшруулах тусгай орчин) бүрдүүлэх
 - Хэт хурц гэрэл, дуу чимээг багасгах
 - Таних тэмдэг бүхий зурагт самбар, ГСТ

Хүснэгт 6. Жишээ тохируулга (1-р ангийн математикийн хичээл)

Сургалтын хөтөлбөр	Тохируулсан хөтөлбөр
10 хүртэлх тоо тоолох	Тооны зураг, дүн тавих хүснэгт ашиглах
Бодолтыг бичгээр хийх	Модел, тооны шоо, дүрс ашиглах
Багаар ажиллах	1:1 багштай ажиллах, эсвэл хосоор ажиллах
Аман бус даалгавар	Сонгох тест, зураг тэмдэглэгээний даалгавар

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ) боловсруулах

Аутизмтай суралцагчид дараах агуулгатай ГСТ боловсруулна:

- Богино, урт хугацааны зорилго
- Ойлгомжтой, хэмжигдэхүйц чадварын үзүүлэлтүүд
- Хөтөлбөрийн ямар хэсэгт тохируулга хийхийг сонгох (агуулга, арга зүй, орчин, хэрэглэгдэхүүн, үнэлгээ)
- Дэмжлэг үзүүлэх багш, эцэг эхийн үүргийг тодорхойлох

Үнэлгээний тохируулга

- Уламжлалт тест биш, ажиглалт, бүтээлч ажлуудыг ашиглах
- Видео бичлэг, фото тайлан ашиглах
- Өөрийнхөө амжилтыг таньж мэдэх өөрийгөө үнэлэх самбарт тэмдэглэх

Хэрэгтэй арга, нөөцүүд

- TEACCH арга зүй: бүтэцтэй орчин, харааны дэмжлэг
- PECS (Picture Exchange Communication System): зураг ашиглан харилцах
- Social Stories (Carol Gray): нийгмийн дүрмийг тайлбарласан зүйл

Анхаарах зүйлс

- Аутизм “эмгэг” биш, харин хөгжлийн онцлог гэдгийг хүндэтгэх
- Тохируулга нь тусгаарлах биш, оролцоог нэмэгдүүлэх зорилготой
- Суралцагчийн чадварыг онцолж, түүгээр дамжуулан сургалтыг төлөвлөх

Багшид өгөх зөвлөмж: Аутизмтай хүүхдэд зориулсан сургалтын хөтөлбөрийг тохируулахдаа тухайн суралцагчийн онцлог, хөгжлийн түвшин, сурах арга барилын онцлогт нийцүүлэн хандлага, аргачлал, орчны зохион байгуулалтад өөрчлөлт оруулах шаардлагатай байдгийг анхаарна.

Тэгш хамруулан сургах боловсрол нь багш бэлтгэх асуудалд анхаарал хандуулдаг.

Багш нар суралцагчдад хандах арга барил, ашигладаг сургалтын хэрэглэгдэхүүн, арга зүй, суралцагчийн харилцан адилгүй байдлыг хүлээн авч, үүнийг давуу тал хэмээн харах чадвар, тулгарч буй сорилт, бэрхшээл, суралцагчийн харилцан адилгүй сурах хэрэгцээнд дасан зохицон, эерэг хандах чадавхи зэргээрээ тэгш хамруулан сургах боловсролын үйл явцад чухал үүрэг гүйцэтгэдэг. Багш боловсролоор тэгш хамруулан сургах чадвартай багш нарыг бэлтгэх нь ихээхэн чухал бөгөөд зөвхөн тэгш хамруулан сургах боловсролын онолыг заагаад зогсохгүй боловсролын хүртээмж, оролцоо, сурахад тулгарч буй саад бэрхшээлийг олж тогтоох, эргэцүүлэн бодох чадвартай, бүтээлч сэтгэлгээтэй, асуудал шийдвэрлэх чадвартай, суралцагчид эрх тэгш хандах зэрэг практик чадварыг эзэмшүүлэх нь чухал байдаг.

Тэгш хамруулан сургах боловсрол эзэмшүүлэх нь оюутан-багш нарын заах арга зүйг сайжруулах, тэдний үүргийг илүү тодорхой болгох, багш нарыг сургалтын хөтөлбөр боловсруулах чадвартай болгох асуудал тул оюутан-багшийн үүрэг, хандлага, чадамжийг нарийвчлан үздэг туршлага байна.Тэгш хамруулан сургах боловсролыг хэрэгжүүлэгч багш нь суралцагчийн сурах, сургах үйлийг дэмжиж, нийгэм, соёлын янз бүрийн нөхцөлд байгаа суралцагчийн онцлог, сурах арга барилын ялгаатай байдал, харилцан адилгүй хэрэгцээг зөв үнэлж, боловсролын үйлчилгээг чанартай үзүүлэхэд анхаарч ажилладаг. Үүнд:

- Суралцагчийн суралцах боломжийг бүрдүүлсэн уян хатан хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх;
- Багшид ажиллах арга барилаа сонгох боломж олгох;
- Практик үйл ажиллагаандаа туслалцаа авах боломжоор багш нарыг хангах;
- Мэргэжлийн баримжаа олгох сургалтыг онцгойлон авч үзэх гэх мэт асуудлыг онцгойлон авч үздэг.

ГУРАВ. СУДЛАГДАХУУНЫ ХӨТӨЛБӨРТ ТОХИРУУЛГА ХИЙХ АРГА ЗҮЙН САНАА

СУДЛАГДАХУУНЫ НЭР: МОНГОЛ ХЭЛ

II АНГИ

Суралцагч бүрд адил тэгш боломж бүрдүүлэхийн тулд тэдний ялгаатай хэрэгцээг харгалзан тухайн хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээнд тулгуурлан сургалтын хөтөлбөрийн агуулгад нийцсэн арга зүй, сургалтын орчин хэрэглэгдэхүүнд тохируулга хийлээ. Энэ нь суралцагчдад хүртээмжтэй, чанартай боловсрол олгох нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

Энэхүү зөвлөмжид ЕБС-ийн 2-р ангийн Монгол хэлний сургалтын хөтөлбөрийн уншиж ойлгох чадварын “2.2в. Уншсан үлгэр, ёгт үлгэр, өгүүллэгийн сургамж, ёс суртахууныг ойлгож, үйл явдлыг дарааллаар нь тоочин ярьдаг болно” суралцахуйн үр дүнг суралцахуйн бэрхшээлтэй тэр дундаа дислексиа буюу уншиж ойлгох чадварын хөгжлийн хоцрогдолтой суралцагчидтай ажиллахдаа (СТЗ) суралцахуйн түгээмэл загварын дагуу хэрхэн тохируулга хийх боломжийг тусгаж байна.

Ямар арга зүйгээр хэрэгжүүлэх вэ?

2-р ангийн монгол хэлний судлагдахууны “2.2в” суралцахуйн үр дүнд тохируулга хийхдээ Суралцахуйн түгээмэл загвар (СТЗ)-ын гурван үндсэн зарчимд тулгуурлан боловсруулж байна. Суралцахуйн түгээмэл загвар нь хүүхэд бүрд тохирсон нэг арга бус, олон арга зам, хэлбэртэй, хүртээмжтэй сургалтын орчныг бий болгодог суралцахуйн загвар юм.

СТЗ-ыг монгол хэлний сургалтад нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага: Уншаад ойлгох чадварын түвшин ялгаа харилцан адилгүй сурагчид, хэлний хөгжил хожуу эхэлсэн, хоёр дахь хэлээр суралцагч казах, тува хүүхдүүд, анхаарлын бэрхшээл, унших бэрхшээл, ялгаатай танин мэдэхүйн хэв шинжтэй гэх мэт хүүхдүүдтэй багш ижил арга зүй, арга барилаар ажиллахад хүндрэлтэй байдаг. Иймд суралцахуйн түгээмэл загвар нь

1. Унших эхийг олон янзын хэлбэрээр сонирхолтой байдлаар өгөх
2. Оновчтой олон төрлийн дасгал даалгавраар суралцах идэвх сонирхлын татах
3. Ойлгосноо олон хэлбэрээр илэрхийлэх боломж олгох

гэсэн гурван зарчимд тулгуурласнаар хүүхдийн танин мэдэхүйн түвшин, чадвар, суралцах арга барилын ялгаатай байдлыг харгалзан арга зүй, орчин, хэрэглэгдэхүүнд өөрчлөлт оруулж, дэмжлэг үзүүлснээр хүүхэд бүрд тэгш боломж олгож хичээлийг илүү хүртээмжтэй, тэдний оролцоог тэгш, бүрэн хангасан хэлбэрээр заах боломж бүрддэг. Мөн суралцахуйн үйл ажиллагаанд Orton–Gillingham арга зүй буюу унших бэрхшээлтэй сурагчдын унших, бичих чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн олон мэдрэхүйн оролцоонд суурилсан шаталсан алхамтай сургалтын арга зүйг тусгалаа.

Уншихын бэрхшээл (дислексиа)-тэй хүүхдийн онцлог

Уншихын бэрхшээл нь уураг тархины төвийн хэсэг дэх яриа ба бичгийн хэлний үйл ажиллагааны өөрчлөлтөөс үүсэлтэй хамгийн түгээмэл бэрхшээл юм. Юмс үзэгдлийн талаарх төсөөллийг илүү цогц бүхэл байдлаар хүртдэг онцлогтой. Ихэвчлэн үг, өгүүлбэр унших чадвар сул, удаавтар уншдаг. Үйл явдлын дараалал, холбоосыг сэргээн санах, гол санааг ойлгох дүгнэх чадвар болон ойлгосноо илэрхийлэх зэрэг танин мэдэхүйн чадвар сул байдаг.

Ийм онцлогоос шалтгаалан тэдний уншиж ойлгох чадварт хоцрогдол бий болж, зөвхөн монгол хэлний хичээл бус бусад хичээл дээр мэдээллийг уншиж ойлгох, даалгавар гүйцэтгэхэд хүндрэлтэй болдог. Улмаар хичээлд идэвхгүй болж, өөрийгөө бусдаас муу гэж мэдрэх, өөртөө итгэх итгэл алдагдагдах, цаашдын суралцах урам зориг суларлах зэрэг сөрөг нөлөөтэй.

Хүснэгт 1. Уншихын бэрхшээлтэй сурагчдын онцлогт 2.2в. суралцахуйн үр дүнг тохируулга хийх хэрэгцээ, шаардлага

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн онцлог	Суралцахуйн үр дүнг хэрэгжүүлэхэд тулгарах хүндрэлүүд	Суралцахуйн түгээмэл загварын зарчмыг тусгах нь
“2.2в. Уншсан үлгэр, ёгт үлгэр, өгүүллэгийн сургамж, ёс суртахууныг ойлгож, үйл явдлыг дарааллаар нь тоочин ярьдаг болно”	Сурагчийн танин мэдэхүйн хөгжлийн хамгийн чухал хэсэг болох уншиж ойлгох суурь чадварыг төлөвшүүлэх зорилготой бөгөөд уншиж ойлгох нь зөвхөн үг, өгүүлбэр, эхийг уншихаас гадна гол утга санааг ойлгож, олж авсан туршлагаа бусадтай харилцах явцдаа хэрэглэх танин мэдэхүйн чухал чадамж юм.	<ul style="list-style-type: none"> - Үйл явдлыг дарааллыг алдагдуулж эхлэл, гол, төгсгөл хэсгийн байрыг солих, зарим хэсгийг алгасаж орхигдуулж ярих, илэрхийлэх - Эхийг ерөнхийд гүйлгэн унших боловч эхийн гол санаа, сургамжийг ойлгох, ялган танихад хүндрэл бэрхшээл үүсэх - Уншаад ойлгосноо илэрхийлэхдээ оновчтой үг хэллэг сонгож чадахгүй байх, өгүүлбэр бүтцийг алдагдуулж ярих - Эхийн гол санаанд төвлөрөхгүй, бусад жижиг хэсгүүдэд анхаарснаас гол үйл явдлаас төөрөх гэх мэт. 	<ul style="list-style-type: none"> - Зарчим 1: Унших материалыг олон хэлбэрээр өгснөөр хүүхэд үйл явдлын дараалал, гол санааг олон арга замаар дамжуулж ойлгох - Зарчим 2. Хүүхэд өөрийн сонирхол, боломжид тохирсон даалгаварт чиглүүлж сурах идэвх сонирхлыг татах - Зарчим 3: Уншиж ойлгосноо олон хэлбэрээр илэрхийлэх боломж олгох

Тохируулга хийснээр ямар үр дүнд хүрэх вэ?

Суралцахуйн ялгаатай хэрэгцээтэй хүүхэд бүрийн уншиж ойлгох суурь чадварыг хөгжүүлэх, сургалтын чанарыг тэгш хүртээмжтэй болгох ач холбогдолтой. Энэ нь

сурагчдын зөвхөн унших чадварыг дэмжихээс гадна тэдний танин мэдэхүй, сэтгэн бодох, өөрийгөө илэрхийлэх болон суралцахуйн урам зоригийг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ.

Харин дислекситэй суралцагч энэ тохируулгаар хичээллэснээр уншсан эхийн гол санаа, сургамжийг тодорхойлох, үйл явдлын дарааллыг зөв тогтоох, ойлгосноо аман болон бичгийн хэлбэрээр илэрхийлэх зэрэг чадамжийг нэмэгдүүлэх, улмаар монгол хэлний хичээл төдийгүй бусад хичээлийг ойлгох, даалгавар гүйцэтгэх, бүтээлчээр оролцох зэрэг ахиц дэвшилд хүргэхийг зорьж байна.

ХОЁР. ҮНДСЭН ХЭСЭГ

2-р ангийн унших чадварын “2.2в. Уншсан үлгэр, ёгт үлгэр, өгүүллэгийн сургамж, ёс суртахууныг ойлгож, үйл явдлыг дарааллаар нь тоочин ярьдаг болно” гэсэн суралцахуйн үр дүнд ялгаатай хэрэгцээтэй суралцахуйн дислекси бэрхшээлтэй сурагчийн онцлог, хэрэгцээнд суурилан арга зүй, сургалтын орчин, хэрэглэгдэхүүнд дэмжлэг үзүүлнэ. Суралцахуйн түгээмэл загварын “Яагаад сурах вэ?”, “Юуг сурах вэ?”, “Хэрхэн сурах вэ?” гэсэн гурван зарчимд тулгуурлана.

Нэгж хичээлийн төлөвлөлт

Зорилго: Сурагч үлгэрийн сургамж санааг ойлгож, үйл явдлыг дарааллаар нь тоочин ярьдаг болно.

Хүснэгт 2: Нэгж хичээлийн төлөвлөлт

№	Суралцахуйн үр дүн	Ээлжит хичээлийн сэдэв	Хугацаа	Ээлжит хичээлийн үйл ажиллагааны чиглэл	СТЗ–ын зарчим тусгасан үйл ажиллагаа
1	“2.2в. Уншсан үлгэр, ёгт үлгэр, өгүүллэгийн сургамж, ёс суртахууныг ойлгож, үйл явдлыг дарааллаар нь тоочин ярьдаг болно”	“Торх” өгүүллэгийг уншиж ойлгоё	40 мин	<ul style="list-style-type: none"> - Үлгэрийг уншиж ойлгох - Энгийн асуултад хариулан ярилцах - Ямар ямар дүр гарч байгааг тоочих, - Эхэд юуны тухай өгүүлсэн болохыг ярилцах 	<ul style="list-style-type: none"> - Танил биш үгсийг зураг, бичлэг, биеийн хөдөлгөөнөөр дүрслэн харуулах зэргээр олон хэлбэрээр утгыг тайлбарлах; - Эхийг унших, аудио бичлэгээр сонсох, дүрс бичлэгийг үзэх, - Зургийг хараад ярилцах
2	“2.2в. Уншсан үлгэр, ёгт үлгэр, өгүүллэгийн сургамж, ёс суртахууныг ойлгож, үйл явдлыг дарааллаар нь тоочин ярьдаг болно”	“Торх” өгүүллэгийн үйл явдлын дарааллыг тоочъё	40 мин	<ul style="list-style-type: none"> - Үлгэрийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг зааглаж, төгсгөлийг ярилцах, 	<ul style="list-style-type: none"> - Цуврал зурагт тулгуурлан үйл явдлын дарааллыг тогтоох, байрлуулах; - Эхийг үйл явдалтай зөв тохируулах, хөдөлгөөнөөр дүрслэх

					<ul style="list-style-type: none"> - Эхийн бүтцийг хэсгийг хосоор, багаар ярилцах - Санаагаа илэрхийлэх, бусдын санааг сонсож өөрийн санааг нэмэх
2		“Торх” өгүүллэгийн дүрийн зан чанар, сургамжийг ярилцъя.	40 мин	<ul style="list-style-type: none"> - Дүрийн зан чанарыг харьцуулан дүгнэх - Дүрүүдийн зан чанараас авах сургамжийг хэлэлцэх 	<ul style="list-style-type: none"> - Өгүүллэгийн үйл явдлын зураглал (Story map) бүтээх; - Дүрд тоглох; - Дүрийн зан чанар, сургамжийн талаар зургаар, бичгээр болон аман байдлаар өөрийн үгээр тайлбарлах, санаа бодлоо илэрхийлэх

Ээлжит хичээлийн төлөвлөлт

Хичээлийн сэдэв 1: “Торх” өгүүллэгийг уншиж ойлгоё

Хичээлийн сэдэв 2: “Торх” өгүүллэгийн үйл явдлын дарааллыг тоочъё

Хичээлийн сэдэв 3: “Торх” өгүүллэгийн дүрийн зан чанар, сургамжийг ярилцъя.

Судлах хугацаа: 3 цаг

ТОРХ

Нэгэн хүү дүүрэн тостой торх гэртээ хүргэхээр өнхрүүлж явжээ. Өөд газар торхоо чүү ай өнхрүүлсээр хөтөл дээр гарч ирвэл гэр нь ойрхон харагдаж байв.

“Ингэж биеэ зовоож байхаар өөрийг нь явуулчихъя. Гэрийн гадаа төвөггүйхэн хүрчихнэ биз” гэж бодоод торхоо газрын уруу түлхчихжээ.

Том торх ойж бууж явсаар гэрээс бүр өнгөрч гүн жалганд тогтов. Хүү жалга дотроос торхоо гаргах гэж өдөржин ноцолдоод дийлсэнгүй гэнэ.

Зохиогч: Д.Давааням

Үгийн тоо: 66 үг

1. “ЯАГААД СУРАХ ВЭ?” БУЮУ ОРОЛЦООГ ДЭМЖИХ ҮЕ ШАТ

Энэ үе шатад сурагчийн суралцахуйг сэдэлжүүлэх, сургалтын үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулж сонирхол, урам зоригийг өдөөх, дасгал даалгавар, үйл ажиллагааг өөрөө хийж гүйцэтгэх дуртай, хүсэл эрмэлзэлтэй болгоход чиглэнэ.

Тохируулга:

Алхам 1: Сэдэлжүүлэх, сонирхлыг төрүүлэх

- Эхийг уншихын өмнө дүрийн зураг болон эхийн үйл явдлын талаар богино видео үзүүлэх
- “Торх” өгүүллэгийн талаар хүүхдийн амьдралд ойр асуулт асуух
 - Чи хүнд зүйл түлхэж байсан уу?
 - Чи өргөж байсан хамгийн хүнд зүйл юу байсан бэ?
 - Чи яаж өргөж байсан бэ? Ямар арга хэрэглэсэн бэ?
 - Аливааг хялбарчилж, амархан байдлаар хийхийг хүсч байсан уу? гэх мэт

Алхам 2: Суралцах хэв маягт тохирсон сонголт өгөх

- Сонголт 1: Цуврал зургийг хараад үйл явдлыг тайлбарлаж ярих
- Сонголт 2: Эхийг багштай хамт унших
- Сонголт 3: Эхийг аудиогоор сонсох
- Сонголт 4: Үе тэнгийн дэмжлэгт тулгуурлах буюу хамтдаа хосоор ажиллуулж “үе тэнгийн багшлах арга” ашиглах

Алхам 3. Сурагчдад эхийг тарааж өгөн утгыг мэдэхгүй танил биш үгийн доогуур зуруулна. Сурагч танил биш үгийг олуулах нь давтан уншилтын нэг арга юм. Их бичвэр текст хараад унших дургүй залхдаг сурагчийн унших ачааллыг багасгах үүднээс эхийг эхлэл, гол, төгсгөл хэсгийг хэсэгчлэн өгч уншуулж болно. Торх эх 66 үгтэй. Эхлэл хэсэгт 24 үг, гол хэсэг 18 үг, төгсгөл хэсэг 21 үгтэй тул хүүхдэд сэтгэл зүйн хувьд амархан, хөнгөн санагдана.

2. “ЮУГ СУРАХ ВЭ?” БУЮУ АГУУЛГЫГ ОЛОН ХЭЛБЭРЭЭР ХҮРГЭХ ҮЕ ШАТ

Энэ үе шатад сурагч эхийг зөвхөн уншаад ойлгохгүй байлаа ч өөр хэлбэрээр ойлгох боломжтой болно. Иймд нэг эхийг арга зүйн хувьд үсгийн хэмжээг томруулах, үеэр зааглах, зурагтай өгөх зэрэг тохируулга хийх, хэлбэрийн хувьд бичвэр, зураг, видео зэрэг олон хэлбэрийг санал болгох хэрэгтэй. Мөн арга зүйн хувьд аль болох олон мэдэрхүйн оролцоог чухалчлах нь илүү үр дүнтэй.

Алхам 1. Үгийн утгыг тайлбарлахдаа харах үзэх, ярих, биеийн хөдөлгөөнөөр илэрхийлэх, дуу авиаг сонсох зэрэг олон мэдрэхүйн арга хэрэглэх


- Үгийн утгын тайлбарыг зургаар үзүүлж, тайлбарлах
- Үйл хөдлөл заасан үгсийг видео хэлбэрээр харуулах
- Хөдөлгөөн илэрхийлсэн үгсийг биеэр хийж үзүүлэх
- Дуу авиагаар илэрхийлэх боломжтой үгийн утгыг сонсгож болно. Жишээ нь: шуурга, бороо, чоно улих, шаазгай шагшрах гэх мэт

Тайлбар: Сурагч эхийг уншихаас өмнө багш тэдний хувьд танил биш үгийн утгыг зургаар болон карт хэлбэрээр үзүүлж тайлбарлан утгыг ойлгоход дэмжлэг үзүүлнэ. Ингэхдээ сурагчдын хувьд утгыг мэдэхгүй үгийг багш урьдчилан бэлтгэсэн байх ба эхэд байгаа энгийн үгээс эхлэн утгын хувьд хүнд ямар ч үг байж болох тул боломжит хувилбарыг тооцож бэлтгэнэ.

Үгийн утгыг зургаар болон видео бичлэг зэрэг харах, сонсох хүртэхүйгээр дамжуулан ойлгуулах, зарим тохиолдолд бодит үзүүлэн хэрэглэгдэхүүн хэрэглэн барьж, хүртэж мэдрэх нь сурагчдад хамгийн сайн ойлголтыг өгдөг.



- **ТОРХ**
Шингэн зүйл
агуулах
томоохон
модон сав



- **ХӨТӨЛ**
өндөр уул
давааны
орой



- **ЖАЛГА**
цас, борооны
ус урсаж
тогтсон
хонхор газар



- **ӨӨД ГАЗАР**
уул, газрын
орой, дээш,
дээшээ гарах

- **чүү ай** (маш хэцүү гэсэн утгатайг тайлбарлах)
- **ноцолдоод** (хөдөлгөөнөөр үзүүлэх)
- **төвөггүйхэн** (амархан)

Алхам 2. Эхийг сурагчийн онцлогт тохируулан ганц хэлбэрээр бус олон хувилбараар өгөх

Сурагчдад уншихад дэмжлэг үзүүлэх зорилгоор үсгийн хэмжээ том, үеийг өнгөөр ялгасан эх ашиглах нь олон давуу талтай. Унших сонирхолгүй хүүхэд жижиг бичвэртэй эхээс илүү том бичвэртэй, том үсэгтэй эх, том ном, зураг ихтэй бичвэр багатай ном зэргийг илүү унших сонирхолтой байдаг. Мөн сурагчдын түвшнээс хамааран уншиж ойлгоход дэмжсэн арга зүйг тусгасан унших эхийг бэлтгэсэн байна. Ингэхдээ үе, үг, холбоо үг, өгүүлбэрийг зөв холбон уншихад чиглүүлнэ.

Эхийг үеийн аргаар уншуулахын тулд 2-оос дээш үетэй үг бүрийг өөр өөр өнгөөр будаж ялгасан байна. Мөн унших үйл төлөвших үед бага ангийн сурагчдад том үсэгтэй байх унших сэдэл, дадалд эерэг нөлөөтэй тул үсгийн хэмжээ том байх нь давуу талтай.

Хэрэглэгдэхүүн 1:

ТОРХ

Нэгэн хүү дүүрэн тостой торх гэртээ хүргэхээр өнхрүүлж явжээ. Өөд газар торхоо чүү ай өнхрүүлсээр хөтөл дээр гарч ирвэл гэр нь ойрхон харагдаж байв.

“Ингэж биеэ зовоож байхаар өөрийг нь явуулчихъя. Гэрийн гадаа төвөггүйхэн хүрчихнэ биз” гэж бодоод торхоо газрын уруу түлхчихжээ.

Том торх ойж бууж явсаар гэрээс бүр өнгөрч гүн жалганд тогтов. Хүү жалга дотроос торхоо гаргах гэж өдөржин ноцолдоод дийлсэнгүй гэнэ.

Хэрэглэгдэхүүн 2:

ТОРХ

Нэгэн хүү дүүрэн тостой торх гэртээ хүргэхээр өнхрүүлж явжээ. Өөд газар торхоо чүү ай өнхрүүлсээр хөтөл дээр гарч ирвэл гэр нь ойрхон харагдаж байв.



“Ингэж биеэ зовоож байхаар өөрийг нь явуулчихъя. Гэрийн гадаа төвөггүйхэн хүрчихнэ биз” гэж бодоод торхоо газрын уруу түлхчихжээ.



Том торх ойж бууж явсаар гэрээс бүр өнгөрч гүн жалганд тогтов. Хүү жалга дотроос торхоо гаргах гэж өдөржин ноцолдоод дийлсэнгүй гэнэ.

Зөвхөн 3-аас дээш үетэй хүндэвтэр үгийг уншихад дэмжлэг болгох үүднээс үеэр зааглаж өгнө. Мөн эхийн үйл явдлыг харуулсан зураг нь сурагчдын бодит үйлийн сэтгэхүйг дэмжиж, ойлгоход чухал нөлөө үзүүлдэг тул аль болох цуврал зурагтай эхийг сонгох хэрэгтэй.

Алхам 3. Эхийн гол санааг ойлгох энгийн асуултад хариулан ярилцана.

- Эхэд юу, юу гарч байна вэ?
- Эхэд дүр хэн байна вэ?
- Хүү юу хийж явсан бэ?
- Торхонд юу байсан бэ?
- Эхийн үйл явдал хаана, хэзээ болж байна вэ?
- Хүү хаашаа явж байсан бэ?
- “Ингэж биеэ зовоож байхаар өөрийг нь явуулчихъя” гэдэг нь хэр зөв санаа байсан бэ? Яагаад
- Торх яагаад жалганд унасан бэ?
- Хэрэв хүү торхоо түлхээгүй бол юу болох байсан бол? гэх мэт сэргээн санах, ойлгох түвшний энгийн асуултауд асууж, ярилцана.

Алхам 4. Эхийн үйл явдлыг цуврал зурагт тулгуурлан эхлэл, гол, төгсгөл хэсгийг дүрд тоглон хөдөлгөөнөөр илэрхийлэх, аудиогоор сонсгох, зурагт карттай холбох зэрэг хараа, сонсгол, хөдөлгөөний оролцоотой арга үр дүнтэй ойлгуулна. Жишээ нь:

- “**Торх өнхрүүлж**” гэсэн үгийг уншихдаа сурагчаар торхыг өнхрүүлж буй хөдөлгөөнийг гар болон биеэр хийлгэнэ.
- “**Ойж бууж явсаар**” гэсэн хэсгийг унших үед үсэрч буй, унаж буй зэргээр дүрд тоглон утгыг хөдөлгөөнөөр илэрхийлнэ.
- Торх, жалга зэрэг үгсийг бичүүлж, зуруулах, эсвэл бэлэн зургийг өгч будуулж болно.

Сонсож мэдрэх <i>(Багш унших эсвэл аудио хэлбэрээр сонсоно)</i>	Харж мэдрэх <i>(зураг эсвэл бичлэгээр үзэж болно)</i>	Хөдөлгөөнөөр илэрхийлэх <i>(дүрд тоглож илэрхийлнэ)</i>
Нэгэн хүү дүүрэн тостой торх гэртээ хүргэхээр өнхрүүлж явжээ. Өөд газар торхоо чүү ай өнхрүүлсээр хөтөл дээр гарч ирвэл гэр нь ойрхон харагдаж байв.	Хөтөл дээр гарч ирвэл гэр нь ойрхон харагдаж байв.	Өөд газар торхоо чүү ай өнхрүүлэх
“Ингэж биеэ зовоож байхаар өөрийг нь явуулчихъя. Гэрийн гадаа төвөггүйхэн хүрчихнэ биз” гэж бодоод торхоо газрын уруу түлхчихжээ		торхоо газрын уруу түлхчихжээ.

Том торх ойж бууж явсаар гэрээс бүр өнгөрч гүн жалганд тогтов.	гэрээс бүр өнгөрч гүн жалганд тогтов.	Том торх ойж бууж явсаар гэрээс бүр өнгөрч гүн жалганд тогтов.
Хүү жалга дотроос торхоо гаргах гэж өдөржин ноцолдоод дийлсэнгүй гэнэ. Энэ эхийн бичлэг байдаг уу? youtubr		Хүү жалга дотроос торхоо гаргах гэж өдөржин ноцолдоод дийлсэнгүй гэнэ.

Алхам 5. Үлгэрийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг зааглаж, төгсгөлийг ярилцана.

Уншихын бэрхшээлтэй сурагч үйл явдлыг дарааллыг алдагдуулж эхлэл, гол, төгсгөл хэсгийн байрыг солих, зарим хэсгийг алгасаж орхигдуулж ярих, илэрхийлэх зэрэг суралцах үйл ажиллагааны алдагдалтай тул 4,5,6 дугаар үйл ажиллагааны алхам чухал ач холбогдолтой юм.

- Эхийн үйл явдлын эхлэл, гол, төгсгөл хэсгийн утгыг ойлгуулахын тулд үйл явдал харуулсан цуврал зургийг ажиглуулна.
- Дараа нь зургийг зөв дараалуулна. Ингэхдээ дарааллыг дугаарлаж болно эсвэл зургийг өгч өөрсдөөр нь зөв байрлуулж болно.
- Дараалуулсан үйл явдлыг сурагч өөрийн үгээр бусдад ярьж өгнө. Зөв байрлуулсан тохиолдолд үйл явдал уялдаа зөв гарч ирнэ. Буруу байрлуулсан тохиолдолд үйл явдал уялдаагүй болох ба багш асуултаар чиглүүлнэ.



Алхам 6: Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг зөв байрлуулахын тулд сурагч давтан уншилт хийнэ. Энэ нь сурагч эхийн бүтцийн хэсгүүдийг таних болон бүтцийн хэсгүүдийг хооронд нь холбож агуулгыг ойлгоход чиглүүлнэ.

Том торх ойж бууж явсаар гэрээс бүр өнгөрч гүн жалганд тогтов. Хүү жалга дотроос торхоо гаргах гэж өдөржин ноцолдоод дийлсэнгүй гэнэ.

ТОРХ

Нэгэн хүү дүүрэн тостой торх гэртээ хүргэхээр өнхрүүлж явжээ. Өөд газар торхоо чүү ай өнхрүүлсээр хөтөл дээр гарч ирвэл гэр нь ойрхон харагдаж байв.

“Ингэж биеэ зовоож байхаар өөрийг нь явуулчихъя. Гэрийн гадаа төвөггүйхэн хүрчихнэ биз” гэж бодоод торхоо газрын уруу түлхчихжээ.

Алхам 7: Эхийн үйл явдлын цуврал зургийг зөв байрлуулах, эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг дугаарласны дараа эхийн бүтцийн хэсгүүдийг тохирох зурагтай холбох дасгал даалгавар хийлгэнэ. Энэ нь сурагч эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг бататгаж, эхийн агуулгыг ойлгоно.

Торх

Нэгэн хүү дүүрэн тостой торх гэртээ хүргэхээр өнхрүүлж явжээ. Өөд газар торхоо чүү ай өнхрүүлсээр хөтөл дээр гарч ирвэл гэр нь ойрхон харагдаж байв.



“Ингэж биеэ зовоож байхаар өөрийг нь явуулчихъя. Гэрийн гадаа төвөггүйхэн хүрчихнэ биз” гэж бодоод торхоо газрын уруу түлхчихжээ.




Том торх ойж бууж явсаар гэрээс бүр өнгөрч гүн жалганд тогтов. Хүү жалга дотроос торхоо гаргах гэж өдөржин ноцолдоод дийлсэнгүй гэнэ.



3. “ХЭРХЭН СУРАЛЦАХ ВЭ?” БУЮУ АГУУЛГЫ ОЙЛГОСНОО ОЛОН ХЭЛБЭРЭЭР ИЛЭРХИЙЛЭХ ҮЕ ШАТ

Сурагчдад эхийн гол санаа, дүрийн зан чанар, сургамжийг ойлгосноо өөрт тохирох олон төрлийн хэлбэрээр илэрхийлэх боломжийг олгох нь чухал юм.

Алхам 1: Эхийн гол санааг ойлгох, бататгахын тулд эхийн зураглал (story map) хийнэ.



Алхам 2: Дүрийн зан чанарыг тодорхойлох асуултууд асууж ярилцах

- Хүүгийн зан чанарыг ямар үгээр илэрхийлж болох вэ? (жишээ нь: хичээнгүй, тэвчээргүй, итгэмтгий, залхуу гэх мэт)
- Хүү яагаад торхоо түлхэх шийдвэр гаргасан бол?
- Энэ шийдвэр нь яагаад буруу байсан бэ?
- Торх жалганд орсны дараах хүүгийн сэтгэл ямар байсан бол?
- Хүүгийн алдаанаас чи юу ухаарсан бэ?
- Хүүгийн зан чанар өөрчлөгдөх боломжтой юу? Яагаад?

Алхам 3: Сургамжийг ойлгох ба өөрийн санаа бодлыг илэрхийлэх асуултууд асууж ярилцах

- Энэ өгүүллэг ямар сургамж өгөхийг хүссэн бэ?
- “Хялбар замаар явах” гэж юу гэсэн үг вэ?

- Аливаа ажлыг тэвчээртэй хийснээр ямар үр дүн гардаг вэ?
- Хэрвээ чи хүүгийн оронд байсан бол ямар шийдвэр гаргах байсан бэ?
- Өдөр тутмын амьдралдаа энэ сургамжийг хэрхэн тусгах вэ?

Тохируулга хийхдээ:

Яриа, зураг, хөдөлгөөн, бичгийн олон хувилбар өгөх

- Үйл явдлын дарааллыг зурах
- Өгүүллийн зураглалыг янз бүрийн загвар хэлбэрээр хийх
- Цуврал зургийг зөв байрлуулж үйл явдал, сургамжийг ярих
- Богино видео бичлэг, хөдөлгөөнөөр үзүүлэх
- Багаар болон хосоор ярилцах
- Ярих агуулгыг чиглүүлсэн асуулт, загварыг өгөх

Гурав. Дүгнэлт, зөвлөмж

Дислексиа нь суралцагчийн унших, бичих, үг таних, авиаг ялган таних зэрэг чадварт нөлөөлж, цаашлаад өөртөө итгэх итгэл, суралцах урам зориг буурах шалтгаан болдог. Ийм онцлогтой суралцагчдын суралцахуйг дэмжихэд гэр бүл, багш, сургууль гурвын хамтын ажиллагаа хамгийн чухал бөгөөд энэ нь хүүхдийн танин мэдэхүй, сэтгэн бодох чадвар, өөрийгөө илэрхийлэх болон суралцах урам зоригийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болдог.

Багшид өгөх дэмжлэг ба зөвлөмж: Уншихын бэрхшээлтэй сурагчийг чиглүүлэх зааварчилгаа нь маш тодорхой, системтэй, дараалалтай байх шаардлагатай. Мөн олон мэдрэхүйн оролцооны арга зүй (Multisensory Approach)-ээр дамжуулан эхийн агуулгыг хараа, сонсгол, хүрэлцэхүй, хөдөлгөөнөөр дамжуулан ойлгуулах нь илүү үр дүнтэй. Ингэхдээ зураг, зурагт карт, видео бичлэг, бодит хэрэглэгдэхүүн зэргийг түлхүү ашиглана. Эхийн утгыг ойлгуулахын тулд үйл явдлыг биеийн хөдөлгөөнөөр илэрхийлэх нь тэдний бодит үйлийн сэтгэхүйг дэмжиж, агуулгыг ойлгоход ач холбогдолтой. Мөн хүүхдийг хэт ачаалахаас сэргийлж, унших эхийн агуулгыг эхлэл, гол, төгсгөл хэсгүүдэд хувааж, үйл ажиллагааг үе шаттай төлөвлөх нь чухал. Дасгал даалгаврыг сурагчдын нас, онцлог, хөгжлийн түвшин онцлогт тохируулан гүйцэтгэлийн хэлбэрийг өөрчлөж болно. Ингэхдээ сурагчдыг хосоор болон бүлгээр ажиллуулж, бие биедээ харилцан туслах, үе тэнгийнхний дэмжлэг чухал нөлөөтэй. Ийнхүү хамтран ажиллах орчин нь сурагчдын итгэлцэл, урам зоригийг нэмэгдүүлж, сурах хандлагыг эерэг болгодог. Иймд багш болон сургуулийн зүгээс дараах ерөнхий зөвлөмжийг харгалзах нь чухал. Үүнд:

- *Сургалтын орчныг уян хатан зохион байгуулах:* Хүүхдийн хэрэгцээнд нийцсэн хэрэглэгдэхүүн, хугацаа, үнэлгээний арга зүйг хэрэглэж, дасан зохицох боломжийг олгох.
- *Хамтын харилцааны тогтолцоог бий болгох:* Эцэг эх, багш, сургууль гурвын уялдаа холбоог тогтмолжуулж, хүүхдийн ахиц, хэрэгцээ, дэмжлэгийн арга хэмжээг хамтран тодорхойлох.

- *Сэтгэлзүйн болон нийгмийн дэмжлэг үзүүлэх:* Хүүхдийн өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, амжилтын туршлагыг урамшуулах бодлого хэрэгжүүлэх.
- *Мэргэжлийн хөгжлийг дэмжих:* Багш нар унших бэрхшээлтэй сурагчийг дэмжих орчин үеийн арга зүй (Structured Literacy, Orton–Gillingham, Multisensory Approach гэх мэт)-г эзэмших сургалтад хамрагдах.
- *Эцэг эхийн оролцоог тогтмолжуулах:* Гэрийн орчинд хүүхдийн суралцах дадлыг хэвшүүлэх, хамтын уншлага, хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулах.

Эцэг эхэд өгөх дэмжлэг ба зөвлөмж: Эцэг эх нь хүүхдийн суралцах амжилтад хамгийн том нөлөө үзүүлэгчдийн нэг тул идэвхтэй оролцоо, ойлголттой байх шаардлагатай. Унших бэрхшээлийн онцлогийн талаар судалж, холбогдох сургалт, уулзалтад оролцох, бусад эцэг эхтэй туршлага солилцох нь зүйтэй. Хүүхдийнхээ суралцах чадварыг хэт доогуур үнэлэхээс зайлсхийж, харин урам зориг, итгэл найдвар өгөх орчныг бүрдүүлэх нь хамгийн үр дүнтэй дэмжлэг юм. Мөн багштай байнгын холбоотой байх, хүүхдийнхээ ахиц амжилтын талаар мэдээлэлтэй байж багшийн ажиллаж байгаа арга барилаар гэрт нь чиглүүлж ажиллах, гэр бүлийн орчинд өдөр бүр чангаар ном уншиж өгч үйл явдлыг ярилцах нь үгийн баялаг, уншиж ойлгох чадварыг хөгжүүлэхэд бодит дэмжлэг болно. Түүнчлэн хүүхдийнхээ суралцах бэрхшээлийн талаар нээлттэй, илэн далангүй ярилцаж, давуу болон сул талыг хамт тодорхойлох нь хүүхдэд “өөрийгөө хүлээн зөвшөөрөх”, “бусадтай харьцах итгэлтэй байдал” бий болгоход тусалдаг. Энэ нь сэтгэлзүйн хамгаалалт болж, суралцахуйн хандлагыг эерэг байлгахад чухал үүрэгтэй.

Дислексиатай суралцагчдыг дэмжих үр дүнтэй тогтолцоо нь зөвхөн нэг талын хүчин чармайлтаар бус, багш, эцэг эх, сургуулийн хамтын оролцоонд тулгуурлана. Хамтын ажиллагааны зорилго нь сурагчийн уншихуйн чадварыг хөгжүүлэх, өөртөө итгэх итгэлийг сэргээх, сурах урам зоригийг нэмэгдүүлнэ.

НОМ ЗҮЙ:

Боловсрол, шинжлэх ухааны яам. (2022). Уншихуйн чадварыг хөгжүүлэх арга зүй: Бага ангийн багшийн гарын авлага. Улаанбаатар: БШУЯ.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. (2023). Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл эрүүл мэндийн олон улсын ангилал. Улаанбаатар.

НҮБ Хүүхдийн сан. (2010). Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй. Улаанбаатар.

Боловсролын хүрээлэн. (2020). Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих арга зүйн зөвлөмж. Улаанбаатар.

Цэвээнлхазал, Я. А. (2016). Хувь хүүхдийн хөгжлийг дэмжих заслын аргууд. Улаанбаатар.

Япон улсын Хүүхдийг ивээх сан, М. (2020). Сургалтын үйл ажиллагааг дэмжих тусгай хэрэгцээт боловсролын арга зүй - бага ангийн жишээн дээрх 172 шилдэг санаа. Улаанбаатар.

Cambridge University Press & Assessment. (2024). Supporting learners with dyslexia: A teacher's guide –Cambridge University Press. <https://www.cambridgeenglish.org/Images/609744-supporting-learners-with-dyslexia-a2-keys-for-schools-b1-preliminary-for-schools-and-b2-first-for-schools-a-guide-for-teachers.pdf>

Dyslexia Alba. (2015). What is dyslexia? <https://www.bdadyslexia.org.uk/dyslexia/about-dyslexia/what-is-dyslexia>

International Dyslexia Association. (2019). The IDA dyslexia handbook: <https://dyslexiaida.org/ida-dyslexia-handbook/>

Pivler, J., & Rooney, T. (2019). The Orton–Gillingham training manual. Rooney Foundation. <https://or.dyslexiaida.org/wp-content/uploads/sites/20/2020/06/OG-Training-Manual-2019.pdf>

СУДЛАГДАХУУНЫ НЭР: МАТЕМАТИК

АНГИ: I-V АНГИ

Математикт суралцахуйн бэрхшээл (dyscalculia)-Тоо бодох, тооцоолох бэрхшээл

Онолын мэдээлэл: Дискалькулиа (dyscalculia) гэдэг нь Грек болон Латин үгнээс гаралтай. Dys (Грек) нь муу, calculia (Латин) нь тооцоолол хийх “calcularе” гэсэн үгнээс гаралтай бөгөөд нийлээд “тооцоолоход муу” буюу тооцоолол хийхэд бэрхшээлтэй гэсэн үг юм (LDA). Дискалькулиа математиктай холбоотой тодорхой сурах чадварын бэрхшээл бөгөөд тооцоолох, бодлого бодох эсвэл хоёуланд нь нөлөөлж болно. Суралцах явцад ямар ч суралцагчидийн хооронд хувь хүний ялгаа гардаг. Суралцагчидийн нэг хэсэг нь хоёр бодлого, нөгөө хэсэг нь таван бодлого бодсоны дараа ойлгодог. Зарим нь нэлээд хэдэн бодлого, дасгалын дараа ч ойлгохгүй байж болно (Mathematics made easy for children with visual impairment).

Суралцахуйн бэрхшээлийн талаар хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолт хараахан гараагүй байгаа ч Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан “Үйл ажиллагааны олон улсын ангилал (ҮАОУА)”-д дурдсан тооцоолон бодох (d172), бодож сурах (d150)-д тоо, математикийн үндсэн ойлголт, ухагдахууныг цээжлэх, үнэн зөв бөгөөд чөлөөтэй тооцоолох зэрэг бэрхшээлүүдийн талаар дурдсан байдаг.

Дискалькулиагийн нийтлэг шинжүүдийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 10. Дискалькулиагийн нийтлэг шинжүүд

<i>Илрэх шинж</i>		<i>Тайлбар</i>
<i>Тооны тоолохтой холбоотой утга,</i>	<i>Цөөн тооны бодит юмсыг тоолохгүйгээр хэд байгааг мэдэхгүй байх</i>	<i>Жишээ нь, ширээн дээр 3 ширхэг харандаа байгаа бол суралцагч түүнийг нэг, хоёр, гурав гэж тоолж байж хэд байгааг мэдэх)</i>
	<i>Тоонуудын аль нь их эсвэл багыг харьцуулж чадахгүй, хэрхэн харьцуулахыг ойлгохгүй байх</i>	<i>Жишээ нь, 5 ба 7-ийн аль нь ихийг хэлж мэдэхгүй, тооны утгыг ойлгодоггүй</i>

	<i>Ямар нэгэн хэрэглэгдэхүүн ашиглалгүйгээр цээжээр тооцоолж чадахгүй байх</i>	<i>Жишээ нь, 8+5-ыг суралцагч бичиж эсвэл хэрэглэгдэхүүн ашиглаж (хуруугаа тоолох) тоолж олдог, шууд 13 гэж хэлж чадахгүй</i>
	<i>Энгийн нийлбэрийг олохдоо хуруугаа ашигладаг байх</i>	<i>Жишээ нь, Гуравдугаар ангийн суралцагч 2+5-ийг цээжээр хэллэгүй, хуруугаа тоолж олох</i>
	<i>Нэмэх үйлдлийг хийхдээ нэг тоон дээр нөгөө тоог нэмэхийн оронд бүх тоог эхнээс нь тоолох</i>	<i>4+3-ыг бодохдоо 4-өөс эхлээд тоолохын оронд нэг, хоёр, гурав гэх мэт эхнээс нь тоолох</i>
	<i>Бодит юмсыг тоололгүйгээр хэд байгааг нь ойролцоогоор хэлж чадахгүй байх</i>	<i>Жишээ нь, хайрцагт байгаа 20 чихрийн тоог тоолохгүйгээр таамаглаж чадахгүй</i>
	<i>Тоог зөв тоолж чадахгүй, бодит юмсыг хэд байгааг хэлж мэдэхгүй, тооны орны утгыг мэдэхгүй, тоонуудыг өсөх эсвэл буурах эрэмбээр зөв дараалуулж чадахгүй байх</i>	
<i>Математикийн баримтын мэдлэг, үйлдлийг сэргээн санахтай холбоотой</i>	<i>Математикийн баримтын мэдлэгийг мэдэхгүй, цээжлээгүй байх</i>	<i>Жишээ нь, 35 нь хэд болохыг шууд хэлдэггүй, дахин тоолж бодох шаардлагатай байх</i>
	<i>Математикийн үйлдлийн тэмдгүүдийн утгыг мэдэхгүй, санахгүй байх</i>	<i>Жишээ нь, + тэмдгийг хараад утгыг нь санадаггүй, эсвэл тэмдэгтэй андуурдаг</i>
	<i>Математикийн ямар нэгэн арга сурсан ч хурдан мартдаг</i>	<i>Жишээ нь, өнөөдөр хасах үйлдлийг хэрхэн гүйцэтгэх тухай сурчихаад маргааш нь түүнийгээ санахгүй, дахин заалгах шаардлагатай болох</i>
	<i>Үржүүлэхийн хүрдийг цээжилж хэрэглэхийн оронд дахин дахин нэмэх үйлдлээр боддог</i>	<i>Жишээ нь, $43 = 12$ гэдгийг шууд хэлэхийн оронд $4 + 4 + 4 = 12$ гэж бодох</i>
	<i>Олон алхамтай бодлого бодож чаддаггүй</i>	<i>Жишээ нь, эхлээд нэмэх үйлдлийг гүйцэтгээд, дараа нь үржүүлэх гэх мэт бодлогыг ойлгодоггүй, эсвэл нэг алхмыг эсвэл дарааллыг нь мартдаг</i>
	<i>Математикийн бодлого бодож байх явцдаа юу хийж байснаа мартан, өөр аргаар үргэлжлүүлэх</i>	<i>Жишээ нь, эхлээд тоонуудыг нэмж байснаа гэнэт хасаж эхлэх, ямар нэгэн алхам дээр явж байснаа алгасаад дараагийн алхам руу үсрэх</i>
	<i>Математикийн ойлголт, үйлдлийг ойлгох, хэрэглэхэд хүндрэлтэй байх</i>	<i>Жишээ нь “хуваах” гэдэг үгийг мэдэх боловч яаж хийдгийг мэдэхгүй, эсвэл бодлогод нэг удаа хуваах үйлдлийг хэрэглэсэн боловч түүнтэй адил</i>

		төрлийн бодлогод тэр аргаа хэрэглэж чаддаггүй
	Бодлого бодож байхдаа юу асууж байсныг мартаж	Жишээ нь, бодлогоо бодож эхлээд алхмуудаа дуусгах үед яг юу олохыг мартаж, нийлбэрийг нь олох байсан уу эсвэл дөрөөг нь олох байсан уу гэх мэтээр будилах
Орон зайн төсөөлөл болон бичиглэлтэй холбоотой	Тооны цифрүүдийн дарааллыг андуурах, эсвэл сольж ашиглах	Жишээ нь, 12-ыг 21 гэж уншдаг, эсвэл 21-ийг 12 гэж цифрүүдийг зөв таньдаг ч дарааллыг сольж хэлдэг
	Математикийн үйлдлийн тэмдгүүдийг андуурах	5+3 гэж хараад хасах үйлдлийг хийдэг, эсвэл 6-3 гэж хараад нэмэх үйлдлийг хийдэг, тэмдгийг харж байгаа ч түүний утгыг санадаггүй
	Тоонуудыг буруу дарааллаар нэгтгэх эсвэл задлах	Жишээ нь, 42+35 нийлбэрийг олохдоо аравт болон нэгжийг андуурч 4+3 ба 2+5-ыг буруу нэмэх
	Математикийн бодлогоо дэвтэр дээрээ эмх цэгцтэй бичиж чадахгүй байх	
	Хасах үйлдлийн хасагдагч, хасагчийн дарааллыг өөрчлөхөд хариу өөрчлөгддөгийг ойлгохгүй байх	Жишээ нь, $6 - 2 = 4$, харин $2 - 6 = -4$ хоёрыг ижил хариу гэж бодох
	Тоо, үсэг, тэмдгийг уруу орлуулах эсвэл солих	Жишээ нь, $b - d$ гэж бичих, 3-ыг 8 гэж бичих, эсвэл $+$ ба $-$ тэмдгийг андуурах
	Нэг хуудсан дээр хэт олон тоо, бодлого байвал андуурах	
	Дэвтэр дээрээ эмх цэгцтэй, ойлгомжтой байдлаар зохион байгуулж бичиж чаддаггүй	
	Цаг болон минутын зүүтэй цагийг уншиж чаддаггүй	Жишээ нь, цагийн зүүг нь харж байгаа ч 3:15 эсвэл 3:45 гэж ялгахгүй байх
	Хуулж бичихдээ алдаа гаргах	Жишээ нь, 74-ийг 47 гэж бичих, нэг тэмдэгт эсвэл нэг тоог алдаж бичих
Математик хэл, үгийн сангай холбоотой	Математикийн үг хэллэг, нэр томъёог ойлгохгүй байх	Жишээ нь, нийлбэр, ялгавар, үржвэр, ногдворын утгыг ойлгохгүй байх, -аас их эсвэл -аас багыг ялгахгүй байх
	Бодлогыг хэрхэн бодсоноо тайлбарлаж чадахгүй байх	Жишээ нь, бодлогыг бодож чадсан боловч яагаад нэмсэн эсвэл

		үржүүлснээ тайлбарлаж чадахгүй байх
	Ойлгохгүй байгаа ч асуулт асууж, тусламж хүсдэггүй	
	Сурсан зүйлээ өөр нөхцөл ашиглаж чадахгүй байх	Жишээ нь, нэг бодлогыг хуваах аргаар бодож сурсан ч өөр бодлогод тэр аргаа хэрэглэж мэдэхгүй байх
	Өгүүлбэртэй бодлогын тоон өгөгдлүүд дээр үйлдэл гүйцэтгэж чадах ч утгыг нь тайлбарлаж чадахгүй, ойлгохгүй байх	Жишээ нь, хүү 5 чихэртэй байгаад нэмж 3-ыг авчээ, нийт хэдэн чихэртэй болсон бэ гэсэн бодлогод зөвхөн тоонуудыг нэмээд 8 гэж гаргасан боловч бодлогын асуултыг ойлгохгүй, эсвэл тайлбарлаж чадахгүй байх
	Тоог харьцуулах, жишихдээ математик үг хэллэгийг андуурах	Жишээ нь, $5 > 3$ гэснийг хараад 5 нь 3-аас бага гэж бодох
Зарцуулах хугацаа, дараалалтай холбоотой	Бодлого бодоходоо бусдаас илүү хугацаа зарцуулах	Жишээ нь, нэмэх эсвэл үржүүлэхдээ удах, хялбар бодлого бодоход ч хугацаа их зарцуулах
	Бодлого бодоход утга учрыг нь ойлгохгүйгээр, зүгээр л дагаж хийх	томьёо ашиглаж бодож байгаа боловч яагаад гэдгийг ойлгодоггүй, тоо эсвэл нөхцөл өөрчлөгдсөн ч жил алхмыг давтан давтан хийх
	Тоолох эсвэл үржүүлэхийн хүрд хэлэхдээ дарааллаа мартаж	1,2,3,... гээд тоолж эхлэхдээ тоог алгасах эсвэл давтан хэлэх, 3-ын хүрдийг 3,6,9, ... гэж хэлэхдээ дараагийн тоог мартаж
	Олон алхамтай бодлогын дарааллыг алдах	Жишээ нь, бодлогын эхний алхмыг хийгээд дараагийн алхмыг мартаж
Математик сэтгэлгээ, ойлголттой холбоотой	Бодлогын алхмуудыг зөвхөн цээжлэх эсвэл дуурайн хийж, яагаад ийм алхмаар бодож байгаагаа ойлгохгүй байх	Жишээ нь, заасан аргыг яг дуурайж хийн өөрийн үгээр тайлбарлаж чаддаггүй, тоонууд нь өөрчлөгдвөл хэрхэн тохируулж бодохоо мэддэггүй
	Тоог зөв нэмж чаддаг ч нийлбэрийг хэрхэн олсноо тайлбарлаж чаддаггүй	$7 + 5 = 12$ гэж зөв бодсон ч 12 гаргасан алхмаа тайлбарлаж чадахгүй байх

Математикт суралцахуйн бэрхшээлтэй суралцагчид дараах хүснэгт дэх бэрхшээлтэй тулгарч болно (Brodesky et al., 2002; Hannell, 2013).

Хүснэгт 2

Хэл ба унших (Монгол хэл ба математик хэл)	<ul style="list-style-type: none"> • Математикт хэрэглэдэг үгс, үгсийн санг ойлгох • Математикийн өгүүлбэрийг унших, тайлбарлах
--	---

Санах ой ба мэдээлэл боловсруулах	<ul style="list-style-type: none"> • Богино хугацааны ой санамжийг ашиглах (Жишээ нь, тооцоолох асуудлыг шийдвэрлэх) • Урт хугацааны ой санамжийг ашиглах • Мэдлэгийг хадгалах, ашиглах
Гүйцэтгэлийн хурд болон хариу үйлдэл үзүүлэх хугацаа	<ul style="list-style-type: none"> • Асуудлыг цаг тухайд нь шийдвэрлэх • Асуултад хариулах • Математикийн баримтын мэдлэгийг сэргээх
Харааны болон орон зайн зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> • Зурган мэдээлийг ойлгох
Гарын ижиг булчингийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Гар, хуруугаараа жижиг зүйл хийх
Гүйцэтгэх үйл ажиллагааны ур чадвар	<ul style="list-style-type: none"> • Бодох, төлөвлөх, сэргээн санах, өөрийгөө хянах замаар үйл ажиллагаагаа амжилттай гүйцэтгэх
Анхаарал	<ul style="list-style-type: none"> • Даалгаварт анхаарлаа төвлөрүүлэх
Сэтгэл зүй, нийгмийн ур чадвар	<ul style="list-style-type: none"> • Сэтгэл хөдлөлийг хянах, зохих ёсоор хариу үйлдэл үзүүлэх

Суралцагчийн сурах ялгаатай хэв маяг, үйлдлийн чадваруудыг тодорхойлж, тэдний сурах урам зоригийг нь өдөөн идэвхжүүлдэг ялгаатай аргуудад нийцүүлэн суралцах үйлийг дэмжих асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байна (БШУЯ, 2023). Суралцагчийн ялгаатай хэрэгцээг хангах түгээмэл загвар, сургалтын тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин бүрдүүлэх үүргийг сургууль хүлээсэн байдаг (СӨБЕБТХ, 6.1). Мөн сургууль нь суралцагчийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн үндэсний сургалтын хөтөлбөрт тохируулга хийж болно (БЕХ, 10). Суралцагч бүрд хичээл, сургалтын үйл ажиллагаанд оролцох, амжилттай суралцах, хөгжих боломж олгохын тулд хөтөлбөрийн агуулга, арга зүй, орчин, хэрэглэгдэхүүн, үнэлгээнд тохируулга хийж болно. Ингэснээр математикт суралцахуйн бэрхшээлтэй суралцагч бусад үе тэнгийнхнийхээ нэгэн адилаар боловсролд хамрагдах, оролцох боломжтой болно.

Математикт суралцахуйн бэрхшээлтэй суралцагчийг дэмжих арга зүй

Бид суралцагч бүр сурч чадна гэдгийг мэддэг, гэвч тэд нэгэн ижил арга замаар сурдаггүй. Тэд хичээл, сургалтын үйл ажиллагаанд хэрхэн оролцож, сурч буй зүйлээ хэрхэн ойлгож, сурснаа хэрхэн илэрхийлдэг зэргээрээ харилцан адилгүй байдаг. Суралцахуйн түгээмэл загвар (Universal Design for Learning) нь суралцагч бүрийн өмнөх мэдлэг, сурах хэв маяг, чадвараас үл хамааран хүртээмжтэй, үр дүнтэй сургалтыг бий болгох боловсролын хүрээ юм. Энэхүү загвар нь суралцагч бүр өөр өөрөөр суралцдаг гэдэгт суурилан хичээл, сургалтыг уян хатан, олон янзаар зохион байгуулах шаардлагатай гэж үздэг. UDL-ийн үндсэн зорилго нь суралцагч бүрд хүрэх сургалтыг төлөвлөх, зохион байгуулах явдал юм.

Суралцахуйн түгээмэл загварын үндсэн зарчим:

- Суралцагчийн сонирхол, хэрэгцээ, идэвхийг татах олон аргыг санал болгох

- Суралцагчид мэдлэг, мэдээллийг түргэн ойлгоход нь олон хэлбэрээр хүргэх (тухайлбал, текст, аудио, видео, дүрс зураг, гараар хийх үйл ажиллагаа гэх мэт)
- Суралцагчид мэдлэгээ олон янзаар харуулах боломж олгох (бичих, ярьж тайлбарлах, зурж илэрхийлэх, технологи ашиглах, гараар хийх гэх мэт).

Математикт суралцахуйн бэрхшээлтэй суралцагчийн хичээл, сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулахад багш дараах арга, аргачлалыг ашиглах хэрэгтэй. Эдгээр нь нотолгоонд суурилсан үр дүнтэй гэж судалгаагаар батлагдсан. Үүнд:

1. Тодорхой зааварчилгаа (*Explicit instruction*)
2. Математик үг хэллэг ашиглах
3. “ТДХ” арга ашиглах
4. Баримтын мэдлэг, тооцоолох ур чадварыг эзэмших
5. Өгүүлбэртэй бодлого бодох

Дараах хүснэгт нь эдгээр аргуудын онцлогийг харуулсан бөгөөд эдгээр нь математикт суралцахуйн бэрхшээлтэй суралцагчийг дэмжихэд үр дүнтэй байдаг.

Хүснэгт 11. Суралцахуйн бэрхшээлтэй суралцагчийг дэмжих арга

Арга	Гол санаа
<i>Explicit instruction</i> (тодорхой зааварчилгаа)	<p>“<i>Explicit instruction</i>” буюу “Тодорхой зааварчилгаа” нь багш суралцагчдад сурах зүйл, хийх алхмуудыг шууд тодорхой зааж өгдөг сургалтын арга юм. Энэ аргын гол зорилго нь суралцагчид юуг сурах, яаж хийх, ямар үр дүнд хүрэх хэрэгтэйгээ бүрэн ойлгох боломжийг олгох явдал юм. Энэ аргын гол онцлогууд:</p> <ul style="list-style-type: none"> • Багш хичээлийн эхэнд суралцагчдад юу сурахыг нь тодорхой хэлдэг. • Суралцагчийн эзэмших математикийн мэдлэг, ойлголт, чадварыг багш тодорхой, ойлгомжтойгоор тайлбарладаг. • Багш жишээ үзүүлж, алхам бүрийг харуулдаг. • Суралцагч багшийн тусламжтайгаар хамтран ажиллана. • Суралцагчид дараа нь өөрсдөө бие даан даалгавраа гүйцэтгэнэ. • Багш суралцагчид шууд зөвлөгөө өгч, алдааг нь залруулдаг. <p>Жишээ нь, Хэрэв та энгийн бутархайг нэмэх аргыг зааж байвал эхлээд бутархай тоонуудыг тайлбарлана. Дараа нь бутархайн хуваарьд байх тоог тодорхойлж, тэдгээрийн ерөнхий хуваарийг олох алхам бүрийг жишээгээр үзүүлнэ. Суралцагчидтай хамт хэдэн дасгал ажиллана. Эцэст нь суралцагчид бие даан ажиллана.</p>
Математик үг хэллэг ашиглах	Багш суралцагчийн математик үг хэллэг ашиглах чадварыг сайжруулахад анхаарах хэрэгтэй. Математик нэр томъёо ашиглах, тэдгээрийг хэрэглэж сургахын тулд хичээл заахаас өмнө математик нэр томъёо, түүний хэрэглээг төлөвлөх хэрэгтэй.

<p>ТДХ арга</p>	<p>Т нь тодорхой, Д нь дүрслэл, Х нь хийсвэр гэсэн үгийн товчлол бөгөөд ТДХ нь тодорхой биет, бодит зүйлсээр дамжуулан, тэдгээрийг зураг, дүрслэл, диаграммаар илэрхийлж, тоо, тэмдэгт гэх мэт хийсвэр ойлголтыг ойлгох үе шатуудын хоорондын холбоогоор суралцагчдад математик ухагдахуун, ойлголтыг таниулах арга юм. Энэ аргын дагуу эхлээд биет хэрэглэгдэхүүн, бодит юмс ашиглах, тэдгээрийг зураг, дүрслэл, загвараар илэрхийлэх, загвар, дүрслэлд суурилан математик ухагдахууныг ойлгох, бичих, тэмдэглэх гэсэн дарааллаар суралцахуйн үйл ажиллагааг хэрэжүүлнэ.</p> <p>Тодорхой: Биет, гараар барих янз бүрийн хэрэглэгдэхүүн</p> <ul style="list-style-type: none"> • Дүрслэл: Зураг, дүрс эсвэл цахим материал • Хийсвэр: Тоо, тэмдэгт, үгс <p>ТДХ арга ашиглах нь суралцагчийн математикийн ухагдахууныг илүү сайн ойлгох, гүн бат мэдлэг эзэмшихэд дэмжлэг үзүүлдэг.</p>
<p>Баримтын мэдлэг, тооцоолох ур чадварыг эзэмших</p>	<ul style="list-style-type: none"> • Хэрэв суралцагч $7+6=13$, $8 \times 5=40$ гэх мэт энгийн бодлогын хариуг шууд хэлдэг, $26+37$-ыг $20+30=50$, $6+7=13$ тэгээд $50+13=63$ гэж бодож байгаа бол түүнийг баримтын мэдлэг, тооцоолох чадвартай гэнэ. • Суралцагчид тооцоолох аргуудыг сонгож, гаргасан хариугаа тайлбарлаж чаддаг болсон үед тооцооллын чадвар илэрдэг. • Багш баримтын мэдлэгийг хөгжүүлэхийн тулд тоглоом, дасгал ашиглах хэрэгтэй. • Зөвхөн баримтын мэдлэгээс гадна, суралцагчийн олон оронтой нэмэх, хасах, үржүүлэх, хуваах зэрэг тооцоолох чадварыг хөгжүүлэх шаардлагатай. • Тооцоолох чадварыг дэмжих дасгалыг богино хугацаатайгаар өдөр бүр хийх хэрэгтэй.
<p>Өгүүлбэртэй бодлого бодох</p>	<ul style="list-style-type: none"> • Бага ангид ихэвчлэн нийлбэр, ялгаарыг олох, өөрчлөлтийг олох, тэнцүү хуваах, харьцуулах гэх мэт төрлийн өгүүлбэртэй бодлогыг боддог. • Багш өгүүлбэртэй бодлогыг бодоход суралцагчийн өмнөх мэдлэгийг сэргээн сануулж, туслах хэрэгтэй. Жишээ нь, Эхлээд юу болсон бэ? Дараа нь яасан бэ? Өчигдөр бид яаж бодсон билээ? • Өгүүлбэртэй бодлого бодох аргыг өгүүлбэр доторх түлхүүр үг (нийт, үлдсэн, зөрөө...) эсвэл үйлдлэлтэй (нэмэх, хасах, үржүүлэх, хуваах) шууд холбон зааж болохгүй. Багш суралцагчийн өгүүлбэртэй бодлогын утгыг ойлгоход анхаарах ёстой. Жишээ нь, “нийт” эсвэл “нийт хэд байна вэ?” гэвэл үргэлж нэмэх гэсэн үг биш. Тодруулбал, зөвхөн өгүүлбэрийн доторх түлхүүр үг эсвэл үйлдэлд тулгуурлан ойлгох бус, өгүүлбэртэй бодлогын нөхцөлийг үнэлж шийдвэр гаргахад сургах ёстой.

Тодорхой зааварчилгаа (Explicit instruction)-г суралцахуйн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан үр дүнтэй математик сургалтын арга гэж тодорхойлдог (Hudson et al., 2006; Jitendra et al., 2018; Witzel et al., 2003) бөгөөд дараах гурван үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй.

а. Загварчлах:

Тайлбар болон жишээнээс бүрдэнэ. Багш эхлээд хичээлийн зорилго, ач холбогдлыг 2-3 өгүүлбэрээр хэлнэ. Бодлого бодох алхам, шаардлагатай үгсийн сан, математик үг хэллэгийг багтааж болно. Суралцагчийн математикийн агуулгыг сайн мэддэг эсэхээс хамааран нэг жишээ эсвэл хэд хэдэн жишээ сонгоно. Суралцагчийг ойлголтыг дэмжихийн тулд хичээлийн өмнө жишээг сайтар төлөвлөнө. Багш дараах дэмжлэгүүдийг анхаарч үзэх хэрэгтэй. Үүнд:

- Багш суралцагчдаас минут тутамд нээлттэй болон хаалттай асуулт асуух нь тэднийг хичээлд идэвхтэй оролцоход тусалдаг. Нээлттэй асуулт нь суралцагчийг сэтгэн бодох чадварыг дэмжиж, багшид тэдний математикийн ойлголтын талаарх үнэлгээ хийх боломж олгодог. Жишээ нь, Ерөнхий хуваарийг олсноор бутархайг харьцуулахад хэрхэн тусалдаг вэ? Асуудлыг шийдэхийн хэзээ дахин бүлэглэх шаардлагатай вэ? Өөрийн бодлоо тайлбарлана уу? Хаалттай асуулт нь илүү энгийн хариулт шаарддаг. Хаалттай асуулт нь суралцагчийн оролцоог нэмэгдүүлж, бухимдлыг багасгадаг. Жишээ нь, 9-ийг 7-оор үржүүлэхэд хэд вэ? 2-ыг нэмэхэд хэд болох вэ? Өгүүлбэртэй бодлогыг бодоход ямар үйлдлүүдийг ашиглаж болох вэ? гэх мэт.
- Суралцагчдаас тогтмол хариулт авах нь тэдний анхаарлыг тогтоох, хичээлд дахин заах эсвэл нэмэлт жишээ шаардлагатай эсэхийг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Суралцагч бүх асуултад амаар хариулт өгөх шаардлагагүй. Тэд хамтран багаар хариулах эсвэл цаас, ажлын хуудас эсвэл самбарт хариуг бичих эсвэл зурж болно. Мөн эрхий хуруугаа дээш эсвэл доош харуулан дохио зангаагаар хариулж ч болно.
- Суралцагчийн хариултад багш батлах эсвэл залруулах тайлбар өгөх ёстой. Тайлбар нь суралцагчийг чиглүүлэх, эсвэл итгэлийг нь нэмэгдүүлэх боломж бүрдүүлдэг бөгөөд математикийн хичээлд өөртөө итгэх итгэл багатай, түгшүүр ихтэй суралцагчдад чухал. Багш тайлбарыг аль болох хурдан, олон удаа өгөх хэрэгтэй.

Би чамайг хоёр тоог нэмэхдээ “тоолж нэмэх” арга ашигласныг анзаарлаа. Чамайг гео самбарт “гуравны хоёр” бутархайг дүрслэх гэж байгааг би харж байна гэх мэтээр суралцагчдад ойлголт болон аргачлалын талаар тодорхой тайлбар өгөх нь хамгийн үр дүнтэй. Суралцагч алдаа гаргах эсвэл ойлголт, аргачлалыг буруу ойлгосон үед багшаас залруулах тайлбар өгнө. Ингэхдээ ихэвчлэн асуулт асуух, хийсэн алхам болон өөрийн бодол санаагаа тайлбарлахыг хүснэ. Ингэснээр багш суралцагчийн алдааг хаана, яагаад гаргасныг ойлгох боломжтой болдог.

- Багш суралцагчийн идэвхтэй, хурдтай оролцоог хангахын тулд хичээлээ сайтар төлөвлөх хэрэгтэй. Хичээлийн өмнө багш асуултуудаа төлөвлөнө. Мөн тухайн хичээлийн агуулга болон түүнийгээ хэрхэн зааварлах аргачлалаа сайн мэддэг

байх хэрэгтэй. Хичээлийг төлөвлөхдөө шаардлагатай материалаа урьдчилан бэлтгэх нь сургалтын үр дүнг нэмэгдүүлдэг.

б. Дадлага хийх:

Загварчлах нь суралцагчийг дасгал, даалгаврыг амжилттай гүйцэтгэхэд бэлтгэдэг бол дасгал, даалгавар нь суралцагчдад сурсан мэдлэг, чадвараа олон удаа давтаж хэрэглэх боломжийг олгодог. Дадлага хийх нь хоёр хэсэгтэй. Нэгд багш, суралцагчид хамтран математикийн бодлого бодно. Багш самбарт бодлого бодож, суралцагчид ширээн дээрээ дагаж бодож болно. Багш суралцагчдаас асуулт асуух, хэрэглэгдэхүүн (жишээ нь, гараар барих хэрэгсэл, 100-ын хүснэгт, ажлын хуудас гэх мэт) ашиглан бодлого бодоход чиглүүлдэг. Мөн багш, суралцагчид эсвэл суралцагчид хосоор, бүлгээр ажиллах үйл ажиллагааг багтаана. Гэсэн ч багш суралцагчтай хамтран бодлого бодох нь хамгийн үр дүнтэй байдаг. Суралцахуйн бэрхшээлтэй сураалцагчдад тусалж, загварчлалаас дадлага хийх рүү аажмаар шилжих хэрэгтэй. Хоёрт суралцагчид бие даан даалгаврыг гүйцэтгэх, асуултад хариулна. Энэ нь багшид хичээлийн явцад заасан мэдлэг, чадварыг ойлгосон эсэхийг тодорхойлох боломж олгодог. Суралцагчид бие даан бодлого бодсон ч багшийн удирдлага дор хийх хэрэгтэй. Гэрийн даалгаварт өдөр тутам бие даан бодлого бодох хэрэгцээ гарах ч суралцагчид хангалттай дэмжлэг үзүүлж байгаа баталгаа биш гэдгийг ойлгох хэрэгтэй.

в. Дэмжлэг үзүүлэх:

Суралцагчид багштай хамтран болон бие даан дадлага хийх явцад багш дараах дэмжлэгийг үзүүлэхэд анхаарах хэрэгтэй. Үүнд: хаалттай ба нээлттэй асуулт асуух, хариултыг тогтмол авах, батлах эсвэл залруулах тайлбарыг шууд өгөх, суралцагчийн идэвхтэй оролцоог хангах

Тодорхой зааварчилгаа нь загварчлал болон дадлага хийхийг багтаадаг бөгөөд харин бүрд дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Багш хичээлийн агуулгыг танилцуулсны дараа нэг жишээг загварчилж, суралцагчдад хэд хэдэн дасгал ажиллах боломж олгож, дээр дурдсан дэмжлэгт анхаарч ажиллах хэрэгтэй.

Тодорхой зааварчилгаа нь уян хатан бөгөөд өдөр бүр, хичээл бүрд өөр өөр байж, суралцагчийн хувь хүний хэрэгцээнд тулгуурлан өөрчлөгдөх ёстой.

Тодорхой зааварчилгааг төлөвлөхдөө багш өөрөөсөө дараах асуултыг тогтмол асууж, төлөвлөлтөө сайжруулна. Асуулт: Миний төлөвлөсөн “тодорхой зааварчилгаа” дараах бүрэлдэхүүн хэсгийг багтаасан уу? Үүнд:

- Алхам бүрийг товч тодорхой загварчлах
- Чиглүүлэх дасгал ажиллах
- Бие даан дасгал хийх боломжийг олгох
- Асуулт асуух, хариулт авах, тайлбар, залруулга өгөх, зохион байгуулалтад дэмжлэг үзүүлэх.
- Математик үг хэллэг.

Багш тодорхой зааварчилгааг ашиглан загварчилж, суралцагчдаар дадлага хийлгэхэд математик үг хэллэг ашиглах шаардлагатай. Математикийн нэр томъёо нь суралцахуйн

бэрхшээлтэй суралцагчдад дараах шалтгааны улмаас сорилт болдог (Riccomini et al., 2015; Rubenstein & Thompson, 2002). Үүнд:

- Математик үг хэллэг нь зөвхөн математикийн салбарт хэрэглэгддэг техникийн нэр томьёо, тэмдэглэгээ, диаграммыг багтаадаг. Ихэнх суралцагч эдгээрийг өмнө нь сонсоогүй, хараагүй байдаг. Жишээ: **нийлбэр, умга, үржвэр** зэрэг нэр томьёо нь математик тодорхойлолттой бөгөөд ихэнх суралцагчдад танил боловч суралцахуйн бэрхшээлтэй суралцагчдад шинэ ойлголт байж болно (Freeman & Crawford, 2008). Мөн математикийн тэмдэг, тэмдэглэгээ нь (тэг, тэнцүү гэх мэт) нь тоо болон тэмдэглэгээг тайлбарлахад хэрэглэгддэг боловч суралцагчдад танил бус байж болно (Powell et al., 2017).
- Зарим нэр томьёо нь хоёр буюу түүнээс дээш үгнээс бүрддэг (жишээ нь, хурц өнцөг, рационал тоо, гурвалжин пирамид). Суралцагчид зөвхөн нэг үг биш харин хэд хэдэн үгийг ойлгож, хооронд нь холбоос үүсгэх шаардлагатай болдог тул нэмэлт хүндрэл үүсгэж болзошгүй.

Суралцагчийн математикийн нэр томьёог ойлгох, хэрэглэх чадварыг дэмжихийн тулд багш дараах арга хэмжээг авах хэрэгтэй. Үүнд:

- Хичээлд математикийн нэр томьёо ашигладаг байх
- Хичээлд нэр математикийн нэр томьёотой холбоотой дасгал багтаах
- ТДХ арга.

ТДХ нь судалгаагаар баталгаажсан, нотолгоонд суурилсан арга юм (жишээлбэл: Flores et al., 2014; Witzel et al., 2008). Энэ аргын тодорхой (concrete), дүрслэл (pictorial), болон абстракт (abstract) үе шатууд нь суралцагчийн математикийн мэдлэг ойлголтод дэмжлэг үзүүлдэг. Зарим суралцагчид бодитоор дасгал хийх шаардлагатай байхад, зарим нь бодит болон зураг, дүрслэл хослуулан математикийн хийсвэр ойлголтыг хүлээн авч чадна. Энэ аргыг ашигласнаар суралцагчид бодит болон зураг, дүрслэлээс хийсвэр ойлголт руу ерөнхийлж сурах чадвартай болдог (Peltier & Vannest, 2018). Мөн багш нар гурван үе шатын хооронд тодорхой холбоо үүсгэх нь маш чухал (Strickland & Maccini, 2013).

Зураг 1.

Математикт суралцахуйн бэрхшээлтэй суралцагчдад янз бүрийн түвшний дэмжлэг шаардлагатай болдог. Зарим суралцагчдад тодорхой бодит хэрэглэгдэхүүн ашиглаж дадлага хийх хэрэгцээ илүү шаардлагатай байж болох бол заримд нь математикийн хийсвэр ухагдахууныг ойлгохын тулд тодорхой бодит хэрэглэгдэхүүн болон зураг, дүрслэл ашиглах дэмжлэгийг хослуулж хэрэглэх хэрэгцээ гарна.

ТДХ-ийн математикийн тодорхой, дүрслэлийн (зураг) болон хийсвэр үе шатуудыг суралцагчийн математикийн мэдлэг, ойлголтыг гүн бат ойлгоход туслах зорилгоор хүрээ гэж тодорхойлж болно. Ингэснээр суралцагчид өөрсдийн ойлголт, мэдлэгийг зураг, дүрслэл болон тодорхой бодит түвшнээс хийсвэр лүү холбох чадвартай болдог (Peltier & Vannest, 2018).

Зураг 2. Т-Д-Х-ийн хүрээ

Тодорхой шат: Суралцагч гараар барьж, хөдөлгөж болох бодит юмс, хэрэглэгдэхүүн ашиглан математикийн мэдлэг, ухагдахууныг ойлгоход тусалдаг. Бодит юмс,

хэрэглэгдэхүүнд танграмм, гео самбар, тоолох хэрэгсэл, савх, хайрцаг гэх мэт зүйлс багтана.

Дүрслэл шат: Хавтгайд зурсан зураг, дүрслэл, эсвэл цахим хэрэглэгдэхүүн багтана. Зураг дүрслэлийг сурах бичигт, дэвтэрт, самбарт үзүүлж болно. Зураг, дүрслэлд график багтдаг бөгөөд энэ нь суралцагчид системтэйгээр ойлгоход тусалдаг (Jitendra & Star, 2012). Зураг, дүрслэл нь технологи ашиглан виртуал хэрэгслээр илэрхийлэгдэж болно.

Хийсвэр шат: Тоо, тэмдэглэгээ, үгсээс бүрддэг. Жишээ: $42 + 102 = 144$). Ихэнх тохиолдолд хийсвэр шат нь суралцагчийн зорилго байдаг. Багш бодит болон зураг, дүрслэл ашиглан математикийн хийсвэр ойлголтыг мэдэхэд дэмжлэг үзүүлдэг.

Баримтын мэдлэг, тооцоолох ур чадварыг эзэмших

Бага ангид суралцагч бүхэл тоон дээр тооцоолох чадвар эзэмших бөгөөд энэ нь дараагийн математик ойлголтуудын суурийг тавьдаг. II ангийн төгсгөлд суралцагчид 100 дотор нэмэх, хасах, IV ангийн төгсгөлд үржүүлэх, хуваах үйлдлийн тооцооллыг хийж сурсан байна. Багш суралцагчийг тухайн нөхцөл байдал, зорилгод тохирсон тооцоолох арга, хэрэгслийг ашиглахад дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

Баримтын мэдлэг гэдэг нь суурь тооны үйлдлүүдийг (нэмэх, хасах, үржүүлэх, хуваах) хурдан зөв хийх чадвар юм. Энэ чадварыг хөгжүүлэх нь суралцагчийг дээрх үйлдлүүдийг бодолгүйгээр шууд хэрэглэж сурах тухай асуудал юм. Математикт суралцахуйн бэрхшээлтэй суралцагчийнэнэ чадварыг хөгжүүлэхийн тулд тэднийг чөлөөтэй ярихыг дэмжих хэрэгтэй. Суралцахуйн бэрхшээлтэй суралцагчдад шаардлагатай үед баримтын мэдлэгийг өдөр бүр богино хугацаанд ашиглах боломжийг олгох, тоон тооцооллын дасгалуудыг багтаах хэрэгтэй. Баримтын мэдлэгийг янз бүрийн аргаар (жишээ нь, тоглоом, ажлын хуудас гэх мэт) дадлагажуулна. Суралцагчид үр ашигтай арга сонгох, ашиглах дадлага хийх шаардлагатай.

Хүснэгт 12. Нэмэх, хасах үйлдэлтэй холбоотой баримтын мэдлэг

Жишээ	Арга
$5+4=9$ (5-аас эхлэн 9 хүртэл өгсүүлж тоолох) $7-4=3$ (7-оос эхлэн 3 хүртэл уруудуулж тоолох)	Өгсүүлж, уруудуулж тоолох
$1+1; 2+1; 3+1$ эсвэл $1+2; 2+2; 3+2$ $5-1; 4-1; 3-1$ эсвэл $5-2; 4-2; 3-2$	Нэгээр нэмэгдүүлэх эсвэл хоёроор нэмэгдүүлэх Нэгээр хорогдуулах эсвэл хоёроор хорогдуулах
$3+3; 4+4$ $3+4=3+3+1; 4+5=4+4+1$	Ижил тоог нэмэх Ойролцоо хоёр тоог нэмэх
$8+5=8+2+3=13;$	10 гүйцээн нэмэх
9-4-ыг бодоход 4-ийг 9 болгохын тулд хэдийг нэмэх вэ?	Хасах үйлдэлд нэмэх үйлдлийг ашиглах
6+2 ба 2+6 хоёрын үр дүн ижил	Байр солих чанар хэрэглэх

$5+3=8; 3+5=8; 8-5=3; 8-3=5$	Өөр хоорондоо холбоотой бодлого
$5+0=5; 9+0=9$	Тоон дээр тэгийг нэмэх (тэр тоо өөрөө гарна)

Үржүүлэх, хуваахтай холбоотой бодлого бодох аргад цээжээр тооцоолох, орны утга болон үйлдлийн чанар ашиглах бодлогууд орж болно.

Хүснэгт 13. Үржүүлэх, хуваах үйлдэлтэй холбоотой баримтын мэдлэг

Жишээ	Арга
5, 10, 15, 20, 25...	Тодорхой тоогоор нэмэгдүүлж, хорогдуулж тоолох
$6 \times 2 = 6 + 6; 8 \times 2 = 8 + 8$	Тоог 2 дахин нэмэгдүүлэх
$9 \times 6 = 4 + 5 \times 6 = (4 \times 6) + (5 \times 6)$ 9×6 үржвэрийн аль нэг (9) үржигдэхүүнийг задалж, 4 ба 5-ын үржүүлэхийн хүрдээр олох боломжтой болно. Мэдэж буй үржүүлэхийн хүрдээс мэдэхгүй байгаа хүрдийг гаргахад дараах зүйлс орно: 2 дахин (2-ын хүрд), 2 дахиныг 2 дахин авах (4-ийн хүрд), 5-ын хүрд (арвын хагас) гэх мэт	Мэдэхгүй байгаа үржүүлэхийн хүрдийг мэдэж байгаа хүрдээсээ гаргах
Үржүүлэхийн байр солих ($8 \times 4 = 4 \times 8$) болон бүлэглэх чанар нь 6×7 үржвэрийн аль нэг (7) үржигдэхүүнийг задалж, 4 ба 3-ын үржүүлэхийн хүрдээр олох боломж олгоно. $6 \times 7 = 6 \times 4 + 3 = 6 \times 4 + 6 \times 3 = 24 + 18 = 42$	Үйлдлийн чанар ашиглах
$42 \div 6$ -ыг бодоход 6-г 42-тэй тэнцүү болгохын тулд хэд дахин авах вэ?	Хуваах үйлдэлд үржүүлэх үйлдлийг ашиглах
$6 \times 4 = 24, 4 \times 6 = 24, 24 \div 6 = 4, 24 \div 4 = 6$	Өөр хоорондоо холбоотой бодлого
$8 \times 1 = 8, 10 \times 1 = 10$	Үржүүлэх үйлдлийн шинж: Тоог нэгээр үржүүлэх (тэр тоо өөрөө гарна)

Тооцоолох чадварыг хөгжүүлэхийн тулд янз бүрийн тооцооллын алгоритмуудыг загварчилж, дадлага хийхэд ашиглаж болно. Тухайлбал, багш олон оронтой тоо бодох өөр өөр алгоритмуудыг танилцуулж, суралцагчид өөрт хамгийн тохиромжтой аргыг сонгон бодсон талаар санаагаа хуваалцах зэрэг үйл ажиллагаа хийж болно. Тооцооллыг

чөлөөтэй хийж сурахад цээжлэх нь зорилго биш, харин тооцооллыг хэрхэн үр ашигтай хийж байгаад анхаарах хэрэгтэй.

1. Өгүүлбэртэй бодлого

Математикт суралцахуйн бэрхшээлтэй суралцагчийнасуудал шийдвэрлэх чадварыг дэмжихэд өгүүлбэртэй бодлого бодох арга, алхмуудыг үр дүнтэй зааварчилгаагаар чиглүүлэх нь чухал. Өгүүлбэртэй бодлого бодох нь суралцагчдад математикийн мэдлэг, чадвараа харуулах боломж олгодог боловч энэ нь суралцахуйн бэрхшээлтэй суралцагчдад ихэвчлэн хэцүү байдаг.

Унших, математикийн мэдлэг ойлголтоо хэрэглэх нь өгүүлбэртэй бодлогыг ойлгоход зайлшгүй шаардлагатай ур чадвар болдог тул олон суралцагч, ялангуяа суралцахуйн бэрхшээлтэй суралцагчид өгүүлбэртэй бодлогыг бодоход бэрхшээлтэй тулгардаг (Jitendra & Star, 2011; Krawec et al., 2012; Xin et al., 2005).

Багш өгүүлбэртэй бодлогыг дараах алхмын дагуу бодоход анхаараарай. Ингэснээр суралцагчид юуг эхэлж хийх, дараа нь, эцэст нь яах хэрэгтэйг мэддэг болно. Үүнд:

1. Бодлогын өгүүлбэрийг анхааралтай унших
2. Юу олох гэж байгаагаа тодорхойлох
3. Чухал, хэрэгцээтэй мэдээллийг сонгох
4. Бодох арга болон үйлдлийг сонгох, гүйцэтгэх
5. Хариуг шалгах

Багш суралцагчийг тухайн өгүүлбэртэй бодлогыг ямар төрлийнх гэдгийг таньж сурахад анхаарна. Тэгвэл тэд тухайн бодлогын төрөлд тохирсон алхмуудаар бодлого бодож чадна. Жишээ нь, Төгөлдөрт 5 алим байсан. Тэр 3-ыг нэмж авсан. Одоо хэдэн алимтай болсон бэ гэвэл энэ нь өөрчлөлт (нэмэх)-тэй холбоотой бодлого, харин Төгөлдөрт 8 алим байсан. Туулд 5 алим байна. Төгөлдөр Туулаас хэдээр илүү алимтай вэ? гэвэл харьцуулах (хасах) бодлого гэдгийг ойлгох хэрэгтэй.

Тоо бодох, тооцоолох чадварын алдагдалтай сурагчид сургалтын хөтөлбөрийн тохируулга хийхдээ **алхам алхмаар, харааны болон хөдөлгөөний дэмжлэгтэй, бодит амьдралын жишээтэй** холбож хийх нь хамгийн үр дүнтэй байна.

Хүснэгт 14. Хичээлийн алхамчилсан жишээ

Хичээлийн алхам	Үйл ажиллагаа	Тайлбар
Загварчлал: Багш, суралцагчийн хамтын үйл ажиллагаа	Хичээлийн зорилгыг танилцуулна. Дараах бодлогыг харуулна. Өгүүлбэртэй бодлого: Худалдагч эхний өдөр 36 ширхэг, дараагийн өдөр 27 ширхэг ундаа худалджээ. Худалдагч хоёр өдөрт нийт хэдэн ширхэг ундаа худалдсан бэ?	Суралцагчид бодлогын өгүүлбэрийн уншиж ойлгоно. Шаардлагатай бол давтан уншина. Суралцагч бодлогын өгүүлбэрийг уншиж ойлгох, асуудлыг ойлгох, задлан шинжлэх, шийдлийг олох дадал төлөвшүүлэхэд “3R” аргыг хэрэглэж болно. Энэ арга нь “Read-Retell-Respond” гэсэн 3 алхамтай. 1 дүгээр алхам: Өгүүлбэртэй бодлогыг анхааралтай уншиж

	<p><i>Асуулт: Бодлогын өгүүлбэрээс юу ойлгосон бэ? Юуг олох гэж байна вэ? Бодлогыг бодоход хэрэг болох мэдээллүүд нь юу байна вэ?</i></p>	<p><i>ойлгоно. Бодлогод юу өгсөн, юу олохыг толдорхойлно.</i></p> <p><i>2 дугаар алхам: Өгүүлбэрийн утгыг ойлгосноороо өөрийн үгээр тайлбарлана.</i></p> <p><i>3 дугаар алхам: Бодлогын хариуг гаргах арга, шийдлээ баталгаажуулна.</i></p> <p><i>Суралцагч бодлогын өгүүлбэр дэх гол санааг өөрийнхөөрөө тайлбарлахад багш анхаарна.</i></p>
<p><i>Дадлага: Багш суралцагчийн хамтын үйл ажиллагаа</i></p>	<p><i>Тодорхой түвшин:</i></p> <p><i>Энэ үе шатад бодлогын өгүүлбэр дэх ундааг жижиг кубээр төлөөлүүлнэ. Өгсөн тоотой тэнцүү тооны тоолох хэрэгсэл авна.</i></p> <p><i>Нийт 36, 27 ширхэг хоёр багц кубийг сонгож, байрлуулна.</i></p> <p><i>Асуулт. Нэмэх үйлдлийн талаар та нар юу санаж байна вэ? Нэмэх гэдэг нь юу гэсэн үг вэ?</i></p> <p><i>Багш тоолох хэрэгслийг зөөж, орон ангийн хүснэгтэд байрлуулна. Багш аравтуудыг хооронд нь нэмээд нэгжүүдийг</i></p>	<p><i>Энэ шатанд суралцагч гараар барьж мэдрэх хэрэгцээтэй тул багш тоолох хэрэгсэл (жижиг куб)-ийг суралцагчдад аль болох хүртээмжтэй байхад анхаарах хэрэгтэй.</i></p> <p><i>Жич: Савх мэт өөр зүйлээр орлуулж болно.</i></p> <p><i>Нэг жижиг куб нь нэгжийг, 10 ширхэг жижиг куб аравтын орныг илэрхийлэхийг суралцагчид мэдсэн байна.</i></p> <p><i>Суралцагчид 36-г 3 аравт (арван ширхэг шооны багц 3), 6 нэгж (зургаан ширхэг куб), 27-г 2 аравт (арван ширхэг шооны багц 2), 7 нэгж (долоон ширхэг куб)-ийг гараараа барьж сонгосон байна.</i></p> <p><i>Суралцагчийн хариултад нэмэх нь нийлүүлж тавих, эсвэл нэгтгэх гэх мэт санаанууд багтана.</i></p> <p><i>Орон ангийн хүснэгтэд байрлуулсан кубуудийн нийт тоог хэрхэн олж байгаад анхаарлаа хандуулна.</i></p>

	<p><i>хэрхэн нэмж байгааг суралцагчдад тод харуулна.</i></p> <p><i>Багш эхлээд аравтын орны кубүүдийг нэмээд дараа нь нэгжийн орны кубуудийн тоог олно.</i></p> <p><i>Хийсвэр түвшин:</i></p> <p><i>Аравтуудыг (арван ширхэг кубийн багц) нэмээд 50-тай тэнцэнэ.</i></p> <p><i>Дараа нь нэгжүүдийг (ногоон саваа) нэмээд 13-тай тэнцэнэ.</i></p> <p><i>Эцэст нь 50 дээр 13-ыг нэмээд нийлбэр нь 63 болно. 36 дээр 27-ыг нэмээд 63 болно.</i></p>	<p><i>Нэгжийн орны кубүүд 6 ба 7-ийн нийлбэрийг хэрхэн олж байгаад анхаарна.</i></p> <p><i>Арав гүйцээн нэмэх тухай мэдлэгийг суралцагчид хэрэглэж байгаа эсэхийг нягтлаарай. Нийлүүлээд тоолж олох суралцагчид ч ангид байж болно.</i></p> <p><i>Хоёр оронтой тоог хэрхэн нэмэх аргыг зааж байх явцад багш эхлээд шууд баганан бичиглэлээр бичихгүй байхад анхаараарай.</i></p>
<p><i>Дадлага: Суралцагчийн бие даасан үйл ажиллагаа</i></p>	<p><i>Багш хоёр оронтой тоог нэмэх дасгал харуулна.</i></p> <p><i>Суралцагчид хосоор ажиллана.</i></p> <p><i>Нэг суралцагч нь тоолох хэрэгсэл хэрэглэн нэмнэ. Нөгөө нь бичгээр нэмж, хариугаа хоорондоо харьцуулна.</i></p>	<p><i>2 оронтой тоог нэмэхэд аравтын орны тоон дээр аравтын орныг, нэгжийн орны тоон дээр нэгжийн орныг нэмэх, тооцоолох аргад суралцана.</i></p>

Хөтөлбөрт тохируулга хийх жишээ:

Сурагчийн ерөнхий мэдээлэл: Сурагч “М”, эмэгтэй, ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар анги, эрүүл мэндийн байдал: Хэвийн. Эрүүл мэндийн байгууллагаас тусгайлсан онош байхгүй. Тухайн сурагчийн хувьд тоо бодох, тооцоолох чадварын алдагдалтай гэж үзэх үндэслэлтэй байна. Цээж бичиг бичихдээ алдаа их гаргадаг. Багшийн зүгээс тоо бодох, тооцоолох чадварыг дэмжих зорилгоор 3 сарын хугацаанд долоо хоногт 1 цагийн нэмэлт давтлага өгч ажиллаж байгаа боловч үр дүн багатай байна. Суралцахуйн бэрхшээлтэй (тоо бодох, тооцоолох чадварын алдагдалтай) гэж үзэх үндэслэл байгаа учраас сурагч “М”-ийн математикийн сургалтын хөтөлбөрт тохируулга хийж ажиллах (хугацааг 3 сар гэж ойролцоогоор) хүсэлтэй байгаа болно.

Суралцагчийн төлөв байдал

- Математикийн хичээлийн хоцрогдолтой.
- Дүрслэх урлаг, биеийн тамир, хөгжим зэрэг хичээлд сонирхолтой. Багш болон ангийн найз нартайгаа харилцахдаа хэвийн. Ангийн найз нартайгаа цэвэрлэгээ хийх, бусдад туслах, өөрийгөө илэрхийлэх бүрэн чадвартай. Хооллох зуршил сайн. Биеийн ерөнхий хөгжил сайтай.

- Зарим тохиолдолд хүүхэдтэй муудалцдаг боловч, уучлал гуйж эвлэрч чаддаг.
- Ангийнхан нь дээрэлхдэггүй. Спорт, урлагийн арга хэмжээнд сайн оролцдог.
Ар гэрийн байдал:
- Аав, ээж, 3 дүүтэйгээ амьдардаг. Ам бүл 6
- Эрэгтэй дүүтэйгээ тоглодог, эмэгтэй дүүгээ гэртээ хардаг, гэрийн ажилд тусалдаг.
- Гэртээ гэрийн даалгавраа хийх дургүй, ихэнхдээ кино, компьютерээр тоглодог.
- Аав, ээж нь хүүхдийнхээ гэрийн даалгавар хийлгэх, бие даан суралцахад тусалж төдийлөн чаддаггүй. Ажил ихтэй гэж ярьдаг. Ээж нь ихэвчлэн сургуулиас нь авдаг.

Сургууль дээрх байдал:

- Ангийн багш нь сурагч “М”-г тоо бодуулж сургахад нэмэлт цаг зурцуулж байгаа боловч үр дүн муу байгаа учраас сургалтын хөтөлбөрт тохируулга хийх хэрэгцээтэй гэдгийг гэр бүлийн гишүүд аав, ээжид нь танилцуулж, зөвшөөрөл авсан. Сургууль дээрх “Дэмжлэгийн баг”-ийн гишүүдэд асуудлыг танилцуулсан.
“2 оронтой тоог нэмэх” сэдвийн хүрээнд тохируулгын арга зүйн жишээтэй танилцъя.

Суралцахуйн үр дүн: “ 2 оронтой тоог нэмэх”

Зорилго: Тоолох хэрэгсэл ашиглан хоёр оронтой тоог нэмэх аргад суралцах

Хэрэглэгдэхүүн: Тоолох хэрэгсэл (жижиг шоо)

1. Сургалтын зорилго нь :

- **Сурагч 2 оронтой тоог нэмэх үйлдлийг ойлгож, алхам алхмаар гүйцэтгэх.**
- **Сурагчид харааны, хөдөлгөөний, бодит амьдралын практик хэрэглээний дэмжлэгээр тооцоолох чадварыг эзэмшүүлэх.**

2. Сургалтын орчин ба хэрэглэгдэхүүн

- **Харааны хүртэхүйг хөгжүүлэх картууд:** тоо бүхий өнгөт карт, жижиг шоо, тоон шугам.
- **Бодит зүйлс:** жимс, тоглоом, машин, жижиг шоо
- **Дижитал хэрэгсэл:** тооны нэмэх дасгалыг харуулсан цахим хичээл, тоглоом, интерактив самбар.

3. Алхамчилсан арга зүй

- **Алхам 1: Тоог таних**
Хүүхдэд 2 оронтой тоог карт дээр харуулж, уншиж таних дасгал хийлгэнэ.
Жишээ нь: “25” гэсэн тоог хараад “хоёр аравт, таван нэгж” гэж задлуулна.
- **Алхам 2: Аравт ба нэгжийг ялгах**
Тоог аравт, нэгжийн оронд хувааж, бодит зүйлээр илэрхийлнэ.
Жишээ нь: $34 = 3 \text{ аравт модон савх} + 4 \text{ ширхэг жимс}$.

- **Алхам 3: Нэмэх үйлдлийг хийж үзэх**
Тооны шугам дээр эсвэл бодит зүйлсийг ашиглан нэмэх үйлдлийг хийлгэнэ.
Жишээ нь : $25 + 13 \rightarrow$ эхлээд 25 дээр 10 нэмээд 35, дараа нь 3 нэмээд 38.
- **Алхам 4: Харааны дэмжлэгтэй бичгээр бодох**
Тоог аравт, нэгжийн оронгоор бичиж, баганан үйлдлээр нэмэх дасгал хийлгэнэ.
Жишээ:

- $$\begin{array}{r} 25 \\ +13 \\ \hline 38 \end{array}$$

- **Алхам 5: Амьдралын өдөр тутмын танил жишээтэй холбох**
Хүүхдэд ойлгомжтой нөхцлөөр өгүүлбэртэй бодлого өгч бодуулна.
Жишээ нь: “Чамд 25 тоглоом байна. Найз чинь 13 тоглоом нэмж өглөө. Чи хэдэн тоглоомтой болсон бэ?”

4. Дэмжлэгийн арга

- **Хүүхдийн гаргасан алдааг засах дэмжлэг:** Хүүхэд буруу бодсон тохиолдолд зөв хариуг харааны аргаар дахин тайлбарлана.
- **Давталт ба тоглоомчлол:** Тоо нэмэх дасгалыг тоглоомын хэлбэрээр олон дахин давтуулан хийнэ.
- **Урамшуулах:** Хүүхэд зөв бодсон тохиолдолд од, наалт, оноо өгч урамшуулна.

5. Үнэлгээ

- Хүүхэд харааны хүртэхүйн дэмжлэгтэйгээр 2 оронтой тоог нэмэх чадвартай болсон эсэхийг шалгана.
- Бага багаар харааны дэмжлэгийг хасаж, бие даан бодох чадварыг хөгжүүлнэ.

СУДЛАГДАХУУНЫ НЭР: БАЙГАЛЬ ШИНЖЛЭЛ

АНГИ: IV анги

Суралцахуйн үр дүн: “Дэлхий” айн - Орон зай дэд айд хамаарах “4.4а. Таних тэмдэг, зүг чигийн тэмдэглэгээ ашиглан гэр ба сургууль орчмын план зураг зурж танилцуулна”

Нэг. Сурагчийн талаарх ерөнхий мэдээлэл: Сурагч “Х”, эрэгтэй, ерөнхий боловсролын сургуулийн 4 дүгээр анги, эрүүл мэндийн байдал: Сул хараатай (ЭМБ-ын нүдний нарийн мэргэжлийн эмчийн оноштой. Хязгаарлагдмал зайд 0,5 м орчимд харах боломжтой). Сурагч “Х”-ийн хувьд хичээлийн агуулгаа бүрэн эзэмших боломжтой, оюун ухааны хөгжил, биеийн хөгжил хэвийн харин хөдөлгөөн чөлөөтэй боловч тэнцвэрийн хувьд бага зэргийн алдагдалтай, одоогоор бие дааж нийгмийн үйлчилгээнд оролцох боломж хязгаарлагдмал байна.

Сурагч “Х” харааны бэрхшээлийн улмаас суралцах үйлд тодорхой хүндрэл үүсэж байгаа учраас 4 сарын хугацаанд долоо хоногт 1 цагийн нэмэлт давтлага өгч ажиллаж байна.

Суралцагчийн төлөв байдал

- Математик, монгол хэлний болон бусад хичээлийн хувьд хоцрогдол багатай байгаа боловч, брайл, аудио хэрэглэгдэхүүн ашиглаж сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг авах хүсэлтэй. Биеийн тамирын хичээлд анги нийтийн хэлбэрээр хамрагдах сонирхолгүй, ганцаарчилсан хэлбэрээр тэнцвэр хөгжүүлэх дасгал хийх, хязгаарлагдмал бус орон зайд явах, хөдлөх арга техник эзэмших хүсэлтэй байна.
- Багш болон ангийн найз нартайгаа харилцахдаа хэвийн. Ангийн найз нартайгаа цэвэрлэгээ хийх, бусдад туслах, өөрийгөө илэрхийлэх бүрэн чадвартай. Хооллох зуршил сайн. Биеийн ерөнхий хөгжил сайтай.
- Ангийн хүүхдүүдтэй эвтэй, найз нөхдийн зүгээс түүнд тусалдаг.
- Ангийнхан нь дээрэлхдэггүй. Хөгжим тоглох дуртай, урлагийн арга хэмжээнд сайн оролцдог.

Ар гэрийн байдал:

- Аав, ээж, 2 дүүтэйгээ амьдардаг. Ам бүл 5
- Эрэгтэй дүүтэйгээ тоглодог, эмэгтэй дүүгээ гэртээ хардаг, гэрийн ажилд тусалдаг.
- Гэртээ гэрийн даалгавраа хийдэг боловч, алдааг нь засаж хэлж өгч, тусалдаг хүн байхгүй. Аудио подкаст их сонсдог. Компьютерт тохиргоо хийж тоглохыг хүсдэг.
- Аав, ээж нь хүүхдийнхээ гэрийн даалгавар хийлгэх, бие даан суралцахад тусалж төдийлөн чаддаггүй. Ээж нь бага насны 2 дүүг нь хардаг. Гэрийн ажил ихтэй, аав нь хөдөө ажилладаг. Ээж нь ихэвчлэн сургуулиас нь авдаг.

Сургууль дээрх байдал:

Ангийн багш нь сурагч “Х”-г байгалийн ухааны хичээлд сонирхолтой, илүү ойлгох, ирээдүйд эзэмших мэргэжлээ геологич болно гэж мөрөөддөг учраас байгалийн ухааны хичээлийн арга зүйд тохируулга хийж, мэдлэг, чадварыг нь ахиулах, бие даан суралцах чадварыг нь дэмжих зорилгоор сургалтын хөтөлбөрт тохируулга хийх хэрэгцээтэй гэдгийг гэр бүлийн гишүүд аав, ээжид нь танилцуулж, зөвшөөрөл авсан. Сургууль дээрх “Дэмжлэгийн баг”-ийн гишүүдэд асуудлыг танилцуулсан.

Бид харааны бэрхшээлтэй сурагчид сургалтын хөтөлбөрийн тохируулга хийхээр төлөвлөж байгаа учраас харааны бэрхшээлтэй хүүхдийн хөгжих, сурах арга барилын онцлогийн талаар товч мэдээлэл хүргэе.

Харааны бэрхшээлтэй сурагч нь харааны алдагдлын түвшингээс хамаарч сурах арга барил нь харилцан адилгүй байдгийг дараах томъёоллоос ойлгож болно.

- *Сул хараатай суралцагч- Харааны задлан ялгах хэсгийн өөрчлөлтөөс шалтгаалан харах чадвар нь буурсан.*
- *Үлдээгдэл хараатай суралцагч – хөдөлгөөнтэй болон томоохон биет зүйлийг хардаг, хуруу тоолдог, нарны ба хурц туяаг бага зэрэг мэддэрдэг.*
- *Огт хараагүй суралцагч – Гэрлийн ямарч мэдрэмжгүй, зөвхөн бусад мэдрэхүйн эрхтэний тусламжтайгаар орчинтой харьцах чадвартай. Зөвхөн тэмтрэх*

маягаар танин мэдэж, арьсны мэдрэхүй харах эрхтэнээ орлон нөхөж байдаг (сан, 2010).

Харааны бэрхшээлтэй суралцагч хөдөлгөөний хувьд орон зай, цаг хугацаа, хөдөлгөөний баримжааны алдагдал, дутуу хөгжилтэй, танин мэдэхүйн хувьд харж танин мэдэх чадварын алдагдалтай, зан төлөвийн хувьд гутрамтгай, өөртөө итгэх итгэл муу болж хөдөлгөөний эвсэл, хурд, хүч суларч дутуу хөгжиж болно. Харин оюун ухааны хувьд мэдэрч танин мэдэхээс сэтгэж танин мэдэх, үйл ажиллагаагаар танин мэдэх, онолын түвшинд танин мэдэхийг хамарч оюун дүгнэлт хийх чадварт доголдол гарч болно. Хэл ярианы хувьд бичгийн хэлэнд бэрхшээл тулгарч, хуруугаар тэмтрэх, сонсох ба сэтгэл хөдлөл нь санаа зовомтгой, сэтгэлийн шаналал давамгайлах байдал ажиглагдана. Бусдын тусламж, дэмжлэг, зөвлөгөө шаардагддаг. Төлөвлөх, зураглах, бүдүүвч хүснэгт гаргахад товгор дүрс, биет материал шаардагдах боловч өөрийн бүтээлийг харж алдаагаа засахад бэрхшээл тохиолдоно (Цэвээнлхазал, 2016).

Хоёр. *Сургалтын хөтөлбөрт тохируулга хийх арга зүйн санаа*

Суралцахуйн үр дүн: “Дэлхий” айн - Орон зай дэд айд хамаарах “4.4а. Таних тэмдэг, зүг чигийн тэмдэглэгээ ашиглан гэр ба сургууль орчмын план зураг зурж танилцуулна” Сургалтын хөтөлбөрт тохируулга хийх чиглэл: Суралцахуйн үр дүн болон арга зүй, хэрэглэгдэхүүнд өөрчлөлт хийх

Харааны бэрхшээлтэй (харааны бүрэн алдагдалтай) суралцагчийн дараах онцлогийг харгалзан үзэж суралцахуйн үр дүнд тохируулга хийж болно. Үүнд:

Мэдээлэл хүлээн авах онцлог:

- Мэдээллийг нүдээр бус, бусад мэдрэхүйн сувгаар (сонсох, барих, үнэрлэх, хөдөлгөөнөөр мэдрэх) авдаг.
- Тактиль (гарын мэдрэмж), аудио (дуу чимээ), кинестетик (хөдөлгөөн) мэдээлэл нь тэдний гол сургалтын эх үүсвэр болдог
- Шинэ мэдээллийг дараалалтай, алхамчилсан, бодит баримтад суурилсан байдлаар өгөх шаардлагатай

Орон зайн ба орчны баримжаа:

- Орон зайн төсөөлөл нь харааны бус мэдрэхүйд тулгуурладаг тул бодит туршлага, хөдөлгөөн, хүрэлцэх мэдрэхүйгээр дамжуулан хөгждөг.
- Чиглэл, байрлал, зай, хэлбэр, хэмжээ зэрэг ойлголт бүрдүүлэхэд биеэр оролцох, хүрэх, алхах, хэлбэр барих зэрэг үйл ажиллагаа чухал.
- Танил бус орчинд чиг баримжаа муу, аюулгүй байдлын мэдрэмж сул байдаг тул орчны дуу чимээ, тэмдэглэгээ, зааг хязгаар ашиглан чиглүүлэх шаардлагатай.

Хүснэгт 15. Суралцахуйн үр дүн, тохируулга

Анхны суралцахуйн үр дүн (БШ IV анги)	Харааны бэрхшээлтэй хүүхдэд тохируулсан үр дүн
4.4а. Таних тэмдэг, зүг чигийн тэмдэглэгээ ашиглан гэр ба сургууль орчмын план зураг зурж танилцуулна.	Сургууль болон анги танхимын орчмын орон зайн онцлогийг ялгаж тодорхойлно.

Эх сурвалж: Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл эрүүл мэндийн олон улсын ангилал (2023)

Ямар үр дүнд (мэдлэг, чадвар, төлөвшил) хүрэх вэ?

Хүснэгт 16. Хүрэх үр дүн ба мэдлэг, чадвар, төлөвшил

Хүрэх үр дүн	Мэдлэг	Чадвар	Төлөвшил
Сургууль болон анги танхимын орчмын орон зайн онцлогийг ялгаж тодорхойлно	Орон зайн ойлголт (чиглэл, байрлал, ойр-хол, өндөр-нам гэх мэт)-ыг мэднэ	Хүрэх, сонсох, үнэрлэх, барих, алхах замаар орчны мэдээллийг цуглуулж, дүрслэн илэрхийлнэ	Орчныг аюулгүй таних, бусдыг сонсох, хамтран ажиллах дадал эзэмшинэ

Ямар арга зүйгээр хэрэгжүүлэх вэ? Харааны бэрхшээлтэй суралцагч орчны мэдээллийг тактиль (гарын мэдрэмж), аудио (дуу чимээ, зүг чиг), үнэр, биеийн хөдөлгөөн гэх мэт бусад мэдрэхүйн сувгаар авдаг. Тиймээс хичээлд туршилт, хөдөлгөөн, дүрслэл, мэдрэхүйн үйлдэлд суурилсан арга ашиглана.

Ямар хэрэглэгдэхүүн ашиглах вэ?

- Тактиль газрын зураг, хөвөн/шавар загвар
- Сургууль болон анги танхимын орчны макет
- Дуу бичлэг төхөөрөмж, зөөврийн чанга яригч
- Ургамал, чулуу, элс, усны дээж (мэдрэхүйгээр ялгах)
- Аюулгүй алхалтын чиг заах цагаан таяг эсвэл саваа, хязгаарлалтын олс

Хэрэгжүүлэх үе шат ба дэмжих чадварууд

Энэ хэсэгт тохируулсан суралцахуйн үр дүнг хэрэгжүүлэхдээ баримтлах үе шат, арга зүй дэмжих чадварыг “Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал”-ын дагуу тусгасан болно.

Хүснэгт 17. Хичээлийн алхамчилсан жишээ

Хэрэгжүүлэх үе шат	Арга зүй ба дэмжих чадварууд
---------------------------	-------------------------------------

<p>Бэлтгэл үе шат - анги дотор (1 цаг)</p>	<ul style="list-style-type: none"> • Мэдрэхүйн тоглоом: “Баруун/зүүн талд юу байна вэ?” — багш дуугаар чиглэл өгч, суралцагч гар эсвэл толгойгоор чиг зааж хариулна. Энэ нь b 1144 Зүг чигийн баримжаалал-ыг хөгжүүлнэ • Жижиг орчны загвар (макет): Хичээлийн танхимын загварыг баримал шавар, хөвөн, модон савх ашиглан тактиль хэлбэрээр бүтээж, орон зайг баримжаалуулна. Энэ нь d1201 Хүрэлцэх үйлдлээр танин мэдэх чадварыг сайжруулна. • Дуу чимээгээр чиглэл тогтоох: Багш өөр газар зогсоод дуу гаргаж, суралцагч дууны зүгийг тодорхойлно.
<p>Сургуулийн орчныг судлах үе шат (1 цаг)</p>	<p>Тактиль газрын зураг: Сургуулийн байр, хашаа, мод, талбайг өндөрлөгтэй, баримал хэлбэрийн зураг (фетр, картон, олс ашиглан) бэлдэнэ.</p> <p>Орон зайн аялал:</p> <ul style="list-style-type: none"> • Багш, туслах багшийн хамт суралцагчийг сургууль орчмоор 5–10 минут алхуулах (туслах багшийн дэмжлэг нь e330, нөхдийн харилцаа эсвэл e340 хувь хүний туслагч, тусламж гэсэн дэмжигч хүчин зүйлстэй нийцнэ) • Дуу чимээ (машин, суралцагчийн инээд, салхины исгээрээ, хаалганы дуу гэх мэт)-ээр газар тодорхойлуулах • Өндөр нам, бартаа, гадаргуу (зөөлөн/хатуу/шороо/зам) ялгуулах - Энэ нь b265 Хүрэлцэх үйлдэл-ийг идэвхжүүлнэ. <p>Аюулгүй байдлын дасгал: Алхалтын чиг баримжаа (саваагаар шалгах, сонсох, алхах дараалал, зогсох тэмдэг)</p>
<p>Мэдээллийг боловсруулах үе шат (1 цаг)</p>	<p>Орон зайн загвар бүтээх: Суралцагчид хамтран сургууль орчны шавар, модон саваа, даавуу, хөвөн зэрэг материалаар дүрслэх - энэ нь дүрслэлийн чадварыг хөгжүүлэх d155 Чадваруудыг эзэмших болон d163 Бодох (төсөөлөн бодох) үйлдлүүдтэй холбогдоно.</p> <p>Дуу бичлэг ашиглах: Сургуулийн орчны дуу чимээг бичиж, түүний дагуу орчны зураглалыг тайлбарлуулах - Энэ нь b230 Сонсох үйл ажиллагаа-г орон зайн баримжаа олоход ашиглах явдал юм.</p> <p>Ярианы зураглал: “Сургууль орчимд би хаагуур алхсан бэ?”, “Юу сонссон бэ?”, “Юуг мэдэрсэн бэ?” гэх асуултаар аман тайлан гаргуулах - Энэ нь d330 Ярих (харилцаа холбоог үүсгэх) чадварыг ашиглан мэдлэгээ илэрхийлэх үйлдэл юм</p>

Нэмэлт тайлбар: “Тактиль” (tactile) гэдэг нь хүрэлцэх буюу мэдрэх мэдрэхүйтэй холбоотой ойлголт юм. Энэ үг нь латин хэлний “tactilis” буюу “хүрэх боломжтой” гэсэн үгнээс гаралтай. Тактиль газрын зураг - байршил, зам, барилга зэргийг товгор, ялгаатай бүтэцтэй материалаар дүрслэн гарын тусламжтай “хардаг” зураг.

Тактиль сургалтын хэрэглэгдэхүүн - бодит зүйлс (чулуу, навч, мод, тоглоомын загвар, байшингийн макет) — суралцагч гарын мэдрэмжээр ялгадаг.

Суралцагчийг бага наснаас нь эхлэн орчных нь эд зүйлийг тэмтэрч мэдрүүлж сургах хэрэгтэй ба энэ мэдрэхүйгээр дамжуулан харааны бэрхшээлтэй суралцагч хүрээлэн байгаа орчны талаар мэдээлэлтэй болно. Ямар нэгэн зүйлийг зөвхөн тэмтэрч үзсэний дараа түүний хэлбэр, хэмжээ, жин, халуун, хүйтэн, гадаад байдлын талаар үнэн бодит мэдээлэл авна (сан, 2010).

Ээлжит хичээлийн жишээ

Хичээлийн сэдэв: *Сургууль болон ангийн орчинтой танилцъя*

Судлах цаг: 3 цаг

Хичээлийн зорилго:

Харааны бэрхшээлтэй суралцагчийг орчныг мэдрэх, тодорхойлох, чиг баримжаагаа олж сурах, байгаль орчны талаарх ойлголтоо бодитоор бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.


Зорилт:

- Орчныг мэдрэх болон орон зайн төсөөллийг мэдрэх чадвар хөгжүүлэх
- Чиг баримжаа олох, хөдөлгөөний ур чадвар эзэмших
- Орон зайн дүрслэл, ойлголт төлөвших
- Байгаль орчны талаарх бодит ойлголт бий болох
- Хамтын үйл ажиллагаанд оролцох чадварыг хөгжих

1. Бэлтгэл үе шат – туршилт хөдөлгөөнөөр зүг чигийн баримжаа олгох арга.

Багш анги танхимд баруун зүүн талд юу байна вэ? – багш дуугаар чиглэл өгч суралцагч өөрийн баруун зүүн гараар эсвэл толгойгоор чиг зааж хариулна. Эхлээд зөвхөн нэг зүг рүү (урагшаа, урагшаа) дохио өгч суралцагч зааврын дагуу нэг нэгээр урагшаа явна.

Дараа нь урагшаа хойшоо гэсэн 2 зүг рүү, түүний дараагаар урагшаа, хойшоо, баруун, зүүн тийшээ гэх мэтээр бага багаар дохиог нэмж өгнө. Суралцагчид зааврын дагуу 4 зүгийн баримжаатай болно. Үүний дараагаар багш өөр өөр газар зогсон дуу гаргаж суралцагч дууны зүг чигийг тодорхойлно.




хананд байна? гэх мэтээр анги доторх орон зайг баримжаалуулна.

Зураг 1. Зүг чигийн баримжаа олгох хөдөлгөөнт дасгал

Эх сурвалж: Сургалтын үйл ажиллагааг дэмжих тусгай хэрэгцээт боловсролын арга зүй-бага ангийн жишээн дээрх 172 шилдэг санаа (159-р хуудас)

Ангийн дотоод орчин (сандал, ширээ, самбар, хаалга, цонх) товойлгон дүрсэлсэн тактиль хэрэглэгдэхүүн макетыг тэмтрүүлж анги дотор хаана юу байгааг нэрлүүлж баримжаалуулна. Жишээ нь ангийн урд хананд юу өлгөөтэй байна? Ангийн багшийн ширээ ангийн аль хэсэгт байна? Чиний суудаг ширээ ангийн хаана байна? Ангийн цонх, хаалга аль талын




Зураг 2. Ангийн дотоод орчны план зураг, макет

Сургуулийн орчныг судлах үе шат – Газар орчинд суурилсан арга (Place based learning)

Багш туслах багшийн хамт суралцагчдыг сургууль орчмоор 5-10 минут алхуулах. Ингэхдээ дуу чимээгээр газар орчны нөхцлийг тодорхойлуулна. Жишээ нь машин, суралцагчийн дуу чимээ, хаалганы дуу чимээгээр хаана юу байгааг баримжаалуулна. Мөн сургуулийн баруун, зүүн, хойно, урд зүгт байгаа хашаа, тоглоомын талбай, сандал, ургаа мод, авто машины зогсоол, явган хүний зам гэх мэтийг мэдрүүлэн танилцуулна.

Мэдээллийг боловсруулах үе шат – Орон зайн загвар, зураглал бүтээх арга

Суралцагчдын цуглуулсан мэдээлэл, баримжаанд тулгуурлан гар доорх материал (баримлын шавар, модон саваа, хуванцар, даавуу, хөвөн гэх мэт) ашиглан сургуулийн гаднах орчны болон анги доторх орчны зураглал, макет хийнэ. Ингэхийн тулд багш өмнөх олж авсан мэдээлэл баримжаалалд тулгуурласан асуултаар чиглүүлнэ. Жишээ нь ангийн урд хананд юу өлгөөтэй байсан бэ? Ангийн ширээ, хаалга аль хананд байсан бэ? авто машины зогсоол, явган хүний зам, ургаа мод, тоглоомын талбай сургуулийн хаана байсан бэ? гэх мэтээр зураглал, макетыг бүтээлгэнэ.



Зураг 3. Сургууль орчмын план зураг, макет

Дүгнэлт ба үнэлгээний үе шат

Үнэлгээний зорилго: Харааны бэрхшээлтэй суралцагчийн байгаль орчны талаарх мэдлэг, орон зайн баримжаа, мэдрэхүйн чадвар, хамтын ажиллагаа, аюулгүй байдлын ухамсар зэргийг илрүүлэх, дэмжихэд чиглэнэ.

Хүснэгт 18. Үнэлгээний шалгуур

Үнэлгээний үзүүлэлт	Үнэлгээний шалгуур
Орчныг тодорхойлох чадвар	Сургууль, анги танхимын орчны байрлал, гол объектыг зөв ялгаж хэлж чадсан эсэх
Орон зайн ойлголт	Чиглэл, зай, ойр-хол, баруун-зүүн ялгаж хэрэглэж чадсан эсэх
Хамтын ажиллагаа	Бусад суралцагчтайгаа хамтран ажиллаж, аюулгүй орчныг хүндэтгэж чадсан эсэх
Өөрийгөө илэрхийлэх	Мэдрэмжээ хэлээр илэрхийлж, тайлбарласан байдал

Үнэлгээнд анхаарах зүйлс:

Үнэлгээг туршилт, мэдрэхүйн туршлага дээр тулгуурлан зохион байгуулах.

Харааны бус оролцоог үнэлэхдээ дуу, хүрэлцэх, үнэрлэх мэдрэмжийг ялгах чадварыг чухалчилна.

Үнэлгээг үе шаттай хийх:

- 1-р шат: анхан баримжаа (таних, ялгах)
- 2-р шат: чиглэл тогтоох (хөдөлгөөн, орчны дүрслэл)
- 3-р шат: тайлбарлах, дүгнэх (ярилцах, бүтээл хийх)

Үнэлгээнд хамтран суралцагч, туслах багш, эцэг эхийн саналыг давхар тусгах.

Үнэлгээний үр дүнг суралцагчийн дэвшилд чиглүүлэн, урамшуулал хэлбэрээр буцаан өгөх (жишээ нь: “Чи өнөөдөр орчны дууг маш сайн ялгалаа” “орчны юмсыг маш сайн мэдэрч танилаа” г.мэт.

Харааны бэрхшээлтэй суралцагчийн орон зайн ойлголт, байгаль орчны мэдлэгийг үнэлэх нь зөвхөн үнэлгээ биш, харин туршлага хуримтлуулах, өөрийгөө илэрхийлэх, орчныг аюулгүй таних чадварыг хөгжүүлэх үйл явц юм.

Багшид өгөх нийтлэг зөвлөмж:

- Харааны бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээг судалж, “чиг баримжаа ба хөдөлгөөн”-ийн мэргэжилтний зөвлөгөөг авах.
- Ойлголтыг гүнзгийрүүлэх үүднээс тактиль материал, дуу бичлэг, үнэрт ургамал, бодит объект ашиглах
- Харааны бэрхшээлтэй суралцагчийн алхах зам, суудлын байрлал, гэрэлтүүлэг, саадгүй орчин бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангах
- Харааны бус оролцоог үнэлэхэд анхаарах (жишээ нь: дуу чимээг зөв ялгасан, баримжаа зөв тогтоосон, өөрийгөө тодорхой илэрхийлсэн гэх мэт).
- Суралцагчаар гүйцэтгүүлэх сорил даалгавар нь бодит зүйлсийг тэмтэрч мэдрүүлэн асуултаар чиглүүлэн ярилцах, биеийн хөдөлгөөнөөр гүйцэтгүүлэх хэлбэртэй байна.

Харааны бэрхшээлтэй суралцагч “харж бус, мэдэрч, сонсож, хийж туршиж суралцдаг.” Тиймээс тэдэнд тохирсон сургалт нь орчны мэдрэхүйд суурилсан, дуу, хөдөлгөөн, хүрэлцэх мэдрэмжийг идэвхжүүлсэн, бодит оролцоотой байх ёстой.

Хүснэгт 19. Суралцагчийн ахицыг үнэлэх хуудас

<i>Үнэлгээний шалгуур</i>	<i>Үнэлгээ</i>			<i>Тайлбар</i>
	<i>Бага (1)</i>	<i>Дунд (2)</i>	<i>Сайн (3)</i>	
<i>Сургууль, анги танхимын орчны байрлал, гол объектыг зөв ялгаж хэлж чадсан эсэх</i>				
<i>Чиглэл, зай, ойр-хол, баруун-зүүн ялгаж хэрэглэж чадсан эсэх</i>				
<i>Бусад суралцагчтайгаа хамтран ажиллаж, аюулгүй орчныг хүндэтгэж чадсан эсэх</i>				
<i>Мэдрэмжээ хэлээр илэрхийлж, тайлбарласан байдал</i>				

Жич: Үнэлгээний түвшнийг дараах байдлаар тооцно.

- Бага (1) - Багшийн шууд удирдамж дор орчны мэдээллийг ялгах, баримжаалах оролдлого хийдэг.
- Дунд (2) - Тодорхой тусламжтайгаар зөв тодорхойлдог, ойлголтоо яриагаар илэрхийлдэг.
- Сайн (3) - Орон зайн чиглэл, байрлалыг зөв тогтоож, бодит орчны талаар ойлголттой, бие даан ажиллаж чаддаг.

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. (2023). Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл эрүүл мэндийн олон улсын ангилал. Улаанбаатар.
2. НҮБ Суралцагчийн сан. (2010). Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтэй ажиллах арга зүй. Улаанбаатар.
3. Боловсролын хүрээлэн. (2020). Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих арга зүйн зөвлөмж. Улаанбаатар.
4. Цэвээнлхазал, Я. ., А нар, (2016). Хувь суралцагчийн хөгжлийг дэмжих заслын аргууд. Улаанбаатар.
5. Япон улсын Суралцагчийг ивээх сан, М. (2020). Сургалтын үйл ажиллагааг дэмжих тусгай хэрэгцээт боловсролын арга зүй - бага ангийн жишээн дээрх 172 шилдэг санаа. Улаанбаатар.

АНГИ: III

Суралцахуйн үр дүн: *“Хатуу, шингэн, хийн төлөвийн шинж чанарыг харьцуулан тайлбарлана.”*

Сурагчийн талаарх ерөнхий мэдээлэл: Сурагч “С”, эмэгтэй, ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар анги, эрүүл мэндийн байдал: Сонсголтгүй. (ЭМБ-ын чих хамар хоолой, сонсгол судлалын нарийн мэргэжлийн эмчийн оноштой. Сурагч “С”-ийн хувьд хичээлийн агуулгаа бүрэн эзэмших боломжтой, оюун ухааны хөгжил, биеийн хөгжил хэвийн, харин хөдөлгөөн чөлөөтэй боловч тэнцвэрийн хувьд бага зэргийн алдагдалтай, одоогоор бие дааж нийгмийн үйлчилгээнд оролцох боломж хязгаарлагдмал, хэл яриа хөгжөөгүй, дохионы хэлээр харилцдаг.

Сурагч “С” сонсголтгүйн улмаас суралцах үйлд тодорхой хүндрэл үүсэж байгаа учраас сургалтын хөтөлбөрийн арга зүйд тохируулга хийх үндэслэлтэй байна.

Суралцагчийн төлөв байдал

- Математик, дүрслэх урлаг, дизайны хичээлд сонирхолтой. Монгол хэлний хичээлд хоцрогдолтой. Бичих чадвар муу, цээжээр бичиж чадахгүй, хуулан бичлэг хийдэг, үгийн утга ойлгоход хүндрэлтэй. Дохионы хэл, видео хэрэглэгдэхүүн ашиглаж сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг авах хүсэлтэй.
- Биеийн тамирын хичээлд анги нийтийн хичээлд сонирхолтой, хөгжмийн хичээлээр бүжиглэх авьяасаа хөгжүүлж, дугуйланд хичээлээс гадуур хамрагдах сонирхолтой.
- Багш болон ангийн найз нартайгаа харилцахад хүндрэлтэй. Ангийн сурагчид дохионы хэл мэдэхгүй. Багш нар дохионы хэл мэдэхгүй учраас харилцааны хувьд маш их хүндрэлтэй. Ангийн найз нартайгаа дохио зангаагаар харилцаж, цэвэрлэгээ хийх, бусдад туслах, өөрийгөө илэрхийлэхэд хүндрэлтэй. Хооллох зуршил сайн. Биеийн ерөнхий хөгжил сайтай.
- Ангийн хүүхдүүдтэй эвтэй, найз нөхдийн зүгээс түүнд тусалдаг.
- Ангийнхан нь дээрэлхдэггүй. Бүжиглэх дуртай, урлагийн арга хэмжээнд сайн оролцдог.

Ар гэрийн байдал:

- Аав, ээж, эмээ, өвөө, нэг дүүтэйгээ амьдардаг. Ам бүл 6
- Дүүтэйгээ тоглодог, гэрийн ажилд тусалдаг.
- Эмээ, өвөө нь охинд тусалж чаддаггүй. Гэртээ гэрийн даалгавраа хийдэг боловч, алдааг нь засаж хэлж өгч, тусалдаг хүн байхгүй. Компьютер их тоглодог. Дэлгэцийн хамаарал ихтэй байна.
- Аав, ээж нь хүүхдийнхээ гэрийн даалгавар хийлгэх, бие даан суралцахад тусалж төдийлөн чаддаггүй. Ээж нь ээлжийн ажилтай. Гэрийн ажил ихтэй, настай аав, ээжийгээ асардаг. Ээж нь ихэвчлэн сургуулиас нь авдаг.

Сургууль дээрх байдал:

Ангийн багш нь сурагч “С”-н монгол хэл, байгалийн ухаан, нийгмийн ухааны хичээлийн сургалтын хөтөлбөрт тохируулга хийж ажиллахыг багш нараас хүсч, сурлагын хоцрогдлыг багасгах зорилгоор сургалтын хөтөлбөрт тохируулга хийх хэрэгцээтэй гэдгийг гэр бүлийн гишүүд аав, ээжид нь танилцуулж, зөвшөөрөл авсан. Сургууль дээрх “Дэмжлэгийн баг”-ийн гишүүдэд асуудлыг танилцуулсан.

Хоёр. Үндсэн хэсэг

Сонсголын бэрхшээлтэй (сонсголгүй) суралцагчтэй ажиллах арга зүй нь тэдний харааны хүртэхүй болон дохионы хэлд суурилсан байх шаардлагатай бөгөөд сургалтын үйл явцад эдгээр арга зүйн тохируулга хийгдэнэ. Сурагч “С”-ийн хувьд дээр дурдсан хичээлийн сургалтын хөтөлбөрийн арга зүйн хэсэгт тохируулга хийнэ. Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн хөгжих, сурах арга барилын ялгаатай байдлыг харгалзан сонсголын бэрхшээлтэй сурагчтай ажиллах дараах арга зүйн онолыг баримтлан ажиллах нь үр дүнтэй болно. Үүнд:

Хос хэлний арга зүй: Энэ нь дохионы хэлийг бичгийн монгол хэлтэй хослуулан, хараан дээр суурилан боловсрол олгодог арга зүй юм. Сонсголтой болон сонсголгүй суралцагчийн аль алинтай нь хичээлийн танхимд хос хэлээр заах боломжтой.

- *Багш үндсэн ойлголт, нэр томъёо, үг хэллэг (хатуу, шингэн, хий, хэлбэр, шахагдах, урсах)-ийг дохионы хэл ашиглан, тод, зөв дохиогоор тайлбарлах*
- *Бичгийн хэлийг ашиглан самбар, слайд, ажлын хуудсанд ойлгомжтой, том үсгээр бичин агуулгыг таниулах, ойлгоход чиглүүлэх*

Харааны хүртэхүйд суурилсан арга: Сонсголгүй суралцагчид мэдээллийг харааны мэдрэхүйгээр хүлээн авдаг. Тиймээс бүх сургалтын материалыг зураг, дүрс, инфографик, дүрс бичлэг, диаграмм зэрэг хараанд түшиглэсэн хэлбэрээр бэлтгэх шаардлагатай.

- *Хатуу (чулуу, мод), шингэн (ус, тос), хий (агаар) зэрэг бодисыг нүдэнд харагдахуйц бодит хэрэглэгдэхүүн болон зураг ашиглана. Бодисын төлөвийн шинж чанарын ялгааг харуулсан энгийн, өнгөт зурагт үзүүлэн, тэмдэглэгээт дүрс ашиглана.*

Мэдрэхүйд суурилсан арга: Хүрч мэдрэх, ажиглах, турших үйл ажиллагаагаар суралцагч өөрийн мэдрэхүйгээр танин мэднэ.

- Хатуу биетийг барьж, шингэнийг юулж, хийг шахаж үзэх зэрэг үйлдэл нь суралцагчийн туршлага дээр суурилсан суралцахуйг дэмжинэ.

Хүснэгт 20. Нэгж болон ээлжит хичээлийн төлөвлөлт

Суралцахуйн үр дүн	Ээлжит хичээл	Тохируулга хийх арга зүй
Хатуу, шингэн, хийн төлөвийн шинж чанарыг харьцуулан тайлбарлана.	Хатуу, шингэн, хий бодисыг ялгаж таньдаг болно.	Харааны хүртэхүй болон хос хэл (Дохионы хэл + Бичгийн хэл)
	Хатуу, шингэн, хийн шинж чанар (хэлбэр, шахагдах, урсах)-ыг туршиж харьцуулдаг болно.	Хос хэл (Дохионы хэл + Бичгийн хэл), Харааны хүртэхүй, Мэдрэхүйн арга

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ арга зүйн тохируулга хийж, сурагчид хичээлийг зааснаар дараах чадварыг эзэмшинэ:

- Танин мэдэхүйн чадвар: Бодис, материалын гурван төлөв болох хатуу, шингэн, хийн төлөвийг бодит биет, зурагт карт дээр ажиглах, ялган таних
- Шинжлэн судлах чадвар: Хатуу, шингэн, хийн шинж чанарын талаар таамаглал дэвшүүлэх, туршилтыг төлөвлөх, гүйцэтгэх, үр дүнг тэмдэглэх, харьцуулах
- Мэдрэхүйн (хүрэлцэх) чадвар: Хатуу (мөс, чулуу, мод) барьж, шингэн (ус, сүү) юулж, хийг (агаарыг) шахаж мэдрэхүйгээр төлөвүүдийн шинж чанарын ялгааг таних
- Харилцах чадвар: Туршилтын үр дүнг зураг, хүснэгт, бичвэр, дохионы хэлээр бусдад илэрхийлэх
- Хамтран ажиллах чадвар: Хосоор болон багаар туршилт гүйцэтгэх, мэдээллээ солилцох

Ээлжит хичээлийн жишээ

Хичээлийн зорилго:

Хатуу, шингэн, хий бодисыг ялган таних, тэдгээрийн шинж чанарыг харьцуулан тайлбарладаг болно.

Судлах цаг: 3 цаг


Ямар хэрэглэгдэхүүн ашиглах вэ?

- Том хэмжээтэй зурагт карт (хатуу, шингэн, хийн зураг)
- Хатуу, Шингэн, Хий гэсэн үгт карт
- Хатуу төлөв: Чулуу, мөс, харандаа, баллуур, мод гэх мэт зурагт карт болон биет үзүүлэн
- Шингэн төлөв: Ус, тос, сүү, жүүс гэх мэт зурагт карт болон биет үзүүлэн
- Хий төлөв: Агаар, шаар, усны уур, гялгар уутыг (агаараар дүүргэх), дугуйны хий гэх мэт зурагт карт
- Цахим контент medle.edu.mn/interactive/2/4/100005705210421

- Төрөл бүрийн хэлбэртэй тунгалаг шилэн сав
- Төрөл бүрийн хэлбэртэй шаар
- Бодит материал (ус, хөлдөөсөн мөс, хуванцар сав, чулуу, модон шоо)

Алхам 1. Бидний эргэн тойронд байгаа зүйлсийн хатуу, шингэн, хийн биетийн жишээ гарган ярилцах

Биет үзүүлэн эсвэл доорх зургийг ажиглуулах



Аль нь хатуу байна вэ?
 Аль нь шингэн байна вэ?
 Аль нь хий вэ? гэх мэт асуултыг бичвэр болон дохионы хэлээр илэрхийлэх

Алхам 2. Үгт картыг ашиглан тухайн үг хэллэгийг нэрлэх, дохионы хэлээр илэрхийлэх

Хатуу

Шингэн

Хий

Алхам 3. Зурагт карт тус бүрийг нэрлэх, дохионы хэлээр илэрхийлэх
 Хатуу, шингэн, хийн төлөвөөр зурагт картыг ангилуулах



Хатуу

Шингэн


Хий

Алхам 4. Зургийг ажиглаад хатуу, шингэн, хийн аль нь болохыг бичүүлэх



Алхам 5. Хатуу биетийн хэлбэрийг туршиж үзэх

- Мөс бол хатуу болохыг бичвэр болон дохионы хэлээр илэрхийлэх
- Мөсийг бариад үзээрэй, хэлбэр нь ямар байна вэ? гэдгийг бичвэр болон дохионы хэлээр илэрхийлэх
- Туршилтын дарааллыг зургаар харуулж, зааврын дагуу гүйцэтгэх
- Янз бүрийн хэлбэртэй шилэн аяганд мөсийг хийх



- Мөс янз бүрийн шилэн аяганд хийсэн ч хэлбэрээ хадгалж байгааг ажиглах
- Шилэн саванд хийсэн мөсний хэлбэр нь өөрчлөгдөж байна уу? гэдгийг бичвэр болон дохионы хэлээр илэрхийлэх
- Хатуу бол тодорхой хэлбэртэй байдаг талаар бичвэр болон дохионы хэлээр илэрхийлэн тайлбарлах

Алхам 6. Шингэний хэлбэрийг туршиж үзэх

- Ус бол шингэн болохыг бичвэр болон дохионы хэлээр илэрхийлэх
- Шингэн ямар хэлбэртэй болохыг таамаглал дэвшүүлэх гэдгийг бичвэр болон дохионы хэлээр илэрхийлэх
- Туршилтын дарааллыг зургаар харуулж, зааврын дагуу гүйцэтгэх

- Усыг янз бүрийн хэлбэртэй шилэн саванд хийх



Усны хэлбэр өөрчлөгдөж байгаа эсэх

- Усыг шилэн саванд юүлэхэд хэлбэр хэрхэн өөрчлөгдөж байна вэ? гэдгийг бичвэр болон дохионы хэлээр илэрхийлэх
- Шингэн бол тодорхой хэлбэргүй, харин хийсэн савныхаа хэлбэрийг дагадаг болохыг дохионы хэлээр илэрхийлэн тайлбарлах

Алхам 7. Хийн хэлбэрийг туршиж үзэх

- Энэ бол хий (үлээсэн шаар эсвэл гялгар уутыг барина). Бид агаарыг харахгүй, гэхдээ шаар болон уутан дотор хий байгаа гэдгийг бичвэр болон дохионы хэлээр илэрхийлэх
- Туршилтын дарааллыг зургаар харуулж, зааврын дагуу гүйцэтгэх
- Өөр өөр хэлбэртэй бөмбөлгийг үлээж, ямар хэлбэртэй болж байгааг ажиглуулах



Хий буюу агаарын хэлбэр өөрчлөгдөж байгаа эсэх

- Хийн хэлбэр өөрчлөгдөж байна уу? гэдгийг бичвэр болон дохионы хэлээр илэрхийлэх
- Хий бол тодорхой хэлбэр дүрсгүй, агуулж буй саваа дүүргэдэг болохыг бичвэр болон дохионы хэлээр илэрхийлэх

Алхам 8. Хатуу, шингэн, хийн шахагдах эсэхийг турших

- Туршилтын дарааллыг зургаар харуулж, зааврын дагуу гүйцэтгэх



- Чулууг гараараа дарж үзээрэй, шахагдаж байна уу? гэдгийг бичвэр болон дохионы хэлээр илэрхийлэх

- Хуванцар савыг усаар дүүргэн таглаад шахаж үзээрэй, ус шахагдаж байна уу? гэдгийг бичвэр болон дохионы хэлээр илэрхийлэх

- Үлээсэн шаарыг шахаж үзээрэй, бөмбөлөг доторх агаар шахагдаж байна уу? гэдгийг

бичвэр болон дохионы хэлээр илэрхийлэх

Хатуу төлөв болох чулуу шахагдахгүй байна. Харин шингэн төлөв болох ус бага зэрэг шахагддаг байна. Хий төлөв болох агаар хамгийн сайн шахагддаг байна гэдгийг бичвэр болон дохионы хэлээр илэрхийлэн тайлбарлах

Алхам 9. Хатуу, шингэн, хийн урсах эсэхийг турших

- Туршилтын дарааллыг зургаар харуулж, зааврын дагуу гүйцэтгэх



- Тэгш гадаргуу дээр модон шоог тавихад урсаж байгаа эсэхийг ажиглах гэдгийг бичвэр болон дохионы хэлээр илэрхийлэх

- Тэгш гадаргуу дээр усыг урсгахад, урсаж байгаа эсэхийг ажиглах гэдгийг бичвэр болон дохионы хэлээр илэрхийлэх

- Бөмбөлөг доторх хийг гаргахад хий тархаж байгаа эсэхийг ажиглах гэдгийг бичвэр болон дохионы хэлээр илэрхийлэх

Хатуу урсахгүй, харин шингэн сайн урсдаг. Хийг урсах гэж хэлэхгүй бөгөөд үүнийг хий тархаж байна гэх мэт үг хэллэгийг бичвэр болон дохионы хэлээр илэрхийлэн тайлбарлах

Алхам 10. Хатуу, шингэн, хийн шинж чанарыг харьцуулах
 -Туршилтын үр дүнг бичвэр ашиглан хүснэгтээр илэрхийлэх



Шинж чанар	Хатуу	Шингэн	Хий
Хэлбэр			
Шахагдах			
Урсах			

-Тухайн сэдэвтэй холбоотой үг хэллэгийг нэрлэх, дохионы хэлээр илэрхийлэх

Багшид өгөх зөвлөмж:

- Хичээлийн бүх үйл явцад хараанд тулгуурласан орчныг бүрдүүлэх
- Багш суралцагч хоорондоо чөлөөтэй харилцаж болохуйц хагас дугуй эсвэл "П" хэлбэр анги танхимыг зохион байгуулах
- Суралцагчдад багшийн царай, амны хайрцаг, нүүрний хувирал, үйл хөдлөлийг тод харах боломжийг олгох
- Сургалтдаа цахим техник хэрэгслийг (үзүүлэн, видео, интерактив самбар гэх мэт) түлхүү ашиглах
- Багш сэдвийг заахдаа эх хэлний зөв бичгийн дүрмийг баримтлах, дохионы хэлийг зөв бүтэцтэй өгүүлбэрээр илэрхийлэх, суралцагчдыг унших, бичих, харилцан ярилцахад дэмжлэг үзүүлэх
- Туршилт болон дасгал даалгаврын зааварчилгааг товч, тодорхой өгөх, туршилтын дарааллыг зураг дүрслэлээр харуулж тайлбарлах
- Багш самбарын бичиглэлийг суралцагч харахад ойлгомжтой байхаар төлөвлөх, үүнд асуулт, хариулт, тайлбар зэрэг мэдээллийг хуваарилан бичих

Сонсголын бэрхшээлтэй суралцагчийн хувьд үнэлгээний зорилго нь хатуу, шингэн, хийн шинж чанарын талаарх мэдлэг, ажиглах, таамаглах, турших, үр дүнг тэмдэглэх, бусдад танилцуулах чадвар шалгахаас гадна тэдний оролцоо, өөрийгөө илэрхийлэх чадварыг үнэлэхэд чиглэнэ.

Хүснэгт 21. Суралцагчийн ахицыг үнэлэх хуудас

<i>Үнэлгээний шалгуур</i>	<i>Үнэлгээ</i>			<i>Тайлбар</i>
	<i>Бага (1)</i>	<i>Дунд (2)</i>	<i>Сайн (3)</i>	
<i>Хатуу, шингэн хийг зурагт карт болон биет үзүүлэнгээс ялгаж чадсан эсэх</i>				
<i>Хатуу, шингэн, хийн шинж чанар (хэлбэр, шахагдах, урсах)-ыг туршилтаар тодорхойлж чадсан эсэх</i>				
<i>Хатуу, шингэн, хийн шинж чанарыг харьцуулж чадсан эсэх</i>				
<i>Туршилтын үр дүнг бичгээр эсвэл зураг дүрслэл ашиглан бусдад илэрхийлж чадсан эсэх</i>				

Сонсголын бэрхшээлтэй суралцагчдын хувьд харааны хүртэхүй болон мэдрэхүйн аргад суурилсан хос хэлний (Дохионы хэл, Бичгийн хэл) арга зүйгээр заах нь суралцахуйн үр дүнд хүрэх хамгийн үр дүнтэй арга зам юм. Ялгаатай хэрэгцээтэй суралцагчийг ЕБС-д тэгш хамруулан сургахын тулд сургалтын хөтөлбөрт тухайн суралцагчийн онцлогт тохируулан тохируулга хийснээр тэднийг амжилттай сургах боломж нөхцөл бүрдэнэ.

СУДЛАГДАХУУНЫ НЭР: НИЙГМИЙН УХААН

АНГИ II АНГИ

Суралцахуйн үр дүн: “2.1ж. Монгол гэрт баримтлах дэг ёс, бэлгэдэл, цээрийн ёсноос тайлбарлана, хэвшүүлнэ”

Нэг. Сурагчийн талаарх ерөнхий мэдээлэл: Сурагч “Т”, эмэгтэй, ерөнхий боловсролын сургуулийн 2 дугаар анги, эрүүл мэндийн байдал: Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй (F71) (ЭМБ-ын мэдрэлийн нарийн мэргэжлийн эмчийн оноштой. Сурагч “Т”-ийн хувьд хичээлийн агуулгаа бүрэн эзэмших боломжгүй, оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй, хэл яриа танин мэдэхүйн хоцрогдолтой, биеийн хөгжил хэвийн, хөдөлгөөн чөлөөтэй, тэнцвэрийн хувьд алдагдалтай, бие дааж нийгмийн үйлчилгээнд оролцох боломж хязгаарлагдмал, өөрийгөө илэрхийлж чадахгүй, нийгэмшлийн чадвар муу.

Сурагч “Т” оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй учраас суралцах үйлд маш их хүндрэл бэрхшээл үүсэж байгаа учраас ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх, сургалтын хөтөлбөрт тохируулга хийх хэрэгцээ үүсэж байна.

Суралцагчийн төлөв байдал

- Дүрслэх урлаг, дизайны хичээлд сонирхолтой. Монгол хэл, математик, байгалийн ухаан, нийгмийн ухаан зэрэг хичээлд хоцрогдолтой, ангийн сурагчдын нэг адил сургалтын хөтөлбөрөөр хичээллэх боломжгүй, бичих чадвар муу, цээжээр бичиж чадахгүй, давхарлан бичдэг, үгийн утга ойлгохдоо маш муу. Видео хэрэглэгдэхүүн, хүүхдийн өдөр тутмын амьдралд ашигладаг танил

хэрэглэгдэхүүнийг ашиглаж сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх шаардлагатай.

- Биеийн тамирын хичээлд анги нийтийн хичээлд сонирхолтой, хөгжмийн хичээлээр бүжиглэх авьяасаа хөгжүүлж, зургийн дугуйланд хичээлээс гадуур хамрагдах сонирхолтой.
- Багш болон ангийн найз нартайгаа харилцахад хүндрэлтэй. Харилцааны хувьд маш их хүндрэлтэй. Ангийн найз нартайгаа цэвэрлэгээ хийх, бусдад туслах, өөрийгөө илэрхийлэхдээ муу. Хооллох зуршил сайн. Биеийн ерөнхий хөгжил сайтай.
- Ангийн хүүхдүүдтэй эвтэй, найз нөхдийн зүгээс түүнд тусалдаг.
- Ангийнхан нь дээрэлхдэг. Бүжиглэх дуртай, урлагийн арга хэмжээнд сайн оролцдог.

Ар гэрийн байдал:

- Аав, ээж, хоёр дүүтэйгээ амьдардаг. Ам бүл 5
- Дүүтэйгээ тоглох дургүй. Ганцаараа тоглох дуртай, гэрийн ажилд тусалдаг.
- Эмээ, өвөө нь охинд тусалж чаддаггүй. Гэртээ гэрийн даалгавраа хийдэг боловч, алдааг нь засаж хэлж өгч, тусалдаг хүн байхгүй. Зурагт их үздэг боловч үзэж байгаа зүйлийнхээ тухай ярьж чадахгүй.
- Аав, ээж нь хүүхдийнхээ гэрийн даалгавар хийлгэх, бие даан суралцахад туслахыг хүсдэггүй. Ээж нь сэтгэл санаагаар унасан байдалтай. Аав нь хүүхдээ тоодоггүй. Ээж нь ээлжийн ажилтай. Гэрийн ажил ихтэй. Ээж нь ихэвчлэн сургуулиас нь авдаг.

Сургууль дээрх байдал:

Ангийн багш нь сурагч “Т”-ийн монгол хэл, математик, байгалийн ухаан, нийгмийн ухааны хичээлийн сургалтын хөтөлбөрт тохируулга хийж, шаардлагатай тохиолдолд ГСТ боловсруулж ажиллахгүй бол сурлагын хоцрогдол үүсч, сургуулиас завсардах эрсдэлтэй гэж үзсэн. Гэр бүлийн гишүүд аав, ээжид нь сурагчийн сурлагын хоцрогдлын талаар танилцуулж, зөвшөөрөл авсан. Сургууль дээрх “Дэмжлэгийн баг”-ийн гишүүдэд асуудлыг танилцуулсан. Иймээс нийгмийн ухааны хичээлийн сургалтын хөтөлбөрт тохируулга хийх шаардлагатай гэж үзлээ.

Энэхүү сурагчийн бэрхшээлийн онцлог, сурах арга барилын тухай товч мэдээлэл өгье.

Танин мэдэхүйн онцлог:

Ой санамж (working memory) сул байх, анхаарал төвлөрөл богино, амархан сарнидаг: Даалгавар гүйцэтгэхдээ удаан тогтоон суух, чухал ба чухал биш мэдээллийг ялгах, анхаарлаа төвлөрүүлэх нь хүндрэлтэй. Шинэ мэдээллийг ойлгож авах хурд удаан: “Түүнд олон дахин тайлбарлаад ч ойлгохгүй байна” гэх биш, харин “түүнд илүү их давтамж, илүү жижиг алхам, илүү олон мэдрэхүйн дэмжлэг хэрэгтэй байна”. Анхаарлын шилжилт маш муу: Нэг орчинд сургасан зан үйлийг өөр орчинд шилжүүлэн хэрэглэх чадвар маш сул бөгөөд энэ нь оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хамгийн түгээмэл ажиглагддаг.. Иймээс зөвхөн нэг удаа хийлгээд орхих биш, “дүр тоглох”, “амлалтын карт”, “эцэг эхийн бататгал”-тай холбох ёстой болдог.

Танин мэдэхүйн онцлогоос харахад оюун ухааны бэрхшээлтэй суралцагч аливааг бодитоор сэтгэдэг, юмыг мэдэрч танин мэддэг бөгөөд ухаарч танин мэдэх хийсвэр сэтгэхүй сул хөгжсөн байдаг Хэл ярианы хөгжил сул, өгүүлбэрийн бүтцээр богино өгүүлбэрээр ярьдаг, илүү бодит зүйл хэрэглэгдэхүүнд суурилсан сургалтыг дахин давтан олон удаагийн давтамжтайгаар явуулах, дүрэм, дэг баримтлахад сургах, сэтгэл зүйн хувьд урам өгөх, алдаа гаргалаа гэж буруутгахгүй байх нь зүйтэй юм.

Суралцахуйн үр дүнг өөрчлөх аргачлал ба жишээ

Суралцахуйн үр дүн (СҮД)-г өөрчлөх, хэрэгжүүлэхэд анхаарах гол зүйл:

- “Хэмжээний бус, чанарын өөрчлөлт хийх”. Энэ нь зөвхөн даалгаврын тоог цөөлөх бус. “Бүрэн зөв”-д төвлөрөх биш, харин тухайн суралцагчийн “оролдлого гаргасан” байдлыг үнэлэх. Суралцагчийн хүчин чармайлтыг урамшуулна, үнэлнэ.
- Олон мэдрэхүйн оролцоог дэмжих. Хараа, сонсгол, хөдөлгөөн зэрэг мэдрэхүйг хамруулсан сургалт илүү үр дүнтэй.
- Гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэх. Гэртээ бататгах дадлага хийхийг байнга санал болгоно.

Хүснэгт 22. Суралцахуйн үр дүнг өөрчлөх алхам

№	Алхам	Тайлбар	Жишээ
1.	Гол санааг ялгах	Сургалтын хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, ур чадварыг сонгоно, тодорхойлох	2.1ж. Монгол гэрт баримтлах дэг ёс, бэлгэдэл, цээрийн ёсноос тайлбарлана, хэвшүүлнэ.
2.	Хүрэх түвшинг бууруулж, өөрчилнө.	Танин мэдэхүйн түвшин	“Тайлбарлах, харьцуулах” гэх ойлгох, задлан шинжлэх түвшний СҮД-г “нэрлэх, ялгах” мэдэх, танин мэдэх түвшин болгож өөрчлөх
	Үг хялбар ойлгомжтой	Сэдвийн үг, өгүүлбэрийн бүтцийг ойлгоход хялбар болгох	“Ёс, бэлгэдэл, цээр” гэх үгс ойлгоход төвөгтэй тул зөв, буруу, дүрэм гэх мэт үгээр солино.
3.	Үйлдэл төвтэй болгох	“Тайлбарлах, харьцуулах” гэх оюуны даалгаврыг “харуулах, үзүүлэх” зэрэг үйлдэлтэй болгох	Зөв, буруу үйлдлийг зураг, хөдөлгөөнөөр харуулна.
4.	Үнэлгээг тохируулах	Амаар илэрхийлэх, зургаар, үйлдлээр харуулах, үзүүлэх зэрэг олон хэлбэрийг зөвшөөрнө.	Сурагч зөв үйлдлийг хөдөлгөөнөөр харуулж чадна.

Жишээ — II ангийн Нийгмийн ухааны сургалтын хөтөлбөр

Суралцахуйн үр дүн: 2.1ж. Монгол гэрт баримтлах дэг ёс, бэлгэдэл, цээрийн ёсноос тайлбарлана, хэвшүүлнэ.

Оюуны бэрхшээлтэй сурагчид зориулан өөрчилсөн хувилбар (Modification):

Монгол гэрт баримтлах 1–2 дүрмийг зураг, үйлдлээр харуулна.

Зөв үйлдэл (ж.нь. мэндлэх, босго дээр гишгэхгүй байх)-ийг сонгоно эсвэл дүрсэлнэ.

• **Сургалтын арга зүй, арга**

“Шаталсан дэмжлэг” арга зүйг “Би хийе (I do), Хамтдаа хийе (we do), Чи хий (you do)” буюу “Эхлээд багш тухайн зүйлийг өөрөө хийж харуулна, дараа нь суралцагчтай хамтдаа хийнэ, эцэст нь суралцагч өөрөө бие даан гүйцэтгэнэ” гэсэн дарааллаар үе шаттайгаар сургалтад ашиглах нь үр дүнтэй.

Уг аргыг ашиглан оюуны хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажиллах энгийн жишээг Хавсралт (тал 10-12)-аас харна уу.

Хоёр. Суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа

Энэ хэсэгт бага боловсролын Нийгмийн ухааны сургалтын хөтөлбөрийн II ангийн нэг суралцахуйн үр дүнг оюун ухааны дунд хэлбэрийн бэрхшээлтэй суралцагчид зориулан өөрчилж, “Би хийе (I do), Хамтдаа хийе (we do), Чи хий (you do)” аргаар сургалтыг зохион байгуулах жишээг танилцуулж байна.

Суралцахуйн үр дүнг өөрчлөхдөө өмнөх хэсэгт хүснэгтээр харуулсан аргачлалыг баримталсан болно.

Хүснэгт 23. Хичээлийн алхамчилсан жишээ

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн өөрчилсөн үр дүн (Modification)
2.1ж. Монгол гэрт баримтлах дэг ёс, бэлгэдэл, цээрийн ёсноос тайлбарлана, хэвшүүлнэ	<ul style="list-style-type: none">• Монгол гэрт баримтлах 1–2 дүрмийг зураг, үйлдлээр харуулна.• Зөв үйлдэл (ж.нь. мэндлэх, босго дээр гишгэхгүй байх)-ийг сонгоно эсвэл дүрсэлнэ.• Буруу үйлдлийг ялгаж зааж харуулна (тэмдэглэнэ, хийж үзүүлнэ).

1. Сэдэлжүүлэх үе шат: Хугацаа: 10 минут

а) Би хийе.

Багш: Багш нь гараараа гэр шиг дүрс үүсгэж үзүүлье. Гараа бөөрөнхий болгох дасгалыг өөрөө хийж үзүүлнэ. Энэ бол гэр гэж хэлнэ.

b. Хамтдаа хийе.

Суралцагч: Багшийн хөдөлгөөнийг дуурайж хийнэ. Мөн ангийн суралцагчид хамтдаа багшийн хөдөлгөөнийг дуурайна.



Багш: QR кодыг уншуулж, гэрийн тухай бичлэг” үзүүлж, сонсгож анхаарлыг төвлөрүүлнэ.



Суралцагч: Гэрийн дүрсийг багшийн дэмжлэгтэй гараараа дүрс үүсгэж, энэ бол гэр гэж хэлнэ.

2. Шинэ мэдлэг бүтээх: Хугацаа: 20 минут

Хэрэглэгдэхүүн: Монгол гэрийн зураг, өнгийн харандаа, наалт г.м

b) Би хийе.



Багш: Монгол гэрийн зураг үзүүлж Энэ бол гэр. Гэрт хаалга, тооно, хана байдаг. гэж хэлнэ. Зураг дээрх “хаалга”, “тооно”, “ханыг” “босго”-ыг заана.

“Гэр” үлгэрийг 3 удаа сонсгож, үгсийг давтуулна.

c) Хамтдаа хийе.

Суралцагч: “Хаалга”, “Тооно” “Хана” “Босго” гэсэн үгийг багшийн араас хоёр удаа давтаж ○ хэлнэ.

Даалгавар: Гэрийн зургаас хаалга, тооно, хана, босго хэсэгт ○ тэмдэглэнэ.

Жишээ нь Гэрийн босгыг тэмдэглэв.



- Хаалга
- Хана
- Тооныг дугуйлаарай.

d) Хамтдаа хийе.


Багш: “Одоо үгийг зөв нэрлэсэн зургийг сонгоё” гэж хэлээд хоёр зураг харуулна.

Даалгавар: Сонголт 1: Хаалга, Хана, Сонголт 2: Тооно, Хаалга

Өөрөө зөв гэж үзэж буй хэсэг дээр өнгийн наалтыг хамтран наагаарай.

Сонголт 1: Хаалга / Хана

Сонголт 2: Тооно / Хаалга




Дэмжлэг:

Зөв гэж үзэж буйгаа давтаж хэлэхэд тусална.

Сурагч зөв гэж үзэж буй хэсгийг сонгож наалт наахад тусална.

Багш: Хаалга алдалж зогсох нь болохгүй буруу болохыг биеэр үзүүлнэ. Суралцагч:



Дуурайж хийж үзүүлээд болохгүй болохыг багшийн дэмжлэгтэй хэлнэ.

Суралцагчийн хийсвэр сэтгэлгээ хөгжөөгүй байгаа боловч үүнийг заавал хэлж сануулж, биеэр үзүүлж, буруу болохыг сануулах шаардлагатай.

Бататгах. Хугацаа: 14 минут

Хэрэглэгдэхүүн: Гэрийн бүдүүвч зураг, улаан харандаа, гэрийн хэсэг г.м

e) Хамтдаа хийе.


Багш: “Хамтдаа гэрийн хэсгүүдийг байрлуулъя.” гэж хэлээд 3 хэсэгтэй гэрийн эвлүүлэг гаргана.

Суралцагч: Багшийн тусламжтайгаар гэрийн хэсгийг эвлүүлж, дараа нь бие даан өөрөө хийнэ.

f) Чи хий.

Багш: “Хаалгыг улаанаар будаарай” гэж хэлж, өөрөө хийж үзүүлнэ.

Суралцагч: Хаалгыг улаан харандаагаар бие даан анхааралтай будна.



Багш: Хаалга алдалж зогсох, босгон дээр гишгэж болохгүй болохыг дахин тайлбарлана. Суралцагчаар босго хэсгийг хэсгийг тэмдэглүүлнэ.

Суралцагч: Босго хэсгийг тэмдэглэнэ.

Даалгавар:

3 хэсэг зураг, гэрийн зургийг гаргаж тавина.

- Хаалга, хана хэсгийг доод талд, тооныг дээвэр дээр байрлуулаарай.
- Хаалгыг улаан харандаагаар анхааралтай будаарай.
- Суралцагч босгон дээр зогсож байгаа хэсгийг тэмдэглээрэй.



Дэмжлэг:

Сурагчийн ээлж болоход нэрийг хэлэх эсвэл гараараа дохино.

Багшийн тусламж хэрэгтэй үед өөр лүүгээ зааж удирдан чиглүүлнэ.

Зааварчилгааг аажмаар багасгаж сурагч аажмаар зарим үйлдлийг бие даан хийдэг болоход чиглүүлнэ.

Дүгнэлт Хугацаа: 6 минут

g) Хамтдаа хийе.

Багш: “Гэрт хэн хэн амьдардаг вэ?” гэж асууна.

Суралцагч: Аав, Ээж, Нохой хариулна.

Багш: Суралцагчийн хариултыг бүтэн өгүүлбэр болгон бататгана: Тийм ээ, Гэрт аав, ээж амьдардаг.

h) Чи хий.


Багш: Босгон дээр зогсох нь зөв үү, буруу юу?

Суралцагч: Гэрийн босгон дээр гишгэх нь буруу болохыг хэлнэ.

Багш: Босгон дээр гишгэх нь буруу болохыг биеэр үзүүлээрэй.

Суралцагч: Босгон дээр гишгэж, энэ бол буруу гэнэ.

Даалгавар: Суралцагчтай ярилцаарай.
 Асуулт: Гэрт хэн амьдардаг вэ? бичүүлнэ.
 Хариулт бичих талбар: _____



Асуулт “Босгон дээр зогсох нь зөв үү, буруу юу?”
 Хариулт бичих талбар: _____

Дэмжлэг:

(Аав, Ээж, Нохой) (босго, гишгэх)
 Хүүхэд 1–2 үг хэлэхэд нь багш бүтэн өгүүлбэр болгон бататгана: Тийм ээ, Аав, Ээж гэрт амьдардаг. Буруу гэж хэлж байвал маш сайн байна.
 Үгийн санг өргөжүүлэхийн тулд зурагтай сонголтын карт (Аав, Ээж, Нохой) ашиглах.
 “Манай гэрт...” гэж өгүүлбэрийг эхлүүлж, хүүхдээр үгийг нөхүүлэх байдлаар даалгаврыг өөрчлөх боломжтой.

Хүснэгт 24. Үнэлгээний шалгуур

Онцлог	Бие даан гүйцэтгэсэн (3 оноо)	Дэмжлэгтэй гүйцэтгэсэн (2 оноо)	Нэлээд дэмжлэгтэй гүйцэтгэсэн (1 оноо)
Танин мэдэхүй	Хаалга, тооно, хана, босго гэсэн 4 үгийг байнга ялгаж, зөв байрлалыг таньж, босгыг заасан.	Ихэнхдээ ялгаж таньсан ч, 1-2 удаагийн бага дэмжлэг авсан.	Багшийн дэмжлэгтэйгээр үг, байрлалыг гүйцэтгэсэн.
Хэл яриа	Үгийг 3 удаагийн давталтаар зөв дуудаж, асуултад 1-4 үгээр хариулж, буруу болохыг хэлсэн.	Дуу авианы бичлэгийг давтахдаа бага зэрэг дэмжлэгтэйгээр дуудсан.	Багшийн хамт давтаж эсвэл их дэмжлэгтэйгээр нэг үг хэлсэн.
Хөдөлгөөний эв, ур	Дугуйлах, тэмдэглэх, будах, наалт наах зэрэг үйлдлийг бие даан, шугамыг дагуулан гүйцэтгэж, биеэр үйлдлийг үзүүлсэн.	Наалт наах, будахдаа бага зэрэг хяналт тавьсан. Үгэн зөвлөмжийн дагуу үйлдлийг зөв хийсэн.	Биет дэмжлэг (гараас нь барих) шаардлагатай байсан ч, эхлүүлсэн үйлдлээ хийж дуусгасан.

Гурав. Дүгнэлт, зөвлөмж

Оюуны хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн хувьд сургалтын хөтөлбөрт тохируулга хийхэд суралцахуйн үр дүнг өөрчилдөг бөгөөд энэ нь тухайн сургалтын хөтөлбөрийн чанарыг бууруулж буй хэрэг бус, харин суралцагчийн амжилт, оролцоог бодитоор нэмэгдүүлэх зорилготой.

Оюуны бэрхшээлтэй суралцагчийн онцлогийг үндэслэн сургалтын арга, орчинтой холбоотой дараах зүйлсийг багш байнга анхаарч байх хэрэгтэй:

- *Алхамчилсан заавар өгөх: Урт, том даалгаврыг жижиг хэсгүүд болгон, алхам, алхмаар хийлгэх нь ажлын ой санамжид ирэх ачааллыг бууруулдаг. Жишээ: “Суудлаа зас” → “Гараа өргө” → “Сайн байна, одоо над руу хар” гэх мэт нэг нэгээр нь хийлгэх.*
- *Хэд хэдэн мэдрэхүйг нь оролцуулах: Зөвхөн сонсох биш, зураг харах, гараараа хийх, хөдөлгөөнөөр үзүүлэх. Энэ нь тэдэнд хурдан тогтоохоос гадна ой санамждаа илүү удаан хадгалахад тусална.*
- *Давтах, бататгах: Ижил ойлголтыг өөр орчинд (ангийн дүрэм → гэрийн дүрэм → зочилж орохдоо баримтлах дүрэм) давтаж сургаснаар шилжүүлэлтийн бэрхшээлийг багасгана.*
- *Загвар үзүүлэх + дагуулан хийх: “Зөв зан үйл”-ийг үгээр тайлбарлахаас илүү, багш/найз нь хийж үзүүлэх, суралцагч яг давтаж хийх нь илүү үр дүнтэй. Энэ нь гүйцэтгэлийн үнэлгээг хийх боломжийг давхар олгоно.*
- *Гол зүйлд төвлөрөх: Тухайлбал, оюуны хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид олон дүрэм зэрэг санахад хүндрэлтэй тул 1–3 түлхүүр дүрэмд төвлөрөх, дүрмийг зураг, постер хэлбэрээр харагддаг газарт ил тод байрлуулбал тэд тухайн дүрмийг баримталж хэвшихэд тусална.*

Энэхүү жишээ болгон танилцуулсан бага боловсролын Нийгмийн ухааны сургалтын хөтөлбөрийн II ангийн нэг суралцахуйн үр дүн, түүний хэрэгжүүлэх арга, үйл ажиллагаа нь суралцагчийн танин мэдэхүй, хэл яриа, хөдөлгөөнийг ур чадварыг дэмжих олон талт зорилго агуулсан, үндэсний уламжлалын суурь ойлголтыг хялбар, ойлгомжтой хэлбэрээр эзэмшүүлэхийг хичээсэн жишээ юм. Үүнийг хэрэгжүүлэхдээ:

- *Зураг, эвлүүлэг, будах даалгавруудыг том хэмжээтэй, өнгө ялгаралт сайтай хэвлэж хэрэглэнэ.*
- *Хараа болон анхаарлын ачаалал багатай орчин бүрдүүлнэ. (Чимээ багатай орчин бүрдүүлэх)*
- *Даалгавар хийх болон тоглох үед хэрэглэгдэхүүнийг сонгож өгөх бус болж өгвөл суралцагчийг өөрөөр нь аль нэгийг сонгуулах, гүйцэтгэх үйлийг хийлгэ.*
- *Тухайн үйлийг хүүхдэд тайлбарлаж өгч даалгаврыг хийлгэхдээ тоглох үйлийг орхигдуулж болохгүй.*
- *Нэгэн хэвийн ширээ засалттай байхаас татгалзаж, багаар нүүр нүүрээ харж суулгана. Энэ тухайн суралцагчийг анги хамт олондоо хэрэгтэй гэдгийг мэдрүүлэхэд чухал.*
- *Суралцагчийг урамшуулах, түүнд урмын үг хэлэх боломж бүрийг ашиглана.*

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

- Цэвээнлхазал, Я., Алтанхуяг, Ц. (2016). Хувь хүүхдийн хөгжлийг дэмжих заслын аргууд. Улаанбаатар
- (НҮБ-ын Хүүхдийн сан) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй УБ,201
- UNESCO. (2017). A guide for inclusive education.

- OECD. (2019). Inclusive Education for Students with Disabilities.
- WHO. (2023). Global Report on Developmental Disabilities.
- International Journal of Special Education (2019–2023).
<https://www.brainpowerneuro.com>
- <https://my.clevelandclinic.org/health/diseases/25015-intellectual-disability>

СУДЛАГДАХУУНЫ НЭР: КОМПЬЮТЕРЫН УХААН

АНГИ: II

Нэг. Ерөнхий мэдээлэл

Ялгаатай хэрэгцээ шаардлагатай суралцагчтай ажилладаг багш юун түрүүнд тэдний хэл, соёл, онцлог, сурах арга барилын талаар өргөн хүрээний мэдлэг, ойлголттой байх хэрэгтэй. Багш ялгаатай хэрэгцээний талаар мэдээлэлтэй танилцаж, ойлголт мэдлэгээ нэмэгдүүлснээр эдгээр суралцагчтэй ажиллахад дөхөм байх болно (Soltero, 2004).

Сонсголын бэрхшээлтэй суралцагчийн хэл ба харилцаа:

Сонсголгүй суралцагчдын хувьд тэдний эх хэл бол дохионы хэл юм. Дохионы хэл нь ярианы хэлний нэгэн адил тэгш эрхтэй хэл бөгөөд сургалтын үндсэн хэл гэж хүлээн зөвшөөрөгддөг. Компьютерын ухааны хичээлийг үр дүнтэй явуулахын тулд багш, боловсролын ажилтнууд дохионы хэлний өндөр чадвартай байх, мөн сонсголгүй хүний хараан дээр суурилсан соёл болон онцлогийн талаар мэдлэгтэй байх нь чухал.

Тохируулгын үндсэн суурь: UDL ба олон модальт арга зүй

Сонсголын бэрхшээлтэй (СБ) суралцагчдад зориулсан Компьютерын ухааны боловсролыг зохион байгуулах үндсэн суурь нь хамруулан сургах дизайн (Universal Design for Learning - UDL) болон олон модальт сургалтын стратегийн зарчмуудад тулгуурладаг.

UDL нь сургалтын зорилго, арга, материал, үнэлгээг суралцагчийн ялгаатай байдалд тааруулан уян хатан байхаар зохион бүтээх арга барил юм. UDL-ийн үзэл баримтлал нь суралцахад тулгарч буй саад бэрхшээл нь зөвхөн суралцагчийн чадамжид бус, харин хөтөлбөрийн харилцан үйлчлэлд үүсдэг гэсэн үндэслэл дээр баригддаг. Иймд UDL нь суралцагчдаас уян хатан бус хөтөлбөрт дасан зохицохыг шаардахын оронд суралцагчдын хэрэгцээнд дасан зохицох чадвартай хөтөлбөрийг чухалчилдаг.

UDL (Universal Design for Learning)-ийг Компьютерын ухааны сургалтад нэвтрүүлэх нь:

КУ-ны хичээлийн зорилго нь суралцагчийг технологийг аюулгүй, ухаалгаар ашиглах, энгийн код бичих, бүтээлчээр сэтгэх, асуудал шийдвэрлэх суурь чадамжийг эзэмшүүлэхэд чиглэдэг. UDL-ийн зарчмуудыг нэвтрүүлэх нь СБ суралцагчдад сургалтын үйл явц, үнэлгээний материалын тэгш хүртээмжийг нэмэгдүүлдэг.

Тохируулга хийхдээ Компьютерын ухааны сургалтыг зөвхөн дуу авиа, ярианд тулгуурлахгүйгээр хараа, мэдрэхүй, хөдөлгөөнөөр дамжуулан хүртэх боломжтой болгодог.

UDL-ийн үндсэн гурван зарчим ба Компьютерын ухааны хичээлийн дэх хэрэглээ:

1. Олон загвараар мэдээлэл өгөх (Representations):

Суралцагчдад мэдээллийг хүртэх олон аргыг олгох нь зорилго. КУ-ны хичээлийн онолын ойлголтуудыг (жишээлбэл, өгөгдөл, хиймэл оюун) хүргэхдээ зөвхөн сонсголд найдахгүй, харин зураг, бүдүүвч, өнгө ялгалттай материал, болон визуал (харааны) хэрэглэгдэхүүн ашиглана. Техник хэрэгсэл (компьютер, таблет, ухаалаг самбар) нь харааны мэдээлэл авах боломжийг бүрдүүлнэ.

2. Олон загвараар үйлдэл хийх ба илэрхийлэх (Action and Expression): Суралцагчдад өөрсдийн мэдлэг, ойлголтыг илэрхийлэх олон аргыг олгох нь зорилго. КУ-ны даалгаврыг гүйцэтгэхдээ (жишээлбэл, энгийн кодчиллын даалгавар, асуудал шийдвэрлэх) СБ суралцагчдад бичгээр дүн шинжилгээ хийх (d170), дохионы хэлээр гүйцэтгэх, эсвэл практик туршилт хийх зэрэг олон төрлийн сонголтыг өгөх нь мэдлэг, чадвараа хязгаарлуулахгүйгээр харуулах боломжийг олгоно.

3. Олон загвараар оролцох ба сэдэлжүүлэх (Engagement):

Суралцагчийн сонирхол, сэдэл, оролцоо, ахиц амжилтыг тасралтгүй дэмжих нь зорилго. Багш нар урам зориг өгдөг, тууштай, тэвчээртэй байдлыг дэмждэг, эерэг таатай уур амьсгал бүхий орчныг бүрдүүлэхийг чухалчилна. Сургалтын явц нь бүтээлч онол дээр суурилж, суралцагч төвтэй үйл ажиллагааг дэмжих, мөн хамтын ажиллагааг (багаар ажиллах) дэмждэг байх ёстой.

Хоёр. Компьютерын ухааны хөтөлбөрт тохируулга хийх ач холбогдол:

1. Тэгш хүртээмж /Суралцахуйн саадыг арилгах/

- *Тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх: Бүх нийтийн хэрэглээний дизайн (Universal Design for Learning - UDL) болон олон модальт сургалтын стратегийн зарчмуудыг нэвтрүүлэх нь СБ суралцагчдад сургалтын үйл явц болон үнэлгээний материалын тэгш хүртээмжийг нэмэгдүүлнэ.*
- *Хөтөлбөрийг уян хатан болгох: UDL-ийн үзэл баримтлал нь суралцахад тулгарч буй саад бэрхшээл нь суралцагчийн чадамжид бус, харин хөтөлбөрийн харилцан үйлчлэлд үүсдэг гэсэн үндэслэл дээр баригддаг. Иймд тохируулга нь суралцагчдын хэрэгцээнд дасан зохицох чадвартай хөтөлбөрийг чухалчилдаг.*
- *Мэдээллийн хүртээмж: Тохируулга хийх нь Компьютерын ухааны сургалтыг зөвхөн дуу авиа, ярианд тулгуурлахгүйгээр хараа, мэдрэхүй, хөдөлгөөнөөр дамжуулан хүртэх боломжтой болгодог.*

2. Боловсролын Чанар ба Хэлний Хэрэгцээг хангах

- *Эх хэлээр боловсрол олгох: Сонсгологүй суралцагчидийн хувьд Дохионы Хэл (ДХ) нь тэдний эх хэл бөгөөд сургалтын үндсэн хэл гэж хүлээн зөвшөөрөгддөг. Олон улсад (жишээлбэл, АНУ-д ASL) 500,000 орчим хүнд харилцааны үндсэн хэрэгсэл болдог ч, КУ-ны хичээлийг Монгол ДХ-ээр заах онлайн эх сурвалж хязгаарлагдмал байдаг.*
- *Суралцах сонирхлыг нэмэгдүүлэх: Төрөлхийн буюу бага насандаа сонсгологүй болж, Дохионы Хэлийг эх хэлээрээ сурсан суралцагчид (pre-lingual individuals) кодоор дамжуулан сурах сонирхол нь ДХ-ээр хичээл заахад илүү ихээр нэмэгддэг.*

Компьютерын ухааны хичээлийг тэдний хэрэгцээнд нийцсэн хэлээр заах нь суралцагчийн тэгш оролцоо, сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ.

- Ухаагдахууны ойлголтыг сайжруулах: КУ-ны хичээлд ДХ-ийн видео ашиглах нь Англи хэлний "call" гэх мэт үгсийн утга болон нэрлэсэн утгын зөрүүтэй байдлаас үүдэн гардаг утгын будлианыг (denotation and connotation confusion) багасгахад тустай.
- Багшийг чадавхжуулах: СБ суралцагчийг сургадаг багш нарын дийлэнх нь сонсголттой бөгөөд тэдний цөөн хувь (22%-иас бага) сонсголгүй байдаг. Иймд ДХ-ээр хийгдсэн КУ-ны видео хичээлүүд нь компьютерын ухаан болон бага боловсролын багш нарт сонсголын бэрхшээлтэй суралцагчдад КУ-ны ойлголтыг танилцуулахад туслах хэрэгсэл болно.

3. Сургалтын Аргын Тохируулга (Multimodal Approach)

Тохируулга нь сонсголын бэрхшээлтэй суралцагчид харааны ойлголтоор суралцагчид байдаг гэдгийг ашиглаж, мэдлэгийг хүргэх олон аргыг нэвтрүүлдэг (UDL-ийн нэг зарчим).

- Визуал болон Кинестетик Сургалт: СБ суралцагчдад зориулсан сургалт нь харааны болон үйлдлээр мэдрэх (кинестетик) аргад суурилсан байх ёстой. Хийсвэр ойлголтуудыг (жишээлбэл, Давталт (Loop)) нүдлэн тогтоох, биеийн хөдөлгөөнөөр мэдрэх байдлаар эзэмшүүлэх нь тооцоолох сэтгэлгээний суурь ойлголтыг бий болгоно.
- Олон модальт нэгдэл: Олон модальт хандлага нь мультимедиаг агуулгын тексттэй хамт ашигладаг бөгөөд энэ нь Д/НН хүмүүст ашигтай байдаг. График, зураг, видео болон бусад мультимедиа хэлбэрүүд нь нарийн төвөгтэй онол, ерөнхий ойлголтуудыг сурахад дэмжлэг үзүүлдэг.
- Харааны эргэх холбоо (Visual Feedback): Программын үр дүнг зөвхөн дуу авиагаар бус, харин цаг тухайн үед нь хараанд суурилсан эргэх холбоо (visual-based feedback) буюу тодорхой визуал дохио (текст, график) ашиглан дамжуулах нь КУ-ны хэрэглээний хүртээмжийг баталгаажуулдаг.
- Хэрэглэгчийн хяналт: Тохируулга хийсэн сургалтын орчин нь хэрэглэгчдэд туршлагаа өөрсдөө хянах боломжийг олгох ёстой. Жишээлбэл, суралцагчид ДХ-ийн видеоны хурд болон хадмал үгийн хэмжээг хянах, мөн кодчиллын блокуудын тайлбарыг ДХ-ээр үзэх эсвэл текстээр үзэх сонголтыг өгдөг.

Гурав. Компьютерын ухааны үндсэн тохируулга:

Сургалтын үндсэн тохируулгууд

1. **Хэлний хүртээмж (ДХ):** Сонсголгүй суралцагчдын хувьд дохионы хэл нь эх хэл нь тул, багш нь ДХ-ийн өндөр чадвартай байх ёстой. Мөн КУ-ны ойлголтыг тайлбарласан ДХ-ийн видео (ASL) материалыг ашиглана.
2. **Визуал ба олон талт сургалт:**
 - Блок орчин дахь ДХ: Блок кодчиллын орчинд ('IF-ELSE', 'WHILE' эсвэл 'Repeat' блок) курсороо аваачихад тухайн блокийн ДХ-ийн дохиог харуулдаг Tooltip функцийг ашиглах нь үр дүнтэй.

- *Визуал дизайн: Дэлгэцийн өнгөний ялгарал, визуал ойлголтыг нэмэгдүүлэхийн тулд хэрэггүй мэдээллийг арилгасан (minimalist design) орчинг бүрдүүлнэ.*
3. **Кинестетик сургалт (дэлгэцгүй):** Компьютерын ухааны хийсвэр ойлголтууд болох Давталт (Loor)-ыг заахдаа суралцагчаар энгийн хөдөлгөөн, үйлдлүүдийг тодорхой тоогоор давтан хийлгэснээр тэд суурь ойлголтыг хялбар эзэмшинэ.
 4. **Үнэлгээний уян хатан байдал:** Үнэлгээг даалгаврын эцсийн гүйцэтгэлийн үр дүнгээс гадна асуудал шийдвэрлэх чадвар зэрэг явцын үр дүнгээр тооцох

Энгийнээр хэлбэл давталтын алгоритмыг заах нь бүжиг, эсвэл хөдөлгөөнт дасгал дээлэхтэй адил юм. Хэрэв бид "Баруун тийш 3 алхам, Гараа өргөх" гэсэн үйлдлийг 4 удаа давтах дасгал гүйцэтгүүлэхийг хүсвэл, үйлдэл бүр дээр 8 тусгай заавар өгөхийн оронд, уг 2 үйлдлийг нэг блок болгоод, "4 удаа давт" гэсэн Давталтын блокийг төлөвлөж ажиллуулах нь цаг хэмнэж, алдаа гаргах магадлалыг багасгадаг. Харааны болон кинестетик аргын тусламжтай суралцагчид үйлдлийг биеэрээ мэдэрч, ойлголтыг логиктой суралцах боломжтой болно.

Холбогдох нэр томъёо, ойлголтууд:

- *Хэрэглээний бүх нийтийн дизайн (Universal Design for Learning (UDL): Сургалтын хөтөлбөр, материал, үнэлгээг уян хатан, ялгаатай байдалд нийцүүлэн зохион бүтээх арга барил.*
- *Олон талт арга Зүй (Multimodal Approach): Мэдээллийг зөвхөн нэг мэдрэхүйгээр (жишээлбэл, сонсголоор) бус, олон хэлбэрээр (хараа, мэдрэхүй, текст, видео, ДХ) хүргэх хандлага.*
- *Кинестетик Сургалт (Kinesthetic Learning): Биеийн хөдөлгөөн, үйлдлээр дамжуулан суралцах арга. СБ суралцагчдад зориулсан сургалт нь үйлдлээр мэдрэх (кинестетик) аргад суурилсан байх ёстой. Энэ нь Давталт (Loor) гэх хийсвэр ойлголтыг биеэр гүйцэтгүүлэхэд ашиглагддаг.*
- *Харааны хүртэхүйд суурилсан (Visual-based Feedback): Программын үр дүнг зөвхөн дуу авиагаар бус, хараагаар хүртэхүйн дохио (текст, график) ашиглан хүргэх, илэрхийлэхийг хэлнэ.*

Компьютерын ухааны үндсэн ойлголтууд:

- *Давталт (Loor): Программ хангамжийн үндсэн логик элемент, үйлдэл эсвэл команд тодорхой тоогоор давтагдах тухай ойлголт. Давталтын алгоритмыг биеийн хөдөлгөөнөөр мэдэрч, блок кодчиллоор дүрсэлж сурах нь КУ-ны суурь ойлголт юм.*
- *Алгоритм ба буюу үйлдлийн дараалал: Асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн алхам алхмын дараалал.*
- *Блок Кодчилал (Block-Based Coding): Програмын кодыг бичвэрээр бус, харин хооронд нь угсардаг харааны блокууд (Code.org, Scratch зэрэгт) ашиглах арга.*
- *Нөхцөл: Хөтөлбөрт тодорхой нөхцөл биелсэн тохиолдолд үйлдэл хийх логик (жишээ нь: "Хэрэв (IF)... Тэгвэл (THEN)...").*

- *Хувьсагч (Variables)*: Өгөгдөл хадгалах, өөрчлөх боломжтой санах ойн нэр.
- *Алдааг олж засах (Debugging)*: Программ хангамж дахь алдааг илрүүлж, засах үйл явц.
- *Дохионы Хэл (ДХ) / ASL*: Сонсголтгүй суралцагчийн эх хэл бөгөөд сургалтын үндсэн хэл гэж хүлээн зөвшөөрөгддөг.
- *Tooltip*: Блок кодчиллын орчинд хулганы курсорыг блок дээгүүр аваачихад гарч ирдэг, тухайн блокийн ДХ-ийн дохиог харуулдаг график хэрэглэгчийн интерфэйсийн элемент. *Tooltip*-ийг ДХ болон зургаар үзүүлэх нь зөвхөн текстээр үзүүлэхээс илүү үр дүнтэй байдаг.

Жишээ: Суралцахуйн үр дүн: “2.26. Өгсөн даалгаврыг давталттай алгоритмаар дүрсэлж, блок код ашиглан кодчилдог болно”.

Сонсголын бэрхшээлтэй суралцагчдад зориулсан сургалт нь **харааны болон үйлдлээр суралцах (кинестетик)** аргад суурилсан байх бөгөөд Монгол дохионы хэлийг эх хэлнийх нь хувьд ашиглах нь чанартай боловсрол эзэмшүүлэх нэг чухал хөшүүрэг болно.

Хүснэгт 25. Сургалтын хөтөлбөрийн тохируулга хийсэн жишээ

<i>Үе шат</i>	<i>Багшийн арга зүйн тохируулга</i>	<i>Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх хувилбар</i>
1. <i>Танилцуулга (Representation)</i>	<i>Дохионы хэл, визуал карт, өнгө ялгалттай схем</i>	<i>Багш суралцагчийн харааны хүрээнд сууж, дэлгэц, самбар, картуудыг нэг чиглэлд байрлуулна. Суралцагчийн анхаарал сарниулахгүй орчныг бүрдүүлнэ.</i>
2. <i>Кинестетик дасгал (Unplugged)</i>	<i>Давталтыг хөдөлгөөнөөр (4 удаа алхах гэх мэт) заах</i>	<i>Суралцагчийн биеийн хөдөлгөөнийг хамт гүйцэтгэж, багш хөдөлгөөний тоо, дарааллыг дохионы хэлээр хянаж өгнө. Алдаа гаргавал гараар зөөлөн чиглүүлж засах.</i>
3. <i>Кодчилал (Code.org)</i>	<i>Давталт блокыг ашиглан даалгавар биелүүлэх</i>	<i>Харааны интерфэйсийг томруулж, toolbar ба block тайлбаруудыг хадмал болон дохионы хэлний бичлэгтэйгээр үзүүлэх. Суралцагч нэг алхам бүрийн дараа визуал эргэх холбоо авна.</i>
4. <i>Эргэцүүлэл ба үнэлгээ (Feedback)</i>	<i>Суралцагчийн кодын үр дүнг хамт дүгнэх</i>	<i>“Яагаад энэ блокийг сонгов?” гэх асуултыг дохионы хэлээр тавьж, суралцагч хариултаа дохиогоор эсвэл тэмдэглэлийн дэвтэрт зураг/бичгээр илэрхийлнэ.</i>

Харааны болон орон зайн зохион байгуулалт

- Гэрэл ба харааны чиглэл: Суралцагч багшийг бүрэн харж, дохионы хэлний хөдөлгөөн тод харагдах байрлалд байх ёстой.
- Олон дэлгэц ашиглах: Хэрэв боломжтой бол нэг дэлгэцийг Code.org орчинд, нөгөөг дохионы хэлний видео/visual cue-д ашиглана.
- Нэгэн төрлийн дизайн: Code.org орчны интерфэйсийн өнгө, фонтыг тогтмол байлгаж, нэг дэлгэц дээр хэт олон зүйл байршуулах (visual overload) үүсгэхгүй байх хэрэгтэй.

Хэлний ба сэтгэлзүйн дэмжлэг

- Дохионы хэлний хосолсон орчуулга: Үгсийн болон ойлголтын хувьд тодорхойгүй нэр томъёог (жишээ нь: “Loop”, “If-Else”) тус бүрт нь ДХ + зураг + энгийн амьдралын жишээгээр (жишээ нь “дөрвөн удаа суух”) тайлбарлах
- Бага ба тогтмол даалгавар: Сонсголын бэрхшээлтэй суралцагчид анхаарлаа удаан төвлөрүүлэхэд илүү хүч зарцуулдаг тул 20–25 минут тутамд богино “visual rest” буюу дэлгэцээс түр холдуулж амраах
- Эерэг визуал урамшуулал: Зөв хариулт бүрийн дараа тод өнгийн icon, жижиг хөдөлгөөнт gif, эсвэл багшийн thumbs-up дохио өгөх хэрэгтэй.

Code.org платформ дээрх ганцаарчилсан тохируулга

Code.org нь хэд хэдэн хүртээмжийн тохиргоотой. Ганцаарчилсан сургалтад дараахыг онцолж хэрэглэнэ.

Хүснэгт 26. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах жишээ

Тохируулга	Зорилго	Ашиглах хэлбэр
Хадмал үг (Captions)	Хэлний ойлголтыг бэхжүүлэх	Хичээлийн видеонд хадмал үгийг идэвхжүүлж, гол үгсийг өнгөөр ялган тэмдэглэх
Блок текст (Block Text Labels)	Блок бүрийн утгыг харуулах	Харааны даалгавар дээр блокийн нэрийг томруулж үзүүлэх
Харааны дохио/тэмдэг Visual Cues (Highlight)	Алдаа илрүүлэхэд туслах	Код ажиллахад буруу хэсгийг улаан хүрээтэйгээр тодруулах
Бага багаар ажиллуулах Step-by-step playback)	Хурд тохируулах	Код ажиллуулах хурдаа суралцагч өөрөө хянах боломж өгөх

Зураг 1. Code.org платформын тохиргоо (Captions, Visual Cues, Step-by-step playback идэвхжсэн байдал).

6. Ганцаарчилсан үнэлгээний аргачлал

- *Гүйцэтгэлд суурилсан үнэлгээ (performance-based):* Суралцагч блок кодын дарааллаар дүрсийг зөв хөдөлгөж чадсан эсэхийг харгалзах
- *Өөрийн үнэлгээ (self-reflection):* “Яагаад ингэж кодчилсон бэ?” гэдгийг дохиогоор эсвэл зургаар илэрхийлүүлэх
- *Ахицын карт:* Хичээл бүрийн дараа “би сурсан”, “би давтсан”, “би ойлгоогүй” гэсэн гурван дүрсийг харуулсан карт дээр тэмдэглэгээ хийх
- *Визуал портфолио:* Суралцагчийн кодын screenshot, өөрийн тайлбар, зургаар илэрхийлсэн даалгаврыг багцалж хадгалах
- *Ахиц хөтлөх дэвтэр:* “Миний кодын дэвтэр” – суралцагчийн хийсэн кодын зураг, зурсан ойлголтын схем, тайлбар бүхий жижиг дэвтэр хөтлүүлэх

Бусад:

- *ASLCORE (RIT, USA):* Ганцаарчилсан сургалтад нэр томъёог тогтмол дохиогоор хэрэглэж хэвшүүлэх <https://aslcore.org/>
- *Deaf Kids Code:* Хичээлийн дараа суралцагч өөрийн хөдөлгөөнөөр “loop dance” эсвэл “code story” бүтээх нь ойлголтыг гүнзгийрүүлнэ. <https://www.deafkidscode.org/>
- *Code Jumper (Microsoft):* Харааны болон хөдөлгөөнөөр код бичих төхөөрөмжийг ашиглах санааг цаашид хэрэгжүүлэхэд тохиромжтой. <https://apps.microsoft.com/detail/9nxj2dqdqvvg>
- *Нэг ойлголт – нэг хичээл:* Давталт (Loop) гэх мэт хийсвэр ойлголтыг дараагийн хичээл рүү үсрэлгүйгээр бүрэн ойлгуулах
- *Сургалтын үеийн дэмжлэг:* Хичээл эхлэх, дуусах дохиог (visual cue) тогтмол хэрэглэх
- *Хос хэлний материал:* Монгол дохионы хэл + текст + зурагтай жижиг картуудыг хэрэглэх
- *Сургалтын явцын тэмдэглэл:* Суралцагчийн гүйцэтгэлийг бичиж, дараа нь хамт үзэж сайжруулах шаардлагатай ур чадварыг илрүүлэх

Дөрөв. Сургалтын үйл ажиллагаа

Суралцагчид мэдлэгээ хэрэглэх, асуудлыг шийдвэрлэх чадварыг хөгжүүлэхэд чиглэнэ.

Хүснэгт 27. Хичээлийн алхамчилсан жишээ

Үе Шат	Багшийн Үйлдэл / Тохируулга	Үр Дүн
Асуудлаа тодорхойлох	Багш "Робот нь дөрвөлжин зам дээр 4 тал дагуу алхах ёстой" гэсэн даалгаврыг зурган схем (визуал) болон ДХ-ээр танилцуулна.	Суралцагч асуудлыг харааны хүртэхүйгээр ойлгож, дарааллыг төсөөлнө.

Алгоритм төлөвлөх	Эхлээд алхам алхмын дарааллыг энгийн карт (Жишээ нь: 'Урагш 5 алхам', 'Баруун эргэх') ашиглан байрлуулна (1-р тал).	Асуудлыг төлөвлөх хөгжинө. ойлгох, чадвар
Давталтыг таниулах	Суралцагч энэ 4 алхмыг 4 удаа давтах шаардлагатайг ойлгуулж, 4 давталтыг давталтын блок (визуал блок) ашиглан нээгэнэ. Багш "Хэрхэн энэ үйлдлийг хялбарчлах вэ?" гэсэн ДХ-ээр хэлэлцүүлэг өрнүүлнэ.	Суралцагч төвлөрсөн сургалтыг дэмжих, логиктой сэтгэх чадвартай болно.
Кодчилох (Турших)	Суралцагч блок кодчиллын программ дээр хавтангууд шиг харагдах блокуудыг ашиглан даалгаараа кодчилж, хөдөлгөөнөөр (программын үр дүн) шалгана.	Алдаагаа илрүүлэн сайжруулах чадвартай болно.

Тав. Үнэлгээ

Үнэлгээ нь суралцагчийн ахиц дэвшлийг урамшуулахад чиглэнэ.

Хүснэгт 28. Хичээлийн алхамчилсан жишээ

Үнэлгээний арга	Багшийн үйлдэл / Тохируулга	Анхаарах зүйлс
Гүйцэтгэл	Суралцагчийн бичсэн код зөв ажиллаж, робот/дүрсийг амжилттай давталттайгаар удирдаж ажиллуулж байгаа эсэхийг хялбар аргаар шалгах	Зөвхөн хичээлийн үр дүнгээс гадна мета-хичээлийн үр дүнг (асуудал шийдвэрлэх чадвар) чухалчлах
Дэлгэрэнгүй тайлбар	Суралцагчаас яагаад "Давталт" блок ашигласан шалтгаанаа дохионы хэлээр эсвэл бичгээр тайлбарлахыг хүсэх	Суралцагчийн бичих чадвар, бодол санаагаа бичиг болон дүрсээр илэрхийлэх ур чадварыг үнэлэх
Дэмжлэг	Даалгавар гүйцэтгэлийн үе шат бүрт тусламж үзүүлэх Хэрэв суралцагч даалгавар гүйцэтгэхэд хүндрэлтэй байвал ахиц гаргах хүртэл нь суралцагчийн хурдад тулгуурлан нэмэлт тайлбар, туслалцаа үзүүлэх	Суралцагчийг даалгавраа гүйцэтгэж дуустал нь тэвчээртэй хүлээх, тогтмол дэмжлэг үзүүлэх
Урамшуулал	Суралцагчийн ахиц амжилтыг урамшуулан, хийсэн даалгаварт нь чанарын үнэлгээ хийж, ямар ур чадвараа түлхүү хөгжүүлэх боломжтойг тайлбарлан өгөх	Энэ нь суралцагчийн гүйцэтгэлийг үнэлж байгаа явцын үнэлгээ болохыг ойлгуулах

Зургаа. Ээлжит хичээлийн төлөвлөгөө

Сэдэв: Давталт (Loop) гэж юу вэ?

Хүснэгт 29. Хичээлийн алхамчилсан жишээ

Үе шат	Багшийн үйлдэл / Арга зүй / Тохируулга	Суралцагчийн гүйцэтгэл / үр дүн
1. Ойлголтыг Танилцуулах (Representation) - Дэлгэцгүй (Unplugged)	Онол, Ойлголтыг Танилцуулах: "Давталт" (Loop) гэсэн хийсвэр ойлголтыг ДХ-ээр тайлбарлаж, өнгө ялгалттай дүрслэлээр (зурсан карт, бүдүүвч) үзүүлнэ. Асуудал Тавих: Багш "Робот нь дөрвөлжин зам дээр 4 тал дагуу алхах ёстой" гэсэн даалгаарыг зурган схем (визуал) болон ДХ-ээр танилцуулна.	Суралцагч "Давталт" гэсэн үгний утгыг ДХ болон харааны дүрслэлээр хүлээн авч, даалгаарыг ойлгоно.
2. Кинестетик Туршилт (Kinesthetic Action)	Алгоритм Төлөвлөх: Эхлээд 1-р талыг (жишээ нь: Урагш 5 алхам, Баруун эргэх) энгийн карт ашиглан дарааллаар байрлуулна. Давталтын Үйлдэл (Kinesthetic): Багш энгийн үйлдлүүдийг (жишээлбэл, 4 удаа алхах, 3 удаа босож суух) суралцагчдаар биеэр нь гүйцэтгүүлнэ. Энэ үйлдлийг 4 удаа давтуулахыг ДХ-ээр зааварчилна. Хэлэлцүүлэг: Багш "Хэрхэн энэ үйлдлийг хялбарчлах вэ?" гэсэн асуултыг ДХ-ээр тавьж, суралцагчидтай энэ 4 алхмыг 4 удаа давтах шаардлагатайг ойлгуулах хэлэлцүүлэг өрнүүлнэ.	Суралцагч асуудлыг ойлгож, төлөвлөх чадварыг хөгжүүлнэ. Биеийн хөдөлгөөнөөр дамжуулан Давталтын хийсвэр ойлголтыг мэдэрч эзэмшинэ.
3. Code.org дээрх Кодчилал (Action & Expression)	Кодчилох (Турших): Code.org (эсвэл үүнтэй төстэй блок кодчиллын орчин)-ыг ухаалаг самбар дээр томруулж харуулна. Командуудыг Танилцуулах: Командуудыг (жишээлбэл, 'move forward', 'turn right') ДХ-ээр нэг бүрчлэн тайлбарлаж, блок кодчиллын орчинд хэрхэн ашиглахыг визуалаар үзүүлнэ. Блок Ашиглах: Суралцагчдавталтын блок (Repeat block)-ийг ашиглан өмнөх 4 алхмыг нэгтгэн кодлох даалгаарыг өгнө. Хэрэглэгч блокууд дээр курсороо аваачихад ДХ-ийн дохио (ASL) үзүүлэх тохиргоог идэвхжүүлсэн байна.	Суралцагч блок кодчиллын орчинд Давталтын блокыг ашиглан давталттай алгоритмыг үүсгэнэ.

<p>4. Үнэлгээ ба Эргэх Холбоо (Assessment & Feedback)</p>	<p>Үйлдлийн Гүйцэтгэл: Суралцагчийн бичсэн код зөв ажиллаж, робот/дүрсийг амжилттай давталттайгаар удирдаж байгаа эсэхийг шалгана. Визуал Эргэх Холбоо: Хэрэв код амжилттай ажиллавал текст эсвэл графикаар тодорхой хараанд суурилсан дохио өгөх. Тайлбар: Суралцагчаас яагаад энгийн дарааллаас илүү "Давталт" блок ашигласан шалтгаанаа ДХ-ээр эсвэл бичгээр тайлбарлахыг хүсэх. Урамшуулал: Суралцагчийн ахиц амжилтыг урамшуулж, асуудал шийдвэрлэх чадварыг нь онцолно.</p>	<p>Суралцагч алдаагаа илрүүлэн сайжруулж, давталтын хэрэглээний талаарх логик сэтгэлгээгээ илэрхийлнэ. (Алдаа илрэхэд анхааруулах тэмдэг гарч ирнэ. Даалгаврыг амжилттай гүйцэтгэсэн тохиолдолд like харагдана).</p>
---	---	--

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ:

- CAST. (2018). *Universal Design for Learning guidelines version 2.2*. CAST. <https://udlguidelines.cast.org>
- Code.org. (n.d.). *Code.org accessibility features*. <https://code.org/accessibility>
- Deaf Kids Code. (n.d.). *Empowering deaf and hard-of-hearing students through coding*. <https://www.deafkidscode.org>
- Hewer, C. J., & Ainsworth, S. (2018). The role of visual and kinesthetic learning in computer science education. *Journal of Computer Assisted Learning*, 34(4), 451–466.
- RIT/NTID. (n.d.). ASLCORE: Computer science glossary. Rochester Institute of Technology. <https://aslcore.org>
- Soltero, S. (2004). *Dual language teaching and learning*. Allyn & Bacon.
- Wong, D., & Leung, C. (2017). Learning preferences of deaf and hard-of-hearing students in visual-based instruction. *Deafness & Education International*, 19(3), 123–135.
- Fleming, N. D., & Baume, D. (2006). Learning styles again: VARKing up the right tree? *Educational Developments*, 7(4), 4–7.
- CSforALL. (2020). *Inclusive CS education framework*. <https://www.csforall.org>
- Bell, T., Witten, I. H., & Fellows, M. (2015). *Computer science unplugged*. CS Education Research Group.
- Mayberry, R. (2002). Cognitive development in deaf children: The interface of language and perception. *Trends in Cognitive Sciences*, 6(4), 139–140.

СУДЛАГДАХУУНЫ НЭР: ДҮРСЛЭХ УРЛАГ, ДИЗАЙН

Нэг. Сурагчийн талаарх ерөнхий мэдээлэл: Сурагч “С”, эмэгтэй, ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар анги, эрүүл мэндийн байдал: Сонсголгүй. (ЭМБ-ын чих хамар хоолой, сонсгол судлалын нарийн мэргэжлийн эмчийн оноштой. Сурагч “С”-ийн хувьд хичээлийн агуулгаа бүрэн эзэмших боломжтой, оюун ухааны хөгжил, биеийн хөгжил хэвийн, харин хөдөлгөөн чөлөөтэй боловч тэнцвэрийн хувьд бага зэргийн алдагдалтай,

одоогоор бие дааж нийгмийн үйлчилгээнд оролцох боломж хязгаарлагдмал, хэл яриа хөгжөөгүй, дохионы хэлээр харилцдаг.

Сурагч “С” сонсголгүйн улмаас суралцах үйлд тодорхой хүндрэл үүсэж байгаа учраас сургалтын хөтөлбөрийн арга зүйд тохируулга хийх үндэслэлтэй байна.

Суралцагчийн төлөв байдал

- Математик, дүрслэх урлаг, дизайны хичээлд сонирхолтой. Монгол хэлний хичээлд хоцрогдолтой. Бичих чадвар муу, цээжээр бичиж чадахгүй, хуулан бичлэг хийдэг, үгийн утга ойлгоход хүндрэлтэй. Дохионы хэл, видео хэрэглэгдэхүүн ашиглаж сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг авах хүсэлтэй.
- Биеийн тамирын хичээлд анги нийтийн хичээлд сонирхолтой, хөгжмийн хичээлээр бүжиглэх авьяасаа хөгжүүлж, дугуйланд хичээлээс гадуур хамрагдах сонирхолтой.
- Багш болон ангийн найз нартайгаа харилцахад хүндрэлтэй. Ангийн сурагчид дохионы хэл мэдэхгүй. Багш нар дохионы хэл мэдэхгүй учраас харилцааны хувьд маш их хүндрэлтэй. Ангийн найз нартайгаа дохио зангаагаар харилцаж, цэвэрлэгээ хийх, бусдад туслах, өөрийгөө илэрхийлэхэд хүндрэлтэй. Хооллох зуршил сайн. Биеийн ерөнхий хөгжил сайтай.
- Ангийн хүүхдүүдтэй эвтэй, найз нөхдийн зүгээс түүнд тусалдаг.
- Ангийнхан нь дээрэлхдэггүй. Бүжиглэх дуртай, урлагийн арга хэмжээнд сайн оролцдог.

Ар гэрийн байдал:

- Аав, ээж, эмээ, өвөө, нэг дүүтэйгээ амьдардаг. Ам бүл 6
- Дүүтэйгээ тоглодог, гэрийн ажилд тусалдаг.
- Эмээ, өвөө нь охинд тусалж чаддаггүй. Гэртээ гэрийн даалгавраа хийдэг боловч, алдааг нь засаж хэлж өгч, тусалдаг хүн байхгүй. Компьютер их тоглодог. Дэлгэцийн хамаарал ихтэй байна.
- Аав, ээж нь хүүхдийнхээ гэрийн даалгавар хийлгэх, бие даан суралцахад тусалж төдийлөн чаддаггүй. Ээж нь ээлжийн ажилтай. Гэрийн ажил ихтэй, настай аав, ээжийгээ асардаг. Ээж нь ихэвчлэн сургуулиас нь авдаг.

Сургууль дээрх байдал:

Ангийн багш нь сурагч “С”-н монгол хэл, байгалийн ухаан, нийгмийн ухааны хичээлийн сургалтын хөтөлбөрт тохируулга хийж ажиллахыг багш нараас хүсч, сурлагын хоцрогдлыг багасгах зорилгоор сургалтын хөтөлбөрт тохируулга хийх хэрэгцээтэй гэдгийг гэр бүлийн гишүүд аав, ээжид нь танилцуулж, зөвшөөрөл авсан. Сургууль дээрх “Дэмжлэгийн баг”-ийн гишүүдэд асуудлыг танилцуулсан.

Хоёр. Үндсэн хэсэг

Бага боловсролын дүрслэх урлаг, дизайны сургалтын хөтөлбөрт сонсголын бэрхшээлтэй суралцагчийн хөгжлийн онцлогийг харгалзаж дараах үе шатаар тохируулга хийж хэрэгжүүлнэ.

Сургалтын хөтөлбөрт тохируулга хийх үе шат:

1. **Суралцагчийн хөгжлийн онцлогийг судлах, тодорхойлох:** (сурах хөгжих онцлог, хэрэгцээ, сонирхол)
2. **Дүрслэх урлаг, дизайны сургалтын хөтөлбөрт тохируулга хийх:**
 - Сургалтын зорилт, агуулгын тохируулга
 - Сургалтын арга зүй, үйл ажиллагааны тохируулга
 - Сургалтын хэрэглэгдэхүүн (дасгал, даалгавар), орчны тохируулга
 - Үнэлгээний дэмжлэг ба тохируулга
3. **Хэрэгжүүлж, сайжруулалт хийх:**

Хүснэгт 30. Тохируулга хийж хэрэгжүүлэх үе шат

Үе шат	Үндсэн зорилго	Үндсэн үйл ажиллагаа
1-р үе шат: Суралцагчийн хөгжлийн онцлогийг судлах	Сонсголын бэрхшээлтэй суралцагчийн суралцах чадвар, хэрэгцээ, сонирхлыг тодорхойлох	Сэтгэц, танин мэдэхүйн онцлог (хэл яриа, анхаарал төвлөрөх чадвар), хөдөлгөөний, орчны нөлөөг судлах
2-р үе шат: Сургалтын хөтөлбөрт тохируулга хийх	Сургалтын агуулга, арга зүй, орчин, хэрэглэгдэхүүн, үнэлгээнд тохируулга хийх	Харааны ба мэдрэхүйн мэдээлэл давамгайлсан арга ашиглах
3-р үе шат: Хэрэгжилт ба сайжруулалт	Тохируулсан хөтөлбөрийг туршиж, хэрэгжилтийг үнэлэх	Ажиглалт, үнэлгээ, суралцагчийн ахицын дүн шинжилгээнд тулгуурлан сайжруулах

Үе шат 1. Суралцагчийн хөгжлийн онцлогийг судлах: (сурах хөгжих онцлог, хэрэгцээ, сонирхол)

1. Багш дараах чиглэлээр судалж сонсголын бэрхшээлтэй суралцагчийн онцлогийг тодорхойлно.

А. Сонсголын бэрхшээлтэй суралцагчийг тодорхойлолт

- Сонсох чадвар алдалтын түвшин (огт сонсголгүй/ сул сонсголтой)
- Сонсгол дэмжих нэмэлт төхөөрөмж ашигладаг эсэх
- Дохио хэл, бичгийн хэлний түвшин

Б. Танин мэдэхүйн онцлог

- Харааны ба хүртэхүйн мэдрэхүй давамгайлдаг
- Анхаарал төвлөрөл богино хугацаатай, олон үйлдэл зэрэг хийхэд хүндрэлтэй
- Хэл ярианы хоцрогдлоос үүдэлтэй үгийн нөөц хязгаарлагдмал
- Хийсвэр сэтгэх, үгийн утга ялгах чадвар харьцангуй сул

В. Хөгжлийг дэмжих боломж

- Харааны анхаарал болон дүрсийн ойлголт сайн
- Гар, биеийн хөдөлгөөний зохицол сайн хөгжсөн
- Зураг дүрслэл, биеийн хөдөлгөөнөөр өөрийгөө илэрхийлэх сонирхол өндөр гэх зэргийг судалж тодорхойлох

Мэдээлэл 1. Сонсголын бэрхшээлтэй хүүхэд гэж хэн бэ?, Сонсох чадварын алдалт ямар түвшинд байна вэ? Сонсох чадвар алдалтын түвшнээс хамааран огт сонсголгүй, сул сонсголтой гэж ангилна.

- **Огт сонсголгүй:** Сонсгол бүрэн алдагдсан.
- **Сул сонсголтой:** Сонсголын аппаратын тусламжтайгаар бусадтай харилцах боломжтой.

Сонсголгүй хүүхдийн эх хэл дохионы хэл байдаг. Сонсголын бэрхшээл нь хоёрдогч бэрхшээл болох хэл ярианы бэрхшээлийг үүсгэж улмаар хүүхдийн танин мэдэхүйн болон нийгэмшихүйн хөгжлийн хоцрогдлыг үүсгэдэг. Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сэтгэц, танин мэдэхүйн онцлог: Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сэтгэц, танин мэдэхүйн онцлог дараах байдлаар илэрнэ. Сонсох эрхтний үйл ажиллагаа алдагдсанаар бусад мэдрэхүй, ялангуяа хараа болон хүртэхүйн мэдрэмж нь түүнийг орлон хөгждөг байна. Харааны мэдээллээр эд зүйлсийг гол бус бусад шинж чанараар нь ялгаж, ерөнхийлж ойлгодог ба бие даан задлан шинжлэх чадвар нь хязгаарлагдмал байдаг. Сонсголын алдалт нь авиа ялгах чадварыг бууруулж, шинэ үг, ойлголтыг удаан тогтоох, хадгалахад хүндрэл үүсгэдэг. Мөн анхаарал төвлөрөлт сул ба нэг үйлдлээс нөгөө үйлд шилжихэд хүндрэлтэй. Гэхдээ харааны болон дохионы мэдээллийг хүлээн авч, сэргээн санах чадвар сайн хөгжсөн байдаг. Хүний сэтгэхүйн үйл ажиллагаа хэл ярианаас салшгүй учир хэлний хөгжлийн хоцрогдол нь сэтгэхүйн чадварт шууд нөлөөлдөг. Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн нэгтгэн дүгнэх, хийсвэр сэтгэх чадвар сул, бодит сэтгэхүй нь эмх замбараагүй байдаг. Үгийн нөөц багатай (1-р ангид ойролцоогоор 40–70 үг) бөгөөд үгийг байнга ашиглахгүй бол амархан мартагддаг онцлогтой. Дохионы хэл нь тэдний эх хэл тул үгийн ойлголт, хялбар харилцааг дэмждэг. Хэл яриаг байнга хэрэглэдэггүй нь хэл сурах үйл явцыг удаашруулж, багшийн тусламж, давтан сургалт шаарддаг онцлогтой. Сонсголын бэрхшээлтэй хүүхдэд сургуульд орсон өдрөөс нь эхлэн дохионы хэл, үгийн

Сонсголын бэрхшээлтэй суралцагч нь харааны болон хүртэхүйн мэдрэхүйгээр дамжуулж мэдээллийг илүү хүлээн авдаг онцлогтой. Тэдний танин мэдэхүйн хөгжилд дараах сул талууд илэрдэг байна. Үүнд, хэл ярианы хоцрогдол, үгийн нөөцийн дутагдал, анхаарал төвлөрөх чадварын хязгаарлагдмал байдал, хийсвэр сэтгэхүйн чадвар сул байх магадлалтай байна.

Үе шат 2. Дүрслэх урлаг, дизайны сургалтын хөтөлбөрт тохируулга хийх:

2.1. Тохируулгыг хийхдээ, тухай судлагдахууны сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүй, үнэлгээний уялдаа холбоо, онцлогийг судална.

Мэдээлэл 2. Бага боловсролын дүрслэх урлаг, дизайны сургалтын хөтөлбөрийн онцлог

Зорилго, хүрэх үр дүн: Дүрслэх урлаг, дизайны сургалтын хөтөлбөр нь суралцагчдад зурах, дүрслэх, урлан бүтээх суурь чадамж болон бүтээлчээр сэтгэх, гоо зүйн мэдрэмж, сэтгээдлээ илэрхийлэх, шүүн тунгаах, хамтран ажиллах ерөнхий чадамжийн хөгжлийг дэмжихэд чиглэнэ.

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр суралцагч дараах үр дүнд хүрсэн байна:

- Дүрслэх урлаг, дизайны үндсэн элемент, арга зарчмыг ойлгож хэрэглэх
- Өөрийн мэдлэг туршлагад тулгуурлан бүтээлийн санаа гаргаж, хөгжүүлэх
- Материал, хэрэглэгдэхүүнээ сонгон, хийх арга дарааллыг төлөвлөж, бүтээлчээр гүйцэтгэх
- Үндэсний болон дэлхийн урлагийн бүтээлээс судалж, мэдрэмж сэтгээдлээ илэрхийлэх

Агуулга:

- Дүрслэх урлаг, дизайны хөтөлбөрийн агуулга нь гурван үндсэн айтай.
- 1. Дүрслэлийн хэл (Дүрслэлийн үндсэн элемент, арга, зарчмуудыг багтаана).
- 2. Урлан бүтээхүй (Зураг урлалын материал, хэрэглэгдэхүүн, урлан бүтээх арга ажиллагааг багтаана).
- 3. Соёлын үнэт зүйл (Үндэсний болон дэлхийн дүрслэх урлагийн бүтээлээс судална).

Арга зүй:

- Сургалтын хөтөлбөрийг туршлагад суурилсан суралцахуйн арга зүйн дараах алхмаар төлөвлөж хэрэгжүүлнэ.
- 1. Ажиглах-Асуудал дэвшүүлэх: Байгаль, орчны юмс үзэгдэл, дүрслэх урлагийн бүтээлийг ажиглах, асуулт асуух, санаагаа илэрхийлэх.
- 2. Эрэл хайгуул хийх-турших: Материал, хэрэглэгдэхүүн, зурах арга барилыг туршиж үзэх, шинэ санаа шийдэл эрэлхийлэх.
- 3. Бүтээх-гүйцэтгэх: Өөрийн санаагаа илэрхийлэхэд тохирох материал, арга, дарааллаа төлөвлөж, бүтээл хийх, явцдаа анхны санаагаа сайжруулах, өөрчилж загварчлах.
- 4. Үнэлэх-хөгжүүлэх: Бүтээлээ үнэлж өөртөө шүүмжлэлтэй хандах, бусдаас

Дүрслэх урлаг, дизайны хичээл нь үйл явцад төвлөрдөг онцлогтой учир харааны болон хүртэхүйн мэдрэхүй давамгайлсан сургалт, үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулахад тохиромжтой.

2.2. Дүрслэх урлаг, дизайн” судлагдахууны хөтөлбөрт тохируулга хийх арга зүй:

Дүрслэх урлаг, дизайны сургалтын хөтөлбөрийн тохируулгыг харааны болон хүртэхүйн мэдрэхүй давамгайлсан танин мэдэхүйн онцлогт тулгуурлан боловсруулна. Мөн хичээлийн төлөвлөх, зохион байгуулах явцад сонсголын бэрхшээлтэй суралцагчийн үгийн утгыг ойлгох, үгийн сангийн нөөцийг нэмэгдүүлэх, хэл ярианы хөгжлийг онцгой анхаарах хэрэгтэй.

А. Сургалтын зорилт, агуулгын тохируулга

- Хичээлийн сэдэв, зорилгыг товч тодорхой өгүүлбэрээр илэрхийлэх
- Хэл ярианы бус харилцааг (дүрс, дохио, биеийн болон нүүрний хөдөлгөөн, тэмдэг, бэлгэдэл) ашиглан хичээлийн зорилго, утгыг ойлгуулах

- Хичээлийн шинэ мэдлэг, мэдээллийг схем, зураглал, видео, дохионы тайлбартайгаар боловсруулах
- Туршилт, ажиглалт, хийж гүйцэтгэх үйл ажиллагаанд суурилсан агуулга төлөвлөх
- Хичээлийн дасгал, даалгаврыг зураг дүрслэл давамгайлсан алхамчилсан байдлаар төлөвлөх

Б. Сургалтын арга зүй, үйл ажиллагааны тохируулга

- Харааны ба хөдөлгөөний оролцоог нэмэгдүүлэх
 - Багшийн нүүрний хувирал, хөдөлгөөн, дохио зангааг ашиглан мэдлэг, ойлголтыг бататгах
 - Дохио хэл, зурагт заавар, богино видео хичээл ашиглах
- Дасгал, даалгаврыг алхамтайгаар задалж, алхам бүрийг дүрс, зургаар зааварчилж чиглүүлэх
- Хамтын ажиллагаанд суурилсан арга хэрэглэх (хосоор болон бүлгээр ажиллуулах)
- Суралцагчдын бүтээлч оролцоог дэмжих, урамшуулах

В. Сургалтын хэрэглэгдэхүүн ба орчны тохируулга

Хэрэглэгдэхүүн:

- Харааны мэдээлэл давамгайлсан хэрэглэгдэхүүн (зураг болон үгэн карт, зураг ном (комикс), видео заавар, зурагт хуудас (постер))
- Дохио болон дүрслэлтэй ажлын хуудас, алхамчилсан зурагт зааварчилгаа
- Мэдрэхүйд тулгуурласан материалууд (барзгар, гөлгөр, хатуу, зөөлөн гэх мэт)
- Үг–зураг хосолсон карт, зурагт толь

Орчны тохируулга:

- Гэрэлтүүлэг сайтай, чимээ багатай анги танхим
- Сонсголын бэрхшээлтэй суралцагч багшийг бүрэн харах байрлалд суусан байх
- Хичээлийн үеийн заавар, алхмуудыг самбарт зураг хэлбэрээр байрлуулах
- Харааны анхаарал төвлөрүүлэхэд туслах өнгө, тэмдэгт, дүрслэл ашиглах

Г. Үнэлгээний дэмжлэг ба тохируулга

Үнэлгээ нь сонсголын бэрхшээлтэй суралцагчийн бүтээлч оролцоо, хөгжил, ахиц, оролдлого, өөрийгөө илэрхийлэх чадварыг үнэлэхэд чиглэнэ.

Үнэлгээний арга:

- Харааны тэмдэг (наалт, дүрс, өнгө, сэтгэл хөдлөлийн илэрхийлэл (инээмсэглэл)) ашиглах
- Үнэлгээг ажиглалтын тэмдэглэл, бүтээлийн санд тулгуурлан хийх
- Суралцагчийн бүтээлийг өмнөхтэй нь харьцуулан ахиц дэвшлийг тодорхойлж үнэлэх
- Суралцагч өөрийн бүтээлээ дохио, зураг, бичгээр тайлбарлан танилцуулах боломж олгох, өөрийн үнэлгээг харгалзах

Хүснэгт 31. Дасгал даалгаврын тохируулга (шатлалаар)

Шатлал	Анги	Дасгал, даалгаврын онцлог
Бага боловсролын эхлэл шат	I-II анги	Харааны болон мэдрэхүйн арга давамгайлсан, энгийн ойлгомжтой алхамтай дасгал, даалгавар.
Бага боловсролын төгсгөл шат	III-V анги	Бүтээлч, танин мэдэхүйн уялдаатай, дүрс ба бичвэрийг хосолсон, харилцаа хөгжүүлэх даалгавар.

Гурав. Нэгж болон ээлжит хичээлийн төлөвлөлт

1. Бага боловсролын эхлэл шатлал

Нэгж хичээлийн төлөвлөлт

Анги: 2 дугаар анги

Агуулгын ай: **Дүрслэлийн хэл**

Дэд ай: Дүрслэлийн үндсэн элемент, арга, зарчим

Суралцахуйн үр дүн: 2.1а Дүрслэлийн үндсэн элементүүд (үүсмэл өнгө, толбо, зураас, дүрс)-ийг таньж зураг бүтээлд хэрэглэнэ.

Нэгж сэдэв: Дүрслэлийн үндсэн элемент

Хүснэгт 32. Хичээлийн жишээ

Хичээлийн сэдэв	Бид юу хийх вэ?	Суралцахуйн үйл ажиллагаа	Үнэлгээ
Өнгө	Үүсмэл өнгө (улбар шар, ногоон, нил ягаан)-ийг таньж, зураг бүтээлдээ хэрэглэнэ.	<ul style="list-style-type: none"> - Танил юмсыг зурж, үүсмэл өнгийг гараар, хурууны өндөг, будаг ашиглан турших - Өөрийн болон бусдын бүтээлийг ажиглаж, зураг, дохио, тэмдэг ашиглан үнэлэх - Зураг бүтээлээс үүсмэл өнгийг таньж нэрлэх, юунд хэрэглэх талаар зураг, дүрслэлийн жишээн дээр зааж тайлбарлах - Үүсмэл өнгө сонгож өөрийн төсөөллийг илэрхийлсэн бүтээл хийх - Бүтээлээ зураг, дохиогоор тайлбарлах 	<ul style="list-style-type: none"> - Үүсмэл өнгө (улбар шар, ногоон, нил ягаан)-ийг таньж нэрлэдэг. - Үүсмэл өнгийг бүтээлийн онцлогт нийцүүлэн сонгож хэрэглэдэг.
Толбо	Толболж зурж, өөрийн санаагаа бүтээлээр илэрхийлнэ.	<ul style="list-style-type: none"> - Толбо үүсгэх арга (хурууны өндөг, гарын алга) турших - Зураг бүтээлийн жишээн дээр толбыг яаж үүссэн тухай тайлбарлах - Толболж зурсан бүтээлүүдийг харж ажиглаж өөрийн санаагаа дохио, зураг ашиглан хуваалцах - Өөрийн санаа, туршлагадаа тулгуурлан толболох аргаар бүтээл хийх, баяжуулах, зурж, будах 	<ul style="list-style-type: none"> - Толболох аргаар зурсан зургийг таньдаг. - Толболж зурах аргаас сонгож өөрийн төсөөллөө зурдаг.
Зураас	Долгион, нуман зураасны онцлогийг таньж, бүтээлдээ ашиглана.	<ul style="list-style-type: none"> - Долгион, нуман зураасыг харандаа, будаг, хурууны хөдөлгөөнөөр зурж турших - Долгион, нуман зураасны 	<ul style="list-style-type: none"> - Зураасны төрлүүд (долгион, нум)-ийг таньж нэрлэдэг. - Долгион, нуман

		ялгааг харьцуулан зааж тайлбарлах - Зураг бүтээлээс долгион, нуман зураасыг таньж заах үгэн картаар нэрлэх - Долгион, нуман зураасаар бүтээл хийх санаа гаргах, бусадтай санаагаа зураг дүрслэлээр илэрхийлж хуваалцах - Өөрийн бүтээлээ танилцуулж тайлбарлах	зураасыг бүтээлийн онцлогт нийцүүлэн сонгож хэрэглэдэг.
Дүрс	Үндсэн дүрс болон нийлмэл дүрсийг ялган таньж, сонгож бүтээл хийнэ.	- Үндсэн дүрсүүдийг эвлүүлэн зурж, нийлмэл дүрс үүсгэх - Зураг бүтээлээс нийлмэл дүрсийг таньж, үндсэн дүрстэй харьцуулж ялгааг видео/зургаар тайлбарлах - Өөрийн туршлагаар үндсэн дүрсийг өрж нийлмэл дүрс бүтээх, санаагаа хөгжүүлэх - Нийлмэл дүрсийг хялбар аргаар зурж, хайчилж, өрж наах замаар эд юмсын загвар бүтээх	- Үндсэн болон нийлмэл дүрсийг ялгаж таньдаг. - Нийлмэл дүрсийг өрж эд юмсын загвар бүтээдэг.
<p>Сургалтын орчин:</p> <p>1. Эерэг, таатай харилцаа</p> <ul style="list-style-type: none"> • Багш эелдэг, найрсаг, суралцагчидийг дэмжинэ. • Алдаанаас суралцахыг зөвшөөрч, урам зориг өгнө. • Суралцагчдад дохио, зураг, биеийн хөдөлгөөнөөр санаагаа илэрхийлэх боломж олгоно. • Бусдын бүтээлийг ажиглах, харааны дэмжлэгтэйгээр ойлголт гүнзгийрүүлнэ. • Бүтээлч сэтгэлгээ, хамтран ажиллахыг дэмжинэ. <p>2. Эрүүл, аюулгүй, хүртээмжтэй анги танхим</p> <ul style="list-style-type: none"> • Самбарт зурагт, тэмдэгт, өнгөний хүрд, суралцагчийн бүтээл байрлуулж харааны хүртэх мэдээллийг нэмэгдүүлнэ. • Суралцагчийн хөдөлгөөнд тохируулах, байршлыг өөрчлөх боломжтой ширээ, гэрэлтүүлэг байна. • Хүрэлцэхүйц хэмжээний сургалтын хэрэглэгдэхүүнтэй, түүнийг эмх цэгцтэй байрлуулсан байна. • Бүтээл тавих, хатаах булан, анхны тусламжийн хайрцаг, интерактив самбар ашиглах боломжтой. <p>3. Ялгаатай хэрэгцээт орчин</p> <ul style="list-style-type: none"> • Зураг, бүдүүвчээр илэрхийлсэн өнгө ялгалттай сайтай үзүүлэн, тараах материалтай • Видео болон дохио, зурагт болон үгэн карт • Хөдөлгөөн: практик туршилт, хөдөлгөөнтэй тоглоом. • Дохионы болон зурагт толь бичиг. • Түвшний ялгаатай даалгаврын сан 			
<p>Туршилт, дадлагын хэрэглэгдэхүүн</p> <ul style="list-style-type: none"> • Зураг: мольберт, зургийн хавтан, харандаа, будаг, пастель, бийр, усан будаг, маркер, гуаш, баллуур, зургийн дэвтэр, усны сав, цаасан скоч. 			

- Гар урлал: хайч, цавуу, өнгийн болон хатуу цаас, баримлын шавар, байгалийн материал, утас, даавуу
- Нэмэлт: Ном, гарын авлага, зургийн цомог, постер, 3D үзүүлэн, зааварчилгаа, аюулгүй ажиллагааны зурагт карт
- Дижитал: зураг, видео заавар, интерактив хичээл, программ, хөгжмийн болон видео контент.

Ээлжит хичээлийн арга зүйн санаа

Хичээлийн сэдэв: Толбо

Анги: 2-р анги

Түлхүүр үг – Толбо

Бид юу хийж чаддаг болох вэ?

- Хуруу болон гарын алгаар үүсгэсэн толбо таньж мэднэ.
- Толбоор дүр бүтээж өөрийн санаагаа хөгжүүлнэ.

Хөгжүүлэх чадвар:

- Харааны ажиглалт
- Бүтээлч сэтгэлгээ
- Гар хурууны хөдөлгөөн, ур эв дүй
- Өөрийгөө илэрхийлэх

Хэрэглэгдэхүүн:

- Дохионы үгэн карт (толбо, том, жижиг, ус, будаг)
- Алхамчилах зурагт заавар
- Усан будаг эсвэл гуаш, усны сав, бийр, А4 зургийн дэвтэр, салфетка
- Үнэлгээний зурагт карт

Сургалтын орчин:

- Гэрэлтүүлэг сайтай, чимээ багатай анги танхим
- Сонсголын бэрхшээлтэй суралцагч багшийг бүрэн харах байрлалд суусан байх
- Хичээлийн үеийн заавар, алхмуудыг самбарт зураг хэлбэрээр байрлуулах

Хичээлийн үе шат:

Үе шат 1. Ажиглах – Асуудал дэвшүүлэх (10 мин)


Үйл ажиллагаа:

- Гарын хуруу болон алгаар толболон зурсан зураг үзүүлнэ.
- Эсвэл толбо үүсэх зураг зурж буй жишээ видео үзүүлнэ.
<https://www.youtube.com/watch?v=Vz4oVKHQ2ig>
- “Том”, “Жижиг” толбо харьцуулна. Том толбо аль вэ?

Даалгавар 1.

Зургийг ажиглаж ярилцаарай.

- Юу зурсан байна вэ?
- Зургийг яаж зурсан бэ?



- “Том”, “Жижиг” толбо харьцуулж ажиглана.
- Том толбо аль вэ?



Суралцагч асуултад зураг/дохионы хэл ашиглан хариулна.

Багшийн дэмжлэг:

- Дохионы хэл болон биеийн хөдөлгөөн, нүүрний хувирлаар илэрхийлж асуулт даалгавар болон үйл ажиллагааг чиглүүлнэ.
- Зурагт болон үгэн карт харуулж асуулт асуух, нэмэлт ойлголтыг тайлбарлана.
Толбо - цэгээс том хэмжээтэй, ямар нэг зүйлээс тогтсон (будгийн) үлдэц юм.

Үе шат 2. Эрэл хайгуул – Турших (20 мин)

Үйл ажиллагаа:

- Хурууны өндөг болон гарын алгаар толбо үүсгэх
- Өнгө сонгож хольж, том, жижиг хэмжээтэй толбо үүсгэж турших
- Багш алхам бүрийг зураг болон дохиотой карт ашиглан тайлбарлана.

Даалгавар 1.


Хэрэглэгдэхүүн: Усан будаг, гуаш, бийр, устай сав, будгийн нийлүүр, зургийн дэвтэр, эсгий бал

- Өнгө сонгож будгийн нийлүүрт дусааж усаар шингэлж бийрээр холино.
- Гарын алгаа бийрээр жигд будна.
- Дараа нь зургийн дэвтрийн төв хэсэгт гарын алгаар дарж толбо үүсгэнэ.



Даалгавар 2. Гарын алгаар үүсгэсэн толбыг харьцуулан ажиглаж ярилцаарай.

- Аль гарын (баруун, зүүн гар) алгаар толболсон бэ? Харьцуулж ярилцаарай.
- Толбо гэж юу вэ?
- Гарын алгаар толболж өөр юу зурж болох вэ?



Багшийн дэмжлэг:

- Алхам бүрийг зургаар болон биеэр дагуулж үзүүлэх
- Суралцагчдад хосоор ажиллах, туршиж үзэх боломж олгох
- ☐ Ус 💧 “Их ус” - 💧💧 “Бага ус” - 💧
- ☑ Усан будаг 🧠
- ☑ Дарж толбо үүсгэх 🖐



Үе шат 3. Бүтээх-гүйцэтгэх (30 мин)

Үйл ажиллагаа:

- Гарын алгаар үүсгэсэн толбоор бүтээх дүр олох
- Нэмж зурах (нүд, хөл, далавч гэх мэт)

Жишээ үзүүлнэ:

(заан, загас, шувуу, матар, цэцэг)



Дэмжлэг:

- Суралцагчид өөрөө дүр бүтээх нь хүндрэлтэй байвал, багш **дүр санал болгох** (зураг картаар)
- Багш алхмыг дахин дохиогоор сануулна

Үе шат 4. Үнэлэх – хөгжүүлэх (10 мин)

Үйл ажиллагаа:

- Өөрийн бүтээлээ бусдад үзүүлэх
- Дохионы хэл болон биеийн хөдөлгөөнөөр тайлбарлах
- Багш үнэлж урамшуулах

Өөрийн үнэлгээний хуудас:

	Би чадсан	Үнэлгээ (+)
	Толбо үүсгэж чадсан	
	Өнгө өөрөө сонгосон.	
	Дүр санаагаа өөрөө олж бүтээсэн.	
	Бүтээлээ харуулж танилцуулсан	

Багшийн дэмжлэг:

- Үг тус бүрийг зураг + дохиогоор
- Үг, богино өгүүлбэр, удаанаар ам хөдөлгөөнөөр илэрхийлэх
- Алхам бүрийг зураг, дүрслэлээр илэрхийлсэн ажлын хуудас байх
- Хосоор ажиллуулах
- Тэмдэгт, сум, тод өнгөөр чиглүүлэх
- Асуултын хариултыг дохио/зураг/биеийн хөдөлгөөн, үйлдлээр хүлээн авах

3.2. Бага боловсролын төгсгөл шатлал

Анги: 5 дугаар анги

Агуулгын ай: Соёлын үнэт зүйл

Дэд ай: Үндэсний болон дэлхийн дүрслэх урлагийн бүтээл

Хүснэгт 33. Хичээлийн жишээ

<p>Суралцахуйн үр дүн:</p> <p>5.36. Монголын болон дэлхийн хосгүй үнэт уран зургийн бүтээлээс сонгож уран бүтээлчтэй нь холбон хэлэлцэх замаар үнэ цэнийг ойлгох, таньж нэрлэнэ.</p>	<p>Агуулгын тохируулга:</p> <p>Монгол болон дэлхийн хосгүй үнэт уран зургийг харааны мэдээлэл ашиглан таньж, бүтээлээс санаа авч өөрийн санаагаа илэрхийлнэ.</p>
--	---

Хичээлийн сэдэв	Бид юу хийх вэ?	Суралцахуйн үйл ажиллагаа	Үнэлгээ
Монголын уран зургийн бүтээл	Монголын уран зургийг ажиглан өөрийн санаагаа илэрхийлнэ.	<ul style="list-style-type: none"> Хуулбарлах / санаа авч бүтээл хийх: Сонгосон уран зургийн бүтээлийг харж ажиглаж хуулбарлах эсвэл өөрийн санаагаа бүтээл хийж илэрхийлэх Бүтээлээ танилцуулах: Зураг, тэмдэг, дохионы хэлээр өөрийн санаагаа бусдад тайлбарлах 	<p>Монгол уран бүтээлийг таньж нэрлэдэг.</p> <p>Өөрийн санаагаа зураг дүрслэлээр илэрхийлдэг.</p>
Дэлхийн уран зургийн бүтээл	Дэлхийн уран зургийн бүтээлтэй танилцаж, санаа авч бүтээл хийнэ.	<ul style="list-style-type: none"> Зураг + дохио тайлбар: “Одтой шөнө” бүтээлийг харуулж багш дохио, зураг, нүүрний хөдөлгөөнөөр тайлбарлана Дүрс тэмдэгт, зураглал: Өнгө, гэрэл, хөдөлгөөн, мэдрэмжийг зураглал, тэмдэглэлээр харуулах Бүтээл хийх санаа: Сонгосон зургаас санаа авч өөрийн аргаар бүтээл хийх Бүтээлээ тайлбарлах: Зураг, тэмдэг, дохио ашиглан өөрийн санаагаа бусдад илэрхийлэх 	<p>Дэлхийн алдартай уран зургийн бүтээлийг таньж нэрлэдэг.</p> <p>Уран зургийн бүтээлийн талаарх санаагаа илэрхийлдэг.</p>
<p>Багшийн санамж:</p> <ul style="list-style-type: none"> Уран зургийн бүтээлийг багш дохио, дүрс, зураг ашиглан тайлбарлана. Дохионы хэл + дүрслэл, видео, үгэн болон зурагт карт ашиглан зургийн агуулгыг илэрхийлэх дасгал, даалгаврыг тайлбарлана. 			
<p>Сургалтын орчин:</p> <p>1. Эерэг, таатай харилцаа</p> <ul style="list-style-type: none"> Багш эелдэг, найрсаг, суралцагчидийг дэмжинэ. 			

- Алдаанаас суралцахыг зөвшөөрч, урам зориг өгнө.
- Суралцагчдад дохио, зураг, биеийн хөдөлгөөнөөр санаагаа илэрхийлэх боломж олгоно.
- Бусдын бүтээлийг ажиглах, харааны дэмжлэгтэйгээр ойлголт гүнзгийрүүлнэ.
- Бүтээлч сэтгэлгээ, хамтран ажиллахыг дэмжинэ.

2. Эрүүл, аюулгүй, хүртээмжтэй анги танхим

- Самбарт зурагт, тэмдэгт, өнгөний хүрд, суралцагчийн бүтээл байрлуулж харааны хүртэх мэдээллийг нэмэгдүүлнэ.
- Суралцагчийн хөдөлгөөнд тохируулах, байршлыг өөрчлөх боломжтой ширээ, гэрэлтүүлэг байна.
- Хүрэлцэхүйц хэмжээний сургалтын хэрэглэгдэхүүнтэй, түүнийг эмх цэгцтэй байрлуулсан байна.
- Бүтээл тавих, хатаах булан, анхны тусламжийн хайрцаг, интерактив самбар ашиглах боломжтой.

3. Ялгаатай хэрэгцээт орчин

- Зураг, бүдүүвчээр илэрхийлсэн өнгө ялгалттай сайтай үзүүлэн, тараах материалтай
- Видео болон дохио, зурагт болон үгэн карт
- Хөдөлгөөн: практик туршилт, хөдөлгөөнтэй тоглоом.
- Дохионы болон зурагт толь бичиг.

Түвшний ялгаатай даалгаврын сан

Туршилт, дадлагын хэрэглэгдэхүүн

- Зураг: мольберт, зургийн хавтан, харандаа, будаг, пастель, бийр, усан будаг, маркер, гуаш, баллуур, зургийн дэвтэр, усны сав, цаасан скоч.
- Гар урлал: хайч, цавуу, өнгийн болон хатуу цаас, баримлын шавар, байгалийн материал, утас, даавуу
- Нэмэлт: Ном, гарын авлага, зургийн цомог, постер, 3D үзүүлэн, зааварчилгаа, аюулгүй ажиллагааны зурагт карт
- Дижитал: зураг, видео заавар, интерактив хичээл, программ, хөгжмийн болон видео контент.

Ээлжит хичээлийн арга зүйн санаа

Хичээлийн сэдэв: Дэлхийн уран зургийн бүтээл “Одтой шөнө”

Анги: 5-р анги

Бид юу хийх вэ?

- Дэлхийн уран зургийн бүтээл “Одтой шөнө”-ийг таньж мэднэ.
- Дэлхийн уран зургийн бүтээлээс санаа авч өөрийн санаагаа зургаар илэрхийлнэ.

Хөгжүүлэх чадвар:

- Харааны ажиглалт
- Бүтээлч сэтгэлгээ
- Гар хурууны хөдөлгөөн, ур эв дүй
- Өөрийгөө илэрхийлэх

Сургалтын орчин:

- Гэрэлтүүлэг сайтай, чимээ багатай анги танхим
- Сонсголын бэрхшээлтэй суралцагч багшийг бүрэн харах байрлалд суусан байх

- Хичээлийн үеийн заавар, алхмуудыг самбарт зураг хэлбэрээр байрлуулах

Хичээлийн үе шат:

Үе шат 1. Ажиглах – Асуудал дэвшүүлэх (10 мин)

Багшийн дэмжлэг:

- Дэлгэц болон зургаар Ван Гогийн “Одтой шөнө” зургийг харуулна.
- “Од”, “сар”, “салхи”, “уул” гэх мэт үгсийг дохионы хэл, зураг болно үгэн карт харагдахуйц байрласан байна.
- Монголын шөнийн тэнгэрийн харуулсан фото зураг, видео бэлтгэж болно.

Үйл ажиллагаа:

1. Суралцагчид зургийг ажиглана.
2. Багш дохио хэл, нүүрний хөдөлгөөн, зураг ашиглан асуулт асууна.
 - Зурагт юу байна вэ?
 - Тэнгэр ямар өнгөтэй вэ?
 - Од, сар хаана байна вэ?
2. “Монголын шөнийн тэнгэр”ийн зургийг харьцуулж харуулна.
3. Багш “Чи өөрийн одтой шөнө” ямар байх вэ? Юу юуг дүрслэх вэ? Ямар өнгөтэй байх вэ? гэсэн асуултаар суралцагчдад бодол үүсгэнэ.

Даалгавар 1. Суралцагчид та нар шөнийн тэнгэр, оддыг ажиглаж байсан уу? Шөнийн тэнгэр, од, сар ямар харагддаг вэ?



Багшийн дэмжлэг:

- Хараагаар хүртэхүйц асуултын карт (зураг + үг)
- Дохио хэлний багштай байх эсвэл биеийн болон нүүрний илэрхийллээр харилцах
- Суралцагчид асуултын хариултаа зураг, тэмдэг, үгэн карт, дохио, биеийн хөдөлгөөн зэргээр илэрхийлэх боломжийг олгох

Үе шат 2. Эрэл хайгуул – Турших (20 мин)

Үйл ажиллагаа:

1. Суралцагч “Одтой шөнө” зургийг ажиглаж хуулбарлан зурах туршилт хийнэ.
 - Цэнхэр өнгийн **цайвраас бараанд шилжих байдлаар будна.**
 - Цайвар буюу гэрэлтэй хэсэг болон тод бараан сүүдэртэй хэсгийг ялгаж будах туршилт хийнэ.

- “Салхи”-ны хөдөлгөөнийг **мушгиа, долгион зураасаар** илэрхийлж зурна.

Даалгавар 2. Зургийг ажиглаарай. Зурагт юуг харуулсан бэ? зураарай.



Ван Гог. “Одтой шөнө”. 1889. 73 х 92 см.



Голландын их зураач Винсент Ван Гог 1889 онд “Одтой шөнө” алдарт

бүтээлээ зуржээ. Энэхүү зураг АНУ-ын Нью-Йорк хот дахь Орчин үеийн урлагийн музейд байдаг. Уран зургийн тогтсон уламжлалт дүрслэлийг эвдэж, өөрийн мэдрэмж, сэтгэгдлийг өвөрмөц өнгө, дүрслэлээр харуулсан нь Ван Гогийн бүтээлүүдийн онцлог юм.

Дэмжлэг:

- Багш алхам бүрийг зурагт карт, дохио, жишээгээр харуулж тайлбарлана.
- Зурах арга аргачлал, дарааллыг харуулсан үзүүлэнгийн тусламжтайгаар дуурайлгаж зурна.
- Зурах туршилтын үед багш суралцагчийг урамшуулж дэмжлэг урам өгөх хэрэгтэй.

Үе шат 3. Бүтээх-гүйцэтгэх (30 мин)

Үйл ажиллагаа:

1. Багш “зурах дарааллыг харуулсан зурагт карт” үзүүлнэ.
 - Тэнгэр
 - Од, сар
 - Уул, байшин
 - Өнгө хольж цайвар болон бараан өнгө гаргах гэх мэт.
2. Суралцагчид зургийн дэвтэртээ “Өөрийн одтой шөнө” сэдэвт зураг зурна.
3. Суралцагчид зурагт дохио, тэмдэг ашиглан зургийн тухай тайлбар бичиж хавсаргана.
Жишээ нь: Од – гэрэлтэж байна. Салхи хүчтэй салхилж байна.
4. Багш суралцагч тус бүрийн дэргэд очиж харааны, дохионы дэмжлэг үзүүлнэ.

Даалгавар 3.

Монголын хөдөө нутагт шөнийн одод маш тод харагддаг. Гадаадын олон жуулчид шөнийн оддыг харахаар манай оронд ирдэг. Та бүхэн зуны амралтаараар хөдөө нутагт шөнийн оддыг харсан уу? Өөрт төрсөн сэтгэгдлээ сэргээн санаж, “Одтой шөнө” зургийг өөрийн төсөөллөөр зураарай.



Дэмжлэг:

- Материалаа сонгох (усан будаг, гуаш, бийр)
- Хүсэлт бичих
- Зурах дараалал бүхий зурагт хуудас
- Дохио, хөдөлгөөнөөр чиглэл зааварчилгаа өгөх

Үе шат 4. Үнэлэх – хөгжүүлэх (10 мин)

Үйл ажиллагаа:

1. Өөрийн бүтээлээ үнэлэх

Хүснэгт 34. Өөрийн үнэлгээний хуудас

Үнэлгээний шалгуур	Тийм, сайн. <input checked="" type="checkbox"/>	маш <input type="checkbox"/>	Хичээж байна. <input checked="" type="checkbox"/>	Сайжруулах шаардлагатай. <input checked="" type="checkbox"/>
“Одтой шөнө” зургийг таньж нэрлэсэн.				
Зургийн өнгө, гэрэл, хөдөлгөөнийг илэрхийлж чадсан.				
Өөрийн санаагаар бүтээл хийсэн.				
Бүтээлээ дохио, тэмдэг, зураг ашиглан тайлбарласан.				

2. Суралцагчид бүтээлээ самбарт байршуулж “**Миний- Одтой шөнө**” сэдэвт үзэсгэлэн гаргана.
3. Суралцагчид бусдын бүтээлд **өнгөний наалт, инээмсэглэл, зүрхэн тэмдэгт стикер** нааж өөрийн сэтгэгдлээ илэрхийлнэ.
4. Багш суралцагчдын бүрийн бүтээлд “од” нааж урамшуулна.

Дэмжлэг:


- Үгний оронд зурагт тэмдэг бүхий үнэлгээний хүснэгт
- Нүүрний хөдөлгөөн, дохиогоор урамшуулах

Өөрийгөө сорих даалгавар:

1. Шөнийг дүрсэлсэн дараах уран зургуудаас аль нь Ван Гогийн бүтээл вэ? Яагаад?



А.



Б.



В.

2. Өгүүлбэрт тохирох үгийг нөхөж бичээрэй.

..... их зураач 1889 онд “Одтой шөнө” хэмээх энэхүү алдарт бүтээлээ зуржээ. Энэхүү зураг АНУ-ын хотноо Орчин үеийн урлагийн музейд байдаг.

(Италийн, Голландын, Мадонна Литта, Мона Лиза, Парис, Луврын, Леонорда да Винчи, Ван Гог, Нью-Йорк)

Зөвлөмж: Үгэн болон зурагт карт бэлтгээрэй. Нэг талдаа зургаар нөгөө талдаа үгээр илэрхийлсэн байна.

Дүрслэх урлаг, дизайны хичээлд түгээмэл хэрэглэгдэх үг, өгүүлбэр:

1. Зурах, дүрслэх үгс	2. Хэлбэр, хэмжээ, байрлал илэрхийлсэн үгс	3. Материал, багаж хэрэглэгдэхүүн	4. Урлан бүтээх арга ажиллагаа
<ul style="list-style-type: none"> - зурах - будах - дүрслэх - шугам - тойрог - дөрвөлжин - гурвалжин - толбо - өнгө - хэлбэр 	<ul style="list-style-type: none"> - том - жижиг - урт - богино - өндөр - нам - өргөн - нарийн - дээгүүр - доогуур - дотор - гадна - зүүн - баруун 	<ul style="list-style-type: none"> - харандаа - бийр - усан будаг - пастель - палитр/будгийн нийлүүр - цаас - картон - хайч - цавуу - наалт - баримлын шавар - өнгийн цаас - баллуур 	<ul style="list-style-type: none"> - хайчлах - наах - эвхэх - нугалах - хавтаслах - эвлүүлэх - барих - дарах - холих (өнгө холих)

1. Багшийн заавар, зөвлөмжтэй холбоотой өгүүлбэр:	2. Сурагчийн ойлголтыг илрүүлэх өгүүлбэр:	3. Бүтээлд үнэлгээ өгөх холбоотой өгүүлбэр:
<ul style="list-style-type: none"> - “Зурах хэрэгслээ бэлдээрэй.” - “Өнгөө сонгоорой.” - “Тайван будгаарай.” - “Зураасыг дагаж зур.” - “Эндээс эхлээрэй.” - “Энэ хэсгийг томруулж зур” - “Өнгөө сольж будаарай” - “Дараагийн алхам руу оръё.” - “Хайчаа болгоомжтой ашиглаарай.” - “Бүтээлээ хийж дууссан бол нааш ирээрэй.” 	<ul style="list-style-type: none"> - “Чи ойлгосон уу?” - “Хэн жишээ үзүүлэх вэ?” - “Чи аль өнгийг сонгох вэ?” - “Чи өөрийнхөөрөө зурж болно.” - “Хэрэв тусламж хэрэгтэй бол хэлээрэй.” 	<ul style="list-style-type: none"> - “Сайн оролдлого байна.” - “Өнгө зохицол сайхан болжээ.” - “Дахин сайжруулж болно.” - “Чиний санаа үнэхээр сонирхолтой байна.”
4. Дохионы хэлээр илэрхийлэх тохиромжтой үг, өгүүлбэр:		
<ul style="list-style-type: none"> - эхэл - дуус - харж ажигла - сонго - буд - хайч - наа - эвлүүл 	<ul style="list-style-type: none"> - “Дагаж хийгээрэй.” - “Ажиглаарай” - “Ямар өнгө сонгох вэ?” - “Хайчлаарай” - “Энэ хэсгийг будаарай.” - “Алдаж болно – дахин оролдож үзээрэй.” 	

СУДЛАГДАХУУНЫ НЭР: ХӨГЖИМ

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Ялгаатай хэрэгцээ шаардлагатай сурагчтай ажилладаг багш юун түрүүнд тэдний хэл, соёл, онцлог, сурах арга барилын талаар өргөн хүрээний мэдлэг, ойлголттой байх хэрэгтэй. Багш ялгаатай хэрэгцээний талаар мэдээлэлтэй танилцаж, ойлголт мэдлэгээ нэмэгдүүлснээр эдгээр хүүхэдтэй ажиллахад дөхөм байх болно./Soltero, 2004/

Сургалтын хөтөлбөрт тохируулга хийхийн ач холбогдол

Хөгжмийн сургалтын хөтөлбөрт тохируулга хийх нь зөвхөн хөгжмийн мэдлэг, чадвар төдийгүй, хэл ярианы болон нийгэм-сэтгэл зүйн хөгжилд чухал хувь нэмэр оруулдаг нь судалгаагаар батлагдсан. Жишээ нь:

- **Хэл ярианы хөгжилд:** Хэл сурах үйл явцыг хөнгөвчлөх, хэвийн сонсголттой хүүхдийн яриаг бэхжүүлэх, зөв амьсгалах, дуудлага, өгүүлбэрийн бүтцийн нарийн төвөгтэй байдлыг ойлгох зэрэгт тусалдаг.
- **Хэмнэлийн мэдрэмжийг сайжруулах:** Хөгжим сурах нь хүүхдүүдийн яриан дахь үгний хэмнэлийн тогтмол байдлыг нэмэгдүүлдэг.

- **Хувь хүний буюу сэтгэл хөдлөлийн хөгжилд:** Хөгжмийн боловсрол нь сэтгэл хөдлөлийн гиймийн ур чадварыг сайжруулах, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, саатуулах, хяналт болон булчинг бэхжүүлэх зэрэг ач холбогдолтой юм.

Тохируулга хийх нь зөвхөн сургалтын хөтөлбөрт дасан зохицох төдийгүй, хөгжмийг хүртэх олон аргыг нэгтгэсэн, бүтцийн шинж чанартай, цогц хандлага байх юм.

1. **Сургалтын зорилгын шинэчлэлт:** Хөгжмийн ойлголтыг харааны, мэдрэхүйн болон кинестетик аргаар илэрхийлэхэд чиглэсэн функционал зорилтуудыг оруулах.
2. **Технологийн нэгдэл:** Вибротактиль төхөөрөмжүүд, тухайлбал, бүх биеийн мэдрэмж өгөх, хаптик сандал эсвэл анги танхимын хөл, гарын шейкерүүд нь хөгжмийн хэмнэлийг мэдрэх, ингэснээр хэл ярианы хөгжлийг дэмжих чухал хэрэгсэл юм. Сургуулиудад энэ чиглэлийн хөрөнгө оруулах шаардлагатай.
3. **Кинестетик ба визуал аргууд:** Хөгжмийн элементүүдийг (хэмнэл, ая, динамик) дохионы хэлээр эсвэл биеийн хөдөлгөөнөөр илэрхийлэх, мөн партитур дээр бүтцийн дүн шинжилгээ хийх, мэдрэхүйн зураглал ашиглах зэрэг нь хийсвэр ойлголтуудыг бодит болгодог.
4. **Мэргэжлийн хамтын ажиллагаа:** Хөгжмийн багш нар нь хэл ярианы эмч, сонсгол судлаач болон тусгай боловсролын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах нь хөтөлбөрийн үр дүнг нэмэгдүүлж, хөгжмийн боловсролын үйлчилгээг клиник үр дүнтэй уялдуулдаг. Тиймээс хөгжмийн багш нарт мэргэжлийн тусгай сургалт шаардлагатай болно.

Хөгжмийн боловсролд суралцахуйн түгээмэл загварын хэрэглээ

Суралцахуйн түгээмэл загварын зарчмуудыг хөгжмийн сургалтын хөтөлбөрт нэвтрүүлэх нь ялангуяа хөгжлийн онцлог хэрэгцээтэй (жишээлбэл, сонсголын эсвэл харааны бэрхшээлтэй) суралцагчдад сургалтын үйл явц, үнэлгээний материалын тэгш хүртээмжийг нэмэгдүүлдэг.

Суралцахуйн түгээмэл загвар (Universal Design for Learning - UDL) нь гурван үндсэн хэсгийг нэгтгэж, **уялдуулан** хэрэгжүүлэхийг зөвлөдөг. Ингэснээр ямар нэг загварт (жишээлбэл, сонсгол эсвэл хараа) хэт найдахгүй байх боломжтой. Жишээ нь:

1. Олон эх сурвалжаас мэдээлэл өгөх (Representations):

Зорилго: Суралцагчид мэдээллийг янз бүрийн аргаар олон эх сурвалжаас авах

жишээ: Ноот болон хөгжмийн элементүүдийг зөвхөн хэвлэсэн хуудсаар бус, харин томруулсан фонт, Брайль ноот, эсвэл чичиргээг мэдрүүлэх (vibrotactile) технологи ашиглан хүргэх. Энэ нь тухайн мэдээллийг хэрэглэгч бүрийн хэрэгцээнд нийцүүлэн, харааны, мэдрэхүйн, эсвэл сонсголын аргаар хүлээн авах боломжийг олгодог.

2. Янз бүрийн аргаар үйлдэл хийх ба илэрхийлэх (Action and Expression):

Зорилго: Суралцагчид өөрсдийн мэдлэг, ойлголтыг янз бүрийн аргаар илэрхийлэх

жишээ: Сонсголын бэрхшээлтэй суралцагчдад хөгжмийн бүтцийг тайлбарлахдаа бичгээр дүн шинжилгээ хийх, дохионы хэлээр гүйцэтгэх, эсвэл дижитал хөгжим зохиох зэрэг *хоёр буюу гурван өөр даалгаврын сонголт* өгөх. Энэ нь даалгаврын хэлбэрээс хамаарч суралцагч мэдлэг, ур чадвараа харуулах боломжийг хязгаарлахгүй байхад тустай.

3. Оролцох ба сэдэлжүүлэх (Engagement):

Зорилго: Суралцагчдын сонирхол, сэдэл, оролцоо, ахиц амжилтыг тасралтгүй дэмжих.

жишээ: Суралцагчдын сонирхсон хөгжмийн төрөл, соёлын өвийг ашиглан хичээлийг сонирхолтой болгох. Мөн суралцагчдын суралцах явцыг дэмжихийн тулд аудио бичлэг,

эргэцүүллийн тэмдэглэл, хэлэлцүүлгийг ашиглан хариуцлага, дотоод мэдрэмжийг нэмэгдүүлэх.

Хоёр. Суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа

2.1. Сонсголын бэрхшээлтэй хүүхдийг хөгжмийн сургалтаар хөгжүүлэх арга зүй

Сонсголгүй хүүхэд нь сонсголтой хүүхдээс оюун ухаан, хэл яриа, нийгэмшихүй, бие бялдар, хөдөлгөөний хөгжлөөрөө ялгарах зүйлгүй ч сурах арга барилын хувьд ялгаатай. Ялгаатай байдал нь сонсголгүй суралцагчаас нэг их шалтгаалахгүй ба хүрээлэн буй орчин, нийгмийн хандлага, хүмүүсийн харилцаа зэрэг гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр ялгардаг.

Боловсрол эзэмших бүх түвшинд дохионы хэл нь сонсголгүй сурагчийн сургалтын үндсэн хэл гэж хүлээн зөвшөөрөгдөж, дохионы хэлний орчин, харааны хүртэхүйд ээлтэй сургалтын материал, харилцааны өндөр ур чадвартай багш, хэлмэрч зэрэг мэргэжлийн баг боловсролын үйлчилгээг үзүүлэх зайлшгүй шаардлагатай юм.

Сонсголын бэрхшээлтэй суралцагчдад зориулсан хөгжмийн сургалтыг зохион байгуулах үндсэн суурь нь **Суралцахуйн түгээмэл загвар (Universal Design for Learning - UDL)** ба олон төрлийн сургалтын стратегийн зарчмуудад тулгуурладаг. Эдгээр арга зүй нь хөгжмийн сургалтыг зөвхөн сонсголд тулгуурлахгүй хараа, мэдрэхүй, хөдөлгөөнөөр дамжуулан хүртэх боломжийг олгодог.

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх хөгжмийн сургалт нь зөвхөн дуу чимээнд бус, харин биеийн мэдрэхүй, хараа болон хөдөлгөөнд суурилсан цогц арга зүйгээр явагдана. Хэдийгээр тэдний сонсгол хязгаарлагдмал байж болох ч, хөгжмийн хэмнэл, доргио, аялга, мэдрэмжийг бүх бие, оюун, хараагаараа мэдэрч сурах нь тэдний хөгжмийн ур чадвар, танин мэдэхүйг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй.

Бага боловсролын сургалтын хөтөлбөрт "Хөгжмийг сонсоод аялгууны шинж төрхийг тодорхойлно" гэснийг "Сурагчид аялгууны шинж төрхийг тодорхойлно" гэж өөрчлөөд тэдэнд мэдлэг, чадвараа харааны (визуал) болон мэдрэхүйн (кинестетик) аргаар илэрхийлэх боломжийг олгох хэрэгтэй болж байна. Энэхүү өөрчлөлт нь зөвхөн сонсголын бэрхшээлтэй хүүдэд төдийгүй, харааны болон мэдрэхүйгээр илүү сайн суралцдаг сонсголтой суралцагчдад ч мөн адил тустай байдаг.

Нэгж хичээлийн төлөвлөлт

Анги 3

Нэгж хичээлийн зорилго:

- Хөгжмийн бүтээлийн **айзам хэмжээ, хурд, хүч, давталтыг хараа, хөдөлгөөн, хүрэлцэхүйн** тусламжтайгаар тодорхойлдог болно.

Хүснэгт 35. Хичээлийн төлөвлөлт

<i>Суралцахуйн үр дүн</i>	<i>Ойлголт, ухагдахуун</i>	<i>Цаг</i>	<i>Үндсэн арга/ хэрэглэгдэхүүн</i>
---------------------------	----------------------------	------------	------------------------------------

3.1.в Хөгжмийн бүтээлийн айзам хэмжээ, хурд, хүч, аялгууны өөрчлөлтийг тодорхойлдог болно.	Хурд (Tempo)	2	Хараа ба Хөдөлгөөн: Гар, биеийн хурдан/удаан хөдөлгөөн, гэрлэн дохио, зураг.
	Хүч (Dynamics)	2	Хараа ба Хүрэлцэхүй: Гарын том/жижиг булчингийн хөдөлгөөн, чичиргээний хүчтэй/сул мэдрэмж.
	Айзам/Хэмжээ (Rhythm/Meter)	2	Хараа ба Хөдөлгөөн: Биеийн цохилт (алга ташилт, хөлөөр гишгэх), өнгөний зураг, дүрсний давталт.
	Аялгууны давталт (Repetition)	2	Хараа: Өнгөт карт эсвэл А-А-Б-А хэлбэрийн дарааллыг харуулах карт.

Ээлжит хичээлийн төлөвлөлт

Сэдэв: Амьтдын марш

Зорилго: Амьтдын дүрээр төлөөлүүлэн айзам хэмжээ, хурд, хүч, давталтыг хараа, хөдөлгөөн, хүрэлцэхүйн тусламжтайгаар мэдэрч тодорхойлно.

Хугацаа: 80 минут

Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал: (b1403, b1471, b152, b1560, b1561, b1565, b160, b1640, b167, b1670, b16700, b16701, b16702, b16703, b1671, b16710, b16711)

- Ямар нэг үйл ажиллагаанд амаар бус биеийн үйлдлээр тухайлбал гар, нүдний хөдөлгөөн, алхаа гишгээгээр илэрхийлэх
- Мэдрэмж, сэтгэл хөдлөлтэй холбоотой сэтгэхүйн үйлдэл
- Дуу чимээ, авиа, хөг аялгууг ялган сонсож хүртэх үйлдэл
- Аливаа зүйлийг бодитой байгаа, харагдаж байгаагаас нь өөрөөр бодож, шинэ, содон, онцлогтойгоор дүрслэн бүтээх
- Дохио зангаа, илэрхийлэл, хэлний бусад бүрэлдэхүүнийг ашиглан ойлголтоо илэрхийлэх
- Ярьж, бичиж, дохиогоор илэрхийлж байгаа утга санааг тайлж ойлгон ухамсарлах
- Дохио зангаа, хөдөлгөөнөөр илэрхийлж байгаа утга санааг тайлж ойлгон ухамсарлах
- Гар болон бусад хөдөлгөөнөөр илэрхийлж байгаа биеийн хэлэмжийн утга санааг тайлж ойлгон ухамсарлах
- Юмны хэлбэр, дүрсийг нэг болон хоёр нүдээр, хол ба ойрын зайнаас мэдрэх
- Дуу авиаг сонсох, дууны чанар, чанга, сул, дууны нугалааг ялгаж сонсох, дуу чимээгээр байршлыг ялган баримжаалах

Хүснэгт 36. Хичээлийн үе шат

Үе шат	Сурагчийн үйл ажиллагаа	Багшийн чиглүүлэг, үйл ажиллагаа
Сэдэлжүүлэлт (5 мин)	Алхам 1. Багшийг төгөлдөр хуур, бөмбөр, эсвэл бусад хөгжмийн зэмсэг тоглох үед ойрхон сууж, хөгжмийн дуу авианы чичиргээг	- Хөгжим сонсгохын өмнө чичиргээг мэдрэхэд бэлтгэх - Сурагчдыг чанга яригчид ойр суулгах эсвэл том бөмбөлөг бариулах.

	мэдрэх. Жишээ нь: бөмбөр цохих үед үүсэх доргионыг гараараа мэдрэх.	
Хурд ба Хүчийг ялгах (15 мин)	Алхам 2. Хөгжмийн хурдаар өрөөгөөр удаан алхах эсвэл хурдан гүйх. Алхам 3. Хөгжмийн хурдад тохируулан бүжиг, хөдөлгөөн хийх,	- Хөгжмийг хурдан эсвэл удаанаар сонсгох. - Багш меганом (metronome)-ын гэрлийг ашиглан хурдыг илэрхийлэх. - Хэмнэлийг биеэрээ мэдрэхэд тусалж алга таших эсвэл хөлөөрөө товшиж үзүүлэх.
	Алхам 4. Чанга дуугарах үед гараа өндөрт өргөх, биеэр хүчтэй хөдөлгөөн хийх Алхам 5. Сул дуугарах үед гараа доошлуулах, хөдөлгөөнийг удаашруулах Алхам 6. Хөгжмийн чанга сул хүчний өөрчлөлтийг зураглал дээр хуруугаар заах эсвэл даган дуурайж гүйцэтгэх	- Хөгжмийг чанга, сулаар сонсгох. - Багш биеийн хэлээр "Чанга" эсвэл "Сул" (гараа өргөж/буулгах) гэсэн дохио өгөхөд сурагчид хөгжмийг сонсож (эсвэл чичиргээг мэдэрч) багшийн дохиотой тохирч байгаа эсэхийг үзэх, засаж өгөх.
Айзам ба давталтыг тодорхойлох (15 мин)	Алхам 7. Айзмын эхний хүчтэй цохилтыг томоор, бусдыг жижгээр тэмдэглэх. Алхам 8. Эхний хүчтэй цохилтод нэг өнгийн картыг өргөх	4/4 эсвэл 3/4-ийн хэмжээтэй хөгжим сонсгох.
	Алхам 9. Хөгжмийн хэсэг бүрийг А, Б, В гэсэн өнгөт картуудаар тэмдэглэх Алхам 10. Хөгжимд А хэсэг эгшилэхэд сурагчид А картыг өргөх, Б хэсэг эхлэх үед Цэнхэр карт/дүрс өргөх гэх мэт Алхам 11. Сурагчид гурав дахь хэсэг буюу давталт эхлэх үед багшийн Улаан картыг харж,	- А-Б-А бүтэцтэй энгийн хөгжим сонгож сонсгох. - Хөгжмийн хэсгүүдийг өнгөөр кодлох. Жишээ нь: А хэсэг = Улаан карт/дүрс, Б хэсэг = Цэнхэр карт/дүрс, В хэсэг = Ногоон карт/дүрс

	<i>өөрийн Улаан картаа өргөх эсвэл гараараа давталтын дохио хийх.</i>	
<i>Дүгнэлт ба Үнэлгээ (5 мин)</i>	<i>Алхам 12. Сурагчид хурд, хүч, айзам/хэмжээ, аялгууны давталтыг ээлж дараагаар харуулах. жишээ нь: чанга, сул хүчийн үед гараа өргөх, эсвэл зураг, тэмдэгт ашиглан тэмдэглэх</i>	<i>- А-А-Б эсвэл А-Б-В-А гэх мэт өөр өөр бүтэцтэй хөгжим сонсгож, өнгөт картуудаар зөв дарааллаар байрлуулж байгаа эсэхийг нягталж, дүгнэх</i>

Багшид зөвлөмж:

Багш сургалт үйл ажиллагааг төлөвлөлтийн дагуу зохион байгуулахаас гадна дараах аргуудыг суралцахуйн үр дүнгээс хамаарч хослуулан хэрэглэх нь тохиромжтой юм. Тухайлбал, хараанд суурилсан аргаар

- Өнгөт дүрслэл ашиглах: Хөгжмийн ноот, аялгууг өнгөөр илэрхийлэх. Жишээ нь: дээд эгшгийг тод, харин доод эгшгийг бүдэг өнгөөр дүрслэх. Эсвэл дуу авиа бүрт тодорхой өнгө оноож, сурагчид түүнийг хараад хөгжимдөх
- Дохионы хэл ашиглах: Хөгжмийн бүтээл, үг, аяыг дохионы хэлээр орчуулж заах.
- Дүрс бичлэг ашиглах: Мэргэжлийн хөгжимчид хэрхэн тоглож байгааг харуулсан дүрс бичлэг үзүүлэх нь хөгжмийн зэмсэг болон түүнийг тоглох арга барилыг ойлгоход тустай байна.

Технологийн дэвшилтэт аргаар сургалт, үйл ажиллагааг явуулахдаа:

- Дуу авиаг дүрслэх программ ашиглах: Дуу авианы долгионыг дүрслэн харуулдаг программыг ашиглаж, сурагчдад дууны хэлбэрийг нүдээр нь харуулах.
- Дижитал хөгжмийн зэмсэг ашиглах: Дуу авиаг хэмнэл, чичиргээ, эсвэл дүрсээр илэрхийлэх боломжтой дижитал хөгжмийн зэмсгүүд нь байдаг.

Сонсголын бэрхшээлтэй суралцагчдад зориулсан хөгжмийн бүтээлийг сонгохдоо **чичиргээг мэдрүүлэх** болон **бүтцийг тодорхой ойлгуулах** гэсэн хоёр үндсэн шалгуурыг баримтлах хэрэгтэй. Үүнд:

1. **Чичиргээ:** Басс буюу доод давтамж өндөртэй, динамик хүчний ялгаа тод хөгжим байх.
2. **Бүтэц:** Аялгууны хэсгүүдийн давталт тодорхой, А-В-А эсвэл А-А-Б гэсэн хялбар зураглалтай байх.

Жишээ нь: Л.В.Бетховены V симфонийн I хэсэг нь чанга, сулын ялгааг маш тод илэрхийлдэг тул чичиргээг мэдрэх дасгалд хамгийн тохиромжтой гэж үзэж байна. Энэ бүтээлийн нь "Хувь заяаны цохилт" гэгддэг ба 2/4 **айзам** юм.

Энэхүү хэмнэлийг сонсголын бэрхшээлтэй сурагчдад **биеийн хөдөлгөөн** эсвэл **харааны тэмдгээр** ойлгуулна. Харааны тэмдэгт ашигласнаар сурагчид хэмнэлийг хараад, түүнийг хөгжимтэй холбож ойлгоно. Жишээ нь:

- богино хэмнэл – жижиг хар дугуй- нэг цохилт,
- урт хэмнэл – том хар дөрвөлжин –дөрвөн цохилт

<i>тодорхойлдог болно.</i>	Аялгууны давталт (Repetition)	2	<i>болон биеэрээ мэдэрч, хөгжмийн бүтцийн талаарх ойлголтыг дүрсгүйгээр бий болгоно. Оюун ухаан ба ой тогтоолтыг хөгжүүлэх - Хөгжмийн бүтээлийг цээжлэх, ноот болон тэмдэг тэмдэглэгээг ойлгуулж ой тогтоолт, төвлөрөх чадварыг хөгжүүлнэ. Нийгэмшихүйн хөгжлийг дэмжих- Ангиараа дуулах, хөгжим тоглох, хамтарч ажиллах, бусдыг сонсох, харилцах ур чадварыг хөгжүүлнэ.</i>
----------------------------	-------------------------------	---	--

Ээлжит хичээлийн арга зүй, техникүүд

1. Сонсголд суурилсан үйл ажиллагаа

Алхам 1. Сонсголын дасгал: Хүүхдүүдэд янз бүрийн дуу чимээ, хөгжмийн зэмсгийг сонсгож, ялган таних дасгал хийлгэх. Жишээ нь: "Энэ дуу ямар амьтны дуу вэ?", "Ямар хөгжмийн зэмсэг тоглож байна вэ?" гэх мэт асуулт тавьж ярилцах

Алхам 2. Дуу авиаг дуурайх: Багш ямар нэгэн хэмнэл хийх, дуу дуулахад суралцагчид түүнийг давтаж дуулах, эсвэл хөгжмийн зэмсгээр тоглох.

Алхам 3. Сонсгох хөгжмийн бүтээлийн түүх, зохиолчдын талаар ярихдаа тайлбартай лекцийн аргаар болон зогсолттой сонсгож, тухайн хөгжмийн аялгууг мэдэрсэн мэдрэмжээ илэрхийлэхийг хүсэх, тэдгээрийн талаар хэлэлцэх

2. Хүрэлцэх мэдрэхүйд суурилсан үйл ажиллагаа

Алхам 1. Хөгжмийн зэмсгийг мэдрэх: Суралцагчдад төгөлдөр хуур, гитар, бөмбөр зэрэг хөгжмийн зэмсгийг бариулж, хэлбэр, хэмжээ, бүтэц, материалыг нь яриулах

Алхам 2. Дуу дуулах, хөгжим сонсох үед тухайн хөгжмийн хэмнэл, аялгууг дагаж биеэрээ хөдөлгөөн хийх. Энэ нь хүүхдийн биеийн хөгжил, хөдөлгөөний зохицуулалтад тустай.

Алхам 3. Харааны бэрхшээлтэй суралцагчдад зориулсан Брайлын хэлээр бичсэн хөгжмийн ноот, тэмдэг тэмдэглэгээг ашиглан бие дааж хөгжимдөх

3. Технологийн дэвшилд суурилсан үйл ажиллагаа

Алхам 1. Аудио ном ба программ: Хөгжмийн нэр томьёо, үг хэллэгийн тайлбар, ноотны хэмжээ зэргийг аудио хэлбэрээр сонсох боломжтой программыг ашиглах.

Алхам 2. Компьютерын тусламжтай хөгжим хийх: Дуу бичлэгийн программ, Midi keyboard зэргийг ашиглан өөрсдийн бүтээлээ хийх.

Багшид зөвлөмж:

- Дуу тусгаарласан орчин: Хэдийгээр хүүхдийн сонсгол бэрхшээлтэй ч, гаднын ямар ч нэмэлт дуу чимээгүй орчин нь хичээлээ төвлөрч хийхэд тусална.
- Бүлгээр ажиллах: Суралцагчид хамтдаа дуулах, хөгжим тоглох нь нийгмийн харилцааг сайжруулж, ганцаардлаас сэргийлдэг.


Багш суралцагчдад нээлттэй, эерэг хандаж, тэдний өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх нь чухал юм. Хүүхдийн онцлогт тохирсон заах арга барилыг хэрэглэх, мөн сонсголын бэрхшээлтэй суралцагчтай ажиллах тусгай мэдлэг, харааны бэрхшээлтэй хүмүүстэй харилцах туршлагатай байх нь сургалтын үр дүнг нэмэгдүүлнэ.

Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн:




- Хичээллэх орчин нь суралцагч чөлөөтэй хөдөлж хөдөлгөөн хийх, хөгжмийн зэмсэг зэрэг ямар нэг зүйлсийг мэдрэхэд аюулгүй байх ёстой.
- Бүх хөгжмийн зэмсэг болон хэрэгслүүдийг байнга нэг байршилд байрлуулах нь хүүхдийн баримжааг сайжруулдаг.

Эдгээр арга зүйг нэгтгэн ашиглах нь харааны бэрхшээлтэй хүүхдийг хөгжмийн урлагаар дамжуулан бүх талаар хөгжүүлэх боломжийг олгодог. Хүүхдийн сонирхол, авьяас чадварыг дэмжиж, тэдэнд өөртөө итгэх итгэлийг бий болгох нь хамгийн чухал юм.

Visuals from 2nd Grade Lesson



PowerPoint with Animals





1 Амьтдын ү маш удаан



АМЬТАД БОЛЦГООЁ (Хөгжимт хөдөлгөөн)



Хоёр гараа цээжний өмнө авч хулганыг дүрслээрэй.



Хоёр гараа атган эрүүн доор барьж аялгуунд тохируулан хэрмийг дүрслээрэй.



Хоёр гараа дээрээс доош зөрүүлэн хөдөлгөж зальт шар үнэг болоорой.



Хоёр гарыг атган, том том алхан майга бор баавгайг дүрслэн бүжиглээрэй.



QR кодыг уншуулаад бичлэгээ сонсоорой.

DIGITAL AUDIO

Record	Store	Play
 Tablet Headset iPod touch Midi microphone iPod shuffle Desktop phone with answering machine Smartphone	 DVD disk Compact disk Memory card Audio file Shared music album USB drive Hard drive Cloud storage	 Mobile phone Desktop PC Home theatre iPod CD player Music system iPad IP phone

НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Бага боловсролын биеийн тамирын сургалтын хөтөлбөрийг тархины саажилттай суралцагчийн өөртөө үйлчлэх энгийн чадвар, хэл яриа, танин мэдэхүйн чадвар, нийгэмшихүй, бие бялдар хөдөлгөөний чадварт тулгуурлан оношилгоо үнэлгээ хийж онцлог, давуу талуудад нийцүүлэн өөрчлөх, агуулгыг уян хатан тохируулга хийх, арга зүйг тусгайлан төлөвлөх, нэмэлт хөтөлбөрийн тохиргоо эсвэл ганцаарчилсан хөтөлбөр боловсруулах, хүүхдийн хөгжлийн түвшинг тодорхойлж, хэрэгцээ, сонирхолд тулгуурласан багшлахуйн арга зүйд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Биеийн тамирын судлагдахуунд суралцахуйн түгээмэл загварын хэрэглээ

Суралцахуйн түгээмэл загварын зарчимд суурилан биеийн тамирын сургалтын хөтөлбөрт тохируулга хийх нь хөгжлийн бэрхшээлтэй (жишээлбэл, тархины саажилттай) суралцагчдад сургалтын орчин материал, арга барилыг бүх суралцагчдын хэрэгцээ, чадварын онцлогт нийцүүлэн, уян хатан байдлаар тэгш хүртээмжийг нэмэгдүүлдэг.

Суралцахуйн түгээмэл загвар (Universal Design for Learning - UDL) тархины саажилттай суралцагчийг биеийн тамирын хичээлийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд дараах гурван үндсэн зарчим дээр тулгуурлана.

1.Оролцооны олон аргыг хангах (Multiple Means of Engagement):

Зорилго: Суралцагчдын сэдэл, сонирхол, өөрийгөө зохицуулах чадварт анхаарах.

Жишээ: Тархины саажилттай суралцагчдад дасгал, тоглоом, эсвэл оролцох түвшин сонгох боломж олгоно. Жишээлбэл, бөмбөг шидэх, өнхрүүлэх, эсвэл хөдөлгөөнөөр дохио өгөх зэргээс сонгох. Суралцагчийг биеийн тамирын хичээлийн үйл ажиллагаанд оролцуулан хүүхдийн сонирхол, өдөр тутмын амьдралын чадвар, эсвэл багийн хамтын ажиллагаатай холбож өгөх. Суралцагчийн зорилгыг тодорхой, биелүүлэх боломжтой жижиг алхмуудад хувааж, суралцагчийн амжилт, ахиц дэвшилд тогтмол эерэг үнэлгээ өгөх. Суралцагч өөрийнхөө тав тухтай байдлыг мэдэрч, эрсдэл хүлээхээс айхгүйгээр оролцох нөхцөлийг бүрдүүлэх.

2. Мэдээллийг төлөөлөх олон аргыг хангах (Multiple Means of Representation):

Зорилго: Мэдээллийг хүлээн авах, ойлгох арга барилаар дэмжих.

Жишээ:Тархины саажилттай суралцагчийг биеийн тамирын ур чадвар, дүрмийг зөвхөн амаар тайлбарлаад зогсохгүй, **харааны** (зураг, видео, самбар дээрх тэмдэглэгээ), **сонсголын** (аман заавар, дуу хөгжим), болон **хөдөлгөөнөөр** (багшийн болон үе тэнгийнхний үзүүлэх дасгал) дамжуулан хүргэх. Хөдөлгөөн, тоглоомын нэрийг энгийн, ойлгомжтой байдлаар тайлбарлаж, шаардлагатай бол туслах хэрэгсэл (өнгө, хэлбэр, биет объект) ашиглах. Шинэ мэдээллийг өмнөх мэдлэгтэй холбох, ойлголтыг хялбарчлахын хөдөлгөөнт дүрмийг ашиглах.

3. Үйлдэл ба илэрхийлэх олон аргыг хангах (Multiple Means of Action& Expression):

Зорилго: Суралцагчдын мэдлэг, чадвараа илэрхийлэх арга барилаар дэмжих.

Жишээ:Тархины саажилттай суралцагчдад дасгал, тоглоомын үүргийг гүйцэтгэх, эсвэл биеийн тамирын чадварыг харуулах олон аргыг санал болгох. *Жишээлбэл:* Бөмбөгийг гараараа барьж чадахгүй бол өнхрүүлэх, хөлөөрөө өшиглөх, эсвэл тусгай хэрэгсэл (гар бариултай бөмбөг, том хөнгөн бөмбөг) ашиглах. Шаардлагатай тохиолдолд тусгайлан тохируулсан тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эсвэл туслах хүний дэмжлэгийг ашиглах. Хүүхдэд өөрийнхөө ахиц дэвшлийг илэрхийлэх олон арга зам (үгээр хэлэх, хөдөлгөөнөөр үзүүлэх, тэмдэглэгээ хийх, зурах) олгох. Зөвхөн гүйцэтгэлийн үр дүнг бус, оролцоо, хүчин чармайлт, хөдөлгөөний чанарыг үнэлэх⁵.

Биеийн тамирын **сургалтын хөтөлбөрийн агуулга** нь хөдөлгөөн, бие, бялдрын хөгжил гэсэн үндсэн хоёр айтай. Хөдөлгөөн дэд ай алхах, гүйх, үсрэх, харайх, шидэх дамжуулах, өнхрөх, авирах, мөлхөх гэж томъёолсон байдаг. Үүнийг тархины саажилттай суралцагчдын “*биеийн бүтэц, үйл ажиллагаа*”-нд тулгуурлан, биеийн онцлогт тохирсон “*үйл ажиллагаа*”, тухайн суралцагчдын “*оролцоог*” дэмжсэн, онцлог, давуу болон сул тал, сурах арга барилд болон хүүхэд бүрийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн дасгалыг хөнгөнөөс, хүнд рүү чиглэлтэй ачааллыг багасгаж, дасгалын давтамжийн тоог багасгах, хурдыг бууруулах, хугацааг уртасгах агуулгыг хялбаршуулан өөрчилж тохируулга хийнэ.

Биеийн тамирын сургалтын хөтөлбөрийн “хөдөлгөөн дэд ай” хүрээнд тархины саажилттай суралцагчийн онцлог чадварт тохируулга хийцгээе.

Хүснэгт 38.Хичээлийн алхамчилсан төлөвлөлт

<i>Хөдөлгөөн дэд ай</i>	<i>Өөрөө бие дааж алхаж чаддаг</i>	<i>Туслах хэрэгсэлтэй (таяг, алхуулагч)</i>	<i>Тэргэнцэртэй</i>
<i>Алхах, Гүйх</i>	Туулах зайг богиносгох Бага зэргийн 5-10 см саадыг алхаж эсвэл гишгэж давна.	Туслах багш, үе тэнгийнхний тусламжтай, таяг, алхуулагчтай тодорхой зайг туулах. Жижиг саадыг тойрч гарна. Ангийн хүүхдүүдэд өгч байгаа дасгалыг хүүхдийн онцлогт тохируулан хялбаршуулах аргаар хөнгөвчлөн өгч болно.	Тодорхой зайг туулахдаа тэргэнцрээр явах, мөлхөхийг зөвшөөрөх Жижиг саадыг тэргэнцэртэй тойрч гарах.
<i>Үсрэх, Харайх</i>	Хөдөлгөөнийг хялбарчлан өөдгөө нугалах, түлхэх, сунгах, том алхам хийж давах зэргээр тохируулга хийж болно.	Туслах багш, үе тэнгийнхний тусламжтай зөөлөн чихмэл тоглоом дээгүүр том алхам хийн давж болно.	
<i>Шидэх, дамжуулах</i>	Зөөлөн хөнгөн бөмбөгийг түлхэх, өнхрүүлэхийг голчлон ашиглах. Шалаар	1.Дамжуулах, барих: Суугаа байрлалд (тусгай сандал, тэргэнцэртэй) багштайгаа харилцах: а.Хоёр	

⁵https://gemini.google.com/app/4538f5faa264d804?utm_source=app_launcher&utm_medium=owned&utm_campaign=base_all

	зөөлөн өнхрүүлсэн бөмбөгийг хоёр гараар тосож зогсоох эсвэл цээжиндээ тэвэрч авч болно. Хөдөлгөөн их үедээ тэнцвэрээ алдахаас болгоомжлох.	гараа ашиглан зөөлөн, хөнгөн бөмбөгийг 1 метрийн зайд түлхэж өнхрүүлэх . б.Багшийн зөөлөн өнхрүүлсэн бөмбөгийг хоёр гараараа тосож авах тэврэх барих, хялбар оролдлого хийлгэх. 2. Бай онох: Суусан байрлалаас 1-2 метрийн зайд байрлуулсан том, өнгийн бай (жишээ нь, том сагс, конус) руу бөмбөгийг өнхрүүлэх (гараа хөдөлгөж) онохыг хичээнэ.	
Өнхрөх, авирах, мөлхөх	Багшийн дэмжлэгтэйгээр өвдгөө тэврэн “бөмбөг” мэт бөөрөнхий хэлбэрийг биеийн байрлалаа хадгалах) барьж, хойш-урагш зөөлөн бүүвэйлэх - Хэвтэхээс суух руу шилжих бэлтгэл) хөдөлгөөнийг 2-3 удаагийн оролдлого хийх.	Багшийн дэмжлэгтэй тодорхой хугацаанд сандлын түшлэг, гимнастикийн хананд байрлуулсан шатнаас барьж зогсох. Суугаа байдлаас тэнцвэрээ олох (жишээ нь, зөөлөн матраас дээр сууж байгаад хоёр тийш зөөлөн ганхах, эсвэл хэвтээгээс баруун, зүүн тийш ганхах).	Өөрт таатай байрлалаар (жишээ нь, дөрвөн хөллөж эсвэл хэвлийгээр мөлхөх), тодорхой нэг тоглоом руу 1 метрийн зайд бие даан шилжих оролдлого хийнэ.
Суралцагчдад сонголт олгох : “Чи бөмбөг шидэх үү, эсвэл бөмбөгийг өнхрүүлэх үү?”, “Чи энэ саад дээгүүр алхах уу, эсвэл тойрч гарах уу?” гэх мэт сонголт өгөх нь суралцагчийн өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлдэг.			

Арга зүйд тохируулга хийх: Тархины саажилттай суралцагчид багш хөдөлгөөний чадварыг эзэмшүүлэхдээ тухайн сурагчийн спастик (булчингийн чангарал), тэнцвэр, болон танин мэдэхүйн онцлог мөн суралцахуйн түгээмэл загварт тулгуурлан арга зүйн тохируулга хийнэ.

Хүснэгт 39. Тохируулга хийх алхам

Алхам	Суралцахуйн жишиг үйл ажиллагаа	Тохируулга
Таних, ойлгох	<i>Хөдөлгөөнийг ажиглуулах, тайлбар сонсох, нэрлэх.</i>	Олон мэдрэхүйн арга: Зөвхөн ярихаас гадна хөдөлгөөний зурагт хуудас (Visual aids) үзүүлэх. Хэрэв хэл ярианы бэрхшээлтэй бол хөдөлгөөнийг заахад карт сонгох аргыг ашиглана.
Гүйцэтгэх	<i>Хөдөлгөөнийг зааврын дагуу дуурайлган давтуулах.</i>	Биет дэмжлэг (Physical Guidance): Сурагч өөрөө эхлүүлж чадахгүй бол багш гар, хөлөн дээр нь гараа тавьж хөдөлгөөний чигийг зааж өгнө
	<i>Дасгалыг зохих хурд, хүч, далайцаар нь давтуулах.</i>	Хувьчилсан гүйцэтгэл: Хурд, хүчийг шаардахгүй. Харин хөдөлгөөний далайцыг өөрийн боломжит хэмжээнд (өвдөлтгүйгээр) хийхэд анхаарна. “Зөв суух, зогсох байрлал”-ыг хадгалах нь хурдаас илүү чухал.
Хэрэглэх, үнэлэх	<i>Дасгалыг танил бус нөхцөлд гүйцэтгүүлэх.</i>	Тогтвортой орчин: Тархины саажилттай хүүхдэд гэнэтийн өөрчлөлт хүндрэл учруулдаг тул дасгалын орчныг огцом өөрчлөхгүй, харин танил

		орчинд хэрэгсэл өөрчлөх (өөр бөмбөг) аргыг хэрэглэнэ.
<i>Аюулгүй хангаж, ажиллах.</i>	<i>байдлаа багаар</i>	Үүрэг хуваарилалт: Багийн тоглолтод сурагчийн хөдөлгөөнд тохирсон үүрэг өгнө (Жишээ нь: Бөмбөг дамжуулагч, эсвэл тоглоомыг эхлүүлэгч).

Тоглоомд суурилсан арга зүйн тохируулга:

Дүрэм: Даалгавар гүйцэтгэх хугацааг уртасгах. “Гүйх” гэдгийг “Тэргэнцэртэй явах” эсвэл “Туслагчтай алхах” гэж өөрчилнө. Бөмбөгийг барьж авах хугацааг уртасгана. “Найз” (Buddy) системийг ашиглана. Энгийн суралцагчтай хос болгож, бие биедээ туслах даалгавар өгнө. Тоглоомын дүрмийг өөрчилнө. (Жишээ нь: Бөмбөгийг барьж авахаас өмнө 2 удаа ойлгохыг зөвшөөрөх, байг томруулах, зайг ойртуулах, багийн тоглолтод хувь нэмэр оруулах шүүгч хийлгэх, оноо тоолох эсвэл дамжуулагч хийлгэх) замаар өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлнэ. Тархины саажилттай хүүхдүүд илүү их энерги зарцуулж, амархан ядардаг тул амрах завсарлага өгөх.

Хэрэгсэл: Хөөсөн бөмбөг, дуугардаг бөмбөг, бариултай бөмбөг ашиглан сурагчийн атгах, барих чадварыг дэмжинэ.

Тархины саажилттай хүүхдийн сургалтын хөтөлбөрт тохируулга хийх арга зүйн жишээ:

Ерөнхий мэдээлэл: Тархины саажилт (ДЦП) суралцагчийн сургалтын хөтөлбөрт тохируулга хийх арга зүй нь тухайн хүүхдийн биеийн бүтэц, үйл ажиллагаа, суралцахуйн үйлдэл болон зарим хөдөлгөөнд хүндрэл учруулдаг тул, тэдний бодит байдлын үнэлгээнд тулгуурлан, биеийн онцлогт тохирсон үйл ажиллагаа, оролцоог дэмжих, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор сургалтын хөтөлбөрт тохируулга хийх шаардлагатай.

Сурагчийн мэдээлэл: Суралцагч “Ц”, 6 настай, эмэгтэй, ерөнхий боловсролын сургуулийн 1 дугаар анги, эрүүл мэндийн байдал: Тархины саажилт G-80 (ЭХЭМҮТ) оноштой. Тухайн сурагчийн хувьд хөгжлийн ерөнхий зураглал нь дараах байдалтай байна.

Сурагчийн бодит байдлын мэдээлэл:

Хүүхдийн төлөв байдал:

- Тархины саажилт G-80
- Харилцан яриаг ойлгохдоо сайн
- Ярихдаа 2,3 үг хэлэх гэж оролддог. Ихэвчлэн дохио зангаар өөрийгөө илэрхийлдэг
- Баруун хөлөөрөө зураг зурж, бичихдээ маш сайн
- Багшийн тусламжтай хооллодог
- Өөрийн бие тавгүй байх үед нүүрний хөдөлгөөнөөр илэрхийлдэг
- Багшийн тусламжтай алхдаг.

Ар гэрийн байдал:

- Аав, ээж, 2 эгчийн хамт амьдардаг. Ам бүл 5
- Хоёр эгчтэйгээ дохио зангаар харилцаж ярилцах дуртай 77
- Ээж нь агаарт салхинд гарч хамтдаа цагийг их өнгөрөөдөг
- Нөхөн сэргээх, эмчилгээнд улиралдаа нэг удаа явуулдаг

Хүснэгт 40. Суралцагчийн одоогийн бодит байдлыг үнэлгээ

Суралцагч юу мэдэж, юуг сайн хийж чадаж байгааг тодорхой шалгуураар үнэлж, бодит	Өөртөө үйлчлэх энгийн чадвар (Бие даах байдал)	Суралцагч нь өдөр тутмын үйлдлүүд болох бие засах, гар угаах хооллох, хувцас болон гутлаа өөрөө өмсөж, тайлах зэрэг үйлдлүүдийг өөрөө хийж чадаж байгааг багшийн заавар чиглүүлэг шаарддаг.
	Хэл яриа, танин мэдэхүй, тоо тооллын чадвар	Суралцагч нь дасгал хөдөлгөөн хийж байх явцдаа багшийг даган дуурайн тоолох гэж хичээдэг өөрөө бие дааж хийх оролдлоготой багшийн дэмжлэг шаарддаг.
	Нийгэмших чадвар	Суралцагч нь олон нийтийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог.
	Бие бялдар, хөдөлгөөний чадвар	Баруун зүүн гар болон хөлний далайц хязгаарлагдмал
Оролцогч талуудын урт болон богино хугацааны зорилт тодорхойлохын өмнөх санал хүсэлт	Сурагчийн хүсэл, зорилго	Хөдөлгөөний үеийн далайцыг нэмэгдүүлэх сайжруулах. Найзтай болох.
	Эцэг эх, (асран хамгаалагч, харгалзан дэмжигч)-ийн хүсэл зорилго:	Хөдөлгөөний үеийн далайцыг нэмэгдүүлэх сайжруулах, найз нөхөдтэй болгох, биеийн тамирын хичээлд аль болох хамруулах.
	Дэмжлэгийн багийн хүсэл зорилго:	Хөдөлгөөний үеийн далайцыг нэмэгдүүлэх сайжруулах. Хүүхдийг аль болох нийгэмшүүлэх.

Нэгж хичээлийн төлөвлөгөө:

Хичээлийн сэдэв: Саадтай алхалт

Судлах хугацаа: 6 цаг

Хичээлийн зорилго: 1.Суралцагч саад, орон зай ойлголтыг нэмэгдүүлж, аюулгүй зорчих зарчмыг мэддэг болно. 2. Суралцагч саадтай алхалтыг хийхдээ (өөрөө бие даан алхах эсвэл таяг, тэргэнцэр) хэрэглэгдэхүүнд тохируулга хийн саадыг даван туулах аргад суралцана. 3.Суралцагч дасгалыг гүйцэтгэхдээ өөртөө итгэлтэй болж, бусадтай хамтран ажиллах чадвар эзэмшинэ.

Хүснэгт 41. Нэгж хичээл

Суралцахуйн үр дүн	Ойлголт, ухагдахуун	Цаг	Үндсэн арга (зорилго)
1.1а. Биеийн зөв галбираа хадгалан, янз бүрийн хувилбараар алхана.	Орон зайн баримжаа аюулгүй зорчих	2	Зааланд аюулгүй зорчих, дасгал хөдөлгөөн хийхдээ өөрийн орон зайн баримжаагаа мэдрэх чадварыг нь дэмжих.
	Саадыг даван туулах аргад суралцах	2	Зааварчилгааг олон сувгаар өгөхдөө амаар, бичгээр (том үсгээр), өнгөөр ялгасан тэмдэглээ, зураг, видеогоор харуулах, багш
	Дасгал гүйцэтгэхдээ	2	

	<p>өөртөө итгэлтэй болох, бусадтай хамтрах</p>	<p>өөрөө биеэрээ үзүүлж болно. Туслах найз нөхөдтэй болгох.</p> <p>Дасгалын гүйцэтгэлийн олон янзын хувилбараар өгнө. Бие даан өөрөө алхаж чаддаг бол, давж гишгэх эсвэл тойрох, таягтай бол саадын хажуугаар гарах эсвэл тогтвортой саадан дээгүүр алхаж гарах, тэргэнцэртэй бол саадыг түлхэх, тойрох, налуу замаар өгсөх, уруудах зэргээр сонголтыг суралцагчдад өгч өөртөө итгэх итгэлийг хөгжүүлнэ.</p> <p>Бага ангийн суралцагчдад сонирхолтойгоор заахын тулд тоглоомын аргуудыг түлхүү хэрэжүүлэх багийн тоглоомд оролцуулах, өөрийн давахыг хүссэн саадыг сонгуулах эсвэл даалгаврыг хөнгөвчлөн өөрт тохиромжтойг нь сонгуулан хийлгэх, хамтрах, харилцах чадварыг хөгжүүлнэ.</p>
--	--	--

Хүснэгт 42. Суралцахуйн үр дүн, тохируулга

Дэд ай	Суралцахуйн үр дүн I анги	Тархины саажилттай суралцагчдад тохируулсан үр дүн
1. Алхах, гүйх	1.1а. Биеийн зөв галбираа хадгалан, янз бүрийн хувилбараар алхана.	Өөрөө бие даан алхаж чаддаг
		Туслах хэрэгсэлтэй (таяг, алхуулагч)
		Тэргэнцэртэй

Ээлжит хичээлийн төлөвлөлт

Хичээлийн сэдэв: “Саадтай алхалт” (орон зайн баримжаа)

Ээлжит хичээлийн зорилго: 1. Суралцагч саад, орон зайн тухай ойлголтыг нэмэгдүүлж, аюулгүй зорчих зарчмыг мэддэг болно. 2. Суралцагч өөрийн хөдөлгөөний хэрэгсэлд (таяг, алхуулагч, тэргэнцэрт) тохируулан саадыг даван туулах арга техникийг сурч, зохицуулалт сайжирна. 3. Суралцагч дасгал хөдөлгөөнийг хийхдээ өөртөө итгэлтэй болж, бусадтай хамтран ажиллах чадвар дээшилнэ. 4. Тоглоомд идэвхтэй оролцуулах.

Эхний хэсэг: (Орчин, бие, сэтгэл зүйг бэлдэх 5-7 мин)

Алхам 1: Өөрийн чадах хэмжээгээр дасгалыг дагаж хийх. Тэргэнцэртэй суралцагч гараа хөдөлгөх, бусад нь дэмжлэгтэй (сандал түших) зогсож хийх. Багшийн тусламжтай хөлийн булчинг зөөлөн сунгах.

Хэрэглэгдэхүүн: Зөөлөн дэвсгэр, тайвшруулах хөгжим, сандал, түшлэг


Үндсэн хэсэг: (Дэмжлэгтэй алхаа 20-25 мин)

Алхам 2:

а. "Өнгөт замаар алхацгаая" алхах резин замуудыг багш танилцуулах. Эхлээд резин замаар, дараа нь зөөлөн дэвсгэр дээгүүр алхуулна. Суралцагчид өөр өөр гадаргууг мэдэрч, бие даан алхах. Туслах хэрэгсэлтэйгээ алхах үед багш дэмжинэ эсвэл тэргэнцрээр замыг туулах.



26. Тоглоомын арга хэрэглэн "Голын чулууг давъя" шалнаас 5-10 см өндөр зөөлөн саадуудыг (зөөлөн резин диск, резин зам) "голын чулуу" хэмээн байрлуулах. "Голд унахгүйгээр чулуун дээгүүр гишгэж гараарай" гэж багш чиглүүлэх. Суралцагч тэнцвэрээ олж, хөлөө өргөн саадыг давах оролдлого хийх. *Өндөр саад (10 см)* тэнцвэр сайтай суралцагч.



Намхан саад (5 см) тэнцвэр олоход бэрхшээлтэй суралцагч багшийн дэмжлэгтэй. *Саадгүй зам:* Алхаж чадахгүй, бэрхшээлтэй бол саадыг тойрч гарах, эсвэл тэргэнцрээр заасан замыг туулах.



Хэрэглэгдэхүүн: Шалны наалт (чиглэл), өнгөт резин зам, хивсэнцэр, (зөөлөн), резин диск зам мэт.



Алхам 3: Төгсгөлийн хэсэг (тайвшруулах ба дүгнэлт) “Амьсгалын дасгал” дэвсгэр дээр суух, хэвтэх, эсвэл тэргэнцэр дээр гүнзгий амьсгаа авах, гаргах, бүх булчингаа зөөлөн суллах. “Өнөөдөр юу хамгийн хөгжилтэй байсан бэ?,” “Хамгийн хэцүү саад юу байсан бэ?,” Чи хэрхэн даван туулсан бэ?, “Чи маш сайн хичээлээ” гээд суралцагч бүрийг магтаж, наалт өгөх. Суралцагчид амьсгалаа ажиглан тайвшрах. Хичээлийн талаарх сэтгэгдлээ хуваалцах (ярих, дохиогоор, зургаар). Хүн бүр өөрийнхөөрөө оролцоог мэдэрч, ярилцах.



Хэрэглэгдэхүүн: Тайвшруулах хөгжмийн ая, урамшууллын наалт (стикер).

Сургалтын орчны тохируулга:

Орчны хүчин зүйл (Environmental Factors) сурагчийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд орчныг дараах байдлаар бүрдүүлнэ.

а. Хүртээмжтэй орон зай:

- **Талбай:** Тэргэнцэр эсвэл алхагчтай суралцагч чөлөөтэй эргэх боломжтой зай талбайг суллаж өгнө.
- **Гадаргуу:** Хэт гөлгөр шал халтирах эрсдэлтэй тул суралцагчдийн дасгал хийх хэсэгт резинэн дэвсгэр эсвэл иогийн гудас байрлуулна.
- **Амрах хэсэг:** Тархины саажилттай хүүхэд амархан ядардаг тул заалны нэг буланд “Чимээгүй амрах хэсэг” (сандаал, зөөлөн буйдантай) гаргана.

б. Нийгмийн орчин:

- **“Найз” (Buddy) систем:** Ангийн бусад хүүхдүүдээс ээлжлэн “туслах найз” томилж, хамтдаа дасгал хийх, тоног төхөөрөмжийг дөхүүлж өгөх зэргээр хамтын ажиллагааг дэмжинэ. Энэ нь сурагчийг ганцаардахаас сэргийлнэ.

в. Хэрэглэгдэхүүний тохируулга:

Нарийн хөдөлгөөн хөгжүүлэх жижиг зүйлсээс илүү том, тод өнгөтэй, зөөлөн хэрэгслүүдийг бэлтгэнэ (Бочиа бөмбөг, цагариг).

Үнэлгээний тохируулга:

Хүүхдийг ахицаар үнэлэх зарчмыг баримтална.

Хүснэгт 43. Үнэлгээний тохируулгын жишээ

Хүрэх үр дүн	Шалгуур (Үндсэн хөтөлбөр)	Үнэлгээний шалгуурын өөрчлөлт
--------------	---------------------------	-------------------------------

<i>Мэдлэг, гүйцэтгэл</i>	<i>Дасгалыг зааврын дагуу тохирсон хурд, хүч, далайцтай гүйцэтгэдэг.</i>	Оролцоо: Хурд, хүчийг үнэлэхгүй. Харин дасгалыг хийх эрмэлзэл, хөдөлгөөнийг эхлүүлэх болон дуусгах оролдлого , багшийн өгсөн тусламжийг ашиглаж буй байдлыг үнэлнэ.
<i>Хөдөлгөөн, эрүүл мэнд</i>	<i>Өөрт тохирсон цогц дасгалуудыг өдөр бүр тогтмол хийх</i>	Дадал хэвшил: Сурагч өөрийн биеийн байдлыг мэдэрч, спастик хөдөлгөөнийг суллах (сунгах, тайвшрах) дасгалыг хичээлийн үеэр болон завсарлагаанаар хийж хэвшсэн байдлыг үнэлнэ.
<i>Харилцаа, нийгэмшил</i>	<i>Багаар, ангиараа хамтран оновчтой гүйцэтгэдэг.</i>	Харилцааны оролцоо: Багийн гишүүдтэйгээ харилцахдаа нүдээрээ, дохиогоор эсвэл үгээр ойлголцож буй байдал, багийн амжилтад өөрийн хувь нэмрээ оруулсан байдлыг (жишээ нь: оноо тоолох, шүүх, эсвэл дамжуулах) үнэлнэ.
<i>Техник</i>	<i>Спортын энгийн техникийг хийж үзүүлдэг.</i>	Техникийг шаардахгүй. Жишээ нь: Бөмбөгийг сагс руу шидэхдээ гараа өргөж чадахгүй бол доороос шидэх, эсвэл өнхрүүлж дамжуулж байгааг “чадвар эзэмшсэн” гэж тооцно.

Багиуд өгөх зөвлөмж: Тархины саажилттай суралцагчийн үнэлгээний хуудсанд “Тайлбар” гэсэн хэсэг нэмж, тухайн сурагч дасгалыг бие даан гүйцэтгэсэн үү?, эсвэл тусламжтай гүйцэтгэсэн үү? гэдгийг тэмдэглэх нь дараагийн хичээлийн төлөвлөлтөд чухал ач холбогдолтой. Тархины саажилт нь хүүхэд бүрд харилцан адилгүй хэлбэр, хүндрэлээр илэрдэг. Нэг хүүхдэд тохирсон дасгал нөгөө хүүхдэд тохирохгүй, бүр гэмтэл учруулж болзошгүй. Тиймээс тухайн хүүхдийнхээ одоогийн биеийн байдал, булчингийн чангарал, тэнцвэрийн түвшинд тохирсон дасгалын шаардлагатай бол ганцаарчилсан хөтөлбөрөөр, зөв техникээр хийж сургах нь хамгийн чухал гэдгийг анхаарах нь зүйтэй.

ДҮГНЭЛТ

Бага ангийн тархины саажилттай суралцагч биеийн тамирын хичээлд хамруулах эцсийн зорилго нь түүнийг бусадтай адилхан гүйлгэх биш, харин тухайн хичээл, тоглоомд тэгш хөгжилтэй байдлаар оролцох боломжийг олгож, бие бялдрын хөдөлгөөний үйл ажиллагааг сайжруулах явдал юм. Энэ нь суралцагчийг “Би бусдаас өөр, би чадахгүй” гэсэн бодлоос “Би ч гэсэн чадна, би энэ ангийн нэг хэсэг” гэсэн итгэл рүү хөтлөх. Тухайн сурагчийг хичээлээс чөлөөлөх биш, харин хичээлийг суралцагчдад тохируулга хийн биеийн бүтэц, үйл ажиллагаа, хийж чадах зүйлд нь нийгэмд оролцох байдал, хувийн хүчин зүйлс, хөгжлийн түвшин, сурах арга барилын онцлогт нийцүүлэн хандлага, аргачлал, орчны зохион байгуулалтад өөрчлөлт оруулах зэргээр цогцоор нь шийдэх. Тархины саажилттай хүүхдийн хувьд биеийн тамирын хичээлийн гол зорилго нь одоогийн чадаж байгаа хөдөлгөөнийг хадгалах, сайжруулах, нийгэмших, өөртөө итгэлтэй болоход анхааран сургалтын агуулгыг тохируулна. Цаашлаад биеийн тамирын багш суралцагчтай ажиллахдаа суралцахуйн түгээмэл загвар, ОУ-ын ICF-д үндэслэж онцлог хэрэгцээнд тулгуурлан заах арга зүйгээ өөрчлөх, өөрийгөө хөгжүүлэх хэрэгцээ бий болж байна.

Цаашид хэрхэн дэмжих гэр бүл, сургууль багш нарын хамтын ажиллагаа

Тархины саажилттай суралцагчийг амжилттай хөгжүүлэхэд гэр бүл, сургууль, багш нартай нэгдмэл тасралтгүй хамтын ажиллагаа маш чухал. Тархины саажилттай суралцагч зөвхөн хөдөлгөөний асуудалд биш бие даах чадварыг нэмэгдүүлэх, нийгэмшихүй ба сэтгэл хөдлөл, суралцах чадварыг дэмжих, өөрийгөө илэрхийлэх чадварт нь тулгуурлан дэмжлэг үзүүлэх. Эцэг эхийн үүрэг нь хүүхдийнхээ тухай мэдээллийг ангийн багш болон биеийн тамирын багштай хуваалцаж байх. Багшийн өгсөн заавар зөвлөмжийг цаг тухайд нь хэрэгжүүлж хамтран ажилладаг байх. Хүүхдийнхээ чадварыг бодитоор үнэлж жижиг ч гэсэн ахиц дэвшлийг урамшуулах бусад хүүхэдтэй харьцуулахгүй байх. Сургууль, багшийн үүрэг хүлээн зөвшөөрөх сургалтын хөтөлбөр, үнэлгээний аргачлалд уян хатан хандах, аюулгүй, хүртээмжтэй орчинд сургалт үйл ажиллагаагаа явуулах. Ангийн бусад сурагчдад ойлгуулах, улиралд нэг удаа сургуулийн дэмжлэгийн баг болон эцэг эх асран хамгаалагчтай тухайн суралцагчийн улирлын зорилгын талаар ярилцаж гаргасан үр дүнгийн талаар ярилцаж төлөвлөдөг байх. Эцэг эх, асран хамгаалагчтай хичээл сургалтын үйл ажиллагаа, үр дүн, хичээлийн зорилго төлөвлөлтийн талаар харилцааны дэвтэр ажиллуулах.

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ:

1. https://gemini.google.com/app/4538f5faa264d804?utm_source=app_launcher&utm_medium=owned&utm_campaign=base_all
2. ICF.(2023).”Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал”. (ҮАОУА).
3. <https://gemini.google.com/gem/storybook/ee3db690a841bfc2>

СУДЛАГДАХУУНЫ НЭР: БИЕИЙН ТАМИР

АНГИ: II анги

Хүүхдийн 6-10 нас бол бие бялдар, хөдөлгөөний чадвар эрчимтэй хөгжих суурь тавигддаг үе юм. Энэ үед авьяаслаг, бие бялдын хөгжил сайтай суралцагчдыг онцгойлон дэмжих нь тэдний цаашдын спортын амжилтын суурийг тавихад чухал ач холбогдолтой. Сургалтын хөтөлбөр нь бүх хүүхдийн нийтлэг, суурь хөгжил рүү чиглэдэг тул, бие бялдын хөгжил сайтай болон авьяаслаг сурагчдын хөгжлийн хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байх талтай. Тиймээс тэдэнд зориулан зорилтот, ялгавартай, ахиц дэвшилд суурилсан хөтөлбөр боловсруулах шаардлага үүсдэг.

Бие бялдын хөгжил сайтай болон авьяаслаг суралцагчийн онцлог нь:

- Хөдөлгөөний үндсэн чадваруудыг хурдан эзэмшдэг
- Хүч, хурд, тэсвэр, уян хатан байдал зэрэг чанарууд үеийнхнээсээ илүү хөгжсөн байдаг
- Дасгал хөдөлгөөнийг богино хугацаанд сурч, техник тактикийг хурдан ойлгодог
- Өөрийгөө сорих, өрсөлдөх сонирхол ихтэй байдаг.

Бие бялдрын хөгжил сайтай болон авьяаслаг хүүхдийг зөв чиглүүлж хөгжүүлбэл:

- Ирээдүйд тодорхой спортын төрөлд амжилт гаргах боломж нэмэгдэнэ
- Анги, хамт олондоо үлгэр жишээ болж, бусад хүүхдийг хөдөлгөөнөөр идэвхжүүлэх нөлөө үзүүлнэ.

Авьяаслаг, биеийн хөгжил сайтай хүүхдэд зориулсан хөтөлбөр боловсруулахдаа дараах зарчмыг баримтлах нь зүйтэй:

1. Ахиц дэвшилттэй хөгжүүлэх – дасгалын хүндрэлийг шат дараатай нэмэгдүүлэх
 2. Ялгавартай хандлага – энгийн түвшний хүүхдээс илүү сорилттой, гүнзгийрүүлсэн даалгавар өгөх
 3. Өрсөлдөөн ба тоглоом – өөрийгөө сорих, уралдах боломж олгох
 4. Нас сэтгэхүйн онцлогийг харгалзах – хэт их ачаалал өгөхөөс зайлсхийж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх
 5. Олон талаар хөгжүүлэх – зөвхөн нэг спортод эрт мэргэшүүлэх бус, ерөнхий биеийн хөгжил техникийн олон төрлийг хослуулах

Сургалтын аргууд:

1. Суурь чадварыг хөгжүүлэх арга

Байрнаас болон гүйлтээс харайлт, бөмбөг шидэлт, тэнцвэрийн дасгал, хурдны дасгал, сунгалтын дасгал

Суурь чадварыг хөгжүүлэхдээ “Өөрийн рекордыг эвдэх” зарчмаар суралцагч өөрийн өмнөх амжилтыг ахиулахыг хичээж оролцоно.

2. Амжилтаа ахиулж байгаа суралцагчийн чадварыг сорих арга

Алхмын тоо, зайн уртыг нэмэгдүүлэх

Саадыг нэмэх, тоглоомын даалгаврыг хүндрүүлэх

Жишээ: Энгийн суралцагч 4 алхмаас уртад харайх, авьяаслаг суралцагч 6–7 алхмаас, дараалсан 2 саад давж харайх гэх мэт

3. Тоглоомын болон өрсөлдөөнт арга

“Багийн буухиа” – гүйлт, харайлт, шидэлт хосолсон тоглоом

“Амжилтын шат” – өөрийн амжилтаа ахиулсан тохиолдолд дараагийн шатанд орно

“Рекорд тогтоох” – зай, цаг, оноогоор өөрөө болон найзтайгаа өрсөлдөх

4. Техник сайжруулах арга

Алдааг бичиж тэмдэглүүлэх (хамтрагч хүүхэд, багш)

Техник, хөдөлгөөнийг хэсэгчлэн давтуулах (жишээ нь, зөвхөн гарааны түлхэлт, зөвхөн газардалт)

Давталтын аргаар хөдөлгөөнийг хэвшил болгох

5. Өөрийгөө сорих, хөгжүүлэх арга

Амжилтын тэмдэглэл хөтлүүлэх (өөрийн дэвтэр болон самбар дээр)

Сайн гүйцэтгэж байгаа суралцагчаар хийлгэж, үзүүлэх, уралдаан тэмцээнд оролцуулах

Хүлээгдэж буй үр дүн

- Бие бялдрын үндсэн чанарууд хөгжсөн байна.
- Хөдөлгөөний ур чадвар сайжирсан байна.
- Багаар ажиллах, харилцах, хамтрах чадвартай болсон байна.

Авьяас хөгжүүлэх үе шатууд

1. Суурь хөгжлийн үе шат (6–7 нас)

Зорилго: Үндсэн хөдөлгөөн (гүйх, үсрэх, шидэх, барих, тэнцвэр хадгалах)-үүд эзэмшүүлэх

Үйл ажиллагаа:

- Тоглоомын дасгал (сагсан бөмбөгийн бөмбөг дамжуулах, уралдаан тоглоом, дээс, бүжгийн элементтэй хөдөлгөөн)
- Тэнцвэр, уян хатны дасгал, хөдөлгөөнүүд
- Олон төрлийн спортын суурь хөдөлгөөн

2. Хөгжүүлэх үе шат (8–9 нас)

Зорилго: Хөдөлгөөний зохицуулалт, хурд, тэсвэр, авхаалж самбаа хөгжүүлэх

Үйл ажиллагаа:

- Хөнгөн атлетик (ойрын болон холын зайд гүйх, янз бүрийн харайлтууд)
- Багийн спорт (сагсан бөмбөг, гар бөмбөг, хөл бөмбөг)-ын үндсэн техникүүд
- Ганцаарчилсан спорт (жудо, гимнастик, шатрын хөдөлгөөнт хувилбар, ширээний теннис)-ын үндсэн техникүүд
- Уян хатан, хүч хөгжүүлэх суурь дасгал (өөрийн жингээр: сунгалт, суугаа босоо, планк гэх мэт)-ууд

3. Сонгон хөгжүүлэх үе шат (10 нас)

Зорилго: Хүүхдийн авьяасыг тодорхой спортын төрөлд чиглүүлж хөгжүүлэх

Үйл ажиллагаа:

- Хүүхдийн дуртай, сонирхолтой спортыг сонгон бэлтгэл эхлүүлэх
- Уралдаан тэмцээнд оролцуулах
- Сэтгэл зүйн бэлтгэл (зорилго тавих, урам авах, стресс зохицуулах)
- Бага насны тамирчны эрүүл хооллолт, амралтын зөв дэглэм

Хөтөлбөр хэрэгжүүлэх зарчим

1. Эрүүл аюулгүй орчин – эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд сургалт зохион байгуулах
2. Тоглоомын арга ашиглах – хүүхдийг уйдаахгүй, сонирхолтой байлгах
3. Олон төрлийн хөдөлгөөн, энгийн техник хийлгэх – аль нэг спортод эрт мэргэшүүлэхээс зайлсхийх
4. Эцэг эхийн оролцоо – хамт дасгал хийх, урам өгөх, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх
5. Хүүхдийн ялгаатай хөгжил – биеийн хөгжил, зан чанар, сонирхлоор нь дэмжих

Нэгж болон ээлжит хичээлийн жишээ

СҮД 2.26. Байрнаас уртад харайх чадвараа хөгжүүлэх, 4-5 алхам гүйлтээс жижиг саадыг даван харайж харуулна.

Арга зүй: Бага боловсролын биеийн тамирын судлагдахууны хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ “Тоглоомд суурилсан арга зүй”-г голчлон хэрэглэх ба тухай суралцахуйн үр дүнгийн онцлогоос шалтгаалж янз бүрийн аргуудыг ашиглаж болно.

Дээрх суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхдээ эдгээр аргуудыг ашиглавал илүү тохиромжтой юм.

Ачаалал тохируулах арга (АНГ: Load adjustment / Progressive overload) гэдэг нь биеийн тамирын хичээлд дээр хүүхдийн одоогийн чадварт тохирох ачааллыг өгч, аажмаар нэмэгдүүлснээр хүссэн үр дүнд (хүч, тэсвэр, хурд, уян хатан байдал) хүрэх арга юм. Эхний шатанд хүүхдийн одоогийн чадварыг оношлоод (жишээ нь байрнаас 90 см харайж байна) түүнээс 10–20%-иар илүү ачаалал өгнө (105–110 см шугам тавина). Амжилттай гүйцэтгэвэл дараагийн хичээлд ачааллыг дахин 5–10% нэмнэ (саад 15 см → 20 см → 25 см). Ингэснээр жирийн хүүхэд хоцрохгүй, авьяаслаг хүүхэд залхахгүй, хоёулаа тогтмол ахиц гаргана.

Ялгаатай хэрэгцээнд тохируулах арга (АНГ: Differentiation by need) гэдэг нь хүүхэд бүрийн бие бялдар, сэтгэл зүй, сэтгэхүй, сонирхол, суралцах хэв маягийн ялгааг харгалзан тухайн хүүхдэд хэрэгтэй тусламж, дэмжлэг, сорилтыг өгөх арга зүй юм. Жишээ нь: нэг хүүхэд айдастай бол эхлээд гараас хөтөлж харайлгаж, нөгөө хүүхэд хурдан суралцдаг бол түүнд нэмэлт саад, нэмэлт алхам өгч сорилт болгоно. Ингэснээр онцгой хэрэгцээт хүүхэд орхигдохгүй, дунд түвшний хүүхэд амжилт мэдэрч, авьяаслаг хүүхэд уйдаахгүйгээр хөгжинө.

Хичээлийн үе шат	Үйл ажиллагаанууд		Үнэлгээ, хэрэглэгдэхүүн
1-р цаг Байрнаас уртад харайх техникийг сурах	1. Бие халаалт (8-10 мин)		Үнэлгээ: Багш ажиглах, техникийг зөв хийж байгаа эсэхийг (гарын савалт, хөлийн түлхэлт, буулт гэх мэт) тэмдэглэх. Хэрэглэгдэхүүн: Талбай дээр тэмдэглэгээ хийх конусууд, өнгийн хуулга,
	Зөөлөн гүйлт, бие бялдрын ерөнхий хөгжлийн дасгалууд, ялангуяа хөлийн түлхэлт, гарын савалт бүхий дасгалууд, хөлийн өвдөг, шагай, өлмийг халаахад чиглэсэн дасгалууд,		
	2. Үндсэн техник эзэмших (20-25 мин)		
	Жирийн сурагчид	Авьяаслаг сурагчид	
	Гарын савалт: Доош суун, урагш тонгойж гарыг арагш савах дасгал;(1 хийхдээ 4-6 удаа, 2-3 удаагийн давтамжтай) Гарыг урагш, дээш хүчтэй савах үйлдлийг хөлийн түлхэлттэй зэрэг хийн,	Гарын савалт: Доош суун, урагш тонгойж гарыг арагш савах дасгал; (1 хийхдээ 6-8 удаа, 4-5 удаагийн давтамжтай) Гарыг урагш, дээш хүчтэй савах үйлдлийг хөлийн түлхэлттэй зэрэг хийн,	

	<p>урагш үсэрч, өвдгөө бага зэрэг нугалан, хоёр хөлийн өлмий дээр зэрэг зөөлөн буух дасгал; (1 хийхдээ 4-6 удаа, 2-3 удаагийн давтамжтай) Техникийг сайн гүйцэтгэж, хол харайж байгаа сурагчдаар хийлгэж харуулах</p>	<p>урагш үсэрч, өвдгөө бага зэрэг нугалан, хоёр хөлийн өлмий дээр зэрэг зөөлөн буух дасгал; (1 хийхдээ 6-8 удаа, 4-5 удаагийн давтамжтай)</p>	
	<p>3.Төгсгөл хэсэг: Харайлт бүхий тоглоом тоглох</p>		
	<p>“Аль баг хол харайх вэ” Ангийн сурагчдыг хүч, тоо тэнцүү багт хуваан тоглоомын дүрмийг танилцуулна. Эхний сурагч зураасны араас байрнаас уртад харайн буухад, дараагийн сурагч буусан газраас уртад харайна гэх мэтчилэн багийн бүх сурагчид харайж, аль баг илүү хол харайсныг түрүүлсэнд тооцно. Хүүхэд сондгойрох эсвэл илүү гарахаар бол тохируулгад хамрагдаж байгаа сурагчдаар туслах шүүгч хийлгэх ба хэрхэн зөв, хол харайх талаар ярилцана. Ялсан багт баяр хүргэж, багаараа хэрхэн тоглосон талаар ярилцана.</p>		
<p>2-р цаг Байрнаас уртад харайх, хөлийн хүч хөгжүүлэх</p>	<p>1. Бие халаалт (8-10 мин)</p>		<p>Үнэлгээ: Байрнаас уртад харайсан зайг хэмжиж, явцын үнэлгээ хийнэ. Хэрэглэгдэхүүн: Метр, жижиг тавцангууд.</p>
	<p>Алхалт, гүйлтүүд, бие бялдрын ерөнхий хөгжлийн дасгалууд,</p>		
	<p>2. Үндсэн хэсэг. Хүч хөгжүүлэх дасгалууд:</p>		
	<p>Жирийн сурагчид</p>	<p>Авьяаслаг сурагчид</p>	
	<p>Ойрхон татсан (30-40 см) зураас дээгүүр урагш 2 хөлөөс түлхэж харайх, 4-6 удаа; 10-15 см-ын тавцан дээрээс үсэрч буух, 4-6 удаа 2-3 удаа давтамжтай хийх; зураасны 2 талд туулай үсрэлтээр үсрэх, 8-10 м; 1-2 удаа давтаж хийх</p>	<p>Өндөр (30-40 см) тавцан дээр 2 хөлөөр түлхэж үсэрч гарах, өлмий дээр зөөлөн буугаад шууд урагш харайх, 8-10 удаа 2-4 давтамжтай хийх; "Мэлхий үсрэлт" суусан байрлалаас урагш, дээш үсрэх, 8-10 м зайд 2-4 давтамжтай хийх; Ойрхон татсан (60-70 см) зураас дээгүүр урагш, хойш 2 хөлөөс түлхэж харайх, 6-8 удаа; Байрнаас уртад харайсан зайг хэмжиж, сурагчийн хувийн дээд амжилтыг тэмдэглэх.</p>	
	<p>3.Төгсгөл хэсэг. Тоглоом тоглох</p>		
<p>Үсрэлт, харайлт бүхий хөгжөөнт тоглоом тоглох</p>			
<p>3-р цаг</p>	<p>1.Бие халаалт (8-10 мин):</p>		<p>Үнэлгээ: Түлхэлтийн алхмыг зөв тааруулан түлхэлтийг гүйцэтгэж буйг</p>
	<p>Алхах, гүйх, биеийн ерөнхий хөгжлийн доод мөчдийг халаахад чиглэсэн дасгалууд;</p>		
	<p>2.Үндсэн хэсэг. Техник үзэх.</p>		
	<p>Түлхэлтийн болон савалтын хөлийн ялгааг тайлбарлах, бичлэг үзүүлэх,</p>	<p>түлхэлтийн хөлийг олох дасгалыг бүх сурагчдаар хийлгэх,</p>	

Жижиг саадыг давж харайх, хөлийн хүч хөгжүүлэх	Жирийн сурагчид	Авьяаслаг сурагчид	ажиглаж тэмдэглэх. Хэрэглэгдэхүүн: Харайлтын талаар харуулсан бичлэгүүд, конусууд, тэмдэглэгээ хийх хуулга, 4-5 м урт хэц хийх олс, шонгууд.
	2-3 алхаж, түлхэлтийн хөлөөс урагш дээш түлхэлт хийж, савалтын хөлийг урагш савах, 4-6 удаа 2-3 давтамжтай хийх; алхмын тоог ахиулан хийх, түлхэлтийн хөл дээр 6-8 м догонцож явах, 2-3 удаагийн давтамжтай хийх; 4-5 алхам гүйлтээс урагш дээш түлхэлт хийж, савалтын хөлийг урагш савах, 4-6 удаа 2-3 давтамжтай хийх; 15-20 см хэцэн дээгүүр 4-5 алхам гүйлтээс алхаж харайх, 4-6 удаа;	4-5 алхаж, түлхэлтийн хөлөөс урагш дээш түлхэлт хийж, савалтын хөлийг урагш савах, 6-8 удаа 2-3 давтамжтай хийх; алхмын тоог ахиулан хийх, түлхэлтийн хөл дээр 10-12 м догонцож явах, 3-4 удаагийн давтамжтай хийх; 6-7 алхам гүйлтээс урагш дээш түлхэлт хийж, савалтын хөлийг урагш савах, 4-6 удаа 3-4 давтамжтай хийх; 25-30 см хэцэн дээгүүр 6-7 алхам гүйлтээс алхаж харайх, 4-6 удаа;	
	3.Төгсгөл хэсэг. Тоглоом тоглох, хичээл дүгнэх Харайлт бүхий тоглоом тоглох, хичээлийг нэгтгэн дүгнэж, дасгалын ач холбогдол, ачааллыг ярилцах		
4-р цаг 4-5 алхам гүйлтээс жижиг даван харайх чадвараа хөгжүүлэх.	1.Бие халаалт. (8-10 мин)		Үнэлгээ: 4-5 алхам гүйлтээс саадыг (алдалгүй) амжилттай давж харайсан тоо. Хэрэглэгдэхүүн: Янз бүрийн өндөртэй тавцангууд, хэц уях суурьтай шонгууд, хэц хийх уяа,
	Алхалт гүйлт, бие бялдрын ерөнхий хөгжлийн болон хөлийн булчингуудыг халаахад чиглэсэн дасгалууд, Өмнөх хичээл дээр үзсэн дөхүүлэх дасгалуудыг давтах;		
	2.Үндсэн хэсэг: Техник давтах, (20-25 мин)		
	Жирийн сурагчид	Авьяаслаг сурагчид	
	2 хөлөөс ээлжлэн алхам бүрд урагш дээш түлхэн, гарыг хөлийн түлхэлттэй хослуулан дээш савах дасгалыг 6-8 м-т 2-3 удаагийн давтамжтай хийх, 4-5 алхам гүйлтээс 1 хөлөөр түлхэн 20-30 см өндөр тавцан дээр гарч зогсоод, 2 хөлийн өлмий дээр зөөлөн буух дасгалыг 4-6 удаа хийх, Хоорондоо 5-6 м зайтай байрлуулсан 20, 30, 40 см-ийн өндөртэй хэцэн дээгүүр алхаж харайх, дасгалыг 3-4 удаа давтах;	2 хөлөөс ээлжлэн алхам бүрд урагш дээш түлхэн, гарыг хөлийн түлхэлттэй хослуулан дээш савах дасгалыг 10-12 м-т 3-4 удаагийн давтамжтай хийх, 4-5 алхам гүйлтээс 1 хөлөөр түлхэн 40-50 см өндөр тавцан дээр гарч зогсоод, 2 хөлийн өлмий дээр зөөлөн буух дасгалыг 6-8 удаа хийх, Хоорондоо 5-6 м зайтай байрлуулсан 40, 50, 60 см-ийн өндөртэй хэцэн дээгүүр алхаж харайх, дасгалыг 6-8 удаа давтах;	
3.Хичээл дүгнэх (8-10 мин) Хичээлийн үр дүнг дүгнэх, өөрсдийн амжилтын талаар ярилцах, амжилт нь ахисан сурагчдад баяр хүргэх, гэртээ бие даан хийх дасгалуудыг зааж өгөх;			

Бие бялдрын хөгжил сайтай болон авьяаслаг сурагчдын ур чадварыг нарийвчлан хөгжүүлэх ба манлайлах чадварыг дээшлүүлэх нь гол зорилго юм. Сурагчдад давталтыг нэмэх эсвэл гүйлтийн алхам, харайлтын зайг тухай бүр нэмэгдүүлэх, мөн техникийн үзүүлэлт (хөлийн байрлал, гарын савалт, буулт, гэх мэт)-ийг багшийн зааврын дагуу сайжруулах хэрэгтэй. Сурагчдаар дасгал эсвэл тоглоомын дүрмийг илүү хүндрүүлэн зохиох даалгавар өгч, хичээлийн төгсгөлд амжилттай гүйцэтгэсэн баг, сурагчдад баяр хүргэж, урамшуулах хэрэгтэй юм.

Биеийн тамирын хичээл дээр бие бялдрын хөгжил сайтай, авьяаслаг сурагчдыг хөгжүүлэхийн тулд тэдний чадварт тохируулан дасгалын ачаалал, хөдөлгөөний хүндрэлийг үе шаттай нэмэгдүүлэх нь чухал юм. Үндсэн хөдөлгөөнүүдийг илүү ахисан түвшний хувилбараар (өндөр үсрэлт, хол харайлт, холын зайн гүйлт гэх мэт) өгч, техникийг сайжруулахад анхаарч ажиллах хэрэгтэй. Хүүхдийн өөртөө итгэх итгэл, манлайллыг дэмжихийн тулд багийн ахлагч болгох, техникийг бусад сурагчдад үзүүлэх зэрэг манлайллын оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагааг хийж болно. Сурагчийн ахиц дэвшлийг тогтмол ажиглаж, тухайн хүүхдийн онцлогт суурилсан зорилтот цогц дасгалыг боловсруулснаар авьяас, чадварыг тогтвортой хөгжүүлэх боломж бүрдэнэ.

СУДЛАГДАХУУНЫ НЭР: КАЗАХ ХЭЛ

АНГИ: I-V

Нэг. Сурагчийн ерөнхий мэдээлэл

Сурагчийн талаарх ерөнхий мэдээлэл: Сурагч “С”, эмэгтэй, ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар анги, эрүүл мэндийн байдал: Сул сонсголтой. (ЭМБ-ын чих хамар хоолой, сонсгол судлалын нарийн мэргэжлийн эмчийн оноштой. Сурагч “С”-ийн хувьд хичээлийн агуулгаа бүрэн эзэмших боломжтой, оюун ухааны хөгжил, биеийн хөгжил хэвийн, харин хөдөлгөөн чөлөөтэй боловч тэнцвэрийн хувьд бага зэргийн алдагдалтай, одоогоор бие дааж нийгмийн үйлчилгээнд оролцох боломж хязгаарлагдмал, хэл яриа муу хөгжсөн, дохионы хэлээр харилцах сонирхолтой.

Сурагч “С” сул сонсголтойн улмаас суралцах үйлд тодорхой хүндрэл үүсэж байгаа учраас сургалтын хөтөлбөрийн арга зүйд тохируулга хийх үндэслэлтэй байна.

Суралцагчийн төлөв байдал

- Математик, дүрслэх урлаг, дизайны хичээлд сонирхолтой. Монгол хэлний хичээлд хоцрогдолтой. Бичих чадвар муу, цээжээр бичиж чадахгүй, хуулан бичлэг хийдэг, үгийн утга ойлгоход хүндрэлтэй. Дохионы хэл, видео хэрэглэгдэхүүн ашиглаж сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг авах хүсэлтэй.
- Биеийн тамирын хичээлд анги нийтийн хичээлд сонирхолтой, хөгжмийн хичээлээр бүжиглэх авьяасаа хөгжүүлж, дугуйланд хичээлээс гадуур хамрагдах сонирхолтой.
- Багш болон ангийн найз нартайгаа харилцахад хүндрэлтэй. Ангийн сурагчид дохионы хэл мэдэхгүй. Багш нар дохионы хэл мэдэхгүй учраас харилцааны хувьд маш их хүндрэлтэй. Ангийн найз нартайгаа дохио зангаагаар харилцаж, цэвэрлэгээ хийх, бусдад туслах, өөрийгөө илэрхийлэхэд хүндрэлтэй. Хооллох зуршил сайн. Биеийн ерөнхий хөгжил сайтай.
- Ангийн хүүхдүүдтэй эвтэй, найз нөхдийн зүгээс түүнд тусалдаг.

- Ангийнхан нь дээрэлхдэггүй. Бүжиглэх дуртай, урлагийн арга хэмжээнд сайн оролцдог.

Ар гэрийн байдал:

- Аав, ээж, эмээ, өвөө, нэг дүүтэйгээ амьдардаг. Ам бүл 6
- Дүүтэйгээ тоглодог, гэрийн ажилд тусалдаг.
- Эмээ, өвөө нь охинд тусалж чаддаггүй. Гэртээ гэрийн даалгавраа хийдэг боловч, алдааг нь засаж хэлж өгч, тусалдаг хүн байхгүй. Компьютер их тоглодог. Дэлгэцийн хамаарал ихтэй байна.
- Аав, ээж нь хүүхдийнхээ гэрийн даалгавар хийлгэх, бие даан суралцахад тусалж төдийлөн чаддаггүй. Ээж нь ээлжийн ажилтай. Гэрийн ажил ихтэй, настай аав, ээжийгээ асардаг. Ээж нь ихэвчлэн сургуулиас нь авдаг.

Сургууль дээрх байдал:

Ангийн багш нь сурагч “С”-н монгол хэл, байгалийн ухаан, нийгмийн ухааны хичээлийн сургалтын хөтөлбөрт тохируулга хийж ажиллахыг багш нараас хүсч, сурлагын хоцрогдлыг багасгах зорилгоор сургалтын хөтөлбөрт тохируулга хийх хэрэгцээтэй гэдгийг гэр бүлийн гишүүд аав, ээжид нь танилцуулж, зөвшөөрөл авсан. Сургууль дээрх “Дэмжлэгийн баг”-ийн гишүүдэд асуудлыг танилцуулсан.

Хоёр. Үндсэн хэсэг

а. Тохируулгын зорилго:

- *Суралцагчийн танин мэдэхүйн онцлогт нийцүүлэн хөтөлбөрийн арга зүйн тохируулга хийнэ. /сургалтыг дохионы хэлээр заана/*

Тохируулгын арга:

- *Түлхүүр үг, зураг, схем ашиглан ойлголтыг тайлбарлах;*
- *Дасгал, даалгаврын тоог бууруулах;*
- *Эхийн агуулгыг богиносгож, гол санааг энгийн ойлгомжтой, тайлбарлахад хялбар шууд утгатай үгээр илэрхийлэх.*

Хүснэгт 44. Агуулгыг хялбаршуулах тохируулгын жишээ

Хичээлийн сэдэв	Эх хэлний судлагдахууны хөтөлбөрийн ерөнхий агуулга	Тохируулсан хувилбар
Үгийн утга	Ижил/эсрэг утгатай үгс	Зурагтай жишээ, 2-3 үгт тайлбар
Эхийн бүтэц	Эхлэл, гол хэсэг, төгсгөл	Зураглал, бүдүүвчээр илэрхийлэх
Унших эх	100-150 үг	50-70 үг, түлхүүр үгтэй

б. Арга зүйн тохируулга

- *Суралцагчийн сонирхлыг татах сэдэв сонгох: Эх хэлний хичээлийг амьдралтай холбож, суралцагчийн сонирхлыг өдөөх;*

- *Хамтран суралцах боломж бүрдүүлэх: Бусад суралцагчидтэй хамтран ажиллах, харилцах орчныг дэмжих;*
- *Үнэлгээний олон хэлбэр ашиглах: Зөвхөн бичгээр бус, аман, дүрслэх, үйлдлээр үнэлэх аргыг хослуулах хэрэгтэй.*

Мөн дүрд тоглох, зурагт тайлбар, хөдөлгөөнт дасгал, тоглоомын арга (интерактив хичээл), сэтгэл зүйн дэмжлэг (багш-эцэг эхийн хамтын ажиллагаа)-ийг чухалчлах нь үр дүнтэй болно.

в. Орчин, хэрэглэгдэхүүний тохируулга

Судлагдахууны хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын орчин, хэрэглэгдэхүүнд тавигдах үндсэн шаардлага нь:

- *Эерэг, урам өгсөн харилцаа бүхий орчин*
- *Эрүүл, аюулгүй, хүртээмжтэй анги танхим*
- *Ялгаатай хэрэгцээнд нийцсэн орон зай, хэрэглэгдэхүүн байна.*

Хүснэгт 45. Орчны тохируулгын жишээ

Тохируулгын чиглэл	Жишээ
<i>Танхимын зохион байгуулалт</i>	<i>Уян хатан ширээ, гэрэлтүүлэг, амрах хэсэг, багийн ажилд зориулсан орон зай</i>
<i>Хэрэглэгдэхүүн</i>	<i>Суралцагчийн оролцоог дэмжих номын булан, том үсэгтэй ном, аудио эх, интерактив самбар, хараа, сонсгол, хөдөлгөөний бэрхшээлтэй суралцагчдад зориулсан тусгай хэрэгсэл</i>
<i>Технологи</i>	<i>Лингофон кабинет, STEM портал, аппликейшн</i>

в. Үнэлгээний тохируулга

Судлагдахууны хөтөлбөрийн үнэлгээний зорилго нь:

- *Суралцагчийн ахиц, оролцоог дэмжих;*
- *Хувь хүний онцлогт нийцсэн үнэлгээ хийх.*

Хүснэгт 46. Үнэлгээний тохируулга

Үнэлгээний төрөл	Арга хэлбэр
<i>Явцын үнэлгээ</i>	<i>Ажиглалт, ярилцлага, карт, зураг</i>
<i>Үр дүнгийн үнэлгээ</i>	<i>Бүтээл, аман тайлбар, ахицын хяналт</i>
<i>Уян хатан үнэлгээ</i>	<i>Ярьж чадахгүй бол зурагт карт ашиглаж тохирсон үгийг өргөх, дохионы хэлээр хариулах</i>

Суралцагчийг үнэлэхдээ:

- *Алдааг суралцах боломж гэж үзэх;*

- Ахиц дэвшлийг харьцуулж үнэлэх;
- Сэтгэл зүйн дэмжлэгтэй, урам өгсөн хэлбэрээр зааж сургах, үнэлэх.

Багш эх хэлний судлагдахууны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулж, хичээлээ үр дүнтэй зохион байгуулж болно.

Ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулах алхам:

1. Суралцагчийн хэрэгцээ, чадварыг үнэлэх;
2. Зорилго, дэмжлэгийн арга замыг тодорхойлох;
3. Агуулга, арга зүй, орчин, үнэлгээнд тохируулга хийх;
4. Сургалтыг зохион байгуулах;
5. Үнэлгээ хийх.

Ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулахад дохионы хэлний цагаан толгой гол хэрэглэгдэхүүн болно.

Зураг 1: Дохионы хэлний цагаан толгой

А - (1)	Г - (1,2,4,5)		
О - (1,3,5)	Ж - (2,4,5)		
	Л - (1,2,3)		И - (2,4)
М - (1,3,4)	Н - (1,4,6)		
Т - (2,3,4,5)	Ү - (3,4,6)		
	П - (1,2,3,4)		Ө - (3,4,5)
Н - (1,3,4,5)	*Ө* - (1,2,6)		
Р - (1,2,3,5)	Ү - (3,4)		
Ғ - (1,2,4,5,6)	*Ф* - (1,2,4)		
	У - (1,3,6)		*Х* - (1,2,5)
С - (2,3,4)	*Һ* - (1,2,3,6)		
Й - (1,2,3,4,6)	В - (2,4,5,6)		
Б - (1,2)	Ц - (1,4)		
Қ - (1,4,5,6)	Ч - (1,2,3,4,5)		
Ш - (1,5,6)	*Щ* - (1,3,4,6)		
Ы - (2,3,4,6)	Ё - (1,6)		
Е - (1,5)	Ъ - (1,2,3,5,6)		
Д - (1,4,5)	Ь - (2,3,4,5,6)		
К - (1,3)	Э - (2,4,6)		

Зураг 2: Брайл цагаан толгой **I** - (1,3,4,5,6) **Ю** - (1,2,5,6)
З - (1,3,5,6) **Я** - (1,2,4,6)

Багш туслах багш, эцэг эхийн хамтын оролцоог хангаж, суралцагчийн ахицыг тогтмол хянаж, тэмдэглэл хөтөлнө.

Сул сонсголтой сурагчийн хөгжлийн үнэлгээг эрт хийж, дэмжлэг үзүүлэх нь хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэн арилгахад хэрэгтэй бөгөөд явцын болон ахицын үнэлгээ хийх, сургалтаа үр дүнтэй зохион байгуулах зэрэгт эергээр нөлөөлнө.

Хүснэгт 47. Ээлжит хичээлийн хөтөлбөрийн жишээ (2-р анги)

Сэдэв:	У үсэг. О-У авиаг ялгах	Амьтдын дуу чимээ
Сургалтын хөтөлбөрийн суралцахуйн үр дүн	1.4.а (2.4.а) ойролцоо дуудагддаг авиаг ялгаж, зөв дуудна а-о, а-ө, а-э, ө-э, о-у, о-ө, у-ү, э-и, ы-и, и-е, ө-е, м-п, н-т, л-н, т-д.	Ан амьтадын дуу чимээг (морь, үхэр, хонь, муурь, нохой) тусгаж, ялгана.
Хичээлийн зорилго:	- Сонсох, харах үйлдэлд тулгуурлан илэрхийлэх чадварыг хөгжүүлэх; - Амьсгал болон дууны хэмнэлийг төлөвшүүлэх.	- Ярих, сонсох чадварыг хөгжүүлэх; Сөйлеу мен есту қабiлеттерiн қалыптастыру. - Танил болон танил бус дуу чимээг мэдэх, ялгах.
Засах зорилго:	Ярих үед засах үйл ажиллагаа хийх; Зөв ярих, зөв бичих дүрмийг эзэмшүүлэх; Үгийн утгыг ойлгуулах	
Үгийн сан:	- «Би сонсож байна», «Би сонсохгүй байна», «Сайн байна уу?», «Баяртай». - Морь, үхэр, хонь, муур, нохой.	
Хэрэглэгдэхүүн:	Толь, дэлгэц, авианы дуудлагын онцлогийг харуулсан бичлэг, үсэг таниулах үзүүлэн, тарааж өгөх материал, зураг.	

Хичээлийн явц:

Хичээлийн үе шат	Багшийн үйл ажиллагаа	Суралцагчийн үйл ажиллагаа	Үнэлгээ	Нөөц
Зохион байгуулах үе шат (5 минут)	- Суралцагчийг тохиромжтой, тухтай байранд суулгах; - Намайг сонсож байна уу? - Сонсголын аппарат чинь ажиллаж байна уу? гэх мэт асуух.	- Би тухтай сууж байна. - Би таныг сайн сонсож байна. - Надад 2 (1) аппарат байгаа. - Надад аппарат байхгүй.	смайлик	Тарааж өгөх материал
	Хичээл дээр: - Хичээлдээ идэвхтэй оролцоно. - Багшаа анхааралтай сонсоно.	- Багшаа анхааралтай сонсоно. - Хичээлдээ идэвхтэй оролцоно.	урамшуулах үгс	Тарааж өгөх материал

	- У-О авиаг зөв дуудна.	- О-У авиаг ялгаж сурна.		
	Суралцагчийн сэтгэл зүйг засах - Өнөөдрийн сэтгэл санаа чинь ямар байна вэ?	(Өөрийн сэтгэл санааг харуулсан смайликийг сонгоно)		Смайлик
	Дуудах дасгал (ярих эрхтнүүдийн (хэл, уруул, тагнай, шүд гэх мэт) хөдөлгөөнийг сайжруулах) «Хөл бөмбөг», «Цаг», «Сам», «Заан»	- Би дасгал хийнэ. - Би дасгалаа хийсэн.	Их сайн байна, чи дасгалаа сайн хийлээ!	Дуудах дасгал, толь
	Амьсгалын дасгал: «Заан», «Хөл бөмбөг» (Хамраараа зөв амьсгалж, амаараа зөв амьсгаа гаргах)	- Би амьсгалын дасгалыг хийсэн.	Чи сайн хийсэн!	Амьсгалын дасгалын загварууд
	Ярих дасгал: • Аярхан ярих; • Чанга ярих; • Дуугүй ярих.	- Би ярих дасгал хийсэн.		
Шинэ мэдлэг (15 мин)	- У авианы дуудлагаар ажиллах: У авиаг богино болон уртаар дуудаж болно. Алхам 1: 1. У авиаг нээлттэй үе дээр хэлүүлж дадлагажуулах Уртаар дуудаарай / Богино дуудаарай У___ у___ уп Пу___ му___ ут пу___ му___ пу у___ му___ ту 2. Богино дуудаарай. Па-пу а-у папопу Та-пу а-у папопу То-ту о-у ап оп уп По-ту о-у ут уп ут По-по-по о-о-о у-у-у 3. О-У авиаг ялгаж: Сонсож, заагаарай. По-пу ко-ку мо-му То-ту бо-бу со-су	У – эгшиг авиа. У_____	О – эгшиг авиа. О_____	Сулейменов а Р.А., Ибрагимова Қ. Қ., Өміржанова Г.Б. «Дыбыстан у» 30-р тал
		Сонсож, үеийг урт, богиноор дуудна. Сонсож, уншина. Үеийг сонсоно, заана, давтаж хэлнэ.	- Анхааралт ай сонсоорой! - Жақсы! - Их сайн байна!	

	<p>Алхам 2: 1. Сонсоорой, заагаарай. П бу К куәлік Т у ту В сурет С су Ш шу</p> <p>2. Ярих дасгал. Чанга хэлээрэй / Аярхан хэлээрэй УП УТ уп ут УМ УК ум ук УТ УС ут ус</p> <p>3. О-У авиаг ялгах. Тохирох үсгийг олоорой. Зургийг заагаарай. Д...п, қа...ын, оқ...шы, қ...ян.</p> <p>Алхам 3: 1. Сонсоорой, давтаарай, хэмнэлээр алга ташаарай. па ТУ па ТУ па ТУ па ТУ та ТУ та ТУ та ТУ та ТУ татаТА таТУта</p> <p>2. Нэг амьсгалаар хэлээрэй. Сонсоорой, заагаарай. Бала уыз жеді. Уәде бер. Қос уыс тары.</p> <p>3. О-У авиаг ялгах. Зургийг заагаарай. От, орындық, ою, ожау, орақ.</p>	<p>Үеийг сонсоно, заана, давтаж хэлнэ.</p> <p>Сонсоно, үеийг чанга болон аярхан дуугаар хэлнэ.</p> <p>Суралцагч тохирох үсгийг олж уншина. Зургийг заана.</p> <ul style="list-style-type: none"> • Мынау доп. (Энэ бөмбөг) • Мынау қауын. (Энэ шигуа) • Мынау оқушы. (Энэ суралцагч) • Мынау қоян. (Энэ туулай) <p>Суралцагч сонсоно, давтана, хэмнэлээр алга ташна.</p>	<p>- Улам тод хэлэхийг хичээгээрэй!</p> <p>- Сайн байна!</p> <p>- Улам тод хэлэхийг хичээгээрэй!</p> <p>Сайн байна!</p> <p>- Улам тод хэлэхийг хичээгээрэй!</p> <p>Сайн байна!</p> <p>Сайн байна!</p>	<p>31-р тал</p> <p>Зураг</p>
--	---	---	---	------------------------------

	<p>Уық, тауық, ұлу.</p> <p>Алхам 4: 1. Багшийг сонсож, давтаарай. Уылдырық ута Уыз упа Уақыт уто Уық упи У__ыл__ды__рық Уыл__ды__рық</p> <p>2. Нэг амьсгалаар хэлээрэй. татату та__то__т у__ тататототуту тата__тото__туту_</p> <p>3. О-У авиаг ялгах. Зөв тохируулах</p>	<p>Өгүүлбэрийг заана. Нэг амьсгалаар хэлнэ.</p> <p>Үгсийг давтаж хэлнэ, зургийг заана.</p> <ul style="list-style-type: none"> • Мынау от. • Мынау ою. • Мынау ожау. • Мынау орақ. • Мынау орындық. • Мынау уық. • Мынау тауық. • Мынау ұлу. <p>Үгсийг сонсоно, давтаж хэлнэ</p> <p>Зургийг нэрлэнэ. Үгсийг давтаж, зургийг заана.</p>	<p>Их сайн байна!</p> <p>Үгсийг зөв дуудахыг хичээсэн, их сайн байна!</p>	<p>Зураг</p> <p>Тарааж өгөх материал</p> <p>Зураг</p>
<p>Бататгах (12 мин)</p>	<p>Амьтадын дуу чимээ:</p> <p>- Сэдэвтэй холбоотой үгсийг зургийн дагуу сонсож, харж тусгах;</p> <p>- Ан амьтадын дуу чимээг (морь, үхэр, хонь, муурь, нохой) тусгаж, ялгах.</p>	<p>- Би сонсож байна. (Амьтадыг зөв заах хэрэгтэй)</p> <p>- Мынау сыр. (Энэ үхэр)</p> <p>- Мынау қой. (Энэ хонь)</p> <p>- Мынау ат. (Энэ морь)</p> <p>- Мынау мысық. (Энэ муур)</p> <p>- Мынау ит. (Энэ нохой)</p>	<p>Их сайн байна! Чи бүгдийг ялгаж чадлаа!</p>	<p>Сэдэвтэй холбоотой зураг, аудио бичлэг</p>
<p>Үнэлэх (3 минут)</p>	<p>- Чи хичээлийн турш юу хийсэн бэ?</p> <p>- Чи сайн ажилласан.</p> <p>- Чи улам их хичээх хэрэгтэй байна.</p>	<p>- Би сонссон, ярьсан, уншсан. Смайликээр өөрийгөө үнэлнэ.</p>		<p>Смайлик</p>

Ээлжит хичээлийн хөтөлбөр (жишээ)

Хичээлийн сэдэв: Эсрэг ба ойролцоо утгатай үгс

Анги: 3-р анги

Хугацаа: 40 минут

Суралцахуйн зорилго:

- Эсрэг болон ойролцоо утгатай үгсийг таньж, ялгаж сурна.
- Зураг, дохио, бичвэр ашиглан үгсийг хэрэглэж өгүүлбэр зохионо.
- Бусадтай хамтран ажиллаж, үгсийн утгыг тайлбарлаж сурна.

1. Хичээлийн төлөвлөлт

Хүснэгт 48. Хичээлийн төлөвлөлт

Үе шат	Үйл ажиллагаа	Тохируулга
Зохион байгуулах (5 мин)	“Эсрэг утгатай үг гэж юу вэ?” – багш жишээ үгсийг зургаар танилцуулна.	Зурагт карт, дохионы хэлний тайлбар
Үг таниулах (10 мин)	“Том - Жижиг”, “Хүйтэн - Халуун”, “Аз жаргалтай - Гунигтай” гэх мэт үгсийг харьцуулан тайлбарлана.	Зураг, хөдөлгөөн, нүүрний хувирал ашиглах
Ойролцоо, эсрэг утгатай үгс (10 мин)	“Аз жаргалтай – баяртай”, “Гоё – сайхан”, “Ухаантай – мэргэн” гэх мэт үгсийг жишээгээр тайлбарлана.	Дохионы хэл, бичмэл харилцаа, жишээ өгүүлбэр
Бичих дасгал (10 мин)	Суралцагчид эсрэг болон ойролцоо утгатай үгсийг ашиглан 2–3 өгүүлбэр зохиож бичнэ.	Том үсэгтэй самбар, соронзон үсэг, багшийн дэмжлэг
Хамтран ажиллах (5 мин)	Хосоор ажиллаж, бие биенийхээ өгүүлбэрийг уншиж, үгсийн утгыг тайлбарлана.	Багийн дэмжлэг

2. Хэрэглэгдэхүүн

- Зурагт карт (эсрэг ба ойролцоо утгатай үгс)
- Дохионы хэлний тайлбар бүхий видео
- Том үсэгтэй бичвэр, соронзон самбар
- Аудио бичлэг (хэрэв тохиромжтой бол)
- Үгсийн хослол бүхий дасгалын хуудас

3. Үнэлгээ

Үнэлгээний төрөл	Арга хэлбэр
Явцын үнэлгээ	Ажиглалт, багшийн асуулт-хариулт
Үр дүнгийн үнэлгээ	Бичвэр, аман тайлбар, үгсийн хослолыг зөв ялгасан эсэх
Уян хатан үнэлгээ	Дохионы хэл, хөдөлгөөн, зураг ашиглан тайлбарлах

4. Тохируулгын стратеги

- Үгсийг зураг, хөдөлгөөн, нүүрний хувирал, дохионы хэлээр тайлбарлах
- Суралцагчийн оролцоог нэмэгдүүлэх *peer-based activity*
- Үгсийн утгыг ойлгоход дэмжлэг үзүүлэх жишээ өгүүлбэр, визуал материал
- Үнэлгээг олон хэлбэрээр хийх: аман, бичмэл, хөдөлгөөн, зураг

Ээлжит хичээлийн хөтөлбөр

Хичээлийн сэдэв: Эсрэг болон ойролцоо утгатай үг

Зорилго: Суралцагчид эсрэг ба ойролцоо утгатай үгийг таньж, зөв хэрэглэнэ.

Хугацаа: 40 минут

Хамрах хүрээ: 3 дугаар ангийн харааны бэрхшээлтэй суралцагч

Сургалтын зорилт:

- Эсрэг, ойролцоо утгатай үг гэж юу болохыг ойлгоно.
- Жишээ хэлж чадна.
- Эдгээр үгийг өгүүлбэрт зөв хэрэглэж сурна.

Сургалтын хэрэглэгдэхүүн:

- Брайль үсгээр хэвлэсэн үгийн картууд
- Дуу бичлэг (эсрэг ба ойролцоо утгатай үгсийн жишээ)
- Тактиль (мэдрэх) зурагт материал (жишээ нь: “том – жижиг” гэх мэт ялгаатай хэмжээтэй зүйлс)
- Дуу өсгөгч, чихэвч (хувийн хэрэглээнд)

Хичээлийн явц:

1. Сэдэл төрүүлэх үе шат (5 минут)

- “Хүйтэн” гэдэг үгийг хэлээд эсрэг утгатай үгийг таах (жишээ: “дулаан”)
- Дуу бичлэгээр 2-3 хос үг сонсгох (эсрэг ба ойролцоо утгатай)

2. Шинэ мэдлэг олгох үе шат (15 минут)

- Эсрэг утгатай үг гэж юу болохыг тайлбарлах
 - Жишээ: “өндөр – нам”, “хүйтэн – халуун”
- Ойролцоо утгатай үг гэж юу болохыг тайлбарлах
 - Жишээ: “сайхан – гоё”, “том – их”
- Үгсийг Брайль үсгээр уншуулах, мэдрэх боломж олгох
- Тактиль материал ашиглан ойлголтыг бататгах

3. Бататгах үе шат (15 минут)

- “Үг хослуулах” тоглоом: суралцагчид эсрэг болон ойролцоо утгатай үгийг хослуулна.

- Аман дасгал: багш үг хэлж, суралцагчид эсрэг эсвэл ойролцоо утгатай үгийг хэлнэ.
- Өгүүлбэр зохиох: өгсөн үгсийг ашиглан аман өгүүлбэр зохионо.

4. Дүгнэх үе шат (5 минут)

- Суралцагчдаас “Өнөөдөр ямар үгс сурсан бэ?” гэж асуух;
- 2-3 суралцагч өөрийн дуртай үгсээр өгүүлбэр зохиох;
- Хичээлийн зорилт биелсэн эсэхийг хамтдаа дүгнэх;

Анхаарах зүйлс:

- Суралцагч бүрийн ойлголтын хурдыг харгалзан уян хатан хандана.
- Дуу чимээний түвшинг тохируулж, анхаарлыг төвлөрүүлэх орчин бүрдүүлнэ.
- Харааны бэрхшээлтэй суралцагчдад зориулсан тусгай хэрэглэгдэхүүнийг ашиглана.

Эх сурвалж:

1. Сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах хэл зүйн зөвлөмж
2. Тусгай хэрэгцээт боловсрол | Боловсрол, шинжлэх ухааны яам.
3. Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам
4. UNESCO – Guidelines for Inclusive Education - Search
5. Сулейменова Р.А. нар, «Дыбыстану», Алматы, 2009.

СУДЛАГДАХУУНЫ НЭР: ТУВА ХЭЛ

АНГИ: III

Нэг. Ерөнхий мэдээлэл

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал (2024-2036)-ын Сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд тэгш хамруулах зарчим, арга зүйг баримтлах гэсэн 3.3 дугаар хэсэгт “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшихэд суралцагч бүрд адил тэгш боломж бүрдүүлэх зорилгоор тэдний ялгаатай хэрэгцээг харгалзан, сургалтын хөтөлбөрт талуудын оролцоотой тохируулга хийж, хэрэгжүүлнэ” гэж заасан байдаг. Үүнд ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, дэмжих сургалтын хөтөлбөр, нэмэлт сургалтын хөтөлбөр, жишиг сургалтын хөтөлбөр болон хос хэлний сургалтыг багтаасан байна.

Хос хэлний сургалттай хэл, соёлын ялгаатай суралцагчийн дунд унших, бичих сурах үйлийн бэрхшээлтэй суралцагчид цөөнгүй байна. Энэ төрлийн суралцагчид уншихдаа үсгийг солих, үгийг холих, эгнээ мөр алдах, бичихдээ үсгийг холих, солих алдааг түгээмэл гаргадаг байна. Эдгээр суралцахуйн бэрхшээлийг дислекси (*Dyslexia*, *Dysgraphia*) гэдэг. Өөрөөр хэлбэл, унших, бичих, үсэглэх чадварт бэрхшээл учруулдаг мэдрэлийн гаралтай суралцахуйн бэрхшээл юм. Энэ нь тухайн хүний оюун ухааны түвшин эсвэл хараа, сонсголтой холбоогүй бөгөөд ихэвчлэн авиаг (фонем) үсэг (графем)-тэй холбож, үгийг таних, тайлах үйл явц дахь тархины боловсруулалтын ялгаатай байдлаас үүсдэг. Тухайн бэрхшээл нь дараах үндсэн шинж тэмдгээр илэрдэг байна. Үүнд:

- Унших бэрхшээл: Үсэг солих, үг холих, унших хурд удаан байх, эгнээ мөр алдах

- *Бичих, үсгэлэх бэрхшээл: Үсэг, үгийг сольж бичих, үгийн дарааллыг зөрүүлэх (жишээлбэл, “д” ба “т” үсгийг андуурах)*
- *Хэл ярианы бэрхшээл: дуу авиаг ялгах, нэр, тоо, цээжлэхэд бэрхшээлтэй байх*
- *Санах ой, анхаарал: мэдээлэл боловсруулах хурд сул байх*

Унших, бичих сурах үйлийн бэрхшээлтэй хэл, соёлын ялгаатай суралцагчидтай багш хэрхэн ажиллах арга зүйн зөвлөмжийг бага боловсролын тува хэл судлагдахууны жишээ нь дээр боловсрууллаа.

Хоёр. Үндсэн хэсэг

Гуравдугаар ангид сурдаг үсэг сольж уншдаг суралцахуйн бэрхшээлтэй суралцагчийн нас, хүйс, гэр бүлийн тухай ерөнхий мэдээлэл болон давуу, сул талын тухай мэдээлэл оруулав.

<i>Суралцагчийн код</i>	<i>Нас</i>	<i>Хүйс</i>	<i>Гэр бүлийн тухай</i>	<i>Суралцагчийн давуу тал</i>	<i>Суралцагчийн сул тал</i>
<i>002</i>	<i>8</i>	<i>эр</i>	<i>Эцэг эх нь малчин</i>	<i>Математик сэтгэлгээ сайн, аливаа зүйлийг ойлгож хүлээж авахдаа сайн, уншдаг</i>	<i>Уншихдаа: - үсэг сольдог: ш/с, д/т. - эгнээ, мөр алдаж уншдаг</i>

Тухайн суралцагчийн багш нь суралцахуйн бэрхшээлийг нь багасгах чиглэлээр ганцаарчлан ярилцах, хичээлийн дараа уншуулах зэрэг дэмжлэг үзүүлдэг байна.

Үсэг сольж, эгнээ мөр алдаж уншдаг төрлийн суралцахуйн бэрхшээлтэй суралцагчтэй багш хэрхэн үр дүнтэй ажиллах вэ? Үүнийг тува хэл судлагдахууны 3 дугаар ангийн Унших айн “3.2а. Эхийг зөв, түгдрэлгүй уншиж, утгыг ойлгож, ойлгосноо тоочиж, тайлбарлана.” гэсэн суралцахуйн үр дүнг эзэмшүүлэхийн тулд тухайн суралцахуйн үр дүнд нь тохируулга хийхгүйгээр багшийн заах арга зүйд тохируулга хийх зөвлөмжийг боловсруулав. Ингэхдээ дээрх төрлийн суралцахуйн бэрхшээлтэй суралцагчийн “аливаа зүйлийг ойлгож, хүлээж авахдаа сайн мөн холбож уншдаг” гэсэн давуу тал дээр нь тулгуурлаж сургалтын арга зүйн тохируулгыг дараах байдлаар хийж болохоор байна. Энэхүү арга зүйг хэрэгжүүлснээр суралцагч унших аргачлалд суралцах, унших дур сонирхолтой болох үр дүнд хүрнэ.

Сургалтын арга зүй, орчин, хэрэглэгдэхүүнийг бүх суралцагчийн онцлогт тохируулан уян хатан байдлаар зохион байгуулахыг чухалчилдаг (Universal Design for Learning) хэдий ч, унших, бичих суралцахуйн бэрхшээлтэй суралцагчийн хувьд энэ нь хамгийн чухал ойлголт юм. Ялангуяа үсэг сольж уншдаг суралцагчидтай ажиллахад сургалтын хэрэглэгдэхүүнийг цахим (аудио ном) хэлбэрээр болон цаасан хэлбэрээр бэлтгэн хүргэхийг аль алийг нь тохиромжтой гэж үздэг байна. Өөрөөр хэлбэл мэдээллийг олон хэлбэрээр хүлээн авах (Representation) боломжийг бүрдүүлэх юм. Гэхдээ энэ удаад бид сургалтын хэрэглэгдэхүүнийг цаасан хэлбэрээр бэлтгэх аргачлалыг хүргэж байна.

Ээлжит хичээлийн жишээ

Хичээлийн сэдэв: “Тус”

Судлах цаг: 3 цаг

Хичээлийн зорилго: Уншихдаа үсэг сольж, эгнээ мөр алдаж уншдаг суралцагчид зөв уншиж сурахад дэмжлэг үзүүлэх

Хүрэх үр дүн:

- Үсгээ зөв таньж, түгдрэлгүй унших чадварыг хөгжүүлэх
- Уншсан зүйлээ ойлгож, ойлгосноо илэрхийлэх чадварыг хөгжүүлэх
- “Тус” уран зохиолын бус эхийг уншиж, үгийн нөөцөө нэмэгдүүлэх
- Хүндлэх, талархах уламжлалт ёс заншлаас суралцах

Хэрэгжүүлэх арга зүй: “Зургийн тусламжтай уншлага”, “Түргэн уншлага” болон “Тодотгож ялгах” аргыг хэрэглэнэ. Жич: Эдгээр аргуудын дэлгэрэнгүйг “Багш нарт нэмэлт арга зүйн зөвлөмж” хэсгээс уншаарай.

Сургалтын хэрэглэгдэхүүн:

1. “Тус” эхийн үсгийн хэмжээг томсгож (14-16), мөр хоорондох зайг холдуулж (1.5-2.0) бичээд хэвлэх ба хэвлэсэн эхэд байгаа тухайн суралцагчийн сольж уншдаг үсгийг өнгөөр ялгаж тодруулна (*highlight, bold*). Өөрөөр хэлбэл унших үйлийг хялбарчилна.
2. Уншлагын чиглүүлэгч/цонх (*tracker*) ашиглана. “Уншлагын чиглүүлэгч” нь уншиж буй мөрийг л харуулж, бусад мөрийг хаасан цаасан карт юм.

Сургалтын орчин, зохион байгуулалт: Тухайн төрлийн суралцагч ангид цөөн байгаа тохиолдолд бусад суралцагчидтай хамтад нь хичээллэх ба харин багш унших эхийг зөвлөмжийн дагуу бэлтгэж, тухайн суралцагчтай тусгайлан цаг гаргаж ажиллана. Мөн хичээлийн бус цагаар хамтран ажиллана.

Уншихад бэлтгэх үе

Эхийг уншиж эхлэхээс өмнө багш “Зургийн тусламжтай уншлага” аргыг хэрэглэнэ. Зургийн тусламжтайгаар юуны тухай эх уншихыг асууна. Мөн уншсаны дараа эх доторх шинэ үгийн утгыг илэрхийлсэн зургийг харуулж, үгийн утгыг таниулна. Ингэж уншуулах нь үг таних чадварыг сайжруулахаас гадна төсөөлөн бодох чадварыг хөгжүүлнэ.

Унших үе

Шинэ сэдэвтэй танилцах буюу шинэ эхийг уншихад багш “Түргэн уншлага”-ын аргыг хэрэглэнэ. Эхлээд багш тухайн эхийг зөв, тод уншиж өгнө. Энэ үед суралцагч зөв уншлагын хэв маягийг сонсож тогтооно. Дараа нь хамтдаа уншина. Хамт нэгэн зэрэг ижил хурдтай, чангаар уншина. Энэ нь суралцагчийг зөв түгдрэлгүй уншихад туслах ба алдаа гаргахаас сэргийлнэ.

Нэмэлт тайлбар: Тухайн суралцагч холбож уншдаг учир уншихад асуудалгүй байгаа нь давуу тал болж байна. Харин холбож уншдаггүй суралцагч байвал унших чадварыг хөгжүүлэх “Үе холбох арга”-ыг багш хэрэглэх боломжтой. Үе холбох арга нь үсгүүдийн

хоорондох холбоосыг огцом, хурдан хийж, уншиж сургах арга юм. Жишээлбэл, “м-а” гэж тус тусад нь үсэглэж хэлүүлэхгүйгээр шууд “ма” гэж хэлж, уншуулж сургах юм.

Үүний дараа багш “Тодотгож ялгах” аргыг хэрэглэнэ. Ингэхдээ “Тус” эхийн мөр хоорондох зайг холдуулж, үсгийн хэмжээг томруулж бичээд хэвлэсэн байх ба хэвлэсэн эхэд байгаа тухайн суралцагчийн сольж уншдаг үсгийг өнгөөр ялгаж тодруулсан байна. Жишээлбэл, “т” үсгийг улаанаар, “д” үсгийг хөхөөр, “ш” үсгийг ногооноор, “с” шаргал өнгөөр тодруулсан байна. Гэхдээ олон өнгө холилдуулахаас болгоомжилж, тухайн өдөр сольж уншдаг хоёр үсгийг л сонгон авч тодруулж болно. Энэ удаа “д”, “т” үсгийг тодруулъя. “Дуза” (Тус) эхийг бэлтгэсэн эхийн жишээг харна уу.

Суралцагч унших үед “Уншлагын чиглүүлэгч карт”-ыг давхар ашиглана. Эхний уншилтыг багш хянаж, чиглүүлнэ. Уншсаны дараа эхэд танил бус үг байгаа эсэхийг суралцагчаас асууна. Танил бус үгийг эхийн зураг болон ойр орчмын үг, өгүүлбэрийн тусламжтайгаар утгыг нь танилцуулна. Тухайн үгийн утгыг илэрхийлэх холбоо үг болон өгүүлбэр зохиолгож хэлүүлнэ. Тухайн үгийн утгыг илэрхийлэх өгүүлбэрийг тохирох зураг, тайлбартай нь зөв харгалзуулах, холбох зэрэг дасгал даалгавар гүйцэтгүүлнэ.

Бататгах үе

Эхийг уншиж ойлгосон эсэх, уншсанаа бататгахад дараах даалгавруудыг гүйцэтгүүлнэ. Даалгаврыг эхтэй адилхан бэлтгэнэ. Мөр хоорондох зайг холдуулж, үсгийн хэмжээг томруулаад сольж уншдаг “д”, “т” үсгийг өнгөөр тодруулна. “Уншлагын чиглүүлэгч” – картыг ашиглана.

Даалгавар 1. Асуултад хариулна. (Эхийг уншаад асуултад хариулах нь уншсан зүйлийн утгыг эргэцүүлэн болоход тусалдаг).

а. Сөзүглелдиң кол баатыры кым? Ол канчанган? (Эхийн гол дүр хэн бэ? Тэр яасан бэ?)

б. Аңгаа кым кым чүнү кылып дузалаан? (Түүнд хэн хэн, юу хийж тусалсан бэ?)

в. Сөзүглелди чүге “Дуза” деп адаан? (Эхийг яагаад “Тус” гэж нэрлэсэн бэ?)

Даалгавар 2. Зургийн утгыг илэрхийлж буй өгүүлбэрийг олж дугуйлаарай.

Нэмэлт тайлбар: Суралцагчийг танхимаас гадна бие дааж унших чадвараа хөгжүүлэхэд дэмжлэг болох унших материалыг дээрх зөвлөмжийн дагуу бичиж хэвлэх ба өнгөөр тодруулж тусгайлан бэлтгэхэд багш анхаарна. Унших эхийг сурах бичгээс авна.

Дүгнэлт ба үнэлгээний үе

Үнэлгээний зорилго: Уншихдаа үсэг сольж уншдаг суралцагчийг зөв уншиж сурахад болон унших чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Хүснэгт 50. Үнэлгээний шалгуур

Хүрэх үр дүн	Үнэлгээний шалгуур
Үсгээ зөв таньж, зөв унших чадвартай болно.	Үсгүүдээ ялгадаг, зөв уншдаг.
Уншсан зүйлээ ойлгож, ойлгосноо илэрхийлдэг болно.	Уншиж ойлгосон зүйлээ зургаар зурж илэрхийлдэг, ярьдаг, асуултад хариулдаг.

Үгийн нөөцөө нэмэгдүүлдэг болно.	Танил бус үгийн утгыг илэрхийлдэг өгүүлбэрийг зураг, тайлбартай нь зөв харгалзуулдаг, өгүүлбэр зохиож хэлдэг.
Хүндлэх, талархах уламжлалт ёс заншлаас суралцдаг болно.	Хүндлэх, талархах уламжлалт ёс заншлаас суралцаж, түүгээр бахархаж байгаагаа илэрхийлдэг.

Үнэлгээнд анхаарах зүйл: Суралцагч бүр магтаж урамшуулахад урам авдаг учир тухайн ялгаатай хэрэгцээтэй суралцагч алдаа гаргасан ч буруутгахгүй, харин хичээл зүтгэлийг нь үргэлж үнэлж, жижиг ахиц бүрийг нь магтаж урамшуулахад багш нар анхаарах.

Жич: Ялгаатай хэрэгцээтэй суралцагчидтай багш мэдлэг, чадвараа байнга сайжруулж, дислекситэй суралцагчидтай ажиллах арга зүйгээр сургалтаа явуулах шаардлагатай болно.

Хүснэгт 51. Суралцагчийн ахиц амжилтыг үнэлэх хуудас

Үнэлгээний шалгуур	Үнэлгээний түвшин			Тайлбар
	Сайжруулах шаардлагатай	Суралцаж байгаа	Хангалттай	
Үсгүүдээ ялгаж, зөв уншсан эсэх.	“д”, “т” болон “ш”, “с” үсгийг ялгадаггүй, үсгүүдийг сольдог.	“д”, “т” болон “ш”, “с” үсгийг ялгадаг ч, түгдэрч удаан уншдаг.	“д”, “т” болон “ш”, “с” үсгийг ялгаж, зөв уншдаг.	
Уншиж ойлгосон зүйлээ зургаар зурж илэрхийлсэн, ярьсан, асуултад хариулсан байдал.	Уншиж ойлгохдоо тааруу, ярьж, бичиж хариулахдаа муу.	Уншиж ойлгохдоо удаан, ярихдаа тааруу хэдий ч, асуултад хариулдаг.	Уншиж ойлгосон зүйлээ зурж, ярьж, бичиж бүрэн илэрхийлдэг.	
Танил бус үгийн утгыг илэрхийлж, өгүүлбэрийг зураг, тайлбартай нь зөв харгалзуулсан, өгүүлбэр зохиож хэлсэн эсэх.	Танил бус үгийн утгыг илэрхийлж чаддаггүй, өгүүлбэрийг зураг, тайлбартай нь буруу харгалзуулдаг, өгүүлбэр зохиодоггүй, үг, холбоо үг хэлдэг.	Танил бус үгийн утгыг дутуу илэрхийлдэг, өгүүлбэрийг зураг, тайлбартай нь харгалзуулахад алдаа гаргадаг, дэлгэрэнгүй биш өгүүлбэр зохиодог.	Танил бус үгийн утгыг илэрхийлдэг, өгүүлбэрийг зураг, тайлбартай нь зөв харгалзуулдаг, өгүүлбэр зохиодог.	
Хүндлэх, талархах уламжлалт ёс заншлаас	“Тус” эхийн хүрээнд ахмадаа хүндлэх, тэдэнд талархах ёс заншлаас суралцаж байгаа ч,	“Тус” эхийн хүрээнд ахмадаа хүндлэх, тэдэнд талархах ёс	“Тус” эхийн хүрээнд ахмадаа хүндлэх, тэдэнд талархах ёс	

суралцаж, түүгээр бахархаж байгаагаа илэрхийлсэн байдал.	өөрийн сэтгэгдлээ илэрхийлж чаддаггүй.	заншлаас суралцаж байгаа ч, өөрийн сэтгэгдлээ илэрхийлэхдээ тааруу.	заншлаас суралцаж, түүгээр бахархаж байгаагаа илэрхийлдэг.	
--	--	---	--	--

Жич: Үсэг сольж унших бэрхшээл нь тухайн суралцагчийн оюуны чадамж эсвэл хичээлийн агуулгыг ойлгох чадварыг илтгэдэггүй учир үнэлгээг бусад суралцагчийнадил хийнэ. Иймд багш үнэлгээний түвшнийг тооцох ба тайлбар хэсэгт тухайн суралцагч аль түвшинд хамаарч байгааг тодорхой тусгаж, цаашид хэрхэн сайжруулах төлөвлөлтөө хийж суралцагчтай хамтран ажиллана.

Нэмэлт тайлбар: Багш суралцагчийн ахиц амжилтыг үнэлэхээс гадна сургалтын аргуудаа болон сургалтын хэрэглэгдэхүүнээ тухайн суралцагчид тохирч байгаа эсэх талаар хяналт хийж сургалтын арга, хэрэглэгдэхүүнийг сайжруулахад санал санаачилга гаргаж ажиллахыг зөвлөж байна. Өөрөөр хэлбэл, суралцагчийн хэрэглэх уян хатан байдал (Flexibility in Use) өргөн хүрээний хувийн сонголт, чадварт нийцсэн байхад анхаарна.

Гурав. Ерөнхий дүгнэлт, зөвлөмж

Суралцагчийн хувьд:

- *Багшийн өгсөн заавар зөвлөмжийн дагуу унших чадвараа сайжруулахад бие дааж суралцах хүсэл эрмэлзэлтэй байх, суралцах арга барилаа олох, өөртөө тохирох хэрэглэгдэхүүнийг сонгох. Үүнд:*
- *Энгийн ном, гарын авлага болон сурах бичиг үүний тохируулж бэлтгэсэн хувилбар*
- *Цахим хэрэглэгдэхүүн (аудио, видео)*
- *Ангийн найз нөхдөөс ичиж зовохгүйгээр тусламж дэмжлэг авдаг байх*
- *Анги, сургуулиас зохион байгуулдаг “уншлагын цаг”-аар тогтмол ном уншдаг хэвшилтэй болох*

Багш нарын түвшинд:

- *Ялгаатай хэрэгцээтэй суралцагчидтай багш мэдлэг, чадвараа байнга сайжруулж, дислекситэй суралцагчидтай ажиллах арга зүйгээр сургалтаа явуулах бэлтгэлээ хангах. Тухайлбал, дээр хэлсэнчлэн эх бичвэрийн мөр хоорондын зайг ихэсгэж хэвлэж бэлтгэх, сольж уншдаг үсгийг өнгөөр тодруулах, хэмжээг ихэсгэх гэх мэт сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэх.*
- *Хөдөө орон нутагт буй эцэг эхэд суралцагчтэйгээ ажиллахад дэмжлэг болох зөвлөмж, гарын авлага болон унших материалыг бэлтгэж хүргүүлэх.*
- *Уян хатан, ялгаатай арга зүйг хэрэгжүүлэх, дэмжих орчин бүрдүүлэх. Тухайлбал, сургалтын хэрэглэгдэхүүн, үнэлгээний аргыг олон хувилбар (амаар, бичгээр, дүрсээр)-аар бэлтгэх.*

Сургуулийн түвшинд:

- Бага ангийн багш нарыг дислекситэй суралцагчидтай ажиллах арга зүйн сургалтад хамруулах
- Бага ангийн багш нар хамтарч суралцагчийн суралцахуйн бэрхшээлийг оношлох, тухайн орон нутгийн онцлог хэрэгцээнд тохирсон орчин, хэрэглэгдэхүүн, арга зүйг сонгон хичээл сургалтын үйл ажиллагааг хамтран зохион байгуулах
- Дислекситэй суралцагчийн сургалтын чанарыг ахиулахад эцэг эх, суралцагч, багшийн хамтын ажиллагааг сургуулиас дэмжин ажилладаг байх.
- Сургуулийн түвшинд дислексийн эрт илрүүлэг, оношилгоо хийх тогтолцоог бүрдүүлэх
- Тусгай боловсролын багш эсвэл зөвлөх ажиллуулах, суралцагчдад нэмэлт хичээл, зөвлөгөө өгөх нөөцийн өрөө, танхим ажиллуулах
- Сургалтад ашиглах сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүнтэй болох, ашиглах нөхцөлийг бүрдүүлэх: аудио ном зэрэг.

Багш нарт нэмэлт арга зүйн зөвлөмж

Багш нарын заах аргад дэмжлэг болох үүднээс унших, бичих суралцахуйн бэрхшээлтэй суралцагчидтай ажиллах аргачлалыг бэлтгэн хүргэж байна.

Унших бэрхшээлтэй суралцагчидтай ажиллах аргачлал

Үсэг холих, үсэг сольж унших нь ихэвчлэн харааны болон авианы (фонемийн) ялгамж болон ой санамжийн бэрхшээлтэй холбоотой байдаг тул эдгээрийг шийдвэрлэхэд чиглэсэн аргуудыг хэрэглэнэ.

1. Авиа (фонем) ба үсэг (графем)-ийг ялгаж тогтоох

Гол зорилго нь тухайн үсэг ямар авиаг илэрхийлж байгааг, мөн андуурагддаг үсгүүдийн ялгааг бүрэн ойлгуулахад оршино.

Бэрхшээл	Аргачлал	Суралцахуйн жишиг үйл ажиллагаа
Үсэг холих, солих (б/д, м/н, а/я)	Олон Мэдрэхүйн Арга (ВАКТ – Хараа, Сонсгол, Хүртэх, Хөдөлгөөн): үсгийг зөвхөн хараагаар биш, харин хүрч мэдрэх, хэлж сонсох, бичих хөдөлгөөнөөр тогтоох.	<p>1. Биеийн хөдөлгөөнөөр тогтоох: “Б” үсгийг хэлэхдээ гарын алгаар дугуй хийгээд, шулуун шугамыг гараараа доош татах. “Д” үсгийг хэлэхдээ дээрх хөдөлгөөнийг эсрэгээр хийх.</p> <p>2. Элсэн эсвэл барзгар гадаргуу дээр бичих: Элс, будаа эсвэл барзгар цаасан дээр хуруугаар “Б” үсгийг бичихдээ “ббб” авиаг чангаар хэлүүлж дадлагажуулах. Энэ нь үсгийн хэлбэрийг мэдрэхүйн түвшинд тогтооход тусална.</p> <p>3. Авиаг хөдөлгөөнөөр илэрхийлэх: Тухайн авиаг хэлэх үедээ биеийн тодорхой хэсгээр хөдөлгөөн хийх.</p>

		Жишээлбэл, “А” гэж хэлэхдээ гараа дээш өргөх.
Харааны андуурал (б/д, х/н)	Тодотгож ялгах: андуурагддаг үсгүүдийг тод өнгө болон хэмжээгээр ялгаж харуулах.	1. Өнгөөр ялгах: Бүх “Б” үсгийг цэнхэр, бүх “Д” үсгийг улаан өнгөөр бичиж өгөөд уншуулах. Эсвэл тухайн үсгийн хэмжээг томруулж бичнэ. Энэ нь харааны анхаарлыг хөгжүүлнэ. 2. Эхлэх цэг тогтоох: “Д” үсгийг зурж эхлэх цэгийг тодорхой заах (жишээ нь баруун тийшээ дугуй эхэлнэ) нь “Б” үсгээс ялгаж тогтооход тусална.
Үгийн эхлэл, төгсгөл дээр андуурах	Үсгийн авиаг хэлэх: Үсгийн нэрийг биш, авианы дуудлагыг нь хэлж сургах.	“Б” үсгийг “бэ” гэж нэрээр нь биш, харин “бы” гэж авиагаар нь дуудуулж, дараа нь үгтэй холбож уншуулах. Жишээ нь: бар, бор.

2. Үгээр унших (үсэглэхгүй) чадварыг хөгжүүлэх

Зорилго нь үсгүүдийг нийлүүлэн үе, үеүдийг нийлүүлэн үг бүтээж унших чадварыг хөгжүүлэх.

- Үе холбох арга: Үсгүүдийн хоорондох холбоосыг огцом, хурдан хийж сургах. Жишээлбэл, “м-а” гэж тус тусад нь үсэглэж хэлүүлэхгүйгээр шууд “ма” гэж хэлж, уншуулж сургах.
- Гинжин уншлага: Нэг болон хоёр үгтэй үгийг нүдлэн тогтоох. Жишээлбэл, аав, ээж, ном, цагаан, улаан гэх мэт үгийг шууд нүдлүүлж тогтоолгох. Эдгээр үгийг карт дээр бичиж хурдасгасан байдлаар уншуулж сургах нь үр дүнтэй байдаг.
- Зургийн тусламжтай уншлага: Ном, эх доторх шинэ үгийг утгыг нь илэрхийлсэн зургийн хамт харуулж, уншуулах нь үг таних чадварыг сайжруулна.
- “Түргэн уншлага” (Fluency) ба “Хослон унших” (Choral reading):
- Багш/ эцэг эх уншиж өгөх: Эхлээд багш/ эцэг эх тухайн эхийг зөв, тод уншиж өгнө. Тухайн үед суралцагч зөв уншлагын хэв маягийг сонсож тогтооно.
- Хамтдаа унших: Суралцагчтэйгээ хамт нэгэн зэрэг ижил хурдтай, чангаар уншина. Энэ нь суралцагчийг зөв хэлбэрээр уншихад туслах ба алдаа гаргахаас сэргийлнэ.

3. Эгнээ мөр алдаж уншихыг засах

Үсэг, үе холихтой хамт эгнээ мөр алдаж унших нь ихэвчлэн харааны чиглүүлэг болон анхааралтай холбоотой байдаг. Үүнийг засахад дараах арга тохиромжтой юм. Үүнд:

- Уншлагын чиглүүлэгч (Tracker):
- “Уншлагын цонх” арга: Уншиж буй мөрийг нь л харуулж, бусад мөрийг хаасан цаасан карт ашиглах. Тухайн мөрний үсгийг дуусгасны дараа картыг доош

гүйлгэж дараагийн мөрийг гаргана. Энэ нь анхаарлыг сарниулахгүй байхад тусална.

- Өргөн зайтай эх ашиглах: Үсэг, үе болон мөр хоорондох зайг ихэсгэж бичсэн эхийг ашиглах нь тохиромжтой. Энэ нь харааны андуурлаас сэргийлнэ.
- Хэмнэлттэй уншлага: Тогтмол хэмнэлттэйгээр уншуулах нь анхаарлыг төвлөрүүлж, мөрийг дуустал нь уншихад тусалдаг. Жишээлбэл, нэг үеийг нэг удаа алга ташиж унших.
- Яагаад сургалтын хөтөлбөрт тохируулга хийх шаардлагатай вэ?
- Ямар үр дүнд хүрэхийг зорьж ажиллах вэ?

Суралцагч уншиж буй зүйлээ ойлгохгүй бол унших сонирхол буурдаг тул ойлгох чадварыг нь дэмжих нь чухал юм. Ингэхдээ дараах аргачлалыг баримтлан ажиллах нь тохиромжтой. Үүнд:

- Өмнөх мэдлэгтэй холбох:
- Уншихын өмнө тухайн сэдвийн талаар ярилцах, зураг үзүүлэх, суралцагчийн өмнөх мэдлэгийг сэргээх асуултууд тавих.
- Дүрслэн бодож унших:
- Уншсан хэсгээс юу төсөөлж байгааг асуух, зуруулах эсвэл яриулах. Энэ нь уншсан зүйлийн утгыг эргэцүүлэн болоход тусалдаг.
- Асуулт, хариулт:
- Унших явцдаа тогтмол зогсолт хийж, “Одоо юу болж өнгөрөв?”, “Яагаад ингэв?”, “Дараа нь юу болох бол?” гэх мэт асуултуудыг тавьж, ойлгосныг нь шалгана.

Дээрх аргуудаас ээлжит хичээлд хэрхэн төлөвлөж суралцахуйн үйл ажиллагааг үр дүнтэй болгох жишиг ээлжит хичээлийн төлөвлөлтийг боловсруулж оруулав.

Бичих бэрхшээлтэй суралцагчидтай ажиллах аргачлал

Бичих бэрхшээлтэй (дисграфи) суралцагчтэй, ялангуяа үсгийг холих, үсгийг сольж бичих бэрхшээлтэй ажиллах нь олон талын арга зүй, тогтмол дасгал шаарддаг. Энэ бэрхшээл нь ихэвчлэн нарийн хөдөлгөөний ур чадвар, харааны хөдөлгөөний зохицуулалт, эсвэл үсгийн авиаг бичгийн тэмдэгтэй холбох (фонемийн-графикийн) бэрхшээлтэй холбоотой байдаг. Ийм тохиолдолд дараах арга аргачлалыг хэрэглүүлэхийг зөвлөж байна.

1. Үсгийн хэлбэр ба авиаг тогтоох (фонемийн болон визуаль мэдлэг)

Үсгийг холих, солих нь хамгийн түгээмэл бэрхшээл юм. Жишээ нь “б” бичихдээ “д”-ээр, “м”-г “н”-ээр бичих гэх мэт.

Бэрхшээл	Аргачлал	Жишээ
Үсгийн хэлбэрийг андуурах (б/д, х/н, з/э)	Олон Мэдрэхүйн Арга (ВАКТ – Хараа, Сонсгол, Хүртэх, Хөдөлгөөн): үсгийг зөвхөн хараад бичихээс илүүтэй, бусад мэдрэхүйг ашиглах.	1. Баримал/Наамал: Зөөлөн шавар, эсвэл зузаан утас ашиглан “б” ба “д” үсгийг хийлгэх. Суралцагч гараараа хүрч, хэлбэрийг нь мэдэрнэ. 2. Агаарт бичих/Хүртэхүй:

		Нүдээ аниад агаарт том хэмжээгээр үсгийг зөв дарааллаар бичүүлэх.
Бичих чиглэлийг андуурах	Эхлэх үсгийг тодотгох: үсэг эсвэл зурлагыг бичиж эхлэх үсгийг тод өнгөөр тэмдэглэн, ямар чиглэлээр бичих зааврыг өгөх: жишээ нь, дээрээс доош, нар зөв гэх мэт.	“Б” үсгийг бичихдээ эхлээд шулуун босоо шугамаа, дараа нь баруун талд нь дугуй хэсгийг бичих гэсэн дарааллыг байнга хэлж өгөх.
Авиаг үсэгтэй холбох (Сонссоноо бичихдээ)	Авиа – Үсэг холбоосыг бөгжөөр тогтоох: Сонссон авиагаа гараараа бичиж, чангаар хэлэх дасгал.	Багш “А” гэж хэлэхэд суралцагч чангаар “А” гэж хэлээд, дэвтэртээ зурлагыг нь бичих. Энэ нь сонсгол, яриа, харааны хөдөлгөөний үйлийг нэгтгэнэ.

2. Гарын бичих ур чадварыг хөгжүүлэх

Бичих бэрхшээлтэй суралцагчдын хувьд үзэг барих, хурууны жижиг булчинг удирдах чадвар сул байдаг.

- **Гарын дасгал:** Цаасыг нугалах, хайчлах, жижиг товч, бөмбөлгүүдийг ашиглан хийх нарийн ажлууд хийлгэх.
- **Үзэг барих арга:** Зөв барихыг дэмжих зориулалтын хэрэгсэл (үзгийн бариул, гурвалжин харандаа) ашиглах.
- **Зурлага дасгал:** Монгол хэлний үсгүүдийг бүрдүүлдэг үндсэн зурлагууд (босоо, хэвтээ, ташуу, дугуй) дээр анхаарч, шугамын дагуу гаргалгүйгээр бичих дасгалууд тогтмол хийлгэх.

3. Бичих үйл явцыг хялбаршуулах

Суралцагчийн бичихэд шаардагдах сэтгэл зүйн дарамтыг багасгах, ахиц амжилтыг нь дэмжих. Үүнд:

- **Үгийн загвар (Word Bank) ашиглах:** Тухайн хичээл дээр ашиглах хэцүү, эсвэл байнга алддаг үсгийг том үсгээр бичиж, харагдахуйц байрлуулах. Суралцагч хараад хуулбарлах боломжтой болно.
- **Хоёр үе шаттай бичиглэл:**
- **Ноороглох (Oral or typing):** суралцагч бодлоо эхлээд чангаар хэлэх, эсвэл компьютерын гарыг ашиглан бичих. Энэ нь найруулга болон бодол санаандаа анхаарах боломжийг олгоно.
- **Цэвэрлэх (Handwriting):** Хэлсэн эсвэл компьютероор бичсэн эхээ дараа нь гараар хуулбарлан бичих. Энэ нь бичих үйлдлийг хуулбарлах дасгал болгож, алдааг басгана.
- **Богино даалгавар:** Урт эх, бичвэр бичихээс зайлсхийж, богино өгүүлбэр, цөөн тооны үгээр хариулах даалгаврууд өгөх.

4. Харааны – Орон зайн ур чадварыг хөгжүүлэх

- **Шугамын баримжаа:** Дөрвөлжин, эсвэл тусгай шугамтай дэвтэр ашиглах. Шугамын өнгийг тодруулж өгөх нь үсгийг шугамаас гаргахгүй, хэмжээг нь алдуулахгүй байхад тустай. Жишээ нь: үндсэн мөрийг нь тод өнгөөр тодотгох.
- **Зайн мэдрэмж:** Үг хоорондын зай, мөр хоорондын зайг зөв тохируулан бичихэд сургах. Жишээ нь: Үг хоорондын хурууны өргөнтэй зай авч байхыг заах.

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал үйлчилгээг сайжруулах төсөл” (2019) Өдөр тутмын хэрэглээний 450 үгсийн зурган цомог. 4.6 хх. Улаанбаатар.

https://www.jica.go.jp/Resource/project/mongolian/mongolia/013/materials/c8h0vm0000dfy4g-o-att/materials_0501.pdf

2. Тэгш хамруулсан сургалтыг хэрэгжүүлэх зөвлөмж (2022). Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл. Багш нарт зориулсан гарын авлага. Улаанбаатар. “Очир принтинг” ХХК.

<https://cdn.greensoft.mn/uploads/users/2650/files/PDF%20file>

2. “Суралцагч бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь – 2”. (2022) Төслийн 2 дахь шатны суурь судалгааны тайлан. 9.5 хх. Улаанбаатар.

https://resourcecentre.savethechildren.net/pdf/MoFA_baseline22.pdf

3. Ахутина Т.В., Иншакова О.Б., (2016). Нейропсихологическая диагностика, обследование письма и чтения младших школьников. М.: В. Секачев, 128 с.

4. Дорофеева С.В., (2021). Лингвистические аспекты коррекции дислексии и дисграфии: опыт успешного применения комплексного подхода

5. Лалаева Р.И., (2002). Нарушения чтения и пути их коррекции у младших школьников. Учебное пособие. Издательство “Союз”. 224 с.

-----oOo-----

